



**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛИЙН
НИЙГЭМ, ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ СУРГУУЛЬ
КАНАД УЛСЫН ТОРОНТОГИЙН ИХ СУРГУУЛЬ**



**GOBI-STEPPE
NEOLITHIC PROJECT**

**ГОВЬ, ХЭЭРИЙН БҮС НУТГИЙН НЕОЛИТЫН СУДАЛГАА ТӨСӨЛ: ӨМНӨГОВЬ,
ДОРНОГОВЬ, СҮХБААТАР АЙМГИЙН ӨМНӨД НУТГААР 2024 ОНД ХИЙСЭН
АРХЕОЛОГИЙН ХАЙГУУЛ, МАЛТЛАГА СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

Улсын бүртгэлийн
дугаар.....

Нууцын зэрэглэл:

Аравтын бүтэн
ангилалын код

Төсөл хэрэгжүүлэх гэрээний
дугаар:

**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛИЙН
НИЙГЭМ, ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ СУРГУУЛЬ
КАНАД УЛСЫН ТОРОНТОГИЙН ИХ СУРГУУЛЬ**



**ГОВЬ, ХЭЭРИЙН БҮС НУТГИЙН НЕОЛИТЫН СУДАЛГАА ТӨСӨЛ: ӨМНӨГОВЬ,
ДОРНОГОВЬ, СҮХБААТАР АЙМГИЙН ӨМНӨД НУТГААР 2024 ОНД ХИЙСЭН
АРХЕОЛОГИЙН ХАЙГУУЛ, МАЛТЛАГА СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

Төслийн гүйцэтгэгч: Д.Одсүрэн (доктор Ph.D)
Л.Яанз (доктор Ph.D)
М.Агакун (магистр)
Э.Донойдугар (магистр)
О.Амаржаргал (магистрант)

Санхүүжүүлэгч байгууллага: Канад улсын Торонтогийн Их Сургууль

Тайлан өмчлөгч: МУБИС-ийн НХУС. Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, VIII хороо,
Бага тойруу – 14, Монгол Улс – 210648.
Утас: 77773443

**Улаанбаатар
2024**

Товьёг	
Гарчиг	iii
Зургийн тайлбар	v
Хүснэгтийн жагсаалт	viii
 ГАРЧИГ	
 УДИРТГАЛ	 10
1. МОНГОЛЫН ГОВЬ, ХЭЭРИЙН БҮС НУТАГТ ЧУЛУУН ЗЭВСГИЙН ДУРСГАЛЫГ СУДАЛСАН ТУХАЙ	 13
2. АРХЕОЛОГИЙН СУДАЛГАА	22
2.1. Археологийн судалгааны арга зүй	22
2.2. Хайгуул судалгаа	24
2.2.1. Задгайтын булаг орчимд хийсэн хайгуул судалгаа	24
2.2.2. Сангийн Далайн булаг орчимд хийсэн хайгуул судалгаа	25
2.2.3. Бяруухайн голын орчимд хийсэн хайгуул судалгаа	26
Бяруухайн голын 1-р бууц	27
Бяруухайн голын 2-р суурин	28
2.2.4. Ганган задгайн суурин	32
2.2.5. Харанхуй усны орчимд хийсэн хайгуул судалгаа	35
Харанхуй усны 1-р суурин	36
Харанхуй усны 2-р суурин	38
2.2.6. Хахуулын гол, Баянгол, Цал гүний сайр орчимд хийсэн хайгуул	39
2.2.7. Цагаан дэрс, Шүүлэнгийн застав хооронд хийсэн судалгаа	43
2.2.8. Хар хөвийн булаг орчимд хийсэн хайгуул судалгаа	44
2.2.9. Дуут манханы ар биеэр хийсэн хайгуул	45
2.2.10. Хавцалын булаг орчимд хийсэн хайгуул судалгаа	46
2.2.11. Бүрэгийн сайр орчимд хийсэн хайгуул судалгаа	47
Бүрэгийн сайрын 1-р дурсгал	49
Бүрэгийн сайрын 2а дурсгал	51
Бүрэгийн сайрын 2b суурин	54
Бүрэгийн сайрын 3-р суурин	55
Бүрэгийн сайрын 4-р суурин	55
2.2.12. Эхэн гүний худаг орчимд хийсэн хайгуул судалгаа	56
2.2.13. Хөх хошууны орчимд хийсэн хайгуул судалгаа	58
2.2.14. Говийн төхөмийн чулуун зэвсгийн дурсгалт газарт хийсэн хайгуул судалгаа	60
Говийн төхөмийн 1-р суурин	61
Говийн төхөмийн 2-р суурин	62
Говийн төхөмийн 3, 4-р суурин	63
Говийн төхөмийн 5-р суурин	65
Говийн төхөмийн 7-р суурин	66
Говийн төхөмийн 8-р суурин	67
2.2.15. Булаг шавагтайн орчимд хийсэн хайгуул судалгаа	69
2.2.16. Тэнгэр тойромын орчимд хийсэн хайгуул судалгаа	71
2.2.17. Цахиурт толгойн дурсгал	73
Цахиурт толгойн 1-р суурин	75
Цахиурт толгойн 1b суурин	75

	<i>Цахиурт толгойн 2-р суурин</i>	77
	<i>Цахиурт толгойн 3-р суурин</i>	78
	<i>Цахиурт толгойн 4-р суурин</i>	79
	<i>Цахиурт толгойн хүрэл болон түүхэн үеийн дурсгал</i>	81
2.2.18.	Тэнгэр нуурын бүйлстэй тойром орчимд хийсэн хайгуул	85
2.2.19.	Арын усны шивээ	86
2.2.20.	Дулааны говьд хийсэн хайгуул судалгаа	88
	<i>Дулааны говийн 1-р суурин</i>	91
	<i>Дулааны говийн 2-р суурин</i>	95
	<i>Дулааны говийн 3-р суурин</i>	97
	<i>Дулааны говийн 4-р суурин</i>	98
	<i>Дулааны говийн 5-р суурин</i>	99
	<i>Дулааны говийн 6-р суурин</i>	100
	<i>Дулааны говийн 7-р суурин</i>	100
	<i>Дулааны говийн 8-р суурин</i>	102
	<i>Дулааны говийн 9-р суурин</i>	103
	<i>Дулааны говийн 1-р суурин</i>	105
2.2.21.	Сайрын бууцны хойд толгойн Улаан зуух хэлбэрийн булш	105
2.2.22.	Баян хошууны Улаан зуух хэлбэрийн булш	106
2.2.23.	Дөрвөлжин овооны дурсгал	108
2.2.24.	Хавиргын булагийн адагийн дурсгал	108
2.2.25.	Их булагийн урд дэнжид хийсэн хайгуул судалгаа	109
	<i>Их булагийн урд дэнжийн 1-р суурин</i>	109
	<i>Их булагийн урд дэнжийн 2-р суурин</i>	110
2.2.26.	Өлзийтийн шар манханы орчимд хийсэн хайгуул судалгаа	110
2.2.27.	Хөндлөнгийн голын сав дагууд хийсэн хайгуул судалгаа	112
2.2.28.	Нам ухаагийн дурсгал	113
	<i>Нам ухаагийн 1-р суурин</i>	114
	<i>Нам ухаагийн 2-р суурин</i>	118
	<i>Нам ухаагийн 3-р суурин</i>	119
	<i>Нам ухаагийн 4-р суурин</i>	121
	<i>Нам ухаагийн 5-р суурин</i>	122
	<i>Хөндлөнгийн голын 1-р суурин</i>	127
	<i>Хөндлөнгийн голын 2-р суурин</i>	129
	<i>Нам ухаагийн хүрлийн үеийн дурсгал</i>	132
2.2.29.	Хөндлөнгийн голын хэрэм	135
2.2.30.	Баруун Сөдөтийн голын сав нутагт хийсэн хайгуул судалгаа	137
	<i>Тамга бичигтэй чулуу</i>	137
	<i>Баруун Сөдөтийн зуухны үлдэгдэл</i>	137
	<i>Баруун Сөдөтийн хийдийн туурь</i>	138
	<i>Сөдөтийн хийдийн туурь орчмын түүвэр олдворт газар</i>	139
2.2.31.	Эрдэнэ ууланд хийсэн хайгуул судалгаа	140
2.2.32.	Дагшин булагийн орчимд хийсэн хайгуул судалгаа	145
2.2.33.	Зүүн Нарт орчимд хийсэн хайгуул судалгаа	147
2.3.	Малтлага судалгаа	149
3.	ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮН	160
4.	НОМ ЗҮЙ	169
5.	ХАВСРАЛТ	

Хавсралт 1. Археологийн судалгаа хийх зөвшөөрлийн хуулбар	172
Хавсралт 2. Албан томилолтын хуулбар	173
Хавсралт 3. Судалгааны ажлын удирдамжийн хуулбар	174
Хавсралт 4. Хамтарсан судалгааны гэрээ	178
Хавсралт 5. Хээрийн шинжилгээний ажлын зардлын задаргаа	181
Хавсралт 6. Хээрийн судалгааны явцад илрүүлсэн олдворын жагсаалт	181
Хавсралт 7. Хайгуул судалгааны үр дүнд шинээр илрүүлсэн, судалгаа хийсэн дурсгалын солбицол, он цагийн хамаарал	197
Дурсгалт газар болон олдвор эд өлгийн зүйлийн хадгалалт хамгаалалт	201
Олдвор эд зүйлсийн шилжилт хөдөлгөөний талаарх мэдээлэл	201

Зургийн тайлбар

Зураг 1. 2024 оны хээрийн судалгааны ангийн бүрэлдэхүүн	11
Зураг 2. Задгайн булагийн 1-р дурсгал. Шоргоолжин булш	24
Зураг 3. Задгайн булагийн 2-р дурсгал. Улаан зуух хэлбэрийн булш	24
Зураг 4. Сангийн далайн булаг ба булгийн хөлөөс илрүүлсэн ооль	25
Зураг 5. Сангийн Далайн булагийн орчмоос илрүүлсэн ооль	25
Зураг 6. Бяруухайн гол (зургийг урд талаас. Цаана нь Хөрхийн нуруу харагдана)	26
Зураг 7. Баяруухайн голын 1-р бууц (зургийг баруун талаас)	27
Зураг 8. Баяруухайн голын 2-р суурин (зургийг баруун талаас)	29
Зураг 9. Бяруухайн голын 2-р суурин. 1, 3, 5 – шовх үлдэц	29
Зураг 10. Баяруухайн голын 2-р суурин (зургийг хойд талаас)	31
Зураг 11. Баяруухайн голын 2- сууринаас илрүүлсэн нүдүүр	31
Зураг 12. Ганган задгай (зургийг урд талаас)	33
Зураг 13. Ганган задгайн галын ором олдсон эрэг (зургийг баруун урд талаас)	33
Зураг 14. Ганган задгай 1 суурин. Сүхний члууун үзүүр	34
Зураг 15. Харанхуй ус (зургийг баруун урд талаас)	35
Зураг 16. Харанхуй усны 1-р суурин (зургийг урд талаас)	36
Зураг 17. Харанхуй усны 1-р суурин. 1 – чулуун сүх, 2, 3 – ооль	37
Зураг 18. Харанхуй ус 2-р суурин (зургийг зүүн хойд талаас)	38
Зураг 19. Харанхуй усны 2-р суурин. Үлдэц	38
Зураг 20. Харанхуй усны 2-р суурин. Бифасны хугархай	39
Зураг 21. Тавьтын Улаан зуух хэлбэрийн булш (зургийг урд талаас)	40
Зураг 22. Хахуулын голын Бичигт хад (зургийг урд талаас)	40
Зураг 23. Хахуулын голын хадны зургийн зарим дүрслэл	41
Зураг 24. Баянголын тооройн төгөл ба орвог	42
Зураг 25. Цал гүний сайрын адгийн чулуун зэвсгийн түүхий эд бүхий газар	42
Зураг 26. Сорилын малтлага хийсэн газрын тэмдэглэгээ	43
Зураг 27. Зуувандуу маягаар хүрээлэн суулгасан чулуу	44
Зураг 28. Хүрээ чулууны дундаас галын ором илэрсэн байдал	44
Зураг 29. Хоёр дахь байгууламжийн тодорхой зохион байгуулалтгүй дараас чулуу	44
Зураг 30. Өнгөн хөрсийг цэвэрлэж с илрүүлсний дараах байдал	44
Зураг 31. Дуут манхан (хойд талаас)	45
Зураг 32. Дуут манханы ар бие	46
Зураг 33. Хавцалын булаг (Баруун талаас)	46
Зураг 34. Хавцалын булаг	47
Зураг 35. Хавцалын булагийн эх	47
Зураг 36. Хавцалын булагийн баруун дэнж дэх чулуун байгууламж	47
Зураг 37. Борзонгийн говийн зүүн хэсэг Бүрэгийн сайр	48
Зураг 38. Дурсгалын газрын хөрсөн дээр тархсан чулуун зэвсгийн олдвор	49
Зураг 39. Бүрэгийн сайрын 1-р дурсгал (зургийг зүүн урд талаас)	49

Зураг 40.	Бүрэгийн сайрын 1-р суурин. 1 – хутганы хугархай, 2 – үлдэц, 3 – сүх маягийн зэвсэг, 4 – зэвсгийн бэлдэц	50
Зураг 41.	Бүрэгийн сайрын 2а дурсгал (зургийг баруу урд талаас)	52
Зураг 42.	Бүрэгийн сайрын 2-р суурин. 1 – бэлдэц, Бүрэгийн сайрын 4-р суурин. 2 – хутганы хугархай, 3 - бэлдэц	53
Зураг 43.	Бүрэгийн сайрын 4-р дурсгал (зургийг баруун хойд талаас)	55
Зураг 44.	Эхэн гүний нарны тольтой худаг орчмын газар (Баруун талаас)	56
Зураг 45.	Газрын хөрсөн дээр тархсан ваарын хагархай	57
Зураг 46.	Галын ормын үлдэгдэл	57
Зураг 47.	Гадаад зохион байгуулалт нь эвдэгдсэн чулуун байгууламж	58
Зураг 48.	Газрын хөрсөн дээр буй эвдэрч бутарсан төмөр эдлэлийн хэлтэрхий	58
Зураг 49.	Өндөр Богдын баруун талаас илрүүлсэн шар хасын орд	58
Зураг 50.	Хөх хошуунаас илрүүлсэн бөсөл чулуугаар хийсэн зузаан залтас	59
Зураг 51.	Говийн төхөм (Хойд талаас)	60
Зураг 52.	Говийн төхөмийн 1-р суурин (зургийг хойд талаас)	61
Зураг 53.	Говийн төхөмийн 1-р суурин. 1 – Ирлэсэн техникийн цуулдас, 2 – хутга маягийн эдлэл	62
Зураг 54.	Говийн төхөмийн 3-р суурин. 1, 2, 3 – үлдэц; Говийн төхөмийн 5-р суурин. 4 – хутганы хугархай	64
Зураг 55.	Говийн төхөмийн 5-р суурин. 1 – шаантган үлдэц, 2 – урт ялтас	66
Зураг 56.	Говийн төхөмийн 7-р суурин (зургийг хойд талаас)	67
Зураг 57.	Говийн төхөмийн 8-р суурин ба зэсийн баасын үлдэгдэл (зургийг баруун урд талаас)	67
Зураг 58.	Говийн төхөмийн 7-р суурин. 1 – хосолмол зэвсэг; Говийн төхөмийн 8-р суурин. 2 – бифасны хугархай	68
Зураг 59а.	Говийн төхөмийн зүүн талын түүхий эдтэй газар	69
Зураг 59б.	Булаг шавагтайн дурсгал (зургийг зүүн талаас)	70
Зураг 60.	Булаг шавагтайн 1-р суурин. 1, 2 – үлдэц, 3 - хусуур	71
Зураг 61.	Тэнгэр тойромын баруун хойд биеийн нуур (зургийг хойд талаас)	72
Зураг 62.	Тэнгэр тойромын баруун хойд биеэс илрүүлсэн чулуун байгууламж (зургийг баруун урд талаас)	73
Зураг 63.	Цахиурт толгой (зургийг зүүн урд талаас)	73
Зураг 64.	Цахиурт толгой (Баруун хойд талаас)	74
Зураг 65.	Цахиурт овооны эргэн тойрон дахь түүхий эд ба чулуун зэвсэг	74
Зураг 66.	Цахиурт овооны 1-р дурсгал (зургийг баруун урд талаас)	75
Зураг 67.	Цахиурт овооны 1b дурсгал (зургийг баруун урд талас)	76
Зураг 68.	Цахиурт толгойн 1b суурин. 1 – ялтас, 2 - цоолтуур	77
Зураг 69.	Цахиурт овооны 2-р дурсгал (зургийг баруун талаас)	77
Зураг 70.	Цахиурт толгойн 2-р суурин. 1 – залтас, 2 – үлдэц хэлбэрийн эдлэл	78
Зураг 71.	Цахиурт овооны 3-р дурсгал (зургийг баруун талаас)	79
Зураг 72.	Цахиурт овооны 4-р дурсгал (зургийг хойд талаас)	80
Зураг 73.	Цахиурт толгойн 4-р суурин. 1, 2 – ялтас	80
Зураг 74.	Цахиурт овооны 1-р Шоргоолжин булш	81
Зураг 75.	Цахиурт овооны өвөр бэлийн археологийн дурсгал	82
Зураг 76.	Цахиурт овооны 2-р Шоргоолжин булш	82
Зураг 77.	Цахиурт овооны 3-р Шоргоолжин булш	82
Зураг 78.	Цахиурт овооны 1-р Улаан зуух хэлбэрийн булш	83
Зураг 79.	Цахиурт овооны 2-р Улаан зуух хэлбэрийн булш	83
Зураг 80.	Цахиурт овооны 3-р Улаан зуух хэлбэрийн булш	83
Зураг 81.	Цахиурт овооны 4-р Улаан зуух хэлбэрийн булш	83
Зураг 82.	Цахиурт овооны 5-р Улаан зуух хэлбэрийн булш	84
Зураг 83а.	Цахиурт овооны өвөр бэлийн ээл чулуу	84
Зураг 83б.	Тэнгэр тойромын бүйлсэн төгөл	85

Зураг 84.	Уулын оройг хашиж өрсөн цонж (хойд талаас)	86
Зураг 85.	Өрлөг нь харьцангуй сайн хадгалагдсан хойд талын хана	87
Зураг 86.	Цонжийн орой дээрээс олдсон ахуйн ваарын хагархай	87
Зураг 87.	Цонжийн дээд хэсэг ба орой дээрх чулуун өрлөг (Зүүн урд талаас)	88
Зураг 88.	Дулааны говь	89
Зураг 89.	Дулааны говь (зургийг урд талаас)	90
Зураг 90.	Дулааны говийн 1-р дурсгал (зургийг хойд талаас)	91
Зураг 91.	Дулааны говийн 1-р суурин. 1, 2, 3 – үлдэц, 4 – нүхэлсэн тэмээн хяруулын өндөгний хальс	93
Зураг 92.	Дулааны говийн 2-р дурсгал (зургийг баруун хойд талаас)	95
Зураг 93.	Дулааны говийн 2-р суурин. Үлдэц	96
Зураг 94.	Дулааны говийн 3-р дурсгал (Баруун хойд талаас)	97
Зураг 95.	Дулааны говийн 3-р суурин. Ваарын хагархай	98
Зураг 96.	Дулааны говийн 4-р дурсгал (Баруун урд талаас)	99
Зураг 97.	Дулааны говийн 7-р дурсгал (Хойд талаас)	101
Зураг 98.	Дулааны говийн 8-р суурин ба тэндээс илрүүлсэн нүхэлсэн ваарын хагархай	103
Зураг 99.	Дулааны говийн 10-р суурин (Зүүн талаас)	103
Зураг 100.	Дулааны говийн 9-р суурин. Чулуун зэв	104
Зураг 101.	Дулааны говийн 10-р сууригийн ваар савны хагархай	105
Зураг 102.	Эрдэнэ сумаас Онгон сум явах зам дагуух Улаан зуух хэлбэрийн булш (зургийг урд талаас)	106
Зураг 103.	Баянхошууны 1-р Улаан зуух хэлбэрийн булш	107
Зураг 104.	Баянхошууны 2-р Улаан зуух хэлбэрийн булш	107
Зураг 105.	Баянхошууны 3-р Улаан зуух хэлбэрийн булш	108
Зураг 106.	Өлзийтийн Шар манхан (Сүхбаатар аймаг, Наран сум. Зүүн хойд талаас)	111
Зураг 107.	Өлзийтийн Шар манханы ар хотгорт буй газрын хөрсөн дээрх ваарын хагархай, галын ором	111
Зураг 108.	Хөндлөнгийн гол (Нам ухаагийн баруун хэсгээс зүүн тийш)	144
Зураг 109.	Нам ухаагаас илрүүлсэн чулуун зэвсгийн дурсгалт газрууд (зургийг баруунаас зүүн тийш)	115
Зураг 110.	Нам ухаагаас 2010 онд олсон будмал хээтэй ваарын сэргээн засварласан байдал (Д.Дугарсүрэн абугайн цуглуулга)	115
Зураг 111.	Нам ухаагийн 1 дүгээр суурин (зургийг баруун хойд талаас)	116
Зураг 112.	Нам ухаагийн 2 дугаар суурин (зургийг баруун талаас)	119
Зураг 113.	Нам ухаагийн 3 дугаар суурин (зургийг баруун талаас)	120
Зураг 114.	Нам ухаагийн 4 дүгээр суурин (зургийг баруун талаас)	121
Зураг 115.	Нам ухаагийн 5 дугаар суурин (зургийг баруун урд талаас)	123
Зураг 116.	Нам ухаагийн 5 дугаар суурины олдвор тархсан хэсэг (зургийг урд талаас)	123
Зураг 117.	Нам ухаагийн 5-р суурин. 1, 2 – шаантган үлдэц, 3, 4 – шовх үлдэц.	124
Зураг 118.	Нам ухаагийн 5-р суурин. 1 – сүх, 2 - хусуур	125
Зураг 119.	Нам ухаагийн 5-р суурин. Самбар чулууны хагархай	126
Зураг 120.	Нам ухаагийн 5-р суурин. Чулуун эдлэл	127
Зураг 121.	Хөндлөнгийн голын 1 дүгээр суурин (зургийг зүүн талаас)	127
Зураг 122.	Хөндлөнгийн голын 1 дүгээр суурингаас илрүүлсэн хасаар хийсэн гоёл чимэглэлийн зүй ба олдсон газар	128
Зураг 123.	Хөндлөнгийн голын 2-р дурсгал. 1, 3 – үлдэц, 2 – чулуун зүүлт	128
Зураг 124.	Хөндлөнгийн голын 2 дугаар дурсгал ба голын адаг, Үйзэнгийн цагаан нуур (зургийг зүүн талаас)	130
Зураг 125.	Хөндлөнгийн голын 2-р суурин. 1 – үлдэц, 2 – ооль, 3, 4 - хусуур	131
Зураг 126.	Хөндлөнгийн голын 2 дугаар суурин (зургийг баруун хойд талаас)	132
Зураг 127.	Хөндлөнгийн голын Нам ухаагийн 1-р булш	133

Зураг 128.	Хөндлөнгийн голын Нам ухаагийн 2-р булш	133
Зураг 129.	Хөндлөнгийн голын Нам ухаагийн 3-р булш	133
Зураг 130.	Хөндлөнгийн голын Нам ухаагийн 4-р булш	133
Зураг 131.	Хөндлөнгийн голын Нам ухаагийн 5-р булш	134
Зураг 132.	Хөндлөнгийн голын Нам ухаагийн 6-р булш	134
Зураг 133.	Хөндлөнгийн голын Нам ухаагийн 7-р булш	134
Зураг 134.	Хөндлөнгийн голын урд дэвсэгийн хэрэм (зургийг урд талаас)	135
Зураг 135.	Хөндлөнгийн голын хэрмийн агаарын зураг	136
Зураг 136.	Тамга тэмдэг дүрсэлсэн бололтой боржин чулууны хагархай	137
Зураг 137.	Манхны арын салхинд идэгдсэн хормойгоос ил гарсан шатсан хөрс	138
Зураг 138.	Баруун Сөдөтийн хийдийн туурь	138
Зураг 139.	Сөдөтийн хийдийн туурь. Хавтан чулуу	139
Зураг 140.	Сөдөтийн хийдийн туурь. Дээврийн ваарын хагархай	139
Зураг 141.	Сөдөтийн хийдийн туурь. Хээтэй хавтан чулуу	139
Зураг 142.	Хээлж бичмэглэсэн боржин чулуу	139
Зураг 143.	Сөдөтийн хийдийн туурь орчмын түүвэр олдворт газар ба хятан ваар (зургийг баруун урд талаас)	140
Зураг 144.	Эрдэнэ уул (зургийг урд талаас)	141
Зураг 145.	Эрдэнэ уулын 1-р чулуун байгууламж (зургийг зүүн талаас)	141
Зураг 146а.	Эрдэнэ уулын 2-р чулуун байгууламж (зургийг зүүн талаас)	141
Зураг 146б.	Эрдэнэ уулын 3-р чулуун байгууламж (зургийг зүүн талаас)	142
Зураг 147.	Эрдэнэ уулын 4-р чулуун байгууламж (зургийг зүүн талаас)	142
Зураг 148.	Эрдэнэ уулын 5-р дурсгал. Шоргоолжин булш	144
Зураг 149.	Эрдэнэ уулын 6-р дурсгал. Улаан зуух хэлбэрийн булш	144
Зураг 150.	Эрдэнэ уулын 7-р дурсгал. Хүннү булш	144
Зураг 151.	Эрдэнэ уулын 8-р дурсгал. Хүннү булш	144
Зураг 152.	Эрдэнэ уулын 9-р дурсгал. Улаан зуух хэлбэрийн булш	144
Зураг 153.	Эрдэнэ уулын 10-р дурсгал. Улаан зуух хэлбэрийн булш?	144
Зураг 154.	Эрдэнэ уулын 11-р дурсгал. Шоргоолжин булш	145
Зураг 155.	Эрдэнэ уулын 12-р дурсгал. Улаан зуух хэлбэрийн булш	145
Зураг 156.	Эрдэнэ уулын 13-р дурсгал. Улаан зуух хэлбэрийн булш ба чулуун байгууламж	145
Зураг 157.	Дагшин булагийн эхэн орчимд байх төмрийн баас, шатсан хөрс бүхий газар	146
Зураг 158.	Дагшин булагийн эхэн хэсгийн чулуун зэвсэг, ваарын хагархай, төмрийн баас тархсан элсэн хотгор	146
Зураг 159.	Дагшин булагийн Улаан зуух хэлбэрийн булш	147
Зураг 160.	Зүүн Нартын энгэрийн агуй	147
Зураг 161.	Зүүн Нартын агуй	148
Зураг 162.	Салаа булагийн дурсгал	149
Зураг 163.	Салаа булагт малтлагын талбай сонгосон байдал	151
Зураг 164.	Салаа булагт хийсэн малтлагын урд хана ба хөрсний үе давхаргын тэмдэглэгээ	152
Зураг 165.	Салаа булагийн малтлагын 2-р давхарга	153
Зураг 166.	Салаа булагийн 4б давхаргаас илрүүлсэн олдвор	156
Зураг 167.	Салаа булагийн малтлагын ханаас хөрсний дээж авч буй нь	158
Зураг 168.	Салаа булагт хийсэн малтлагыг нөхөн сэргээж булсан байдал	159
Зураг 169.	Хамтарсан төслийн 2024 онд хайгуул судалгаа хийсэн, шинээр илрүүлсэн археологийн дурсгалын тархалтын бүдүүвч	168

Хүснэгтийн тайлбар

Хүснэгт 1.	Бяруухайн голын 1-р бууцын чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл	28
------------	--	----

Хүснэгт 2.	Бяруухайн голын 2-р суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл	30
Хүснэгт 3.	Ганган Задгай 1, 2-р суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл	34
Хүснэгт 4.	Харанхуй усны 1-р суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл	37
Хүснэгт 5.	Харанхуй усны 1-р суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл	39
Хүснэгт 6.	Бүрэгийн сайрын 1-р суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл	51
Хүснэгт 7.	Бүрэгийн сайрын 2а суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл	53
Хүснэгт 8.	Бүрэгийн сайрын 2b суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл	54
Хүснэгт 9.	Бүрэгийн сайрын 4-р суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл	56
Хүснэгт 10.	Говийн төхөмийн 1-р суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл	61
Хүснэгт 11.	Говийн төхөмийн 2-р суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл	63
Хүснэгт 12.	Говийн төхөмийн 3-р суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл	63
Хүснэгт 13.	Говийн төхөмийн 4-р суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл	65
Хүснэгт 14.	Говийн төхөмийн 5-р суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл	65
Хүснэгт 15.	Говийн төхөмийн 7-р суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл	67
Хүснэгт 16.	Булаг шавагтайгаас илрүүлсэн чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл	70
Хүснэгт 17.	Цахиурт овооны 1а суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл	75
Хүснэгт 18.	Цахиурт овооны 1b суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл	76
Хүснэгт 19.	Цахиурт толгойн 2-р суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл	78
Хүснэгт 20.	Цахиурт толгойн 4-р суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл	79
Хүснэгт 21.	Тэнгэр тойромын чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл	85
Хүснэгт 22.	Дулааны говийн 1-р суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл	92
Хүснэгт 23.	Дулааны говийн 2-р суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл	96
Хүснэгт 24.	Дулааны говийн 3-р суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл	97
Хүснэгт 25.	Дулааны говийн 4-р суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл	99
Хүснэгт 26.	Дулааны говийн 6-р суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл	100
Хүснэгт 27.	Дулааны говийн 7-р суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл	102
Хүснэгт 28.	Дулааны говийн 9-р суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл	104
Хүснэгт 29.	Хавиргын булагийн чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл	109
Хүснэгт 30.	Их булаг 1 суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл	109
Хүснэгт 31.	Их булаг 2 суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл	110
Хүснэгт 32.	Өлзийтийн Шар манханы суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл	112
Хүснэгт 33.	Нам ухаагийн 1-р суурины олдворын ангилал	117
Хүснэгт 34.	Нам ухаагийн 2-р суурины олдворын ангилал	119
Хүснэгт 35.	Нам ухаагийн 3-р суурины олдворын ангилал	120
Хүснэгт 36.	Нам ухаагийн 4-р суурины олдворын ангилал	121
Хүснэгт 37.	Нам ухаагийн 5-р суурины олдворын ангилал	124
Хүснэгт 38.	Хөндлөнгийн голын 1-р суурины олдворын ангилал	129
Хүснэгт 39.	Хөндлөнгийн голын 2-р суурины олдворын ангилал	131
Хүснэгт 40.	Салаа булагийн малтлагын 1-р давхаргаас илрүүлсэн олдворын ангилал	152
Хүснэгт 41.	Салаа булагийн малтлагын 2-р давхаргаас илрүүлсэн олдворын ангилал	153
Хүснэгт 42.	Салаа булагийн малтлагын 3-р давхаргаас илрүүлсэн олдворын ангилал	154
Хүснэгт 43.	Салаа булагийн малтлагын 4а давхаргаас илрүүлсэн олдворын ангилал	154
Хүснэгт 44.	Салаа булагийн малтлагын 4b давхаргаас илрүүлсэн олдворын ангилал	157
Хүснэгт 45.	Салаа булагийн малтлагын 4с давхаргаас илрүүлсэн олдворын ангилал	158

УДИРТГАЛ

Монгол-Канадын хамтарсан GSN буюу Говь, хээрийн бүс нутгийн неолитын судалгаа төслийн судлаачид сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд Монгол орны тал, хээрийн бүс нутагт плейстоцены төгсгөл, голоцены эхэн үеийн анчин – түүвэрлэгчдийн бууц суурин шинээр илрүүлэх, малтан шинжилж бүс нутгийн түүхийг шинэ баримт хэрэглэгдэхүүнээр баяжуулах судалгааг гүйцэтгэж байгаа билээ.

Өнгөрсөн хугацаанд Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг зараа уул, Дорнод аймгийн Халхгол сумын нутаг Тамсагбулагт төвлөрсөн археологийн судалгааг гүйцэтгэсэн бол 2024 оны хээрийн судалгааны улиралд шинэ дурсгал илрүүлэх археологийн хайгуул судалгаанд анхаарал хандуулсан юм. Түүнчлэн, өмнө нь илрүүлсэн Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутаг Салаа булгийн дурсгалыг өргөн хэмжээнд малтан шинжилж холбогдох он цаг, соёлын холбогдлын тухай шинэ мэдээлэл бий болгохыг зорьсон билээ.

Хайгуул судалгааг бид Өмнөговь, Дорноговь, Сүхбаатар аймгийн өмнөд нутгаар хийхээр төлөвлөсөн. Монгол орны говь, хээрийн бүс нутгийн өмнөд хэсгээр өнгөрсөн хугацаанд археологийн судалгаа, тэр дундаа чулуун зэвсгийн судалгаа харьцангуй бага хийгдсэн тул анчин – түүвэрлэгчдийн бууц суурины мэдээлэл тун хомс юм. Өмнөговь аймгийн Ханбогд, Баян-Овоо, Цогтцэций зэрэг сумдын нутагт сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд уул уурхайн хайгуул, ашиглалтын үйл ажиллагаатай холбоотой археологийн судалгаа хийгдэж, палеолитын хэд хэдэн сонирхолтой дурсгал илрүүлж судалгааны эргэлтэд оруулсан боловч голоцены үеийн дурсгалын мэдээ баримт бүрхэг хэвээр байна. Тиймээс хайгуул судалгааг Өмнөговь аймгийн Номгон сумын өмнөд хэсэг, Монгол Улсын хилийн Орвог гашууны бор толгойн ойролцоох газраас эхлэн зүүн тийш улсын хилийн дагууд Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутагт хүртэл гүйцэтгэхээр төлөвлөж байв.

Ийм өргөн уудам газар нутгийг нэг бүрчлэн самнах боломжгүй тул геологийн чулуулгийн зураг, агаарын зураг, 1:100.000 масштабтай зураг, газрын нэрийн зураг зэрэгт тулгуурлан дурсгал байх магадлалтай газрыг урьдчилан тогтоож, эдгээр газар, түүний ойр орчмыг шалгаж үзэв.

Ийнхүү Монгол Улсын өмнөд хилийн бүс нутагт чулуун зэвсгийн дурсгал хайж илрүүлэх нь судалгааны хэд хэдэн ач холбогдолтой юм. Сүүлийн жилүүдэд хятадын археологичид газар нутгийн хойд хэсгээр түүхийн янз бүрийн цаг үед холбогдох археологийн дурсгалуудыг нээж судалгааны эргэлтэд оруулсан билээ. Эдгээрийн дотор чулуун зэвсгийн дурсгалт газрууд ч олон бий. Үүний нэг нь Монгол Улсын хилийн өмнөд цэг Орвог гашууны Бор толгойгоос холгүй орших Ингэн худгийн суурин юм. Тиймээс бид Ингэн худагтай

ойролцоо Улсын хил дээр орших Баянгол, Цал гүний сайр хэмээх газраас судалгааг эхлүүлэн гүйцэтгэсэн юм. Улсын хилийн оролцоо газарт буй дурсгалуудыг илрүүлж цаашид нарийвчлан судалснаар глоцены үеийн анхчин – түүвэрлэгч бүлгүүдийн хоорондын харилцаа, худалдаа, соёлын талаар харьцуулан судлах боломж бүрдэнэ хэмээн үзэж буй юм.

Бид Борзонгийн говийн орчмын нутаг, Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Тэнгэр тойром, Сүхбаатар аймгийн Хөндлөнгийн гол зэрэг газраас олон шинэ дурсгал илрүүлж судалгааг баяжуулсны зэрэгцээ Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутаг Салаа булагт анчин – түүвэрлэгчдийн сонирхолтой дурсгалыг малтан шинжлэв.

Судалгааны баг зөвхөн анчин – түүвэрлэгчдийн бууц сууринаар судалгааг хязгаарлалгүй олон цаг үеийн чулуун байгууламжит дурсгал булш оршуулгыг ч мөн бүртгэж бүс нутгийн археологийн дурсгалын мэдээллийн сан баяжуулахад анхаарал хандуулсан юм.



Зураг 1. 2024 оны хээрийн судалгааны ангийн бүрэлдэхүүн

Хамтарсан судалгааны 2024 оны хээрийн шинжилгээний ангийн бүрэлдэхүүн (Зураг 1)-д МУБИС-ийн НХУС-ийн Түүхийн тэнхимийн багш, доктор (Ph.D) Д.Одсүрэн, Канад улсын Торонтогийн Их сургуулийн судлаач, доктор (Ph.D), профессор Л.Яанз, Канадын Торонтогийн Их Сургуулийн докторант Агакун Моэсией Олуvasей, МУБИС-ийн Түүхийн салбарын докторант Э.Донойдугар, оюутан О.Амаржаргал, 0501 УБӨ Ландкрузер маркийн автомашины жолооч Б.Чинзориг, 2210 ӨМҮ Мицүбиши Делика маркийн автомашины жолооч Д.Одхүү, тогооч Ц.Цэцэгбаяр нар оролцон ажиллав. Мөн орон нутгийн түүх соёлын

дурсгалыг сонирхон судлагч, ахмад багш Д.Дугарсүрэн, түүний гэргий С.Цэрэнханд нар археологийн хайгуул судалгааны багт оролцон ажиллаж, олон сонирхолтой дурсгалыг бидэнд зааж өгсөн билээ. Түүнчлэн, АНУ-ын Йелийн Их сургуулийн доктор (Ph) Д.Бөхчулуун хээрийн судалгаатай танилцсан юм.

1. МОНГОЛЫН ГОВЬ, ХЭЭРИЙН БҮС НУТАГТ ЧУЛУУН ЗЭВСГИЙН ДУРСГАЛЫГ СУДАЛСАН ТУХАЙ

Манай орны говийн бүс нутгийг чулуун зэвсгийн талаар судлах ажил 1920-оод оны эхэн үеэс хийгдэж эхэлжээ. Тухайн үед Г.Ф.Осборн, В.Д.Мэтью, Д.Блэк, П.П.Сушкин нарын эрдэмтэд хүн үүссэн өлгий нутаг нь Төв Ази гэсэн саналыг хүчтэй дэвшүүлэн тавьсан юм. Тэднийхээр 70-аад сая жилийн өмнө чийглэг дулаан уур амьсгалтай байсан Төв Азид уул үүсэх үйл явцтай холбоотойгоор цаг агаар өөрчлөгдөж хуурайшиж эхэлсэн нь органик биес хувьсан өөрчлөгдөх гол түлхэц болж ой модонд амьдарч байсан бич уулархаг хээр талын нөхцөлд аяндаа зохицож хойд хоёр хөл дээрээ явах болсноор анхны хүн энд бий болсон ажээ¹. Энэ үзлийг газар дээр нь шалган үзэх зорилгоор 1922, 1923, 1925-1928 онуудад Р.Ч.Эндрюсийн удирдсан Америкийн “Төв Азийн экспедиц” Монгол орны өмнөд болон баруун өмнөд хэсэгт ажилласан юм. Энэ экспедицэд 1925 оноос археологич Н.К.Нельсоныг чулуун зэвсгийн үеийн дурсгал судлуулахаар урьж ажиллуулсан байна. Түүний Монголын говь нутгаас илрүүлсэн дурсгалуудын цуглуулгын ихэнх хэсэг неолитын үед холбогдож байсан бөгөөд Арц Богд, Орог нуурын хавиас олдсон эдлэлүүд палеолитын үед холбогдож байв. Мөн Баянзагийн Шавар ус хэмээх газраас шинэ чулуун зэвсгийн томоохон суурин газар илрүүлж судалжээ. Н.К.Нельсон Баянзагийн Шавар усны орчимд шаварлаг хөрсөн дээр тархсан чулуун зэвсгийн олдвор, шавар ваар сав, галын ором зэргийг илрүүлсэн бөгөөд эртний хүний соёлын үлдэгдэл агуулсан 23 дурсгалт газар байгааг тогтоон газрын зурагт тэмдэглэсэн байна².

Энэ шинжилгээний ангийн дараа 1949 он хүртэл Монгол улсын нутаг дэвсгэр дээрх чулуун зэвсгийн судалгааны ажил зогсонги байдалтай байсан боловч хөрш зэргэлдээ бүс нутаг тухайлбал, Өвөр Монгол, Манжуур, Хятадын говийн хэсгүүдэд барууны судлаачдын шинжилгээний ажил хийгдэж байсныг³ хэлэх хэрэгтэй.

1948-1949 онд Манай улсын нутаг дэвсгэр дээр С.В.Киселевийн удирдсан Монгол-Зөвлөлтийн хамтарсан түүх-угсаатны зүйн экспедиц ажиллаж эхэлсэн бөгөөд А.П.Окладниковоор удирдуулсан чулуун зэвсгийн үеийн дурсгал судлах анги Монгол улсын төв болон зүүн бүс, Хиагтаас Улаанбаатар, зүүн зүгт Хэрлэнгийн хөвөөнөөс Хархорин, Туул голын сав болон говийн нутгаар олон мянган километр замыг туулан хайгуул судалгааны ажлыг хийжээ. Энэ хайгуул судалгааны ажлын явцад урьд өмнө илэрч мэдэгдээд байсан

¹ H.F.Osborn. The discovery of tertiary man. Nature. Vol. 71. 1930

² Fairservis, W.A. The Archaeology of the Southern Gobi, Mongolia. Durham: Carolina Academic Press. 1993. p. 29

³ Д.Цэвээнэдорж, Б.Гүнчинсүрэн, Б.Цогтбаатар. Чулуун зэвсгийн судалгаа. Монгол Улсын шинжлэх ухаан. 32-р боть. УБ., 2007.

зарим бууц сууринг нягтлан, мөн шинэ дурсгалуудыг илрүүлэн олсон байна⁴. 1950-аад онд Мандалговь, Даланзадгадын Орон нутгийг судлах музейн ажилтнууд тухайн бүс нутгаас өөрсдийн олж цуглуулсан чулуун зэвсгийн дурсгалуудыг археологийн карт дээр тэмдэглэсэн мэдээ байдаг⁵.

1950-аад оны үед археологийн үндэсний боловсон хүчин бий болсноор бие даан судалгаа шинжилгээний ажлыг явуулах боломжтой болсон юм. Х.Пэрлээ, Ц.Доржсүрэн, Н.Сэр-Оджав, эх орныхоо түүх соёлын зүйлийг идэвхтэй эрэн сурвалжлагч О.Намнандорж нар говийн бүс нутгаас олон тооны чулуун зэвсгийн бууц суурин шинээр илрүүлэн олсныг дурдах хэрэгтэй. Тухайлбал, Х.Пэрлээ 1951 онд Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутаг Улаан-зээг, 1955 онд мөн аймгийн Эрдэнэ сумын нутаг Дулааны говь зэрэг газраас палеолит болон неолитын дурсгал, Ц.Доржсүрэн Говь-Алтай аймгийн Наран сумын нутаг Хуурай чацаргана, Цагаан гол, Цээл сумын нутаг Гашуун нуур, Алтан худаг зэрэг газраас шинэ чулуун зэвсгийн зүйлс, Төгрөг сумын Салаа, Хөх морьт сумын Агуйт улаан, Их Жаргалант сумын Дөрөө нуур, Ажиг нуур зэрэг газраас хуучин чулуун зэвсгийн үед холбогдох эдлэлүүдийг түүвэрлэсэн байна⁶. О.Намнандорж Говь-Алтай аймгийн Алтай сумын нутаг Цэнхэр номингийн говийн Цагаан дэрс, Бор цонжийн өвдөг түнх зэрэг газраас чулуун зэвсгийн бууц, суурин илрүүлэн олжээ⁷.

1959 оны намар “Рашаан шинжилгээний анги” Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг Өглөгчийн хэрэм, Дархан сумын нутаг Цахарын рашаан, Чойбалсан аймгийн Цагаан-Овоо сумын нутаг Гурван рашааны дэргэдээс тус тус чулуун зэвсэг олсноос Цахарын рашааны дэргэдээс илрүүлсэн маажуур зэрэг 20 ширхэг чулуун зэвсэг тун сонирхолтой хэмээн тэмдэглэсэн байна⁸.

1959 онд Дорноговь аймгийн Сулинхээр сумын Өлзийтөөс урагш 4.5 км-т жижиг нуураас холгүй орших толгойн хормойд геологич Г.Скворцов палеолит, неолитийн үеийн сонирхолтой зэвсгийн зүйлсийг 2 хэсэг газраас олж түүвэрлэснийг В.Е.Ларичев, В.В.Волков нар тодорхойлон нийтлүүлжээ⁹.

⁴ К.Н.Вяткина. Археологические памятники МНР. С.А. №1. 1960. стр. 59

⁵ А.П.Деревянко, Д.Дорж, Р.С.Васильевский, В.Е.Ларичев, В.Т.Петрин, Е.В.Девяткин, Е.М.Малаева. Каменный век Монголии. Палеолит и неолит Монгольского Алтая. Новосибирск. 1990. стр. 43

⁶ Ц.Доржсүрэн. БНМАУ-ын нутаг дээрх чулуун зэвсгийн судлалын байдал. Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхтгэл. Улаанбаатар. 2003. тал. 94-95

⁷ Ц.Доржсүрэн. Улсын төв музейд байгаа чулуун зэвсгийн зүйлс. Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхтгэл. УБ., 2003. тал. 134

⁸ О.Намнандорж. Бүтээлийн эмхтгэл. УБ., 2003. тал. 382-384.

⁹ В.Е.Ларичев, В.В.Волков. Мустиерские и неолитические памятники Южной Гоби <<Древняя Сибирь>> вып. 1 Новосибирск. 1964.

1961 онд Х.Пэрлээ, Шуберт нарын удирдсан Монгол-Германы хамтарсан археологи-угсаатны зүйн шинжилгээний анги Хэнтий аймгийн нутагт судалгааны ажил хийж Онон, Балж голын эрэг хавиас палеолит, неолитийн үеийн зэвсгийн зүйлс илрүүлэн олсныг тус шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд ажилласан Германы археологич Дитрих Маниа урд өмнө цуглуулсан зарим олдворын хамт нийтэлжээ¹⁰.

1960-1966 онуудад А.П.Окладников, Д.Дорж нарын удирдсан Монголын чулуун зэвсгийн дурсгал судлах анги манай улсын бараг бүх аймгийн нутгийг хамарсан өргөн цар хүрээтэй хайгуул судалгаа явуулж, хуучин чулуун зэвсгийн дунд, дээд үе, шинэ чулуун зэвсгийн үеийн дурсгал олон газраас илрүүлэн олсон байна. Тухайлбал, Говь Алтайн нурууны Их Богд уул, Гурван Сайханы нуруу, Арц Богд, Баянхонгор аймгийн Богд сумын Орог нуур, Өмнөговь аймгийн Ханбогд сумын Оцонмааньт зэрэг газруудаас илэрсэн чулуун зэвсгийн дурсгалт газруудыг дурдаж болох юм. Оцонмааньтын дурсгалт газар нь хуучин чулуун зэвсгийн дунд үед хамаарах бөгөөд тэнд 1960, 1962, 1967 онуудад малтлага судалгааны ажлыг хийжээ. Эндээс олдож буй хар саарал өнгийн чулуугаар хийсэн дугуй хэлбэртэй үлдэц болон гонзгойдуу үлдэц нь маш эртний шинжтэй бөгөөд Европ, Өмнөд Ази, Африкийн мөн үеийн дурсгалуудтай ижилсэж буй нь эрдэм шинжилгээний хувьд чухал ач холбогдолтойд тооцогддог юм. Дээр дурдсан үлдэц болон түүнээс салгаж авсан гурвалжин хэлбэрийн ялтас нь Европ, Африкт ашеллийн үед үүсэж мустье үед хөгжлийнхөө дээд цэгт хүрсэн леваллуагийн чулуун зэвсэг хийдэг аргатай нэгэн ижил арга барилаар хийгдсэн болох нь тогтоогджээ¹¹. Мөн түүнчлэн Их Богд уулын хормойд орших Орог нуурын орчим 1961, 1962 онуудад судалгаа явуулж хайрган хугадас зэвсэг, хянгар зэвсэг нэг дор оршсон хуучин чулуун зэвсгийн үеийн дурсгал болохыг тогтоожээ¹².

1967-1987 он хүртэл манай оронд Монгол-Зөвлөлтийн түүх, соёлын хамтарсан экспедиц Ш.Нацагдорж, А.П.Окладников, Д.Дорж, А.П.Деревянко нарын удирдлага дор хэд хэдэн шинжилгээний анги ажиллаж манай ард түмний эрт, дундад үеийн түүх, археологи, угсаатны зүйн дурсгалыг эрэн сурвалжлах, судлах үйлсэд нэн чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Энэ экспедицийн бүрэлдэхүүнд Монголын чулуун зэвсгийн үеийн дурсгал судлах анги А.П.Окладников, Д.Дорж нарын удирдлагаар тогтмол ажиллаж байсан бөгөөд тус анги 1969 онд Дундговь аймгийн Гурвансайхан сумын Ярх уулын дэргэдээс хуучин чулуун зэвсгийн доод үед холбогдох дархны газар нээсэн нь он цагийн хувьд одоогоос 300 мянга

¹⁰ D.Mania. Archaeologische Studien in der zentralen Mongolei, Sonderdrucke aus der Wissenschaftlichen Zeitschrift der Martin-Luther-Universität Halle-Wittenberg. 1964. Heft 13.

¹¹ А.П.Окладников. Новое в изучении древнейших культур. Монголии. СЭ. I. 1962.

¹² Д.Дорж, Д.Цэвээндорж. Монголын палеолит. УБ., 1978. тал. 38

орчим жилийн өмнөх үед холбогдох юм. Тэндээс хасын хольцтой шаргал өнгийн цахиурын төрлийн чулуугаар хийсэн олон төрлийн зэвсэг, тухайлбал, хөндлөн огтлолоор гурвалжин хэлбэрийн хатуу хутган цуулдас, цохилтын нэг ба хоёр талбайт үлдэц, хянгар, хусуурын төрлийн зүйлс олон байгаагийн зэрэгцээ гилбэр болон үзүүр мэсэн зэвсгүүд цөөнгүй тоотой олджээ¹³. Эндээс гилбэр зэвсэг олдсон нь хуучин чулуун зэвсгийн үед өрнө зүгийн орнуудад гилбэр зэвсэг бүхий хүмүүс, Өмнөд ба Зүүн өмнөд Азийн орнуудад мөлгөр хайрган чулууг хөндлөн хугалж зөвхөн нэг талаас нь ирлэж зассан зэвсэг бүхий хүмүүс гэсэн хуучин чулуун зэвсгийн соёлын хоёр том бүс байсан гэдэг үзлийг эвдэж, гилбэр зэвсэг эзэмшигчдийн нутгийн хил хязгаарыг тэлсэн юм. Судлаачид Ярхын хуучин чулуун зэвсгийн дурсгалд түшиглэн Монгол оронд эрт цагт оршин суугчид нь өрнө зүгийн доод палеолитын хүний нэг адил чулууг засаж, түүгээр хоёр талаас нь янзалж ирлэсэн зэвсэг хийх өөрийн тогтсон арга барилтай байсан¹⁴ гэсэн эрдэм шинжилгээний чухал дүгнэлтэд хүржээ.

1970 онд Сүхбаатар аймгийн Хонгор сумын дэргэдэх Их-Оргио уулын хормойгоос палеолитийн үеийн цөөн тооны эдлэл түүвэрлэсний дотор леваллуа маягийн цохилтын хоёр талбайт үлдэц байжээ.

Д.Дорж “Дорнод Монголын неолит” бүтээлдээ Дорнод аймгаас илэрсэн шинэ чулуун зэвсгийн түүхэнд холбогдох 15 сууринг авч үзэн судалгааны эргэлтэд оруулж он цаг харилцан хамаарлын асуудлыг тогтоосноос Ямаат нуурын суурин, Баруун Өлзийт, Овоот болон Тамсагбулагийн сууц бүхий неолитийн дурсгалт дурсгалт газрууд томоохонд тооцогдоно. Тэрээр Сүхбаатар аймгийн нутгаас Онгон болон Баруун элс, Овон элс, Гүнбулаг, Эхэн усны баруун эрэг, Устай бургастай зэрэг дурсгалт газруудыг, Дорноговь аймгийн Сулинхээр сумын Сүлт хар овоо, Эрдэнэ сумын Дулааны говийн археологийн хэрэглэгдэхүүнийг уг нэгэн сэдэвт бүтээлдээ авч үзсэн байдаг. Түүний бүтээл нь Дорнод, Сүхбаатар, Дорноговь аймгийн нутгаас олдсон неолитийн дурсгалуудыг нэлээд сайн судлагдсан хөрш зэргэлдээ орны мөн үеийн дурсгалтай харьцуулан судалж Монголын неолитийн чулуун зэвсэг үйлдвэрлэлийн арга, түүний хөгжлийг үечлэн, улмаар тэр үеийн хүмүүсийн эрхлэх аж ахуй, нийгэм, оюун санааны хөгжлийг нэгтгэн дүгнэсэн байна. Энэ нь Монголын шинэ чулуун зэвсгийн судалгааны асуудлыг хөндсөн анхны нэгэн сэдэвт бүтээл бөгөөд чулуун зэвсгийн зангилаа асуудлуудыг тухайн үеийн олдвор хэрэглэгдэхүүний хэмжээнд бүхэлд нь авч үзэхийг зорьсон юм¹⁵.

¹³ Д.Цэвээндорж, Д.Баяр, Я.Цэрэндагва, Ц.Очирхуяг. Монголын археологи. УБ., 2003

¹⁴ Д.Дорж, Д.Цэвээндорж. Монголын палеолит. УБ., 1978.

¹⁵ Д.Дорж. Неолит Восточной Монголии. УБ., 1971

1971 онд МЗТСХЭ-ийн чулуун зэвсгийн дурсгал судлах анги Өмнөговь аймгийн Булган сумын нутаг Баянзагийн шинэ чулуун зэвсгийн дурсгалт газарт малтлага судалгаа хийж олон тооны чулуун зэвсгийн зүйлс болон ваарны хэлтэрхийнүүдийг түүвэрлэн цуглуулсан байна. Судлаачид тэрхүү хэлтэрхийнүүдийг Байгаль орчмоос олддог ваарны хэлтэрхийнүүдтэй харьцуулан Исаков-Серовын үе буюу НТӨ IV-III дахь мянганы үед холбож үзсэн байдаг¹⁶. Мөн зэсийн хайлш, хүрэл хутганы хугархай, нимгэн бөөрөнцөг бүхий шавар савны хагархай илрүүлэн олж судалгааны ажлын талаар эрдэм шинжилгээний тайлан бичсэн байна¹⁷. Тус судалгааны анги Булган сумын төвөөс зүүн хойд зүгт орших Баруун, Зүүн хайрхан уулын дэргэдээс Мезолит, Неолитын үед холбогдох дурсгалт газрыг илрүүлжээ. Төгрөгийн ширээгээс хүрэл ойл илрүүлэн олсон байна.

1972 онд МЗТСХЭ-ийн чулуун зэвсгийн дурсгал судлах анги А.П.Окладников, Д.Дорж нарын удирдлагаар Өмнөговь, Дундговь аймгийн нутагт археологийн хайгуул судалгааны ажил хийх явцдаа Баянзагийн суурингаас чулуун зэвсгийн олдвор хэрэглэгдэхүүн цуглуулсны зэрэгцээ Булган сумын төвөөс хойд зүгт 50 км орчим зайд, Арц Богдын нурууны урд талаар уртрагийн дагуу сунасан Эргийн хоолой хэмээх элс загтай хоолойн долоон газраас шинэ чулуун зэвсгийн дурсгалт газар, мөн Эргийн хоолойгоос баруун зүгт холгүй орших Хар тээгээс палеолитын үед холбогдох дурсгалт газар илрүүлжээ. Судлаачид чулуун зэвсгийн олдворуудын хэв шинж, цуулалтын арга барилд үндэслэн тус дурсгалт газрыг Неолитын эхэн үед хамаарна хамаарна хэмээн үзсэн байна¹⁸.

МЗТСХЭ-ийн судлаачид Зүүн, Баруун хайрхан (Тэвш хайрхан хэмээн нэрийдэх бөгөөд өдгөө нутгийн олон энэ хоёр уулыг Хоёр хайрхан хэмээн хүндэтгэн нэрлэдэг) уулаас түүвэрлэн цуглуулсан олдворууд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн сан хөмрөгт хадгалагдаж байна. МЗТСХЭ-ийн чулуун зэвсгийн дурсгал судлах ангийн 1972 оны хээрийн судалгааны тайланд цухас тэмдэглэгдсэн энэхүү дурсгалын олдворуудыг судлаач Д.Одсүрэн чулуун зэвсгийн олдворыг боловсруулах арга зүйн дагуу ангилан ялгаж, эрдэм шинжилгээний тодохойлолт, он цагийн хамаарлын тухай саналаа “Хоёр хайрханы чулуун зэвсгийн дурсгалын судалгаа” хэмээх өгүүлэлд нийтэлжээ¹⁹.

Баянзагийн Шавар усны чулуун зэвсгийн сууринг анхлан судалсан эрдэмтэн Н.К.Нельсон энд он цагийн хувьд ялгаатай хоёр давхарга байна гэж үзжээ. Түүнийхээр

¹⁶ А.П. Окладников, Д.Дорж. Памятники каменного века на Юге МНР (по работам 1971-1972 гг) // *Studia Archaeologica*. Tom. VII, fasc. I. УБ., 1976.

¹⁷ А.П.Окладников, Д.Дорж. Отчет палеолитического отряда ССМИКЭ за 1971-1973 и 1978 гг.

¹⁸ Я.Цэрэндагва, Д.Одсүрэн. Эргийн хоолойн шинэ чулуун зэвсгийн дурсгал // *Acta Historica*. Tom. X, fasc. 2, УБ., 2009. тал. 11-21

¹⁹ Д.Одсүрэн. Хоёр хайрханы чулуун зэвсгийн дурсгалын судалгаа // *Acta Historica*. Tom. XV, fasc. 2, УБ., 2014. Тал. 21-38

сэвхүүл хурдаст байрлах доод давхаргын археологийн олдворууд нь тухайн бүс нутагт орчин үеийн уур амьсгалын нөхцөл бүрэлдэн бий болхоос өмнөх үед хамаарах юм²⁰. Энэ нь доод давхаргын олдворуудын гадна төрх байдлаар мөн давхар нотлогдож байгаа ажээ. Энэ үеийн чулуун зэвсгүүд Мезолитийн эхэн үе буюу азилийн шатны хэлбэр төрхтэйн дээр чулуун зэвсгийн хамт шавар ваар сав, сумны зэв, шинэ чулуун зэвсгийн үеэс чулуун зэвсгийн үйлдвэрлэлд нэвтэрсэн зүлгэж өнгөлөх аргаар боловсруулсан багаж зэвсэг огт гараагүй байна. Хоёр дахь буюу дээд давхарга нь Неолитийн үед хамаарах бөгөөд энэ үеийн хөрс орчин үеийн уур амьсгал тухайн бүс нутагт төлөвшин тогтох үед бүрэлджээ. Энэ үеэс илэрсэн олдворуудын дотор шавар сав суулганы үлдэгдэл, зэв, зүлгэж өнгөлөх аргаар боловсруулсан багаж зэвсэг байгаа учраас эдгээрийг өмнөх үетэй залгамж холбоо бүхий дараагийн шат гэж Н.К.Нельсон ойлгож байжээ. Өөрөөр хэлбэл, тэрээр хоорондоо нягт холбоотой мезолит, Неолитийн давхарга Баянзагийн Шавар усны сууринд хадгалагдаж байна хэмээн үзсэн²¹.

Монгол-Зөвлөлтийн хамтарсан чулуун зэвсгийн судалгааны анги 1971-1973. Мөн Дундговь аймгийн Ёроол говь, Хулд сумын Цахиурт зэрэг газраас хуучин чулуун зэвсгийн доод үед холбогдох сууринг олж нээсэн байна²².

1978 онд урьд өмнө илэрч мэдэгдээд байсан Дорноговь аймгийн Эрдэнэ сумын нутаг Дулааны говийн мезолит, неолитын сууринг археологи-геологийн талаас дахин судлах ажлыг хийжээ²³.

1983, 1984 онд чулуун зэвсгийн дурсгал судлах анги Ховд, Говь-Алтай, Баян-Өлгий аймгийн нутгуудаар ажиллаж олон арван чулуун зэвсгийн дурсгалт газар илрүүлэн олсон юм. Судлаачид 1984 онд Алтайн өвөр говиос олдсон чулуун зэвсгийн дурсгалуудыг эрдэм шинжилгээний хувьд нэлээд сонирхолтой хэмээн үзсэн байдаг.

Монгол нутгаас олдсон палеолитийн үеийн олон соёлт давхарга бүхий хоёр дахь дурсгалт газар болох Рашаан хадны сууринг Х.Пэрлээгийн удирдсан Гурван голын шинжилгээний анги 1973, 1974 онуудад малтаж эхэлсэн бөгөөд 1980 онд А.П.Окладников, Д.Дорж, 1981 онд Р.С.Васильевский, Д.Цэвээндорж нарын удирдлагаар МЗТСХЭ-ийн палеолитийн дурсгал судлах анги үргэлжлүүлэн малтаж судалсан юм²⁴.

1985 онд МЗТСХЭ-ийн А.П.Деревянко, Д.Дорж нарын удирдсан чулуун зэвсэг судлах анги Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Өмнөговь, Дундговь аймгийн нутгийг хамарсан

²⁰ Ch. P.Berkey, N.C. Nelson. Geology and Prehistoric Archaeology of the Gobi Desert // American Museum Novitates. 1926. No. 222. p. 1–16

²¹ N.C. Nelson. Notes on the Archaeology of the Gobi // American Antropologist. 1926a. Vol. 28. No. 1. 305–308

²² А.П.Окладников. Новые данные по древнейшей истории Внутренней Монголии. ВДИ, № 4. Новосибирск. 1976.

²³ Д.Цэвээндорж, П.Хосбаяр. Дулааны говийг археологи, геологийн талаар дахин судалсан // Studia Archaeologica. Tom X, fasc.3. УБ., 1982

²⁴ А.П.Окладников, Р.С.Васильевский. Новые исследования Аршан хаде в Монголии. Изв. СО АН СССР. № 6, Вып. 2, Серия общественных наук. Новосибирск. 1982.

өргөн цар хүрээтэй хайгуул, судалгааны ажлыг гүйцэтгэсэн бөгөөд тус шинжилгээний ангийнхан урьд нь илэрч мэдэгдээд байсан Баянзаг, Төгрөг ширээт зэрэг газар судалгаа явуулсны зэрэгцээ палеолит, неолитын үеийн олон дурсгалт газрыг шинээр нээж, нийт 166 газраас 14 мянга гаруй чулуун эдлэл түүвэрлэжээ.

1986, 1987 онд тус шинжилгээний анги Баянхонгор, Өмнөговь аймгийн нутгаар хуучин чулуун зэвсгийн үеийн хайгуул хийж Баянхонгор аймгийн Уран хайрхан, Цагаан агуй зэрэг эрдэм шинжилгээний хувьд онц ач холбогдол бүхий дурсгалуудыг нээн илрүүлсэн байна.

1995-2000 онуудад А.П.Деревянко, Д.Цэвээндорж, Ж.Олсен нарын удирдсан Монгол-Орос-Америкийн Монголын чулуун зэвсгийн дурсгал судлах экспедиц Говь-Алтайн нурууны салбар уулсын ар, өвөр биеийн нутгаар хайгуул судалгаа хийж чулуун зэвсгийн дурсгалт газрууд олныг илрүүлсэн байна. Мөн түүнчлэн тус судалгааны ангийнхан Баянхонгор аймгийн Баянлиг сумын нутаг Цагаан агуй, Чихэн агуй зэрэг агуйн соёлт давхарга бүхий сууринуудыг малтан шинжилж олон үеийн турш удаан хугацаагаар хүмүүс сууж байсныг тогтоосон бөгөөд Монгол нутаг дахь эртний түүхийг сэргээн тодруулах чухал олдвор хэрэглэгдэхүүнийг цуглуулсан байдаг. Тус судалгааны ангийнхан Алтайн өвөр говь, Говь-Алтайн нурууны салбар уулсаар хайгуул хийж палеолит, мезолитын үед холбогдох олон тооны дурсгалт газруудыг нээн илрүүлсний дотор Өвөрхангай аймгийн Богд сум, Өмнөговь аймгийн Булган сумдын нутгийн заагт, Арц Богд, Гурван Сайханы нуруудын хооронд орших 10 000 м² талбайг эзлэн орших хуучин, дунд, шинэ чулуун зэвсгийн дурсгалууд газрын хөрсөн дээр ил байдлаар маш шигүү оршсон Цахиуртын хөндийн дурсгалт газар багтана. Эдгээр судалгааны үндсэн дээр гурван орны судлаачид хамтран туурвисан Монгол-Орос-Америкийн археологийн экспедицийн тайлан хэмээх 3 боть ном орос, англи, монгол хэлээр хэвлүүлжээ²⁵.

2000-аад он гарснаас хойш Монгол орны говийн бүс нутагт чулуун зэвсгийн дагнасан судалгаа хэсэг хугацаанд завсарласан юм. Гэвч Өмнөговь, Дорноговь аймгийн өмнөд нутгаар уул уурхайн хайгуул, ашиглалтын үйл ажиллагаатай холбоотой археологийн авран хамгаалах судалгааны явцад зарим сонирхолтой дурсгал илрүүлж, судалгааны эргэлтэд оруулсан юм. Үүний нэг нь Галбын говийн хойд хэсэгт орших Хацавчийн толгод, Зүрх уул,

²⁵ А.П.Деревянков, Д.Олсен, Д.Цэвээндорж, В.Т.Петрин, А.Н.Зенин, А.И.Кривошапкин, Р.У.Ривс, Е.В.Девяткин, В.П.Мыльников. Археологические исследования Российско-Монгольско-Американской экспедиции в Монголии 1995 г. Новосибирск. 1996; А.П.Деревянков, Д.Олсен, Д.Цэвээндорж, В.Т.Петрин, А.Н.Зенин, А.И.Кривошапкин, С.В.Николаев, В.П.Мыльников, Р.У.Ривс, Б.Гунчинсүрэн, Я.Цэрэндагва. Археологические исследования Российско-Монгольско-Американской экспедиции в Монголии 1995 г. Новосибирск. 1998; А.П.Деревянко, Д.Олсен, Д.Цэвээндорж, В.Т.Петрин, С.А.Гладышев, А.Н.Зенин, В.П.Мыльников, А.И.Кривошапкин, Р.У.Ривс, П.Д.Брантигхэм, Б.Гунчинсүрэн, Я.Цэрэндагва. Археологические исследования Российско-Монгольско-Американской экспедиции в Монголии в 1997-1998 годах. Новосибирск. 2000.

Байшинт²⁶, Өөшийн говиос илрүүлсэн Шарилын уулын дурсгалыг²⁷ дурдаж болно. Эдгээр дурсгалд олон тооны баргил зэвсэг, тэр дундаа гилбэр, бифас зэрэг олдворын бүрдлээрээ дунд палеолитоос дээд палеолитын үед холбогдоно хэмээн үзсэн байдаг.

Канадын судлаач, доктор Л.Яанз АНУ-ын Төв Азийн экспедицийн Баянзагаас цуглуулсан археологийн материалд дүн шинжилгээ хийсэн бөгөөд шавар ваар савны хагархай тэмээн хяруулын өндөгний хальс зэрэг нийт 22 дээжинд нүүрстөрөгчийн задлан шинжилгээ болон термолюминесценц (дулаан хуримтлал)-ийн аргаар он цаг тогтоох шинжилгээ хийжээ²⁸. Судалгаанд хамрагдсан дээжүүд НТӨ 42,397-39,193BC (AA76423) - 1920-1040 (UW2859) жилийн өмнөх үед буюу он цагийн өргөн хүрээлэлд холбогдох нь тодорхой болсон байна. Лабораторийн судалгаагаар тогтоосон хамгийн эрт үед холбогдох дээжийн он цаг, хожуу үед холбогдох дээжийн он цагууд хоорондоо олон мянган жилээр алслагдсан нь харагдаж байна. Гэвч ихэнх дээжүүд НТӨ 7600-4400 гаруй жилийн өмнөх үед хамаарахыг зааж байгаа нь Баянзагийн суурин шинэ чулуун зэвсгийн эхэн болон дунд үед холбогдохыг харуулж байгаа юм.

Баянзагийн Шавар ус зэрэг томоохон дурсгалуудад ил гал түлсэн ором, тулгын чулуу, түүний эргэн тойронд тархсан чулуун зэвсгийн тархалт зэрэг нь газрын хөрсөн дээр барьсан урц, овоохой маягийн сууцанд хүмүүс суурьшан амьдарч, ан гөрөө, түүврийн аргаар цуглуулах зэрлэг ургамлын гарц дагасан нүүдлийн хэв шинж бүхий амьдралын хэлбэр зонхилж байсан бололтой. Үүнийг мөн Тамсагбулагийн хагас газар сууцнаас илрүүлсэн шавар ваар сав болон Баянзаг, Төгрөгийн ширээ, Хоёр хайрхан, Эргийн хоолой, Хатан суудал уулын орчимд орших Зуухын суурингаас илрүүлсэн шавар ваар савны хагархайд хийсэн харьцуулсан судалгааны дүн мэдээ нотлон харуулдаг²⁹.

Монгол орны хээрийн бүс нутгийн палеолитийн үеийн нэгэн сонирхолтой дурсгал бол Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын нутаг Ачаат уулын суурин юм. Уг дурсгалыг МУИС-ийн оюутны хээрийн дадлага ажлын үеэр анх илрүүлсэн бөгөөд 2012 онд ШУА-ын Археологийн хүрээлэнгийн судлаачид чулуун зэвсгийн олдворуудын тархалтын хүрээг урьдчилсан байдлаар тодорхойлж, олдворуудын түүвэр цуглуулга хийжээ. Судлаачид тухайн дурсгалын

²⁶ Г.Лхүндэв, Д.Одсүрэн, Б.Гүнчинсүрэн. Галбын говийн хойд хэсгээс шинээр илрүүлсэн палеолитын ил суурингууд // *Studia archaeologica*. Tom.XXXVI, fasc.3, УБ., 2017. тал 31-44.

²⁷ Б.Гүнчинсүрэн, Д.Одсүрэн, Г.Лхүндэв. Шарилын уулын чулуун зэвсгийн дурсгал // *Studia Archaeologica*. Tom.XXXIV, fasc.1, УБ., 2014. тал. 7-14.

²⁸ Lisa Janz, James K. Feathers, George S. Burr. Dating surface assemblages using pottery and eggshell: assessing radiocarbon and luminescence techniques in Northeast Asia. *Journal of Archaeological Science* 57 (2015) 119-129

²⁹ F.Iizuka, M.Izuho, B.Gunchinsuren, B.Tsogtbaatar, and D.Odsuren. Manufacturing techniques and formal variability of pottery from five neolithic sites in eastern steppe and the Gobi desert, Mongolia // *Археологийн судлал*. Tom. XXXVII, fasc. 1, УБ., 2018. p. 5-16

чулуун зэвсэг үйлдвэрлэлийн хэв маяг, олдворуудын төрөл зүйлд үндэслэн мустьен сүүл үеэс дээд палеолитийн эхэн үед холбогдуулан үзсэн байна³⁰.

Ачаат уулын орчимд Устай Бургастайн Барга элсний неолитийн сууринд МУИС-иас зохион байгуулсан “Дорнод Монгол” төслийн хүрээнд 2008, 2009, 2011 онуудад ажиллаж олон тооны чулуун зэвсгийн зүйлс цуглуулсан байдаг³¹.

Монгол-Канадын хамтарсан “Говь, хээрийн бүс нутгийн неолитын судалгаа” эрдэм шинжилгээний төсөл 2013 оноос хойш Монгол орны тал, хээрийн бүс нутагт чулуун зэвсгийн судалгааг гүйцэтгэж байна. Хамтарсан төслийн судлаачид Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Зараа ууланд палеолит, неолитын дурсгалыг малтан шинжилж үр дүнг хэд хэдэн эрдэм шинжилгээний өгүүлэлд нийтэлжээ³².

Монгол орны зүүн бүс нутагт хийсэн чулуун зэвсгийн судалгааны эхэн үе буюу 1930-1960-аад онуудад ихэвчлэн мэдээ шалгах, цөөн тооны олдвор түүвэрлэх маягаар цаашдын судалгааны үндэс суурийг боловсруулжээ. Харин 1960-аад оноос МЗТСХЭ-ийн Чулуун зэвсэг судлах анги Зүүн Монголын бүс нутагт өргөн цар хүрээтэй хайгуул судалгаа хийсэн бөгөөд судалгааны үр дүнд илрүүлсэн ихэнх дурсгалууд шинэ чулуун зэвсгийн үед холбогдож байв. Мөн шинэ чулуун зэвсгийн үеийн нүхэн сууц, оршуулгуудыг илрүүлэн судалсан байна. Сүүлийн жилүүдэд Солонгос, Япон, Америкийн судлаачидтай хамтарсан төсөл, хөтөлбөрийн хүрээнд палеолит болон неолитийн дурсгалуудын судалгаа, палеолитоос мезолит, неолитоос төмөрлөг зэвсэгт шилжсэн шилжилтийн үеийн түүхийн асуудлуудыг тодруулах зорилготой судалгааны ажлууд хийгдэж байна.

³⁰ Б.Цогтбаатар, Х.Пүрэвжал. Ачаат уулын чулуун зэвсгийн суурин // *Studia archaeologica*. Tom. XXXIV, fasc.2. УБ., 2014. тал. 15-24

³¹ Н.В.Цыденова, Д.Түмэн, М.Эрдэнэ. Древнее поселение Барга элс в Восточной Монголии // *Древние Культуры Монголии и Байкальской Сибири*. УБ., 2012.

³² Lisa Janz., Arlene M.Rosen, Dashzeveg Bukhchuluun, Davaakhuu Odsuren. Zaraa Uul: An archaeological record of Pleistocene-Holocene paleoecology in the Gobi Desert. *Plos ONE* 16(4): e0249848. <https://doi.org/10.1371/journal.pone.0249848>; Davaakhuu Odsuren, Lisa Janz, William Fox, Dashzeveg Bukhchuluun. Otson Tsokhio and Zuun Shovkh: the Initial Upper Palaeolithic in Eastern Mongolia. *Journal of Paleolithic Archaeology* (2023) 6:10. <https://doi.org/10.1007/s41982-023-00139-x>

2. АРХЕОЛОГИЙН СУДАЛГАА

2.1. Археологийн судалгааны арга зүй

2024 онд өргөн уудам газар нутагт богино хугацаанд хайгуул судалгаа хийхээр төлөвлөсөн тул энэ онцлог байдалд тулгуурлан бэлтгэх, хайгуулыг үр дүнтэй төлөвлөх шаардлагатай байв.

Бид юуны өмнө Монгол орны чулуулгийн зурагт тулгуурлаж түүхий эдийн нөөцтэй газруудыг тодруулж тэмдэглэв. Үүний дараа 1:100000 масштабтай зураг, агаарын зураг, газрын нэрийн зурагт тулгуурлан булаг шанд, эртний урсац, нуур цөөрмийг тодорхойлж, дурсгалын орших орчны мэдээллийг бий болгосон. Ийнхүү дурсгал байх магадлалтай газрыг хэд хэдэн шалгуураар урьдчилан таамаглаж хайгуул судалгааг гүйцэтгэсэн юм.

Манай орны говь, хээрийн бүс нутгийн чулуун зэвсгийн дурсгалт газрууд ихэвчлэн хөрсөн дээр үе үеийн олдворуудыг агуулсан ил суурин хэлбэрээр оршдог билээ. Тиймээс юуны өмнө тухайн дурсгалын хөрсөн дээр тархсан олдворуудын нягтаршил, тархалтын хүрээ заагийг тодорхойлох нь чухал юм.

Чулуун зэвсгийн олдворын тархалтын хүрээ, зааг, нягтаршлыг тодорхойлоход өнгийн туг ашиглахаар төлөвлөж байсан боловч хугацаа, хүн хүчний боломжоос шалтгаалан бүх дурсгалд туг хатгаж тархалтыг тогтоож чадаагүй.

Чулуун зэвсгийн олдворууд хөрсөнд дарагдах, налуу даган гулсах болон усны үйл ажиллагааны нөлөөгөөр зөөгдсөн байдгийг тооцоолох хэрэгтэй юм. Хайгуул судалгааны явцад шинээр илрүүлсэн дурсгалын тархалтын хязгаарыг олдворын тархалтаар нүдэн баримжаагаар тогтоосны дараа гэрэл зураг, агаарын зургаар баримтжуулж, солбицлыг тогтоож дурсгалын тодорхойлолт бичиж баримтжуулав. Хөрсний давхарга бүрэлдсэн байх магадлалтай газруудад гар өрмөн шалгалт, амьтны яс, олдвортой хамт тархсан газарт өнгөн хэсгийг хусаж цэвэрлэх аргаар илүү нарийвчлалтай шалгалтыг хийсэн.

Говь, хээрийн бүс нутагт чулуун зэвсгийн анчин – түүвэрлэгчдийн бууц сууринд хүн хэр удаан тэнд амьдарснаас шалтгаалан олдворын тоо олон цөөн янз бүр байдаг. Тиймээс хайгуулын явцад тухайн дурсгалын тухай анхан шатны мэдээлэл өгөх боломжтой зарим олдворыг сонголтын зарчмаар түүвэрлэн цуглуулсан бөгөөд цуглуулгыг тусад нь уутанд хийж хаягжуулав.

Түүвэр олдворыг лаборатори танхимын нөхцөлд чулуун зэвсгийн олдвор боловсруулах арга зүйн дагуу ангилан ялгаж, тодорхойлж, тайланд тусгасан.

Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутаг Салаа булагт багахан талбайд малтлага судалгаа хийхдээ чулуун зэвсгийн малтлагын үндсэн арга зүйг ашиглав. Эртний анчин –

түүвэрлэгчдийн отог буудлын үлдэгдэл байж болзошгүй хэсэгт талбай сонгож, бүх талбайг 1 x 1 м хэмжээтэй өрөгт хуваав. Өргийг үсэг, тоогоор дугаарлаж малтлагыг 5 см гүнтэйгээр гүйцэтгэсэн бөгөөд хөрсний үе давхарга, өргийн дугаараар олдворыг баримтжуулж хаягжуулав. Малтлагаас гарсан шороог 3 x 3 мм хэмжээтэй тор бүхий шигшүүрээр шигшиж жижиг олдворыг илрүүлэв. Мөн 2 см дээш хэмжээтэй бүх олдворыг илэрсэн байран дээр нь үлдээж план зурагт тэмдэглэсэн.

Малтлагаас гарсан олдворыг хээрийн нөхцөлд болон лабораторийн нөхцөлд чулуун зэвсгийн судалгааны төрөл зүйн ангиллын дагуу боловсруулж тодорхойлолт үйлдсэн болно.

2.2. ХАЙГУУЛ СУДАЛГАА

2.2.1. Задгайтын булаг орчимд хийсэн хайгуул судалгаа

Номгон сумын төвөөс чанх хойш шулуунаар 7.5 км орчим зайд намхан хярын урд үзүүрээс ундрах жижиг булгийг Задгайтын булаг хэмээдэг ажээ. Энэ жилийн зуны эхээр буюу биднийг хайгуул хийх үед гандуу байсан тул ус багатай байв. Булаг баруунаас зүүн тийш чиглэсэн нэлээд гүн, том савтай тул эрт цагт ус ихтэй байсан хэмээн таамаглаж байна. Мөн бороо ихтэй үед үерлэдэг бололтой.

Булгийн урд талын өндөр дэнж, арын уулын бэлээр шоргоолжин булш, улаан зуух хэлбэрийн булш зэрэг хүрлийн үеийн түрүүлгэ нь харуулсан оршуулгат булш хэд хэд байна.

Задгайн булагийн 1-р дурсгал. Эхний булш булгийн урд талын дэнж дээр, авто замын дэргэд оршино. Зүүн буюу толгой талын хашлагыг илүү өндөр чулуугаар хийжээ. Хашлагын төв хэсгийг жижгэвтэр чулуугаар дүүргэсэн тэгш намхан дараастай (Зураг 2).

Задгайн булагийн 2-р дурсгал. Өмнөх булшны зүүн талд мөн намхан дараастай булш байх бөгөөд Улаан зуух хэлбэрийн түрүүлгэ нь харуулсан оршуулга бололтой (Зураг 3).



Зураг 2. Задгайн булагийн 1-р дурсгал.
Шоргоолжин булш



Зураг 3. Задгайн булагийн 2-р дурсгал. Улаан
зуух хэлбэрийн булш

Задгайн булагийн 3-р дурсгал. Өмнөх дурсгалаас зүүн хойш булгийн арын дэвсгэ дээр бий. Гадаад байгууламж нь нэлээд эвдэгдсэн шоргоолжин булш ажээ.

Задгайн булагийн 4-р дурсгал. Өмнөх дурсгалаас хойш 30 м зайд бий. Тэгш өнцөгт маягийн хэлбэртэй намхан дараастай агаад дараас чулуу ихэд хөдөлж анхны хэлбэр алдагджээ. Улаан зуух хэлбэрийн булш бололтой.

Задгайтын булаг орчимд явган хайгуул хийхэд чулуун зэвсгийн зүйл олдсонгүй. Булгийн эхийн хоёр эрэг дагууд дээр дурдсан хүрлийн үеийн булш оршуулга оршиж байна. Говь нутагт усны ундаргад ойр, эсвэл бэлчээр сайн газарт ийнхүү хүрлийн үеийн нүүдэлчид

булш оршуулга, тэр дундаа сүрлэг том шоргоолжин булш үйлдсэн байх нь тааралддаг билээ. Энэ нь нас барсан өвөг дээдсийн оршуулга болох сүрлэг байгууламжаар тухайн газар орныг тэмдэглэж буй үзэл санаа байх магадлалтай билээ.

2.2.2. Сангийн Далайн булаг орчимд хийсэн хайгуул судалгаа

Өмнөговь аймгийн Номгон сумын нутагт, сумын төвөөс урдхан дов сондуултай сайраас эх авах тунгалаг уст булагийг Сангийн Далай хэмээн хүндэтгэн нэрлэдэг (Зураг 4).



Зураг 4. Сангийн далайн булаг ба булгийн хөлөөс илрүүлсэн ооль

Сангийн Далайн булагийн эхэн хэсгийг торон хашаа тойруулан татаж хамгаалжээ. Бид булгийн хоёр эргийн дов сондуул дундуур хайгуул хийхэд шаварлаг хөрсөн дээрээс гүйцэд зассан, цуулалтын ором нь нэлээд элэгдсэн ооль зэвсэг нэгийг илрүүлэв.

Уг эдлэлийг хөх саарал өнгөтэй элсэн чулуугаар хийжээ. Хажуугийн урт ирмэг дээд үзүүр рүүгээ аажим налсан бөгөөд ар, өвөр талаас нь хөндлөн цуулалт хийх явцад долгиотой ирмэг үүсжээ. Доод талын хөндлөн ирмэгийг зөвхөн нэг талаас нь холтчин ирэн хэсгийг бэлтгэжээ (Зураг 5). Ийм ооль Монголын шинэ чулуун зэвсгийн дурсгалуудад нэлээд тааралддаг. Ялангуяа, өмнө нь судалгаа хийсэн Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Зараа уулын Ил энгэрийн шинэ чулуун зэвсгийн дурсгалт газарт газрын хөрсөн дээрээс болон малтлагаас олон илрүүлсэн билээ³³. Оолийг



Зураг 5. Сангийн Далайн булагийн орчмоос илрүүлсэн ооль

³³ Д.Одсүрэн, Д.Бөхчулуун, Л.Яанз. Зүүн Монголын нутагт хийсэн шинэ чулуун зэвсгийн судалгааны зарим үр дүн // Studia Archaeologica. Tom XXXV. fasc. 5. УБ., 2015. тал. 72-96

газар сэндийчин ухах, үр үндэс түүх гэх мэт ахуйн үйлд хэрэглэхээс гадна тулааны ойрын зайн зэвсгийн үүргээр ашиглаж байжээ³⁴.

Өөр олдвор, эд өлгийн зүйл олдсонгүй. Энэ хавьд чулуун зэвсэг хийх сайн чанарын түүхий эд ховор ажээ. Харин гүйцэд зассан энэ эдлэлийг анчин, түүвэрлэгчид усны эх ундарга бүхий газарт санамсаргүй орхисон бололтой.

Бид цаашид хайгуул судалгааг Номгон сумын баруун хойд талаар үргэлжилсэн уулсын дотор 20 км гүнд хүртэл гүйцэтгэсэн боловч чулуун зэвсгийн дурсгал илрүүлсэнгүй.

2.2.3. Бяруухайн голын орчимд хийсэн хайгуул судалгаа

Өмнөговь аймгийн Номгон сумын нутаг, Хөрхийн нурууны өмнөд бие, Борзонгийн говийн хээлээс олон булаг шанд ундарч говийн баянбүрд үүсгэдэг. Эдгээрийг газрын зурагт Борзонгийн булаг хэмээн ерөнхийлөн тэмдэглэсэн байх боловч бүгд тусдаа оноосон нэртэй. Эдгээр булаг шандын дотроос томоохон нь Бяруухайн гол юм (Зураг 6). Энэ орчмын олон задгайгаас ундарга ихтэй, урт зайд урсдаг нь Бяруухай тул нутгийнхан ийнхүү гол хэмээн нэрийдэх ажээ. Бяруухайн суурин алдарт Баянбулагийн тууриас ялимгүй зүүн урагш 14 км зайд байрладаг. Энэ хавийн бусад задгай, булгийн адил Хөрхийн нуруунаас буусан сайрын гүн эргээс эх авах агаад эхэн хэсэгт хоёр эрэг зарим газарт 4-5 м хүртэл өндөр ажээ. Гэвч эрэг төдийлөн урт үргэлжилдэггүй.



Зураг 6. Бяруухайн гол (зургийг урд талаас. Цаана нь Хөрхийн нуруу харагдана)

³⁴ Д.Одсүрэн, Л.Яанз, Д.Бөхчулуун. Говийн бүс нутгийн неолитын үеийн аж ахуй, соёлын асуудалд // Studia Archaeologica. Tom XXXIX. fasc. 2 УБ., 2020. тал. 13-25

Ахмад археологич Х.Пэрлээ абугай энд уг сууринд хайгуул хийж зүүн эргээс нь Сүн улсын бололтой шаазан савны хагархай, хавтгай төмөр эдлэл зэрэг зүйл олж хятад үсэгтэй зоосоор баримжаалан Хятан улсын үеийн гар урчуудын суурин байсан бололтой гэж үзсэн байна. Мөн гар тээрмийн чулуу хэд хэд олдсон бөгөөд энд урд тариа тарьж байсан аман домог байсан тухай мэдээлжээ³⁵.

Судлаач З.Батсайхан 1990 онд Баянбулагийн туурьд малтлага хийх явцдаа Бяруухайн сууринд гүймэг хайгуул хийж зүүн эргээс нь цөөн тооны чулуун зэвсгийн олдвор, хожуу үеийн шавар сав суулганы үлдэгдэл түүвэрлэн цуглуулжээ. Тэрээр чулуун зэвсгийн олдворыг ангилан ялгаж хэвлүүлсэн юм³⁶.

Бяруухайн голын 1-р бууц

Бид Бяруухайн голын адаг орчимд эхлээд хайгуул хийхэд нэг ширхэг палеолитын байх магадлалтай залтаснаас өөр эд өлгийн зүйл олдсонгүй. Харин голын дунд урсгалд зүүн талд нь хайгуул хийхэд хармагийн дов сондуулын дундаас чулуун зэвсгийн олдвор илрүүлснийг Бяруухайн гол 1 гэж тэмдэглэв.

Энэ дурсгал дов сондуул бүхий харьцангуй хатуувтар хөрстэй голын зүүн эрэгт оршино (Зураг 7).



Зураг 7. Бяруухайн голын 1-р бууц (зургийг баруун талаас)

³⁵ Х.Пэрлээ. Монгол ард улсын эрт, дундад үеийн хот суурины товчоон. УБ., 1961. тал. 34-35; Х.Пэрлээ. Өмнөговь, Өвөрхангай аймгуудын говь талын нутгаас эртний судлалын хайгуул хийсэн нь. Эртний судлал-угсаатны зүйн бүтээл. УБ., 1963. тал. 26-37

³⁶ З.Батсайхан. Бяруухайн суурины чулуун зэвсгүүд. Шинжлэх Ухааны Академийн мэдээ. №3. УБ., 1993. тал. 49-51

Бид энд хайгуул хийж 3 ширхэг чулуун зэвсгийн олдвор илрүүлэв. Тэдгээрийг цахиурлаг чулуу ашиглан хийсэн бөгөөд бүгд залтас юм (Хүснэгт 1). Олдворын төрөл зүйл хязгаарлагдмал, тоо цөөн тул он цаг тогтооход хүндрэлтэй. Гэвч олдворын ерөнхий байдлаас үзэхэд, дундаж хэмжээтэй палеолитын залтас байх боломжтой ажээ. Тухайн газарт олдвор цөөн, сийрэг байгаагаас харахад анчин, түүвэрлэгчдийн бууц буудлын үлдэгдэл бололтой.

Хүснэгт 1. *Бяруухайн голын 1-р бууцын чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл*

№	Олдворын төрөл	Тоо	Хэмжээ (mm)	Олдворын дугаар
1	Залтас	3	71x55x19; 43x41x13; 55x56x14	BG-1. №1; BG-1. №2; BG-1. №3
Нийт		3		

Бяруухайн голын 2-р суурин

Бяруухайн голын эх орчимд, голын хоёр эргээр өндөр дов сондуул хужир мараа бүхий шаварлаг хөрстэй. Энд дов сондуулын хооронд болон голын эхний зүүн эргийн шаварлаг дэвсэг дээр чулуун зэвсгийн олдвор харьцангуй нягт тархжээ (Зураг 8). Мөн баруун эргийн бор өнгөтэй шаварлаг хөрсөн дээр ч чулуун зэвсгийн олдвор нэлээд тааралдаж байна. Хайгуулын судалгааны баримтжуулалтад голын эргийн эргэн тойрны энэ газрыг Бяруухайн гол 2 хэмээн тэмдэглэж баримтжуулав.

Эндээс 186 олдвор түүвэрлэн цуглуулсан. Түүвэр цуглуулгад буй олдворууд чулуун зэвсэг үйлдвэрлэлийн бүхий л үе шатыг илэрхийлэх эдлэлүүд юм (Хүснэгт 2). Чулуун зэвсгийн цуглуулгын анхдагч цуулалтын арга ажиллагааг илэрхийлэх 12 тооны олдвор байна. Тэдгээр нь *техникийн цуулдас (4 ш)*, *үлдэц (8 ш)* юм.

Техникийн цуулдас. Эхнийх нь бор саарал өнгөтэй цахиурлаг чулуугаар хийжээ. Зэрэгцээ цуулалтаар нэлээд өргөн ялтас цуулж авсан оромтой үлдцийн цохилтын талбайг тайрч авсан залтас юм. Гадар дээрээ холтчин зассан оромтой. Нэлээд том тэгш цохилтын талбайтай үлдцийг дахин засах явцад бий болсон бололтой. Бусад нь эргэн тойрон бичил ялтас цуулж авсан зэрэгцээ оромтой үлдцийн цохилтын талбай бүхий дээд хэсгийг тайрч бий болгожээ. Сүүлийн эдлэл нь жижиг үлдцийн хажууг дахин засах явцад бий болсон хавирган ялтас бөгөөд нэг ирмэгийг нь жигд холчин ирлэжээ.



Зураг 8. Бяруухайн голын 2-р суурин (зургийг баруун талаас)

Үлдэц. Хоёр үлдэц шаантган хэв шинжид хамаарна. Тэдгээрийг цахиурлаг чулуу ашиглан хийсэн бөгөөд нэг хажуу руугаа ялимгүй налуу цохилтын талбайтай. Цохилтын талбайг холтчин бэлтгэжээ. Суурийг хоёр талаас холтчин зассан оромтой. Цуулалтын гадаргууг нэг өргөн болон хажуугийн нарийн талд бэлтгэж тэгш хэмтэй урт ялтас цуулж авсан зэрэгцээ оромтой. Нэг хажуу ирмэгийг хоёр талаас нь хөндлөн цуулалтаар шаантган ирмэг гаргаж зассан. Энэ ирмэгийг дахин засах оролдлого хийхэд ирмэг автжээ. Ийм шаантган хэв шинжийн өөр нэг үлдэц бий.



Зураг 9. Бяруухайн голын 2-р суурин. 1, 3, 5 – шовх үлдэц

Бусад үлдэц нь шовх суурьтай конус хэлбэртэй. Тэдгээрийн ихэнх булгийн эхний зүүн талын шаварлаг хөрсөн дээрээс олдсон. Үлдцийн хажуугийн гадаргуугийн ихэнх хэсэгт зэрэгцээ цуулалтаар тэгш хэмтэй бичил ялтас цуулж авсан зэрэгцээ ором хадгалагдан үлдсэн байна (Зураг 9. 1, 3, 5).

Хоёрдогч боловсруулалт хийж ирлэсэн 14 ширхэг чулуун зэвсгийн олдвор илрүүлсэн. Тэдгээр нь төрөл зүйлийн хувьд *дутуу зассан хутга, сийлүүр, оолийн хугархай (2 ш), хусуур (6 ш), нүдүүр, ирлэсэн ялтас (2 ш), ирлэсэн залтас* хэмээн ангилагдана.

Хүснэгт 2. Бяруухайн голын 2-р суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл

№	Олдворын төрөл	Тоо	Хэмжээ (mm)	Олдворын дугаар
1	Үлдэц	8	42x23x15; 25x14x16; 30x17x13 28x18x16; 32x17x17 33x17x18; 30x9x5 23x16x20;	BG-2.№4, 10, 11, 12, 13, 14, 15, 16,
2	Техникийн цуулдас (tablet)	4	57x41x15	BG-2.№1, 23, 24, 25
3	Хусуур	6	19x14x5	BG-2.№2, 18-22
4	Дутуу зассан хутга	1	69x35x13	BG-2.№3
5	Сийлүүр	2	26x14x6	BG-2.№5
6	Ооль	1	56x41x19; 52x31x16	BG-2.№6, 17
7	Нүдүүр	1	22x73x54	
8	Иртэй ялтас	2	32x17x6; 20x8x2	BG-2.№7, 9
9	Иртэй залтас	1	8x8x6	BG-2.№8
10	Бүтэн ялтас	5	-	-
11	Ялтасны дээд хэсгийн хугархай	9	15x7x2	-
12	Ялтасны дунд хэсгийн хугархай	2	-	-
13	Ялтасны үзүүрийн хугархай	4	-	-
14	Залтас	107	Дундаж, жижиг	
15	Хагархай хэлтэрхий	33	Том, жижиг	
Нийт		186		

Хусуур. Эхний хусуурыг улаан өнгийн хасаас цуулж авсан зууван хэлбэртэй залтсаар хийжээ. Залтасны төгсгөл хөндлөн ирмэгийг босоо холтчин ирлэсэн төгсгөл хусуур юм. Бусад нь жижиг болон дундаж залтсаар хийжээ. Дөрөв нь төгсгөл хусуурын төрөлд хамаарна. Гурван эдлэлийн залтасны цохилтын товгор бүхий хэсгийг тайрч ишинд суулгахад бэлтгэжээ. Нэг эдлэл цохилтын товгороо хадгалсан. Нэг хусуур нэлээд том хэмжээтэй бөгөөд томоор холтчин болхидуу ирлэжээ.

Дутуу зассан хутга. Хоёр ирмэг нь үзүүр рүүгээ налсан гурвалжиндуу хэлбэртэй уг эдлэлийг бараан өнгөтэй цахиурлаг чулуугаар хийжээ. Түүнийг хийхдээ дундаж хэмжээтэй залтсыг бэлдэц болгон ашигласан бөгөөд залтасны нэг ирмэгт налуу хайрслаг ир гаргажээ.

Залтасны нүүрэн хэсэг нэлээд товгор тул тэр хэсгийг нимгэлж чадалгүй орхисон бололтой. Ерөнхий хэлбэрээс харахад хутга бифас маягийн зэвсэг хийхээр зэхэж байсан бололтой.

Сийлүүр. Тэгш бус хэмтэй зузаан ялтасны дунд талын хугархайгаар хийжээ. Нэг ирмэгийн дундаас дооших хэсгийг холтчин ирлэж үзүүрийг нь ташуу тайрч сийлүүрийн хурц ирмэг үүсгэжээ.



Зураг 10. Баяруухайн голын 2-р суурин (зургийг хойд талаас)

Ооль. Эдгээрийг гүйцэд бэлтгэлгүй орхижээ. Эхнийх нь зуувандуу хэлбэртэй бөгөөд их төлөв нэг талаас нь томоор босоо холтчин засжээ. Нэг талд нь чулууны өнгөн бүрхүүл нэлээд том хэсэгт хадгалагдан үлджээ. Дээд хэсэг хугарсан тул гүйцэд засалгүй орхижээ. Дараагийн эдлэлийн суурь буюу ирэн хэсгээс бусдыг гүйцэд засжээ. Суурь зузаан тул түүнийг нимгэлж чадалгүй орхисон бололтой.

Нүдүүр. Суурь руугаа өргөссөн бүтэн нүдүүр. Сууриас дээшлэх тусам нарийсаж гарт барихад эвтэй болгожээ. Бүхэлд нь зүлгэх аргаар зассан бөгөөд нэг тал нь хавтгай, нөгөө тал нь нэлээд гүдгэр ажээ. Суурь буюу цохих хэсгийн ирмэг эмтэрч хортон суусан нь хэрэглээний ул мөр ажээ. Уг эдлэлийг эргийн ирмэгээс илрүүлсэн бөгөөд хөрсөн доор байсныг илтгэх кальцийн карбонат тогтжээ (Зураг 11).

Ирлэсэн ялтасны хугархай 2. Эхнийх нь гадаргуугийн ихэнх хэсэг нь чулууны өнгөн бүрхүүлээ хадгалсан анхдагч ялтасны дээд хэсгийн хугархай юм. Түүний торгон ирмэгийг



Зураг 11. Баяруухайн голын 2- сууринаас илрүүлсэн нүдүүр

маш жижгээр нэг эгнээ нямбай ирлэжээ. Дараагийнх нь тэгш хэмтэй, хоёр талт ялтасны үзүүрийн хугархай юм. Түүний нэг ирмэгийг ар талаас нь жигд холтчин жижгээр ирлэжээ.

Цуулдасны үйлдвэрлэлд 160 ширхэг эдлэл хамаарна. Тэдгээр нь ялтас, залтас, хагархай, хэлтэрхий юм.

Ялтас. Бүтэн ялтаснууд нь бүгд жижгэвтэр хэмжээтэй. Нэгээс бусад нь тэгш бус хэмтэй, нимгэн. Ялтасны дээд хэсгийн хугархайнууд нь гурав болон хоёр талтай. Ихэнх цохилтын товгороо хадгалжээ. Дунд хэсгийн хугархайн нэг нь тэгш, нөгөөх нь тэгш бус хэмтэй ялтасны хоёр талтай хугархай ажээ. Үзүүрийн хугархайн гурав нь жижиг, нэг нь том, нимгэн.

Залтас. Дундаж, жижиг хэмээн ангилагдана. Дундаж хэмжээтэй залтасны нэг нь гадрын зарим хэсэгт чулууны өнгөн бүрхүүлээ хадгалжээ. Бусад нь өмнөх цуулалтын оромтой хоёрдогч калтас ажээ. Ихэнх нь чулууны өнгөн бүрхүүлээ хадгалжээ. Жижиг залтаснууд бүгд өмнөх цуулалтын ормыг хадгалсан.

Хагархай, хэлтэрхий. Цайвар өнгөтэй жижиг хэмжээтэй манын хагархайнууд юм.

Бяруухайн голын эхэн хэсэгт орших чулуун зэвсгийн дурсгалт газрын олдворын ихэнх чулуун зэвсэг үйлдвэрлэлийн арга ажиллагаа, хэв шинжээрээ шинэ чулуун зэвсгийн үед холбогдох нь тодорхой байна. Харин том хэмжээтэй зарим залтас нь дээд палеолитын төгсгөл үед холбогдох магадлалтай ажээ. Мөн Бяруухайн голын эх орчимд хөх өнгөтэй, нарийн ширхэгтэй шавраар хийсэн шатаалт сайн ваарын хагархай олон олдож байна. Академич Х.Пэрлээ абугай энэ төрлийн ваарыг Сүн улсын үед хамаарах магадлалтайг дурдсан байдаг.

2.2.4. Ганган задгайн суурин

Хоёр талаараа сондуул, их төлөв зүүн талаараа цайвар өнгөтэй нарийн ширхэгтэй шавартай өндөр цагаан эрэг ганга бүхий тунгалаг уст булгийг нутгийн олон Ганган задгай гэнэ (Зураг 12). Энэ булаг Бяруухайн голын зүүн талд 1 км орчим зайд, Хөрхийн нурууны өвөр тал руу уруудсан сайраас ундрах ажээ.



Зураг 12. Ганган задгай (зургийг урд талаас)

Ганган задгайн хоёр эрэг зарим хэсэгт өндөр бөгөөд нарийн ширхэгтэй цайвар өнгөтэй шаварлаг хөрстэй ажээ (Зураг 13).

Бид Ганган задгайн орчмоор хайгуул хийхэд булгийн хөл орчмын зүлгэн дээрээс зүлгэж зассан бүтэн сүх илрүүлж Ганган задгай 1, булгийн зүүн талын нарийн ширхэгтэй цайвар шаварлаг эргийн дээрээс цөөн тооны чулуун зэвсгийн олдвор, галын ором илрүүлснийг Ганган задгай 2 гэж тэмдэглэв (Хүснэгт 3).



Зураг 13. Ганган задгайн галын ором олдсон эрэг (зургийг баруун урд талаас)

Ганган задгай 1. Булгийн хөл орчмын зүлэг, түүний хажуугийн сондуулын дундуур чулуун зэвсгийн олдвор сийрэг тархжээ. Эндээс илрүүлсэн сонирхолтой олдвор бол сүхний чулуун үзүүр юм (Зураг 14).



Зураг 14. Ганган задгай 1 суурин. Сүхний чулуун үзүүр

Сүхний хажуугийн урт ирмэгүүд нь үзүүр рүүгээ аажим налсан гурвалжиндуу хэлбэртэй, тэгш өргөн суурьтай. Түүнийг хар өнгөтэй цахиурлаг чулуугаар хийжээ. Эдлэлийн хоёр өргөн талд зүлгэж мөлийлгөсөн ором мэдэгдэх агаад хажуу ирмэг, суурийг ар, өвөр талаас нь төв рүү чиглүүлэн жижгээр хагалан холтчиж ялимгүй долгиотой ир бэлтгэжээ. Суурийн ирмэгийг оольтой адил нэг тал руу шахаж бус төвд нь байрлуулсан нь энэ эдлэл сүх болохыг илтгэнэ. Түүнийг бэлтгэхдээ неолитын хожуу үеийн зүлгэх аргыг хагалж цуулах аргатай хослон бэлтгэсэн нь сонирхолтой ажээ.

Хүснэгт 3. Ганган Задгай 1, 2-р суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл

№	Олдворын төрөл	Тоо	Хэмжээ (mm)	Олдворын дугаар	Дурсгалын дугаар
1	Сүх	1	119x50x26	GZ.01	1-р суурин
2	Үлдэц	1	35x14x12	GSN-2024. Survey. Bag-2(2)	2-р суурин
3	Техникийн цуулдас	1	33x12x7	GSN-2024. Survey. Bag-2(2)	2-р суурин
4	Залтас	3	Дундаж	GSN-2024. Survey. Bag-2(2)	2-р суурин
Нийт		6			

Ганган задгайн 2-р бууц. Ганган задгайн зүүн талын цайвар өнгөтэй нарийн шавартай эргийн дээд талаас цөөн тооны чулуун зэвсгийн олдвор, амьтны ясны үлдэгдэл илрүүлэв. Амьтны яс орчин үеийнх байх магадлалтай. Галын ором ихэд бүдэг бөгөөд цэвэрлэх явцад жижиг нүүрсний үлдэгдэл гарч байв. Энэ орчимд чулуун зэвсгийн олдвор сийрэг боловч тархжээ. Бид 5 ш чулуун зэвсгийн олдвор илрүүлсэн. Тэдгээр нь бичил ялтас цуулж авсан, тэгш цохилтын талбайтай *үлдэц*, зэрэгцээ цуулалтаар ялтас авсан үлдцийн цуулалтын гадаргуугаас тайрч авсан *техникийн цуулдас*, дундаж хэмжээтэй *залтас (3 ш)* ажээ.

Ганган задгай орчмоос илрүүлсэн дээр дурдсан чулуун зэвсгийн олдворууд шинэ чулуун зэвсгийн үед холбогдох боломжтой. Ялангуяа, зүлгэх, хагалж цуулах аргыг хослуулан хийсэн сүх, тэгш хэмт жижиг ялтас цуулж авсан үлдэц зэрэг нь шинэ чулуун зэвсгийн үйлдвэрлэлийн аргыг илэрхийлж байна. Мөн цайвар шаварлаг хөрсөн дээр буй галын ором нь анчин, түүвэрлэгчид үлдээсэн отог буудлын үлдэгдэл байх магадлалтай. Ганган задгай орчмоос хожуу үеийн ваар савны хагархай нэлээд тааралдах бөгөөд үеийн үед цэвэр усны ундарга бараадан хүн амьтан хөлхөж байсан газар ажээ.

2.2.5. Харанхуй усны орчимд хийсэн хайгуул судалгаа

Ганган задгайгаас зүүн тийш 1 км хүрэхгүй зайд өндөр эргээс эх авч урсах тунгалаг устай булгийг Харанхуй хэмээн нэрийднэ. Харанхуй өмнөх гол, булгийг бодвол ус нь татуу агаад богино зайд урсдаг ажээ (Зураг 15).



Зураг 15. Харанхуй ус (зургийг баруун урд талаас)

Харанхуй усны хоёр эргээр бут сондуул ихтэй. Бид булгийн хоёр эргийн дагууд хайгуул судалгааг гүйцэтгэв. Зүүн эргийн хармагийн сондуулын хоорондох элсэрхэг зөөлөн хөрсөн дээрээс хар бараан өнгөтэй цахиурлаг материалаар хийсэн ооль, сүх маягийн зэвсэг олныг илрүүлсэн бөгөөд Харанхуй ус 1 гэж тэмдэглэв. Харин булгийн савын баруун талаас сийрэг тархсан чулуун зэвсгийн олдвор илрүүлснийг Харанхуй ус 2 хэмээн баримтжуулсан.

Харанхуй усны 1-р суурин

Харанхуй усны голын савын зүүн талын дэвсгэрт хармагийн сондуул олон байх агаад тэдгээрийн завсар хооронд нэлээд том хэмжээтэй чулуун зэвсгийн олдвор тархсан дурсгалыг хайгуул судалгааны явцад илрүүлж баримтжуулав (Зураг 16). Бид эндээс 26 чулуун зэвсгийн олдвор сонголтын зарчмаар түүвэрлэн цуглуулсан. Эндээс илрүүлсэн зарим олдворыг сайтар засаж гүйцэд бэлтгэсэн байх боловч элсэнд ихэд дарагдаж мэдэгдэхгүй шахам болсон байна.



Зураг 16. Харанхуй усны 1-р суурин (зургийг урд талаас)

Сүх. Хажуу ирмэг нь үзүүр рүүгээ налж нийлсэн гурвалжиндуу хэлбэртэй. Хажуу ирмэгээс нь төв рүү чиглүүлэн нимгэн хагалах, зүлгэх аргаар хийжээ. Ялангуяа, доод тал буюу ирэн хэсгийг зүлгэж хурцалсан нь мэдэгдэж байна. Харин хажуугийн ирмэг, иш бэхлэгдэх дээд талыг хагачиж засжээ (Зураг 17. 1).


Ооль. Эхнийх нь зуувандуу хэлбэртэй бөгөөд хажуу ирмэгийг хоёр талаас нь нимгэн холтчин засжээ (Зураг 17. 2). Суурийн нэг талаас хурц ирмэг гаргажээ. Дараагийнх нь гурвалжиндуу хэлбэртэй. Хажуу талыг жижгээр холтчин ялимгүй долгиотой хурц ирмэг

бэлтгэжээ. Нүүрэн талыг бүхэлд нь зүлгэж зассан ором мэдэгдэнэ. Ирэн хэсэг ялимгүй нумарсан, хурц ажээ (Зураг 17. 3).

Хүснэгт 4. Харанхуй усны 1-р суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл

№	Олдворын төрөл	Тоо	Хэмжээ (mm)	Олдворын дугаар
1	Сүх	1	92x51x21	Kh.U-1.1
2	Ооль	2	80x37x15; 83x44x18	Kh.U-1.2; Kh.U-1.3
3	Бүтэн ялтас	1	-	GSN-2024. Survey. Bag-3(2)
4	Ялтасны дээд хэсгийн хугархай	1	-	GSN-2024. Survey. Bag-3(2)
5	Ялтасны үзүүрийн хугархай	2	-	GSN-2024. Survey. Bag-3(2)
6	Залтас	12	Том, дундаж, жижиг	GSN-2024. Survey. Bag-3(2)
7	Хагархай, хэлтэрхий	7	Дундаж	GSN-2024. Survey. Bag-3(2)
Нийт тоо		26		

Цуулдасны үйлдвэрлэлд хамаарах залтас, ялтас, ялтасны хугархай, хагархай хэлтэрхий ч мөн эндээс илрүүлжээ.



Зураг 17. Харанхуй усны 1-р суурин. 1 – чулуун сүх, 2, 3 – ооль

Харанхуй усны энэ дурсгалын олдвор элсэн хөрсөнд нэлээд дарагдсан боловч сүх, ооль, том баргил залтас зэрэг цахиурлаг занар чулуугаар хийсэн сонирхолтой олдвор илэрч олдсон. Бид тухайн дурсгал дээд палеолиын төгсгөл, голоцены эхэн үед хамаарах боломжтой хэмээн үзэж буй бөгөөд дээр дурдсан баргил зэвсгийг хагалж нимгэлэх, зүлгэх зэрэг аргыг хослуулан хийснээрээ онцлог юм.

Харанхуй усны 2-р суурин


Өмнөх дурсгалаас баруун урагш 130 м зайд, булгийн баруун талын дов сондуул ургасан шаварлаг хөрсөн дээрээс цөөн тооны олдвор илрүүлж баримтжуулав (Зураг 18).



Зураг 18. Харанхуй ус 2-р суурин (зургийг зүүн хойд талаас)

Эндээс 26 чулуун зэвсгийн олдвор сонголтын аргаар түүвэрлэн цуглуулсан (Хүснэгт 5). Тэдгээр нь үлдэц, хоёрдогч боловсруулалт хийж зассан багаж зэвсгийн зүйл, цуулдасны үйлдвэрлэлд хамаарах эдлэлүүд ажээ.

Үлдцийн нэг нь шовх үлдэц юм. Суурь руугаа нарийссан гурвалжин хэлбэртэй. Тэгш цохилтын талбайг холтчин гаргасан бөгөөд хоёр хажуу, нүүрэн талаас суурь руу чиглүүлэн цуулалт хийж тэгш хэмтэй бичил ялтас цуулж авсан зэрэгцээ оромтой. Дараагийнх нь жижгэвтэр тэгш цохилтын талбайтай, нэг хажуу, суурийг хоёр талаас холтчиж хурцлан шаантган ирмэг гарган зассан жижиг үлдэц юм. Цуулалтын гадаргууг нэг нарийн талд



Зураг 19. Харанхуй усны 2-р суурин. Үлдэц

бэлтгэж зэрэгцээ цуулалтаар олон жижиг ялтас цуулж авчээ. Мөн зэрэгцээ цуулалтаар олон бичил ялтас цуулж авсан призм маягийн үлдцийн цохилтын талбайг тайрч авсан *техникийн цуулдас* илрүүлсэн байна.

Нэлээд сонирхолтой олдворын нэг бол зуувандуу хэлбэртэй том бифасын үзүүрийн хугархай юм (Зураг 20). Дугуйрсан ирмэгийг хоёр талаас нь томоор холтчин хурц ирмэг гаргажээ. Хийсэн арга ажиллагаа, хэв шинжид тулгуурлавал дээд палеолитын үед холбогдуулан үзэх боломжтой.



Зураг 20. Харанхуй усны 2-р суурин. Бифасын хугархай

Шовх болон шаантган үлдэц, техникийн цуулдас зэрэг нь голоцены үеийн арга ажиллагааг илтгэх боловч том хэмжээтэй цуулалт бүхий хагархай, бифас зэрэг нь палеолитын үед хамаарах бололтой. Тиймээс Харанхуйн булаг орчимд олон үе хүн нутаглаж, өөрсдийн ул мөрийг үлдээсэн хэмээн үзэж байна.

Хүснэгт 5. Харанхуй усны 1-р суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл

№	Олдворын төрөл	Тоо	Хэмжээ (mm)	Олдворын дугаар
1	Шовх үлдэц	2	22x17x10; 32x13x17	Kh.U-2. 1; Kh.U-2. 2
2	Техникийн цуулдас (tablet)	1	9x17x21	Kh.U-2. 3
3	Бифасын хугархай	1	82x74x28	Kh.U-2. 5
4	Ялтасны дээд хэсгийн хугархай	1		Kh.U-2. 4
5	Залтас	18	Жижиг	GSN-2024. Survey. Bag-3(3)
6	Хагархай	1	Жижиг	GSN-2024. Survey. Bag-3(3)
7	Цуулалтын оромтой хагархай	2	90x104x25	Kh.U-2. 6; Kh.U-2. 7
Нийт		26		

2.2.6. Хахуулын гол, Баянгол, Цал гүний сайр орчимд хийсэн хайгуул

Борзонгийн говийн хойд биед байх Бяруухайн булаг, Ганган задгай, Харанхуй усны орчимд судалгааг гүйцэтгэсний дараа улсын хил чиглэн хөдөлсөн юм. Борзонгийн говиор шууд дайрч явах зам байдаг ч элс шуурч мэдэгдэхгүй шахам болсон тул нэлээд баруунаар тойрч төв зам авч Өмнөговь аймгийн Номгон сумын Дэрсэн ус багаар дайрч Шүүлэнгийн заставыг



Зураг 21. Тавьтын Улаан зуух хэлбэрийн булш (зургийг урд талаас)

чиглэв. Шүүлэнгийн заставаас 10 км гаруй зайд Булган хорго, түүний салбар уулс байх бөгөөд зам зуурт археологийн дурсгал төдий л тааралдсангүй. Монголын Соёлын өвийн үндэсний төвийн ажилтан Анхсанаа өмнө нь Булган Хорго уулаас хадны зургийн дурсгал илрүүлж хэвлүүлж байсан юм. Харин Булган хорго уулаас урагш Шүүлэнгийн заставын хойд талд Тавьт хэмээх газарт, авто замын дэргэд гол хэсэг нь чулуу багатай Улаан зуух хэлбэрийн булш байсныг бүртгэж баримтжуулав (Зураг 21).


Шүүлэнгийн заставаар дайрч ахлагч Ганзоригоор газарчлуулан Цал гүний сайр, Баянголын булаг орохоор хөдлөв. Замдаа Хахуулын голын хадны зургийг үзэв. Энэ зургийг заставынхан Бичигт хад хэмээх бөгөөд Хахуулын гол хэмээх намхан хярын дундуур баруун хойноос зүүн урагш чиглэсэн өргөн сайрын хоёр эргийн хаданд бий (Зураг 22).



Зураг 22. Хахуулын голын Бичигт хад (зургийг урд талаас)

Зургийг сайрын хоёр эргийн хүрмэн чулуун хадан дээр сийлж үлдээсэн тул зам яваа хүмүүст төвөггүй танигдаж харагдах ажээ. Ялангуяа, голын эргийн зүүн талын урагш харсан ханан хад, баруун эргийн хойш харсан ханан хаднаа сийлсэн багны дүрслэл ихээхэн анхаарал татах бөгөөд ихэд онцгой юм. Ер нь эндэхийн хадны зургийн гол өгүүлэмж баг ажээ. Гэвч ан амьтад, тэр дундаа үхрийн зураг тухайн дурсгалын он цагийн баримжаа гаргах чухал дүрслэл бололтой байна (Зураг 23).

Хахуулын голын Бичигт хадны зургийг судлаач У.Эрдэнэбат 2008 онд хэвлэсэн бөгөөд он цагийн хувьд неолитоос хүрэл, төмрийн түрүү үе, Хүннү гүрний үе, дундад зууны хожуу үе буюу X-XIII зууны үед хамаарна хэмээн нэлээд өргөн хүрээлэлд авч үзсэн юм³⁷. Бидний хувьд зам зуур тухайн дурсгалыг сонирхон үзэж цөөн зураг авсан бөгөөд дээр дурдсан мэт он цагийн өргөн хүрээлэлд бус неолитын төгсгөл үед хамаатуулах саналтай байна.



Зураг 23. Хахуулын голын хадны зургийн зарим дүрслэл

Цагаан дэрсний засталаас урагш, Хахуулын голыг уруудаж явсаар Баянгол хэмээх газарт хүрнэ. Энд газрын зурагт жижиг булаг тэмдэглэгдсэн байх боловч өдгөө ширгэж элсэнд дарагджээ. Монгол Улсын хилийн шугамаас цааш БНХАУ-ын ӨМӨЗА-ны нутаг дэвсгэрт Ингэн худаг хэмээх шинэ чулуун зэвсгийн үед холбогдох сонирхолтой дурсгал байдаг. Бид хилийн шугамаас нааш Ингэн худагтай ойролцоо бүс нутагт, ялангуяа дурсгал байх магадлалтай булаг шандын орчимд хайгуул хийхээр төлөвлөхдөө Баянгол хэмээх энэ газрыг сонгож авсан юм (Зураг 24).

³⁷ У.Эрдэнэбат. Хахуулын голын хадны зураг // Studia Archaeologica. Tom. (VI) XXVI, fasc. 3. УБ., 2008. тал. 32-56



Зураг 24. Баянголын тооройн төгөл ба орвог

Гэвч намхавтар хадархаг хярын дундуур хойноос урагш чиглэсэн олон хуурай сайр бүхий энэ газар элсэн хурдсанд ихэд дарагджээ. Бид Тооройн төгөл орчимд хайгуул судалгаа хийсэн боловч археологийн дурсгал эндээс илрүүлсэнгүй. Баянголын тооройн төглөөс зүүн урагш 3 км зайд хуурай сайрын эргийн дагуу хайгуул хийхэд чулуун зэвсэг хийх хатуулаг сайн материал тааралдах боловч засаж янзалсан чулуун зэвсгийн зүйл тааралдсангүй (Зураг 25).



Зураг 25. Цал гүний сайрын адгийн чулуун зэвсгийн түүхий эд бүхий газар

Хилийн зурвас газарт тусгай зөвшөөрлөөр, дугаар заставаас томилсон хүний хамт ажиллах ёстой байдаг тул бид тэр өдрийн орой буцаж Цагаан дэрсний заставын орчимд хонов.

2.2.7. Цагаан дэрс, Шүүлэнгийн застав хооронд хийсэн судалгаа

Цагаан дэрсний заставаас өглөө Шүүлэнгийн заставыг чиглэн хөдлөв. Замын 30 дахь км-ийн орчимд Баруун хойноос зүүн урагш чиглэсэн сайрын зүүн тийш огцом эргэсэн тохойд буюу сайрын урд эргийн хойш харсан ирмэглэсэн цохио хадны орчмоор хайгуул судалгаа хийв (Зураг 26).



Зураг 26. Сорилын малтлага хийсэн газрын тэмдэглэгээ

Сайрын тохой буюу ар дэнжээс чулуун зэвсгийн зүйл олдоогүй боловч дундаж хэмжээтэй дөрвөн чулууг зуувандуу хэлбэрт оруулан газарт нэлээд сайн суулгасан илрүүлэв. Ийнхүү чулууг тодорхой хэлбэрт оруулан тавьсан нь хүний гараар үйлдснээс зайлшгүй тул эртний анчин, түүвэрлэгчдийн гал голомтын үлдэгдэл байх магадлалтай юм. Арц Богдын нурууны өвөр хоолойн нуурын савын харьцангуй сайн хадгалалттай анчин, түүвэрлэгчдийн отог бууцын үлдэгдэлд ийм тулгын чулууны ор мэдэгддэг. Мөн Баянзагийн Шавар усны сууринд галд халж бутарсан тулгын чулууны үлдэгдэл олон байсан тухай судлаачид тэмдэглэсэн байдаг тул бид шалгах зорилгоор зуувандуу хүрээ маягаар өрсөн чулууны дотор талын хөрсийг цэвэрлэж үзэв (Зураг 27, 28). Газрын өнгөн хөрснөөс доош 10 см-т гал түлсэн ором болох бүдэг сааралдуу өнгөтэй толбо илрэв. Газрын хөрс улайж

хатуурч дагтаршаагүй, нүүрсний үлдэгдэл цөөн зэргээс үзэхэд, богино хугацаанд гал түлсэн бололтой. Өөр ямар нэг эд өлгийн зүйл байсангүй.



Зураг 27. Зуувандуу маягаар хүрээлэн суулгасан чулуу



Зураг 28. Хүрээ чулууны дундаас галын ором илэрсэн байдал

Хоёр дахь байгууламж өмнөхөөс баруун тийш 30 м зайд байна (Зураг 29). Энэ нь жижгэвтэр чулуугаар хийсэн тодорхой зохион байгуулалтгүй дараастай. Өнгөн хэсгийн сул хайргыг цэвэрлэж үзэхэд юуных нь тодорхойгүй амьтны ясны жижиг хэлтэрхий нэлээд олон гарав. 10 см гүнд нарийн ширхэгтэй цайвар шаварлаг хөрс илэрсэн бөгөөд өөр эд өлгийн зүйл гарсангүй (Зураг 30).



Зураг 29. Хоёр дахь байгууламжийн тодорхой зохион байгуулалтгүй дараас чулуу



Зураг 30. Өнгөн хөрсийг цэвэрлэж с илрүүлсний дараах байдал

Энэ малтсан хоёр байгууламжийн эхнийх түр зуур буюу богино хугацаанд гал түлсэн оромтой. Харин нөгөөх нь амьтны ястай ажээ. Үүрэг зориулалт мэдэгдэхгүй боловч харьцангуй сүүл үед зам зуур явсан хүмүүсийн (аянчин, жинчид) үлдээсэн дурсгал болов уу хэмээн таамаглаж байна. Бид амьтны яснаас дээж авч он цаг тогтоохоор төлөвлөж буй.

2.2.8. Хар хөвийн булаг орчимд хийсэн хайгуул судалгаа

Өмнөговь аймгийн Номгон сумын урд зах нутаг Шүүлэнгийн заставаар дайрч заставын дарга Баяржаргалыг авч Хавцлын булаг, Хар хөвийн булаг орчмыг шалгахаар цааш хөдлөв.

Шүүлэнгийн заставаас урагш өргөн сайрын урд Сухайн орвог бүхий жижиг булаг байсан нь өдгөө ширгэж хатжээ. Энд хайгуул хийхэд эд өлгийн зүйл олдсонгүй. Чулуун зэвсэг хийх түүхий эд ч тааралдсангүй.

2.2.9. Дуут манханы ар биеэр хийсэн хайгуул

Өмнөговь аймгийн урд зах, Монгол Улс, БНХАУ-ын хилийн дээсийг дамнан үргэлжлэх элсэн манхны нэг бол Дуут манхан юм (Зураг 31). Шүүлэнгийн заставаас ялимгүй зүүн урагш шулуунаар 21,6 км зайд Дуут манхан эхлэх бөгөөд урагш үргэлжилдэг. Нутгийн иргэд Дуут манханы орчимд нуурын тогтоол сав нэлээд байдаг гэсэн мэдээ өгсөн тул тэр хавьд нуурын хотгор, савыг шалгахыг зорьсон юм.



Зураг 31. Дуут манхан (хойд талаас)

Гэвч 7 дугаар сарын эхэн үеийн аагим халуун, хуурай салхинд авто хэрэгсэл хааяа явдаг замыг элсээр хучиж явах аргагүй болсон тул манхны ар талаар гүймэг хайгуул судалгааг хийв. Энд элсэн хурдаснаас ил цухуйж харагдах хадан гарш, баруун хойноос зүүн урагш чиглэсэн хуурай сайрын эрэг ирмэгээр цахиур хасын төрлийн чулуулаг мэр сэр тааралдах боловч эд өлгийн зүйл олдсонгүй (Зураг 32).



Зураг 32. Дуут манханы ар бие

2.2.10. Хавцалын булаг орчимд хийсэн хайгуул судалгаа

Шүүлэнгийн заставаас урагш, улсын хилтэй ойролцоо боржин чулуун тогтцыг баруун хойноос зүүн урагш зүсэж тогтсон үзэсгэлэнт хавцал байх бөгөөд тэндээс ундрах жижиг булгийг Хавцлын булаг хэмээн нэрлэдэг ажээ (Зураг 33). 7 дугаар сарын аагим халуунд хавцлын сайраас ундрах булаг ширгэж хатсан байв. Харин булгийн эхэн орчмын сайрын ус дааварласан хэсэгт гүн гүн хонхор үүссэн байгаа нь хулангийн татаал ажээ. Ган гачигтай зуны цагт хулангийн сүрэг булаг шандын эх, сайрын ус ойр зөөлөн хөрстэй газрыг цавчиж ус гаргаж ундаалах бөгөөд түүний мөрөөр зээр зэрэг бусад амьтад ундаалдаг ажээ.



Зураг 33. Хавцалын булаг (Баруун талаас)

Бид боржин чулуун тогтоц бүхий хавцлыг хоёр эргээр хайгуул хийсэн боловч чулуун зэвсгийн ул мөр бүхий газар илрүүлсэнгүй (Зураг 34, 35).



Зураг 34. Хавцалын булаг



Зураг 35 Хавцалын булагийн эх

Харин хавцлын баруун эргээс хашлага чулуунууд нь нэлээд нурсан нэг байгууламж олсон (Зураг 36). Гадаад зохион байгуулалт нь эвдэгдсэн учраас булш оршуулга, тахилын байгууламж аль нь болохыг шууд хэлэхэд төвөгтэй ажээ.



Зураг 36. Хавцалын булагийн баруун дэнж дэх чулуун байгууламж

Ер нь Борзонгийн говиос урагш Монгол Улсын хилийн шугам хүртэлх өргөн уудам зурвас газар нутаг археологийн дурсгал тун цөөн байгаа нь ажиглагдсан юм. Энэ зурвас газар түрүү түүхийн үед нүүдэлчид, суурьшмал иргэдийн хоорондын байгалийн зааг саад болж байсан нь тодорхой юм. Харин үүнээс урагш чулуун зэвсэг, түрүү хүрлийн үед ч энэ нутагт хүн нутаглаж өөрийн ахуй

амьдралын гэрч улбааг үлдээсэн гэх баримт энэ удаагийн хайгуул судалгаагаар илрүүлж олсонгүй.

Өвөр Монголын хойд хэсгийн хүн амьдрахад тохиромжтой үржил шимт газрыг Монгол Улсын хилийн шугамаас дотогш 70 км орчим үргэлжилсэн ус унд муухан газар зааглаж байсан бололтой бөгөөд бидний ажигласнаар Борзонгийн булгуудын орчмоос дурсгал эхэлж байна.

2.2.11. Бүрэгийн сайр орчимд хийсэн хайгуул судалгаа

Өмнөговь аймгийн Номгон сумын урд зах Цагаан дэрс, Шүүлэнгийн заставаас урагш Улсын хилийн зурваст гүймэг маягаар хийсэн хайгуул судалгааны явцад анчин, түүвэрлэгчдийн бууц суурингийн үлдэгдэл илрүүлж олоогүй тул хайгуул судалгааг цаашид нутгийн гүнд үргэлжлүүлэхээр шийдвэрлэв. Бид Шүүлэнгийн заставаас гарч Борзонгийн

говийг гатлан Бүдүүн модны застав ордог замаар явж дурсгал байх боломжтой газруудыг шалгав. Шүүлэнгээс Бүдүүн модны застав явах замын 41,5 км-т буюу Шүүлэнгийн заставаас зүүн хойш шулуунаар 24,6 нэгэн шинэ дурсгал илрүүлсэн юм.



Зураг 37. Борзонгийн говийн зүүн хэсэг Бүрэгийн сайр

Энэ газар Борзонгийн говийн хойд этгээдэд орших Харанхуйн булгаас зүүн урагш 26,8 км зайд, Борзонгийн говийн зүүн этгээдийн заг, сондуул ургасан нарийн хоолойд бий (Зураг 37). Хойноос урагш чиглэсэн хуурай сайраас булаг ундардаг байсан бололтой бөгөөд өдгөө ширгэж хатжээ. Газрын зурагт тухайн газрыг Бүрэгийн сайр хэмээн тэмдэглэсэн байв. Харин энэ нэрийг лавшруулан тодруулах нутгийн хүн, айл амьтан энэ орчимд тааралдсангүй. Булгийн эх байсан ором ус дааварласан сайрын хоёр эргийн сондуулын хооронд янз бүрийн материалаар хийсэн чулуун зэвсгийн олдвор нэлээд нягтаршилтай тархсан байна (Зураг 38).



Зураг 38. дурсгалын газрын хөрсөн дээр тархсан чулуун зэвсгийн олдвор

Бид энд хайгуул хийж чулуун зэвсгийн олдвор тархсан газруудыг тусад нь тэмдэглэж авсан юм. Сайрын эргийн заг, сондуулын хооронд элсэн хурдас нэлээд зузаан хуримтлагдсан боловч тодорхой заагтай тархсан нь мэдэгдэж байв. Мөн олдворын тархалт их байсан тул сонголтын зарчмаар олдвор түүвэрлэв.

Бүрэгийн сайрын 1-р дурсгал


Бүрэгийн сайран дээр гаргасан худгийн эргэн тойронд чулуун зэвсгийн олдвор нэлээд элбэг тааралдаж байна (Зураг 39). Их төлөв цахиур чулуугаар эдгээр олдворыг бэлтгэжээ. Бид хайгуул судалгааны явцад худгийн эргэн тойрноос 51 чулуун зэвсгийн олдвор түүвэрлэн цуглуулсан (Хүснэгт 6). Тэдгээр нь анхдагч цуулалтад хамаарах эдлэл, зассан болон хийж байгаад орхисон багаж зэвсэг, цуулдасны үйлдвэрлэлд хамаарах эдлэлүүд юм.



Зураг 39 Бүрэгийн сайрын 1-р дурсгал (зургийг зүүн урд талаас)

Бэлдэц. Хөх өнгөтэй цахиурлаг чулуугаар хийжээ. Түүхий эдийн нэг талаас өргөн ялтас салган авч ялимгүй налуу цохилтын талбай бэлтгэсэн агаад жижиг ялтас салган авах оролдлого хийж цуулалт хийсэн ором нэг хажуугийн дээд хэсэгт үлджээ. Байгалийн чулуу ашиглан ялтас цуулах оролдлого хийсэн бэлдэц ажээ.

Үлдэц. Эхнийх нь хавтгайдуу байгалийн чулуугаар хийжээ. Нэг өргөн, тэгш талын ирмэгийг жижгээр хагачин цохилтын талбай гаргасан байна. Эндээс шулуун цуулалтууд хийж богино, өргөн ялтас, залтас цуулж авчээ. Мөн чулууны нэг нарийн талд нимгэн, нэлээд өргөн ялтас цуулж авсан ором байна. Үлдцийн цохилтын талбайн хэсэг, суурь, ар талд чулууны өнгөн бүрхүүл үлджээ. Дараагийнх нь шовх суурьтай жижиг үлдэц бөгөөд нарийн цуулалтын гадаргууг холтчин засжээ. Хажуу, нүүрэн талаас тэгш хэмт бичил ялтас цуулж авсан зэрэгцээ оромтой (Зураг 40. 2).



Зураг 40. Бүрэгийн сайрын 1-р суурин. 1 – хутганы хугархай, 2 – үлдэц, 3 – сүх маягийн зэвсэг, 4 – зэвсгийн бэлдэц

Хутганы хугархайн нэг тал нь ялимгүй товгор бөгөөд нөгөөд тал нь тэгш. Ирмэгүүдээс хөндлөн, тууш чиглэлд жижгээр холтчин нарийн хурц ирмэг бэлтгэжээ. Ийм хутга Арц Богдын нуруу орчмын дурсгалуудад нэлээд түгээмэл тааралддаг бөгөөд бүс нутгийн хувьд дээд палеолитын төгсгөл үеэс дунд ба шинэ чулуун зэвсгийн эхэн үед хүртэл

хэрэглэгдэж байжээ. Олон төрлийн зүймэл хутга бий болох хүртэл палеолитын үеийн хянгар зэвсгийн дараа түүний үүргийг гүйцэтгэж байсан багаж хэмээн үзэж болно.

Хүснэгт 6. Бүрэгийн сайрын 1-р суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл

№	Олдворын төрөл	Тоо	Хэмжээ (mm)	Олдворын дугаар
1	Бэлдэц	1	54x33x36	BS-1. 2
2	Үлдэц	2	34x66x39; 24x10x7	BS-1. 1, BS-1. 9
3	Хутганы хугархай	1	36x38x11	BS-1. 3
4	Сүх маягийн зэвсэг	1	62x32x16	BS-1. 5
5	Хутга маягийн зэвсгийн бэлдэц	1	46x43x12	BS-1. 4
6	Зэвсгийн үзүүрийн хугархай	1	41x30x11	BS-1. 6
7	Зэвсгийн бэлдэц	1	45x45x39	BS-1. 7
8	Иртэй залтас	1	78x67x25	BS-1. 8
9	Иртэй ялтас	1	36x10x4	BS-1. 10
10	Ялтасны дээд хэсгийн хугархай	3	Нэг нь том, бусад нь жижиг	BS-1. 13, 11, 12
11	Хоёрдогч залтас	35	Том ба дундаж	BS-1. 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21, 22
14	Хагархай, хэлтэрхий	3	Жижиг	GSN-2024. Survey. Bag-4(1)
Нийт		51		

Сүх маягийн зэвсэг. Зуувандуу хэлбэртэй. Бүх ирмэгээс төв рүү чиглүүлэн холтчин нарийн хурц ирмэг бэлтгэжээ. Ирмэгийг дахин жижгээр ирлэж засаагүй, элэгдсэн ул мөргүй байгаагаас харахад, энэ эдлэлийг гүйцэд засаж ашиглаагүй бололтой. Дутуу зассан бифас маягийн хутга, эсвэл жижиг сүх бололтой (Зураг 40. 3). Неолитын үеийн зүлгэх, хагачин нимгэлэх хоёр аргыг хослуулан хийсэн сүх маягийн зэвсэг Борзонгийн булгуудаас нэлээд хэдийг илрүүлсэн бөгөөд хэмжээгээр энэ эдлэлээс том байдаг билээ.

Мөн эндээс жад, хутга маягийн эдлэлийн хугархай, дутуу зассан зэвсгийн бэлдэц (Зураг 40. 4), иртэй ялтас, залтас зэрэг хоёрдогч боловсруулалтын ул мөртэй бусад төрөл зүйлээс гадна залтас, хагархай, хэлтэрхий зэрэг цуулдасны үйлдвэрлэлийг илэрхийлэх эдлэлүүд ч газрын хөрсөн дээр элбэг тархсан байна.

Олдворын ерөнхий хэв шинж, цуулалтын арга барилд тулгуурлавал энэ дурсгал дээд палеолитын төгсгөл, неолитын эхэн үед хамаарна хэмээн үзэж байна.

Бүрэгийн сайрын 2а дурсгал

Өмнөх дурсгалаас урагш 200 м орчим зайд, хуурай сайрын баруун эргийн лов сондуулын дунд нэлээд нягтаршилтай тархсан чулуун зэвсгийн олдворын бөөгнөрлийг илрүүлэн ийнхүү тэмдэглэж баримтжуулав (Зураг 41). Эндээс 97 чулуун зэвсгийн олдвор

түүвэрлэн цуглуулсан (Хүснэгт 7). Тэдгээр нь бэлдэц, үлдэц, техникийн цуулдас зэрэг анхдагч цуулалтыг илэрхийлэх эдлэл, хутга, иртэй ялтас, хусуур зэрэг хоёрдогч боловсруулалт хийсэн багаж зэвсгийн зүйл, залтас, ялтас, хагархай хэлтэрхий юм.



Зураг 41. Бүрэгийн сайрын 2а дурсгал (зургийг баруу урд талаас)

Бэлдэц. Эхнийх нь богино, өргөн ялтас цуулж авахад зориулагдсан бөгөөд чулууны нэг өргөн талыг хөндлөн хагалан том талбай гаргаад зэрэгцээ цуулалтаар өргөн ялтас цуулж авчээ. Нөгөө талд нь мөн ташуу цуулалт хийсэн оромтой. Дараагийн эдлэлийн арагш налуу нарийн цохилтын талбайг олон холтчин засжээ (Зураг 42. 1). Гурав дахь нь зуувандуу хэлбэртэй, ихэнх хэсэгтээ чулууны өнгөн бүрхүүлээ хадгалжээ. Хэдэн талд нь цуулалт хийж өнгөн бүрхүүлийг нь ховхолжээ. Дөрөв дэх нь шаргалдуу өнгөтэй чүнчигноровоор хийжээ. Хурц ирмэгтэй арагш налуу цохилтын талбай гаргажээ. Хажуу ирмэг, суурийн ар талаас хөндлөн, тууш цуулалт хийж хурц ирмэг бэлтгэжээ. Тав дахь эдлэл нь зууван хэлбэртэй, гадаргуугийн ихэнх хэсэгт өнгөн бүрхүүл хадгалжээ. Нэг нарийн талд цуулалтын гадаргуу гаргажээ. Цуулалтын гадаргуугаас урт залтас салган авсан оромтой. Сүүлийн эдлэл тэгш цохилтын талбайг нямбай холтчин гаргажээ. Хажуу тал, суурийг жижгээр холтчин нямбай засжээ. Зэрэгцээ цуулалтаар ялтас салган авах үлдэц хийхээр зэхжээ.

Үлдэц. Эхнийх нь нямбай холтчин зассан тэгш цохилтын талбайтай. Суурийг мөн адил зассан. Хажуу талын дагууд зэрэгцээ цуулалтаар тэгш хэмт богино ялтас цуулж авсан оромтой. Сууриас мөн цуулалт хийсэн цөөн ором мэдэгдэнэ. Ийм үлдэц неолитын дурсгалуудад таардаг билээ. Дараагийнх нь ялимгүй хотгор цохилтын талбайтай. Хажуу

талын ихэнх хэсэгт цуулалтын гадаргууг бэлтгэж шулуун цуулалт хийх замаар нимгэн, тэгш хэмт ялтас салган авсан зэрэгцээ оромтой.



Зураг 42. Бүрэгийн сайрын 2-р суурин. 1 – бэлдэц, Бүрэгийн сайрын 4-р суурин. 2 – хутганы хугархай, 3 - бэлдэц

Техникийн цуулдас. Эхнийх нь үлдцийн хажууг засах явцад гарсан жижиг ялтас юм. Дараагийнх нь зэрэгцээ цуулалтаар жижиг ялтас цуулж авсан үлдцийн цуулалтын гадаргуугийн хэсэг ажээ.

Хатгуур. Эхнийх нь үлдцийн цохилтын талбайг тайрч авсан техникийн цуулдасны нэг хажуу ирмэгийг томоор холтчин төгсгөлд нь жижиг үзүүр гаргажээ. Дараагийнх нь жижиг залтасны нэг хажуу ирмэгт хурц шовх үзүүр гаргажээ. Энэ ирмэгийн төгсгөлийг нүүрэн талаас нь жижгээр холтчин ирлэжээ.

Хүснэгт 7. Бүрэгийн сайрын 2а суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл

№	Олдворын төрөл	Тоо	Хэмжээ (mm)	Олдворын дугаар
1	Бэлдэц	6	31x50x33; 41x44x18; 25x45x30; 30x52x28; 53x45x29; 32x28x17	BS-2. №1, 2, 3, 4, 5, 6
2	Үлдэц	2	30x26x21; 33x18x16	BS-2. №7, 8
3	Техникийн цуулдас	2	24x7x3; 24x11x7	BS-2. №9, 10
4	Хусуур	3	26x24x9; 26x21x10; 15x15x6	BS-2. №11, 12, 13
5	Хатгуур маягийн зэвсэг	2	19x15x5; 22x16x3	BS-2. №14, 15
6	Иртэй ялтас	1	13x6x1	BS-2. № 16
7	Бүтэн ялтас	4	Том	BS-2. № 17, 18, 19
8	Ялтасны дээд хэсгийн хугархай	5	-	BS-2. № 20, 21, 22, 23, 24
9	Ялтасны дунд хэсгийн хугархай	1	-	BS-2. № 25
10	Ялтасны үзүүрийн хугархай	3	-	BS-2. № 26, 27, 28
11	Анхдагч залтас	14	Том, дундаж	GSN-2024. Survy. Bag-4(2)

12	Залтас	48	Дундаж	GSN-2024. Survey. Bag-4(2)
13	Хагархай, хэлтэрхий	6	-	GSN-2024. Survey. Bag-4(2)
Нийт		97		

Бүх хусуурыг залтсаар хийсэн бөгөөд төгсгөл хөндлөн ирмэгийг босоо холтчин ирлэж бэлтгэжээ. Төгсгөл хусуурын төрөлд хамаарна.

Мөн тэгш хэмтэй жижиг ялтасны дунд хэсгийн хугархайг ирлэжээ. Нэг ирмэгийг нь жижгээр налуулан ирлэжээ. Зүймэл хутганы чулуун ир ажээ.

Хайгуул судалгааны явцад том, дундаж хэмжээтэй анхдагч залтас, цуулалтын оромтой хагархай хэлтэрхий эндээс нэлээд элбэг олдож байсан нь суурин – дархны газрын шинжтэй дурсгал болохыг илтгэнэ.

Чулуун зэвсгийн үйлдвэрлэлийн арга ажиллагаа, хэв шинжид тулгуурлавал дээд палеолитын төгсгөл, голоцены эхэн үед хамаарах дурсгал ажээ.

Бүрэгийн сайрын 2b суурин

Өмнөх дурсгалаас зүүн хойш 130 м зайд сондуулын хоорондох элс нь шуурсан багахан талбайд олон тооны чулуун зэвсгийн олдвор ил гарсан байв. Эндээс 74 чулуун зэвсгийн олдвор түүвэрлэн цуглуулсан (Хүснэгт 8). Тэдгээрийн дотор үлдэц нэг байна. Тэр нь тэгш цохилтын талбайтай, тэгш артай богино үлдэц юм. Цохилтын талбайгаас шулуун цуулалт хийж ялтас авах оролдлого хийсэн оромтой. Үлдцийн ар тал чулууны өнгөн бүрхүүлээ хадгалжээ. Иртэй ялтас нэг буй нь гурван талтай. Доош ялимгүй өргөссөн жижиг ялтасны цохилтын товгор бүхий дээд хэсгийн хугархай юм. Хоёр ирмэгийг нь жижиг холтчин ирлэжээ. Бусад нь ялтас, ялтасны хугархай, залтас, хагархай, хэлтэрхий юм.

Эндээс илрүүлсэн чулуун зэвсгийн олдвор дээд палеолитын төгсгөл үед холбогдоно.

Хүснэгт 8. Бүрэгийн сайрын 2b суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл

№	Олдворын төрөл	Тоо	Хэмжээ (mm)	Олдворын дугаар
1	Үлдэц	1	30x24x21	BS-2a. №1
2	Иртэй ялтас	1	14x9x2	BS-2a. №3
3	Ялтасны дээд хэсгийн хугархай	1	Том, жижиг	BS-2a. №2
4	Ялтасны дунд хэсгийн хугархай	1	Дундаж	BS-2a. №4
5	Ялтасны үзүүрийн хугархай	3	Том, дунд	BS-2a. №6, 7, 8
6	Залтас	52	Том, дундаж, жижиг	GSN-2024. Survey. Bag-4(3)
7	Хагархай, хэлтэрхий	15	Том, жижиг	GSN-2024. Survey. Bag-4(3)
Нийт		74		

Бүрэгийн сайрын 3-р суурин

Худгаас зүүн тийш, загтай элсэн далангийн зүүн этгээдэд оршино. Энд цахиур, хас, манаар хийсэн луун зэвсгийн олдвор сийрэг тархсан байв. Хайгуул судалгааны явцад эндээс олдвор эд өлгийн зүйл түүвэрлээгүй. Газар дээрх олдворын байдлаас үзэхэд, неолитын үед хамаарах магадлалтай.

Бүрэгийн сайрын 4-р суурин

Худгаас урагш сайрын баруун талын дов сондуулын дунд амьтны яс, чулуун зэвсгийн олдворын хамт тархсан дурсгал илрүүлэв (Зураг 43). Бид эндэхийн өнгөн хэсгийн элсийг цэвэрлэж үзсэн боловч давхарга мэдэгдсэнгүй.



Зураг 43. Бүрэгийн сайрын 4-р дурсгал (зургийг баруун хойд талаас)

Хайгуул судалгааны явцад 28 чулуун зэвсгийн олдвор сонголтын зарчмаар түүвэрлэн цуглуулсан (Хүснэгт 8). Тэдгээр нь зуувандуу хэлбэртэй бөгөөд бүх ирмэгээс хөндлөн, тууш цуулалтууд хийж нимгэлэх оролдлого хийж, бифас маягийн зэвсэг хийхээр зэхсэн бэлдэц (Зураг 42. 3), тэгш өнцөгт маягийн хэлбэртэй, хажуу ирмэгээс нь холтчин нимгэлсэн хутга маягийн эдлэл (Зураг 42. 2), иртэй ялтас, ялтасны хугархай зэрэг юм.

Ийм хутганы хугархай Арц Богдын нуруу орчмын дээд палеолитын төгсгөл, голоцены эхэн үеийн дурсгалуудад нэлээд тааралддаг билээ.

Хүснэгт 9. Бүрэгийн сайрын 4-р суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл

№	Олдворын төрөл	Тоо	Хэмжээ (mm)	Олдворын дугаар
1	Бэлдэц	1	82x58x37	BS-4. №1
2	Хутганы хугархай	1	23x29x5	BS-4. №2
3	Иртэй ялтас	1	29x10x2	BS-4. №4
4	Ялтас	1	42x15x4	BS-4. №3
5	Ялтасны дунд хэсгийн хугархай	1	Жижиг	BS-4. №5
6	Залтас	15	Том, жижиг	GSN-2024. Survey. Bag-4(4)
7	Хагархай, хэлтэрхий	8	Дундаж, жижиг	GSN-2024. Survey. Bag-4(4)
Нийт		28		

Бүрэгийн сайрын орчмоос шинээр илрүүлсэн энэ дурсгалд газрын хөрсөн дээр олдвор нэлээд өндөр нягтаршилтай тархсан байна. Харин элсэн хурдасны нөлөөгөөр дурсгал ихэд дарагджээ. Чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл, хийсэн арга барил зэрэгт тулгуурлавал дээд палеолитын дундаас хойш, голоцены эхэн үед хамаарах магадлалтай ажээ. Шавар сав суулганы хагархай хайгуул судалгааны явцад огт олдоогүй нь үүний нэг баталгаа болно.

2.2.12. Эхэн гүний худаг орчимд хийсэн хайгуул судалгаа

Бүрэгийн сайрын өмнө дурдсан дурсгалыг баримтжуулсны дараа төв зам дагаж зүүн урагш чиглэн хөдлөв. 5 км орчим яваад булаг шанд руу хөдөлсөн байж мэдэх малын зөрөг жим элс загтай сайр руу олон чиглэж байсан тул түүнийг дагаж шалгав.

Борзонгийн говийн зүүн хэсэгт халзан загийн хоолой, хар элснээс зүүн тийш сайрын эрэг дээр хуучны эргүүлдэг худаг байсныг газрын зурагт Эхэн гүний худаг хэмээн тэмдэглэжээ. Худгийн зүүн талд баруун хойноос зүүн урагш чиглэсэн өргөн хуурай сайрын зүүн биед сүүл үед нарны толь тавьж байнгын урсацтай худаг гаргасан нь өдгөө эндэхийн мал амьтныг ундаалах усны эх үүсвэр болжээ (Зураг 44).



Зураг 44. Эхэн гүний нарны тольтой худаг орчмын газар (Баруун талаас)

Энэ худгийн баруун талд сайрын дээр хуучны худаг бий. Худаг бүхий сайрын зүүн эргийн элсэн далангийн хооронд эргэдэг хүрдэн дээр хийсэн, шатаалт сайн ваарын хагархай (Зураг 45), цувраа чулуу бүхий байгууламж (Зураг 47) бий. Мөн сайрын эрэг, шавар хөрсөн дээр бий болсон гуу жалгын эргийн дээд хэсгээс ясны хэлтэрхий, ганганы зүүн эргийн амсар дээр төмөр эдлэлийн хэлтэрхий (Зураг 48) мэр сэр тааралдаж байна. Мөн шаварлаг хөрсөн дээр гал түлсэн ором (Зураг 46), нүүрс байна.



Зураг 45. Газрын хөрсөн дээр тархсан ваарын хагархай



Зураг 46. Галын ормын үлдэгдэл

Борзонгийн говийн зүүн этгээдэд, хуучин булаг шандын ойролцоо буй энэ дурсгал анчин, түүвэрлэгчтэй холбоогүй бололтой. Борзонгийн говийн энэ хэсэгт Чингисийн далан хэмээн нэрлэгдсэн эртний хэрмийн нэг хэсэг дайрч өнгөрдөг. Эргэдэг хүрд дээр хийсэн, шатаалт сайн ваар савны хэлтэрхий, төмөр эдлэлийн хэсэг, чулуун байгууламжийн ор үлдэц зэрэг нь Чингисийн далан хэмээн нэрлэгдсэн энэ нүсэр байгууламжийг үлдээгчдийн түүхийн олон асуудлыг тодруулах судалгаанд бага ч атугай хэрэглэгдэхүүн болох болов уу хэмээн найдаж байна. Мөн Борзонгийн говийн хойд хэсгийн Бяруухайн голын саваас илрүүлсэн ваар савны хагархайтай эндэхийн ваар сав нэлээд төстэй байгаа тул нэг цаг үеийнх байх магадлалтай бөгөөд даланг идэвхтэй ашиглаж байх үед тухай бүс нутаг онцгой чухал газар нутаг байсны илрэл байж мэдэх юм.



Зураг 47. Гадаад зохион байгуулалт нь эвдэгдсэн чулуун байгууламж



Зураг 48. Газрын хөрсөн дээр буй эвдэрч бутарсан төмөр эдлэлийн хэлтэрхий

2.2.13. Хөх хошууны орчимд хийсэн хайгуул судалгаа

Бид Борзонгийн говийн зүүн этгээдээс цааш хөдөлж зам дагаж явсаар Бүдүүн модны заставт ирсэн юм. Чухамдаа Шүүлэнгийн засталаас хойш гарч Дэрсэн усны замаар явалгүй зүүн тийш эргэж явбал ганц тод зам хөтөлсөөр Бүдүүн модны заставт хүргэх ажээ. Застав хоорондын энэ замд нутгийн айл тааралдсангүй. Бүдүүн модны засталаас зам заалгаж цааш хөдөлсөн бөгөөд Өндөр Богд уулын баруун талын сайрын эргийн багавтар хадан хөмгийг шалгаж үзэв. Өндөр Богдын баруун талын хойноос урагш чиглэсэн хуурай сайрын эргийн намхан аараг хяраар олон жижиг хонгил, агуй үүсжээ.



Зураг 49. Өндөр Богдын баруун талаас илрүүлсэн шар хасын орд

Бид хайгуул судалгааны явцад зарим газарт зогсож эдгээр хонгил, агуйг шалгасан бөгөөд чулуун зэвсэг хийх түүхий эд шаргал өнгөтэй хасын судал боржин хадан тогтцод үелэн бий болжээ. Тиймээс цөөн дээж цуглуулж баримтжуулаад (Зураг 49) цааш хөдлөв.

Цааш Өмнөговь аймгийн Баян-Овоо сумыг чиглэн явахад сумын төвөөс баруун урагш 27 км зайд хөндөлсөн тогтсон өндөр хар уулыг нутгийн олон Хөх хошуу хэмээн нэрийдэх ажээ. Хөх хошууны баруун биед байх дов сондуултай нарийн хоолойд хайгуул хийхэд чулуун зэвсгийн олдвор 1 олдвор (Зураг 50). Харин бөсөл хэмээх чулуулаг олон байна.



Зураг 50. Хөх хошуунаас илрүүлсэн бөсөл чулуугаар хийсэн зузаан залтас

Бид Тамсагбулагийн дурсгалт газар өмнө нь хийсэн малтлагаар энэ төрлийн материалаар хийсэн чулуун зэвсгийн олдвор, тэр дундаа Тамсаг хэлбэрийн хусуур нэлээд олон олдсон юм. Тиймээс бид түүхий эд бүхий энэ газрыг тэмдэглэж авав. Нутгийн иргэдийн мэдээллээр Хөх хошууны зүүн биед овоотой хөтөл дээр хадны зураг байдаг ажээ. Гэвч цаг хугацааны боломжоос шалтгаалан энэ зургийг үзэж буулгаж чадсангүй.

Номгон сумын өмнөд нутаг улсын хилийн дагуу хийсэн гүймэг хайгуулын үр дүнд тулгуурлан Ханбогд сумын урд хилийн дагууд буюу Галбын говийн өмнөд хэсгээр чулуун зэвсэг хийх түүхий эд, булаг шанд бүхий газарт хайгуул судалгааг үргэлжлүүлэх, эсэхийг шийдвэрлэхээр төлөвлөсөн байв. Гэвч бид Борзонгийн говиос урагш улсын хилийн шугам хүртэлх зурвас газар нутгаас томоохон дурсгал илрүүлж чадаагүй тул дараагийн хайгуулыг нутгийн гүнд үргэлжлүүлэхээр шийдвэрлэсэн юм. Үүнд мөн өмнө нь Ханбогд сумын нутаг дэвсгэрт олон жил хийсэн авран хамгаалах судалгааны явцад анчин, түүвэрлэгчдийн томоохон дурсгал олдоогүй, их төлөв эртний хэв шинжтэй палеолитын дурсгалт газар энэ бүс нутгийн чулуун зэвсгийн үеийг төлөөлж байсан нь ч нөлөөлсөн юм. Тиймээс бид хайгуул судалгааг өмнө нь чулуун зэвсгийн олдвортой хэмээн тэмдэглэгдсэн Говийн төхөм, түүний ойр орчмын нутаг дэвсгэрт үргэлжлүүлэн гүйцэтгэсэн.

2.2.14. Говийн төхөмийн чулуун зэвсгийн дурсгалт газарт хийсэн хайгуул судалгаа

Говь нутгийн зон олон эрт дээрээс өргөн хөндий газарт хошуурч ургасан далан бүхий заган ойг төхөм хэмээн нэрийдсээр иржээ. Тиймээс говийн бүс нутагт элс, загтай газарт “Төхөм” хэмээх нэр олон тохиолддог. Үүний нэг нь Өмнөговь аймгийн Манлай сумын нутаг Говийн төхөм юм (Зураг 51).

Нэрт археологич Х.Пэрлээ абугай Өмнөговь аймгийн Манлай сумын нутаг Говийн Төхөм гэдэг газар зэсийн хүдэр хайлуулж байсан бууц, зэс хайлуулалтын зуух олж малтан шинжилсэн юм. Энд зэсийн хүдрийн шаар, хайлш, хүдэр овоолсон хэд хэдэн овоолго байсны зөвхөн нэг нь 16 х 12 м талбай эзэлсэн 80-90 см өндөр байжээ. Х.Пэрлээ энд урт нь 3.5 м, өргөн нь нэг талдаа 1.6, нөгөө талдаа 1 м хэмжээтэй зэс хайлуулах асар том зуухны ор мөрийг судалж, зуух нэгэнт нурсан боловч 40 м² эзлэхүүнтэй байсан³⁸ тухай өгүүлсэн байдаг. Хэдийгээр Аргалантын уулаас урагш орших өргөн хотос хөндийд буй загтай далан газрын тогтцын хувьд Х.Пэрлээ абугайн тодорхойлолттой тохирох боловч зэсийн шаар, хүдэр тархсан газрын хувьд төдийлөн тохирохгүй байна.

Хожим Монгол-Японы хамтарсан “Төмөрлөгийн түүх” судлах судалгааны баг говийн төхөмд ирж, замын хойд талд зэсийн баас хамгийн их тархсан хэсэгт жижиг хэмжээтэй малтлага хийсэн ором нь өдгөө тод мэдэгдэж байна.

Бид хайгуул судалгааг загийн баруун хаяанаас буюу өнгөн хэсгийн элс нь салхинд хийсэж нарийн ширхэгтэй хатуу шаварлаг хөрс гарч ирсэн хэсгээс эхлэн гүйцэтгэв.

Газрын өнгөн хөрсөн дээр нэлээд хэдэн газарт чулуун зэвсгийн бөөгнөрөл ажиглагдсан бөгөөд бид дээж болгон зарим олдворыг түүвэрлэн цуглуулав.



Зураг 51. Говийн төхөм (Хойд талаас)

³⁸ Х.Пэрлээ. Монголын нүүдэлчдийн металлурги боловсруулалтын түүхийн асуудалд // Studia Archaeologica. Tom. X, fasc. 4. УБ:, 1982. тал. 48-73

Говийн төхөмийн 1-р суурин

Загтай элсэн далангийн баруун хаяанд, авто замын дэргэд энэ дурсгал оршино. Газрын өнгөн хэсгийн элс салхинд хийсэж доороос нь нарийн ширхэгтэй хатуу шаварлаг хөрс ил гарсан байх агаад энд цахиур, мана, хас зэрэг олон төрлийн материалаар хийсэн чулуун зэвсгийн зүйл ил гарсан байна (Зураг 52).

Мөн түүнчлэн гал голомтын ул мөр хэд хэдэн газарт шаварлаг хөрсөн дээр мэдэгдэж байна. харин ваарын хагархай тун цөөн байгаа нь эрт үед холбогдох дурсгал болохыг илтгэх ажээ.



Зураг 52. Говийн төхөмийн 1-р суурин (зургийг хойд талаас)

Эндээс 66 чулуун зэвсгийн олдвор, шавар ваарын хагархай 1-ийг түүвэрлэн цуглуулсан. Тэдгээр нь техникийн цуулдас, хутга, хусуур, ялтас, залтас, хагархай, хэлтэрхий ажээ.

Техникийн цуулдас нь өндөр хамартай зузаан ялтас бөгөөд нэг ирмэгийн дундаас дооших хэсгийн босоо холточсон оромтой (Зураг 53. 1).


Хутганы эхнийх нь нэг урт ирмэгийг хоёр талаас хөндлөн холтчин нимгэлээд торгон ирмэгийг нь ирлэн долгио хурц ир бий болгожээ (Зураг 53. 2). Нөгөөх нь хоёр талаас засаж нимгэлсэн хутганы үзүүрийн хугархай юм. Ийм эдлэл Арц Богдын нурууны өвөр биеийн голоцны эрт үеийн дурсгалуудад элбэг тааралддаг.

Хүснэгт 10. Говийн төхөмийн 1-р суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл

№	Олдворын төрөл	Тоо	Хэмжээ (mm)	Олдворын дугаар
1	Техникийн цуулдас	1	77x30x18	G.T-1. №1

2	Хутга	2	56x30x14; 33x27x10	G.T-1. №2, 3
3	Хусуур	2	Жижиг	G.T-1. №4, 5
4	Ялтасны дээд хэсгийн хугархай	3	Том, дундаж, жижиг	G.T-1. №6, 7, 8, 9
5	Ялтасны үзүүрийн хугархай	1	Жижиг	G.T-1. №10
6	Залтас	40	Том, дундаж, жижиг	GSN-2024. Survey. Bag-6(1)
7	Хагархай, хэлтэрхий	17		GSN-2024. Survey. Bag-6(1)
8	Ваарын хагархай	1	Хэлтэрхий	GSN-2024. Survey. Bag-6(1)
Нийт		67		

Хусуурыг Гадаргуудаа чулууны өнгөн бүрхүүлээ хадгалсан залтсаар хийжээ. Нэг нь хажуу, төгсгөлийн хөндлөн ирмэгийн уулзах буланг, нөгөөх нь жижиг дугуй залтасны бүх ирмэгийг тойруулан ирлэсэн хусуур ажээ.



Зураг 53. Говийн төхөмийн 1-р суурин. 1 – Ирлэсэн техникийн цуулдас, 2 – хутга маягийн эдлэл

Ваарын хагархай бүдүүн ширхэгтэй чулууны орцтой шавраар хийсэн 8 мм зузаан ханын хэлтэрхий юм. Гадар нь улбар бөгөөд дотор нь ис тогтсон бүдэг оромтой. Хүрлийн үед хамаарах бололтой.

Неолитын ваар савны зүйл байхгүйн дээр олдворын ерөнхий хэв шинжид тулгуурлавал, дээд палеолитын төгсгөл үед хамааруулан үзэх боломжтой юм.

Говийн төхөмийн 2-р суурин

Өмнөх дурсгалаас зүүн тийш 360 м орчим зайд бий. Загтай далан дотроос элсэн дээр ил гарсан цөөн тооны чулуун зэвсгийн олдвор илрүүлсэн (Хүснэгт 10).

Хүснэгт 11. Говийн төхөмийн 2-р суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл

№	Олдворын төрөл	Тоо	Хэмжээ (mm)	Олдворын дугаар
1	Цуулалттай түүхий эд	1	Том	G.T-2. №1
2	Хэлтэрхий	5	Жижиг	GSN-2024. Survey. Bag-6(2)
3	Ваарын хагархай	1	Хэлтэрхий	GSN-2024. Survey. Bag-6(2)
Нийт		7		

Эндээс илрүүлсэн олдвор нь цуулалттай түүхий эд, жижиг хэлтэрхий, хүрлийн үеийн ваарын хагархай хэмээн ангилагдана.

Говийн төхөмийн 3, 4-р суурин

Өмнөх дурсгалуудаас урагш, загтай далангийн баруун талын шаварлаг хөрсөн дээрээс гадаргуудаа цуулалтын оромтой түүхий эд, хагархай хэлтэрхий хөрсөн дээр нэлээд шигүү тархсан дурсгал илрүүлэв. Хайгуул судалгааны явцад эндээс 50 чулуун зэвсгийн олдвор түүвэрлэн цуглуулсан нь бэлдэц, үлдэц, шүдлэг иртэй зэвсэг, иртэй залтас, иртэй хагархай, ялтас, залтас, хагархай ажээ (Хүснэгт 11).


Хүснэгт 12. Говийн төхөмийн 3-р суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл

№	Олдворын төрөл	Тоо	Хэмжээ (mm)	Олдворын дугаар
1	Бэлдэц	1	51x32x26	G.T-3. №1
2	Шаантган үлдэц	3	32x14x14; 34x14x14; 32x17x16; 46x27x16	G.T-3. №2, 3, 4, 5
3	Шүдлэг ирт зэвсэг	1	19x31x8	G.T-3. №7
4	Иртэй залтас	1	56x53x7	G.T-3. №6
5	Иртэй хагархай	1	44x28x16	G.T-3. №8
6	Бүтэн ялтас	1	45x18x4	GSN-2024. Survey. Bag-6(3)
7	Залтас	19	Том, дундаж, жижиг	GSN-2024. Survey. Bag-6(3)
8	Хагархай, хэлтэрхий	23	Том, дундаж, жижиг	GSN-2024. Survey. Bag-6(3)
Тоо		50		

Бэлдэц. Зуувандуу хэлбэртэй бөгөөд нэг хажуу ирмэг, суурийг хоёр талаас нь холтчин ирмэг бэлтгэжээ. Цохилтын талбай, цуулалтын гадаргууг бэлтгэлгүй орхижээ.

Үлдэц. Нарийн цохилтын талбайтай бөгөөд нэг ирмэгийг сууринд суулгахад зориулж хөндлөн холтчин засжээ. Нөгөө хажуу дээр зэрэгцээ цуулалтаар тэгш хэмт бичил ялтас цуулж авсан олон зэрэгцээ оромтой (Зураг 54. 1). Дараагийнх нь суурь, нэг хажууг ирмэг

гарган засжээ. Хагас дугуй хэлбэртэй цохилтын талбайг ихэд нямбай холтчин засжээ. Нэг хажуу, өргөн талын зарим хэсэгт цуулалтын гадаргуу бэлтгэж зэрэгцээ цуулалтаар бичил ялтас цуулж авсан олон зэрэгцээ оромтой. Ялимгүй хотгор, дугуй цохилтын талбайг нямбай засжээ. Суурь, нэг хажууг жижгээр хэлтчин ирмэг гарган засжээ. Зэрэгцээ цуулалтаар тэгш хэмт бичил ялтас авсан оромтой (Зураг 54. 3). Сүүлийн үлдэц нь суурь, нэг хажуугийн зарим хэсгийг ирмэг гарган зассан, нэлээд том хэмжээтэй. Нарийн цохилтын талбайг холтчин засжээ. Үлдцийн хажуу талуудыг тойруулан цуулалтын гадаргуу бэлтгэж олон жижиг ялтас цуулж авсан оромтой (Зураг 54. 2).



Зураг 54. Говийн төхөмийн 3-р суурин. 1, 2, 3 – үлдэц;
Говийн төхөмийн 5-р суурин. 4 – хутганы хугархай

Шүдлэг ирт зэвсэг. Залтасны төгсгөлийн урт ирмэгт ялимгүй мохоодуу жижиг үзүүр гаргаж хоёр талд нь хүнхэр ир бэлтгэжээ. Мөн залтас, цуулалтын оромтой хагархай зэргийг ирлэн засаж багаж зэвсэг болгон ашиглаж байжээ.

Эндээс баруун тийш 25 м зайд дараагийн чулуун зэвсгийн бөөгнөрөл илрүүлснийг бид Гөвийн төхөм 4 хэмээн баримтжуулсан билээ. Эндээс 33 чулуун зэвсгийн олдвор сонголтын зарчмаар түүвэрлэсэн (Хүснэгт 12).

Хүснэгт 13. Гөвийн төхөмийн 4-р суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл

№	Олдворын төрөл	Тоо	Хэмжээ (mm)	Олдворын дугаар
1	Иртэй ялтас	1	13x7x2	GSN-2024. Survey. Bag-6(4)
2	Ялтасны дээд хэсэг	2	Жижиг	GSN-2024. Survey. Bag-6(4)
3	Ялтасны дунд хэсгийн хугархай	4	Жижиг	GSN-2024. Survey. Bag-6(4)
4	Залтас	16	Дундаж, жижиг	GSN-2024. Survey. Bag-6(4)
5	Хагархай, хэлтэрхий	10	Том, жижиг	GSN-2024. Survey. Bag-6(4)
Нийт		33		

Энэ дурсгалаас шавар сав суулганы зүйл олдсонгүй. Үлдцийн олонх нь ирмэглэн суулгаж ялтас цуулах шаантган хэв шинжтэй ажээ. Тиймээс бид энэ дурсгалыг дээд палеолитын төгсгөл, голоцны эхэн үед холбогдоно хэмээн үзэж байна.

Гөвийн төхөмийн 5-р суурин

Өмнөх дурсгалаас ялимгүй баруун урагш 100 м гаруй зайд гадаргын элс зөөгдсөн шаварлаг хөрсөн дээр бөөгнөрсөн чулуун зэвсгийн олдворыг илрүүлж ийнхүү дугаарлаж баримтжуулав. Эндээс 79 чулуун зэвсгийн олдвор, тэмээн хяруулын өндөгний хальсны хэлтэрхий 1-ийг илрүүлж түүвэрлэсэн (Хүснэгт 13).

Хүснэгт 14. Гөвийн төхөмийн 5-р суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл

№	Олдворын төрөл	Тоо	Хэмжээ (mm)	Олдворын дугаар
1	Бэлдэц	1	27x37x20	G.T-5. №1
2	Шанатган үлдэц	2	36x29x14; 31x33x14	G.T-5. №2, 3
3	Техникийн цуулдас	1	37x13x8	G.T-5. №5
4	Хутганы хугархай	1	40x27x6	G.T-5. №4
5	Бүтэн ялтас	1	98x43x15	G.T-5. №8
6	Ялтасны дунд хэсгийн хугархай	1	48x22x9	G.T-5. №9, 10, 11
7	Ялтасны үзүүрийн хугархай	3	Жижиг	GSN-2024. Survey. Bag-7(1)
8	Залтас	46	Том, дундаж, жижиг	GSN-2024. Survey. Bag-7(1)
9	Хагархай, хэлтэрхий	23	Том, дунд, жижиг	GSN-2024. Survey. Bag-7(1)
10	Тэмээн хяруулын өндөгний хальс	1	29x23x20	GSN-2024. Survey. Bag-7(1)
Нийт		80		

Бэлдэц. Нарийн, өргөн цохилтын талбайтай бөгөөд суурь, нэг хажууг ирмэг гарган засжээ. Ар, өвөр талын өргөн гадаргуу, нэг хажууд жижиг залтас цуулсан оромтой.



Зураг 55. Говийн төхөмийн 5-р суурин. 1 – шаантган үлдэц, 2 – урт ялтас

Шаантган үлдэц. Эхнийх нь гурвалжиндуу хэлбэртэй. Нэг хажуу ирмэгийг сууринаас нь холтчин ирмэг гарган зассан бол нөгөө хажууд цуулалтын гадаргууг бэлтгэж тэгш хэмтэй нимгэн ялтас цуулсан зэрэгцээ ором үлджээ. Нэг өргөн талд ч бас ялтас салган авсан ором байна (Зураг 55. 1). Ар тал руугаа ялимгүй налуу урт цохилтын талбайг нямбай холтчин засжээ. Дараагийнх нь суурь, хажуу ирмэгийг нь холтчин зассан, урт цохилтын талбайтай үлдэц юм. Нэг хажууг дагуулан ялтас цуулах оролдлого хийсэн оромтой.

Хоёрдогч боловсруулалт хийсэн багаж зэвсгийн зүйл цөөн боловч бий. Тэдгээрийн дотор хоёр талаас нь холтчин нимгэлсэн бифасан хутга (Зураг 54. 4) сонирхолтой бөгөөд Арц Богдын нурууны өвөр хэсгийн дурсгалуудад нэлээд тааралддаг билээ. Бөмбөгөр талбайгаас цуулж авсан том ялтас (Зураг 55. 2), хутга маягийн зэвсэг, олон тооны шаантган үлдэц зэрэгт тулгуурлавал, энэ дурсгал дээд палеолитын төгсгөл, голоцены эхэн үе хамаарах магадлалтай байна.

Говийн төхөмийн 7-р суурин

Загтай далангийн баруун өмнөд хэсгийн сондуулын хоорондох чулуун зэвсгийн олдворын бөөгнөрөл бүхий хэсэг юм (Зураг 56). Эндээс 5 чулуун зэвсгийн олдвор цуглуулсан нь нэлээд том хэмжээтэй хосолмол зэвсэг, залтас, хагархай (Хүснэгт 14) юм.



Зураг 56. Говийн төхөмийн 7-р суурин (зургийг хойд талаас)

Хүснэгт 15. Говийн төхөмийн 7-р суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл

№	Олдворын төрөл	Тоо	Хэмжээ (mm)	Олдворын дугаар
1	Хосолмол зэвсэг	1	92x84x30	G.T-7. №1
2	Залтас	1	Жижиг	G.T-7. №2
3	Хагархай	3	Дундаж, жижиг	G.T-7. №3, 4, 5
Нийт		5		

Говийн төхөмийн 8-р суурин

Заган даланг хөндлөн гатлах авто замын хойд талд, элсэн далангийн баруун биеийн явган загтай шаварлаг хөрстэй газарт дээд палеолитын хожуу үеийн арга ажиллагааг илтгэх ялтас, үлдэц, бифасны бэлдэц (Зураг 58. 2) хянгар зэвсэг хөрсөн дээрээс цөөн боловч олдох бөгөөд зэсийн хүдэр хайлуулж байсан ор улбаа зэсийн баас олон тааралдаж байна. Мөн нэг доор овоорсон байдалтай зэсийн хайлшны үлдэгдэл буй нь ямартай ч зэсийн хүдэр боловсруулж байсны ул мөр ажээ (Зураг 57).



Зураг 57. Говийн төхөмийн 8-р суурин ба зэсийн баасын үлдэгдэл (зургийг баруун урд талаас)

Говийн төхөмийн чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл нэлээд эртний хэв шинжтэй байна. Анчин – түүвэрлэгчид дээд палеолитын төгсгөл үеэс жижиг болон бичил ялтсан зэвсгийг өргөн ашиглах болсон юм.



Зураг 58. Говийн төхөмийн 7-р суурин. 1 – хосолмол зэвсэг; Говийн төхөмийн 8-р суурин. 2 – бифасны хугархай

Ялтас цуулахад шаантган хэв шинжийн үлдцийг сууринд суулгаж зэрэгцээ цуулалтаар ялтас салган авч байжээ. Дээд палеолитын төгсгөл, голоцены эрт үеийн шаантган үлдэц нэлээд том хэмжээтэй байдаг онцлогтой. Говийн төхөмийн дурсгалд ч энэ байдал ажиглагдав. Мөн хоёр талаас нь нимгэлж зассан бифас маягийн зэвсэг олон тааралдаж байна. Палеолитын үеийн туршид өргөн хэрэглэгдэж байсан хянгар зэвсгийг ийм хутга маягийн эдлэл орлох болсон бөгөөд Арц Богдын нурууны өвөр хоолойн дурсгалуудад элбэг тааралддаг. Харин неолитын дунд, хожуу үеийн дурсгалуудад ийм төрлийн зэвсэг байдаггүй. Бифасан хутга маягийн зэвсэг цаашид олон төрлийн зүймэл зэвсгээр солигдсон хэмээн үзэж болно.

Говийн төхөмийн дурсгалыг эрт үед холбон үзэх өөр нэг шижим бол эндээс неолитын дунд, төгсгөл үед өргөн хэрэглэгдэх болсон сийлүүр, хатгуур зэрэг багаж алга. Мөн шавар

ваар савны зүйл нэн цөөн, байгаа зарим нэг нь чулуун зэвсэгтэй хамааралгүй хожуу үеийнх бололтой.

Говийн төхөм орчимд хийсэн хайгуул судалгааны үр дүнд энд буй зэсийн хүдэр хайлуулж, боловсруулж байсан ул мөр эндэхийн чулуун зэвсгийн олдвортой хамааралгүй хэмээн үзэж байна. Чулуун зэвсгийн олдвор нь үйлдвэрлэлийн арга барил, төрөл зүйн бүрдлээрээ дээд палеолитын төгсгөл, голоцены эхэн үеийг илэрхийлж байна.

Говийн төхөмөөс цааш Аргалантын уулыг чиглэн хөдлөхөд жалгын дунд хайлаас мод нэлээд шигүү ургасан хайлаасан төгөл харагдсан бөгөөд булаг шандын ор үлдэц байж магадгүй хэмээн шалгаж үзсэн юм. Гэвч булаг шандын ор үлдэц мэдэгдээгүй бөгөөд усны түр урсгал хуурай сайрын дагууд цуварч ургасан хайлаас ажээ (Зураг 59).

Бид сайрын эргийн дагууд хайгуул хийхэд энд чулуун зэвсэг хийх хатуулаг сайн түүхий эд нэлээд тааралдаж байв. Иймд бид дээж болгон цөөнийг авав. Тухайн газрын солбицлыг тогтоож, гэрэл зураг авч баримтжуулаад цааш хөдлөв



Зураг 59а. Говийн төхөмийн зүүн талын түүхий эдтэй газар

2.2.15. Булаг шавагтайн орчимд хийсэн хайгуул судалгаа

Өмнөговь аймгийн Манлай сумын зүүн өмнөд нутаг Аргалантын уулын баруун хойд биеэс буусан өргөн хуурай сайраас ундрах булгийг нутгийн олон ийнхүү нэрийдэх ажээ.

Сайран дээр гаргасан худгийн зүүн урд талын дов сондуулын дундах багавтар талбайд чулуун зэвсгийн олдвор сийрэг тархсан байв. Тэдгээр нь цуулалтын оромтой түүхий

эд, үлдэц, техникийн цуулдас, хусуур, шүдлэг хүнхэр ирт зэвсэг, хүнхэр ирт зэвсэг, залтас, хагархай, хэлтэрхий (Хүснэгт 15) юм.

Хүснэгт 16. Булаг шавагтайгаас илрүүлсэн чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл

№	Олдворын төрөл	Тоо	Хэмжээ (mm)	Олдворын дугаар
1	Цуулалттай түүхий эд	1	51x35x17	B.Sh-1. №1
2	Үлдэц	2	34x56x38; 53x43x24	B.Sh-1. №2, 3
3	Техникийн цуулдас	1	44x26x9	B.Sh-1. №7
4	Хусуур	1	36x25x7	B.Sh-1. №4
5	Шүдлэг, хүнхэр ирт зэвсэг	1	34x27x10	B.Sh-1. №5
6	Хүнхэр ирт зэвсэг	1	57x42x13	B.Sh-1. №6
7	Залтас	6	Дундаж, жижиг	GSN-2024. Survay. Bag-5(4)
8	Хагархай, хэлтэрхий	2	Дундаж, жижиг	GSN-2024. Survay. Bag-5(4)
Нийт		15		

Эхний үлдэц нь зуувандуу хэлбэртэй нэлээд том цохилтын талбайг зах ирмэгээс нь төв рүү чиглүүлэн холтчин зассан оромтой. Суурь нь ялимгүй шовх бөгөөд нүүр, ар талын өргөн гадаргуу, хажуу талд цохилтын талбайгаас суурь руу чиглүүлэн цуулалт хийсэн оромтой (Зураг 60. 1). Дараагийнх нь цохилтын талбай, нэг талын зузаан хажуу, ар талын ихэнх хэсэг чулууны өнгөн бүрхүүлээ хадгалжээ. Нэг хажуу ирмэг, суурийг засаж хөндлөн цуулалтууд хийсэн оромтой. Нүүрэн талд нь цуулалт хийж өргөн ялтас салган авсан оромтой (Зураг 60. 2).



Зураг 596. Булаг шавагтайн дурсгал (зургийг зүүн талаас)

Хусуурыг зууван хэлбэртэй залтасны нэг хажуугийн шулуун ирмэг, төгсгөлийн дугуйрсан ирмэгийг босоо холтчин нямбай ирлэж бэлтгэжээ (Зураг 60. 3).

Шүдлэг хүнхэр ирт зэвсгийг дундаж хэмжээтэй залтсаар хийжээ. Залтасны нэг богино ирмэгийг нүүрэн талаас ялимгүй дотогш хotoйлгон налуу хайрслал ирээр нямбай

ирлэжээ. Харин урт ирмэгт дундаа хурц үзүүрээр зааглагдсан хүнхэр ирмэг гаргаж бэлтгэжээ

Хүнхэр ирт зэвсгийг том залтасны нэг урт ирмэгийн дээд хэсэгт нүүрэн талаас нь босоо холтчин хүнхэр ирмэг бэлтгэжээ. Саваа мод, нарийн яс зэргийг зүлгэх зориулалттай хүнхэр ирт зэвсэг ажээ.



Зураг 60. Булаг шавагтайн 1-р суурин. 1, 2 – үлдэц, 3 - хусуур

Эндээс баруун урагш нэлээд зайтай газраас өөр хоёр залтас илрүүлсэн нь мөн дундаж хэмжээтэй бөгөөд гадаргуудаа өмнөх цуулалтын ормыг хадгалжээ.

Булаг шавагтайгаас илрүүлсэн чулуун зэвсгийн олдвор хэдийгээр цөөн, анхдагч цуулалтыг илэрхийлэх эдлэлийн төрөл хязгаарлагдмал хэдий ч бид тухайн бүс нутгийн нэгэн адил дээд палеолитын төгсгөл, голоцены эрт үед хамаарна хэмээн үзэж байна.

2.2.16. Тэнгэр тойромын орчимд хийсэн хайгуул судалгаа

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын өмнөд нутаг, Монгол Улсын хилийн бүс, Хэцүү уулын засталаас зүүн тийших өргөн хотос хөндийг Тэнгэр тойром хэмээдэг. Нутгийн зон олон Тэнгэр нуур хэмээн нэрлэдэг агаад хотгор хөндий газар юм. Энд хоорондоо зайтай орших олон нуурын сав буй нь өөр өөр урсгалаар тэжээгддэг ажээ. Эдгээр нуурын сав борооны усаар тэжээгдэж тогтоол нууруудыг үүсгэдэг (Зураг 61).



Зураг 61 Тэнгэр тойромын баруун хойд биеийн нуур (зургийг хойд талаас)

Плейстоцены төгсгөл, голоцены эхэн үед энэ газар нутаг нуур усаар элбэг газар нутаг байсан бололтой. Ар талаараа хөндөлссөн намхан хяр, нөмөр газар олонтой. Мөн хулан, зээр, үнэг, туулай зэрэг зэрлэг амьтад хэдий гантай зун ч бидэнтэй олон тааралдав. Түүнчлэн, Ханбогд, Хатанбулагийн залгаа энэ газарт малчин айлууд олноор зусаж байгаа нь өдгөө ч хүн амьдрах таатай орчин нөхцөлтэй газар гэдгийг илтгэнэ.

Тухайн газар нутаг бол өмнө археологийн чухал дурсгалаар олонд нэгэнт танил болсон билээ. Монгол Улсын хилийн Хэцүү уулын заставын арын агуйд 0-10-аад насны долоон хүүхэд, 30 гаруй насны хоёр эрэгтэй, хоёр эмэгтэй, 60 гаруй настай нэг, нийт 12 хүний шарил байна. Шарилуудын шүд хумс бүтэн, гээг үс, арьстайгаа хатаж үлдсэн, нэг нь арьсан өлгийд боосон хүүхдээ тэвэрсэн байдалтай нас барсан байжээ³⁹. Хожим эдгээр хатмал хүүрийг ШУА-ийн Археологийн хүрээлэнд авчирчээ⁴⁰. Тухайн цаг үедээ оргож дайжиж явсан хүмүүс Хэцүү уулын ээлүүд буйдад буй агуйд нуугдан хоргодож байгаад цаашид амь хоргодох аргагүй болсон үед нэгнээ хөнөөж сүйдсэн байж магадгүй хэмээн таамагладаг. Харин орчны бүсэд нь хайгуул судалгаа хийсэн мэдээ баримт энэ хир үгүй юм. Тиймээс эртний нуурын том хотос энэ газрын хэдэн цэгт хайгуул судалгаа хийхээр төлөвлөсөн.

Биднийг тухайн газарт хайгуул судалгаа хийхэд гандуу, аагим халуун байсан боловч хэд хоногийн өмнө багахан бороо орж тойрмын баруун хойд хэсэгт орших савд нуур үүсгэжээ.

Нуурын хойд талын баруунаас зүүн тийш үргэлжилсэн намхан хяр, түүний энгэр бэл, зүүн талын тэгш газарт явган хайгуул хийхэд анчин, түүвэрлэгчдийн бууц суурин олдсонгүй.

Харин нуурын арын намхан дэнжийн орой дээр дундаж хэмжээтэй чулуугаар хүрээлсэн цагариг хэлбэрийн дараастай зэрэгцээ хоёр байгууламж байна (Зураг 62). Тэдгээр нь 200 – 210 см голчтой, дараасны төв хэсэгтээ чулуугүй ажээ. Он цаг, үүрэг, зориулалт төдийлөн тодорхойгүй ч байршил зүйн хувьд Монгол булш байх магадлалтай байна.

³⁹ Н.Сэр-Оджав. Дорноговь аймагт мэдээ шалгах ажлаар явсан тухай. Хархорум шинжилгээний ангийн 1981-1982 оны ажлын тайлан. УБ., 1982. АХГБСХ. тал. 36-43.

⁴⁰ Н.Батболд, Ц.Амгалантөгс, Б.Эрдэнэ. Дорноговь аймгийн Хэцүү уулын агуйгаас илэрсэн хүний ясны олдворууд // Studia Archaeologica. Tom. XXXIV, fasc. 26. УБ., 2014. тал. 323-327



Зураг 62. Тэнгэр тойрмын баруун хойд биеэс илрүүлсэн чулуун байгууламж
(зургийг баруун урд талаас)

2.2.17. Цахиурт толгойн дурсгал

Тэнгэр тойрмын өмнөд хэсэгт, улсын хилээс 10 км орчим зайд байх тэр хавьдаа харууц сайн өндөр толгойг нутгийн олон Цахиурт толгой хэмээдэг (Зураг 63). Тэнгэр тойрмын орчимд газрын зурагт энэ толгой хамгийн өндөр агаад нэр нь археологийн дурсгал, тэр дундаа чулуун зэвсгийн бууц суурин байх магадлалтай байв.



Зураг 63. Цахиурт толгой (зургийг зүүн урд талаас)

Нутгийн зарим хүмүүс Цахиурт толгойгоос зүүн тийш буй бүйлстэй тойрмыг Тэнгэр тойром хэмээн нэрлэх явдал байдаг ч газрын зурагт Тэнгэр нуур гэж ихэд том газар нутгийг

хамруулан тэмдэглэсэн байдаг. Цахиурт овоо баруунаас зүүн тийш сунаж тогтсон намхан хярын төгсгөлд зүүн тийш дугшиж тогтсон нэлээд өндөр ажээ. Хярын төгсгөл буюу Цахиурт нь хоорондоо нам ониор зааглагдсан гурван толгойгоос бүрдэх ажээ (Зураг 64).

Цахиурт толгой тэр хавьдаа ноёлог өндөр, зүүн, өмнөд талдаа том хөндийтэйн дээр толгойн эргэн тойрон цайвар, шаргал, хүрэндүү өнгөтэй цахиурын төрлийн материалаар нэлдээ хучигджээ. Өөрөөр хэлбэл, Цахиурт толгой хэмээх энэ газар тухайн орчиндоо чулуун зэвсэг хийх хамгийн сайн чанартай материалыг агуулсан байна.



Зураг 64. Цахиурт толгой (Баруун хойд талаас)

Тийм ч учраас толгойн эргэн тойронд эртний хүмүүс чулуун багаж зэвсгээ хийж байсан гэрч баримт болсон арвин баялаг хэрэглэгдэхүүн хадгалагдаж үлджээ (Зураг 65).



Зураг 65. Цахиурт овооны эргэн тойрон дахь түүхий эд ба чулуун зэвсэг

Цахиурт толгойн 1-р суурин

Цахиурт овооны гол өндрийн арын үргэлжилсэн намхан дэнжийн хажуу, оройгоор чулуун зэвсэг хийх түүхий эд цахиур, шар хасын гарш элбэг ажээ (Зураг 66). Энд хагачиж цуулсан олдвор олон тааралдах хэдий ч бид цөөн хэдийг дээжлэн цуглуулсан юм (Хүснэгт 16).



Зураг 66. Цахиурт овооны 1-р дурсгал (зургийг баруун урд талаас)

Эндээс цуглуулсан чулуун зэвсгийн олонх ямар нэг хоёрдогч боловсруулалт хийгээгүй хагархай, хэлтэрхий залтас юм. Ирлэсэн залтас 2 байгаагийн эхнийх жижиг дугуй хэлбэртэй бөгөөд нэг хажуугийн буланг нүүрэн талаас босоо холтчин ирлэжээ. Дараагийнх нь нэлээд зузаан залтас юм. Түүний нэг ирмэгийг ар талаас жижгээр, нөгөө ирмэгийг нүүрэн талаас нь ирлэжээ.

Хүснэгт 17. Цахиурт овооны 1а суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл

№	Олдворын төрөл	Тоо	Хэмжээ (mm)	Олдворын дугаар
1	Иртэй залтас	2	35x46x12; 74x61x30	Ts.T-1a. №1, 2
2	Залтас	6	Дундаж, жижиг	GSN-2024. Survay. Bag-11(1)
3	Хагархай, хэлтэрхий	13	Том, дундаж	GSN-2024. Survay. Bag-11(1)
Нийт		21		

Цахиурт толгойн 1b суурин

Дараагийн дурсгал өмнөхөөс зүүн тийш 200 м гаруй зайд, намхан дэнжийн төгсгөл хэсэгт бий. Газрын хөрсөн дээр цахиурын төрлийн түүхий эд маш баялаг ажээ (Зураг 67)




Зураг 67. Цахиурт овооны 1b дурсгал (зургийг баруун урд талас)

Эндээс 48 чулуун зэвсгийн олдвор түүвэрлэн цуглуулсан. Тэдгээр нь үлдэц, багаж зэвсгийн зүйл, цуулдасны үйлдвэрлэлд хамаарах эдлэлүүд ажээ (Хүснэгт 17).

Хүснэгт 18. Цахиурт овооны 1b суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл

№	Олдворын төрөл	Тоо	Хэмжээ (mm)	Олдворын дугаар
1	Үлдэц	1	28x42x23	Ts.T-1b. №1
2	Цоолтуур	1	41x23x13	Ts.T-1b. №2
3	Иртэй залтас	1	48x59x24	Ts.T-1b. №3
4	Бүтэн ялтас	1	92x35x15	Ts.T-1b. №4
5	Ялтасны дээд хэсгийн хугархай	1	36x27x11	Ts.T-1b. №5
6	Залтас	20	Том, дундаж, жижиг	GSN-2024. Survay. Bag-11(2)
7	Хагархай, хэлтэрхий	23	Том, дундаж, жижиг	GSN-2024. Survay. Bag-11(2)
Нийт		48		

Үлдэц. Тэгш өнцөгт маягийн хэлбэртэй бөгөөд чулууны нэг өргөн талыг цохилтын талбай болгон ашиглаж нимгэн, тэгш хэмт жижиг ялтас цуулж авсан зэрэгцээ ором цуулалтын гадаргууд үлджээ.



Зураг 68. Цахиурт толгойн 1b суурин. 1 – ялтас, 2 - цоолтуур

Цоолтуур. Залтасны нэг талын урт сунасан үзүүрийн ирмэгийг жижгээр холтчин ирлэж торгон үзүүрийг нь хурцалжээ (Зураг 68. 2).

Иртэй ялтас. Нэлээд зузаан залтасны нэг ирмэгийг нүүрэн талаас нь жижгээр холтчин ирлэжээ.

Суурин – дархны газар тул том, дундаж, жижиг янз бүрийн хэмжээтэй залтас, ялтас (Зураг 68. 1) хагархай хэлтэрхий олон байна.

Цахиурт толгойн 2-р суурин

Цахиурт толгойн гол өндрийн баруун бэлд хөрсөн дээр чулуун зэвсгийн олдвор өндөр нягтаршилтай тархжээ. Эндэхийн цул цахиуран тогтоцтой хаднаас эртний анчин – түүвэрлэгчид хагачин авч бага зэвсэг хийж байсан ул мөр ч ажиглагдаж байна (Зураг 69).



Зураг 69. Цахиурт толгойн 2-р дурсгал (зургийг баруун талаас)

Эндээс сонголтын зарчмаар 5 олдвор цуглуулсан нь үлдэц хэлбэрийн эдлэл (Зураг 70. 2), том, дундаж хэмжээтэй залтас (Зураг 70. 1) юм (Хүснэгт 18).



Зураг 70. Цахиурт толгойн 2-р суурин. 1 – залтас, 2 – үлдэц хэлбэрийн эдлэл

Хүснэгт 19. Цахиурт толгойн 2-р суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл

№	Олдворын төрөл	Тоо	Хэмжээ (mm)	Олдворын дугаар
1	Үлдэц хэлбэрийн эдлэл	2	65x70x28	Ts. T-2. №1, 2
2	Залтас	3	Том, дундаж	Ts. T-2. №3, 4, 5
Нийт		5		

Цахиурт толгойн 3-р суурин

Цахиурт овооны орой дээр геодезийн цэгийн суурь байх бөгөөд энд ч чулуун зэвсэг хийх цахиур чулууны түүхий эд элбэг ажээ. Мөн хагачиж цуулсан оромтой хагархай, залтас олон байна. Бид уулын оройн энэ хэсгээс түүвэр цуглуулга хийлгүй тодорхойлолт үйлдэж зургаар баримтжуулав (Зураг 71).



Зураг 71. Цахиурт толгойн 3-р дурсгал (зургийг баруун талаас)

Цахиурт толгойн 4-р суурин

Цахиурт овооны зүүн биед газрын хөрсөн дээр залтас, хагархай хэлтэрхий битүү тархжээ. Харин үлдэц, ирлэж зассан зэвсэг цөөн байна. Эндээс сонголтын зарчмаар 11 олдвор түүвэрлэсэн нь иртэй ялтас (Зураг 73. 2), ялтас (Зураг 73. 1), залтас, хагархай, хэлтэрхий юм (Хүснэгт 19).

Хүснэгт 20. Цахиурт толгойн 4-р суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл

№	Олдворын төрөл	Тоо	Хэмжээ (mm)	Олдворын дугаар
1	Иртэй ялтас	2	75x40x14; 129x41x17	Ts.T-4. №1, 2
2	Иртэй ялтас	2	82x16x11; 57x37x9	Ts.T-4. №3, 4
3	Бүтэн ялтас	1	66x16x7	Ts.T-4. №3, 5
4	Залтас	3	Том, дундаж	GSN-2024. Survey. Bag-12(1)
5	Хагархай	3	Дундаж	GSN-2024. Survey. Bag-12(1)
Нийт		11		

Цахиурт овоо нь тэр хавьдаа ноёлог өндөр содон тогтоцтой бөгөөд эргэн тойрон олон нуурын саваар хүрээлэгдсэн газар юм. Тиймээс түүхий эдийн сайн чанарын баялаг нөөцтэй энэ газарт эртний хүмүүс ирж багаж зэвсгээ хийж байснаас гадна ан гөрөөний байр байц, нүүдлийг өндрөөс тольдон хардаг байсан бололтой. Хагачиж цуулсан чулуун зэвсгийн олдвор хөрсөн дээр олон байгаа нь нэг цаг үеийн дурсгал уу? эсвэл урт хугацааны туршид хүмүүс энэ газарт ирж багаж зэвсгээ хийж байснаас ингэж олноор үлдэж хоцров уу? гэдэг асуулт гарна.



Зураг 72. Цахиурт толгойн 4-р дурсгал (зургийг хойд талаас)

Газрын хөрсөн дээрх олдвор болон цуглуулгын хэрэглэгдэхүүн дотор залтас давамгайлах хандлагатай байна. Ер нь суурин – дархны газрын олдворын бүрдэлд залтас олон байдаг онцлогтой билээ. Эндэхийн хоёрдогч боловсруулалт хийсэн багаж зэвсэг нь цөөн төрөл зүйлтэй агаад иртэй залтас, ялтас голлож байна. Мөн цөөн тооны шүдлэг хүнхэр ирт зэвсэг байх ажээ.



Зураг 73. Цахиурт толгойн 4-р суурин. 1, 2 – ялтас

Цахиурт овооны суурин – дархны газраас бид үлдэц, үлдэц хэлбэрийн эдлэл цөөн илрүүлсэн бөгөөд зэрэгцээ цуулалтын арга ажиллагааг илтгэж байна. Мөн леваллуагийн

хэв шинжийн үлдэц, бэлдэц тааралдсангүй. Тиймээс бид орон нутгийн онцлогийг хадгалсан дээд палеолитын эхэн үеэс дунд үед холбогдох дурсгал хэмээн үзэж байна.

Цахиурт толгойн хүрэл болон түүхэн үеийн дурсгал

Цахиурт овооны өндөр толгойн хоорондох шил, өвөр бэлээр хүрлийн үед холбогдох цөөн боловч булш оршуулга, тахил тайлгын холбогдолт дурсгал бий (Зураг 75). Ер нь тухайн бүс нутаг булш оршуулга зэрэг чулуун байгууламжит дурсгал цөөн бөгөөд харин Цахиурт овоонд нэг доор харьцангуй бөөгнөрсөн байдалтай дурсгал буй нь тухайн газар энд аж төрж байсан нүүдэлчдийн хувьд нас барагсдаа оршоосон онгон дагшин газар байсантай холбоотой бололтой. Өдгөө ч нутгийн иргэд Цахиурт овоог “догшин” хэмээн хэлэлцэх бөгөөд цагаан цахир чулуунаас нь авч болохгүйг сануулж байв.

Эндэхийн булш оршуулга нь говийн бүс нутгийн хүрлийн үеийн хамгийн эртний булш оршуулга болох шоргоолжин булш, улаан зуух хэлбэрийн булш юм. Харин зэл чулуу нь харьцангуй хожуу үед хамаарах юм.

Цахиурт овооны 1-р шоргоолжин булш. Цахиурт овооны зүүн талын хоёр өндөр толгойн хоорондох намхан онь дээр бий. Энэ булш баруунаас зүүн зүгт чиглэсэн голоороо дотогш хотойсон хашлагатай. Хашлаганы дотор талд битүү өндөр дараас үйлджээ. Хөл талын хашлага толгой талынхаас богино байдаг зүй тогтол энэ булшинд мөн ажиглагдана. Харин толгой талын хашлага, дараас чулуунууд нэлээд таржээ. Толгой талын хашлаганд өндөр чулуу босгосон байна. Хашлаганы урт 720 см, толгой талын хашлаганы өргөн 500 см, хашлаганы хотгор хэсэг 370 см, хөл талын хашлага 350 см хэмжээтэй (Зураг 74).



Зураг 74. Цахиурт овооны 1-р Шоргоолжин булш

Говь, хээрийн бүс нутагт шоргоолжин булшийг ийнхүү тэр хавьдаа ноёлох өндрийн орой дээр, сондгой байдлаар, хаанаас ч харагдахаар байрлалд тавьсан нь тохиолддог. Энэ

нь тухайн газар орноо нас барагчийг оршоосон сүрлэг байгууламжаар тэмдэглэж, бусдад мэдэгдэж буй хэлбэр бололтой.



Зураг 75. Цахиурт овооны өвөр бэлийн археологийн дурсгал

Цахиурт овооны 2-р шоргоолжин булш. Цахиурт толгойн зүүн тийш дугших өндөр овооны энгэр бэлд хашлага нь нэлээд эвдэгдсэн булш байна (Зураг 76). Гадаад зохион байгуулалт нь ихэд эвдэгдсэн тул нарийн тодорхойлох боломжгүй ч шоргоолжин булш байх магадлалтай байна.



Зураг 76. Цахиурт овооны 2-р Шоргоолжин булш



Зураг 77. Цахиурт овооны 3-р Шоргоолжин булш

Цахиурт овооны 3-р шоргоолжин булш. Цахиурт толгойн өвөр бэлд, зэрэгцэн орших улаан зуух хэлбэрийн булшны урд голдоо чулуугүй тоногдож эвдэгдсэн нэгэн булш байна (Зураг 77). Баруунаас зүүн чиглэсэн урт өрлөг нь дотогш ялимгүй хотгор буй нь шоргоолжин булш гэдгийг илтгэнэ.

Цахиурт овооны Улаан зуух хэлбэрийн 1, 2-р булш. Овооны бэлд зэрэгцээ хоёр улаан зуух хэлбэрийн булш байна. Хашлаганы дотор талд чулуугүй бөгөөд дараас таржээ (Зураг 78, 79).



Зураг 78. Цахиурт овооны 1-р Улаан зуух хэлбэрийн булш



Зураг 79. Цахиурт овооны 2-р Улаан зуух хэлбэрийн булш

Цахиурт овооны Улаан зуух хэлбэрийн 3, 4-р булш. Өмнөх булшнаас зүүн хойш 100 м зайд, бэлийн налуу дээр хоорондоо 15 м зайтай орших хоёр улаан зуух хэлбэрийн булш байна (Зураг 80, 81). Нэг нь намхан дараастай, дөрвөлжиндүү хэлбэртэй. Зүүн талын булшийг нь ухаж тоножээ.

Эдгээр дурсгалын эргэн тойронд янз бүрийн өнгөтэй цахиур чулуугаар хийсэн чулуун зэвсгийн олдвор сийрэг тархсан байгаа нь хожуу үед хамаарах бололтой.



Зураг 80. Цахиурт овооны 3-р Улаан зуух хэлбэрийн булш



Зураг 81. Цахиурт овооны 4-р Улаан зуух хэлбэрийн булш

Цахиурт овооны 5-р Улаан зуух хэлбэрийн булш. Цахиурт овооны өвөр бэлийн намхан дэнжийн бэлд тэгш өнцөгт маягийн намхан дараастай булш байна (Зураг 82).



Зураг 82. Цахиурт овооны 5-р Улаан зуух хэлбэрийн булш

Цахиурт овооны зэл чулуу. Овооны өвөр бэлийн Улаан зуух, Шоргоолжин булшны урд талаар баруун урдаас зүүн хойд зүгт чиглүүлэн 70 м зайд 31 чулууг газарт суулгаж хийсэн зэл чулуу байна. Энэ зэл зэрэгцээ хоёр эгнээтэй бөгөөд арын цувааг нэлээд том чулуугаар хийжээ (Зураг 83а). Чулуу хоорондын зай дунджаар 2 м зайтай. Газрын өнгөн хөрснөөс дээших өндөр 50 – 70 см ажээ.



Зураг 83а. Цахиурт овооны өвөр бэлийн зэл чулуу

2.2.18. Тэнгэр нуурын бүйлстэй тойром орчимд хийсэн хайгуул

Цахиурт овооноос зүүн тийш баруун хойноос зүүн урагш чиглэсэн өргөн хуурай сайр, сайрын хоёр эргээр шигүү ургасан бүйлс бүхий том тойром буйг нутгийн олон Тэнгэр тойром хэмээх нь бий (Зураг 83b).



Зураг 83б. Тэнгэр тойрмын бүйлсэн төгөл

Бид бүйлстэй сайрын хоёр эргээр хайгуул судалгаа хийхэд палеолитын хожуу үед холбогдох магадлалтай цөөн олдвор байна. Харин анчин, түүвэрлэгчдийн томоохон дурсгал олдсонгүй. Эндээс олдсон чулуун зэвсгийн олдвор нь үлдэц, үлдэц маягийн эдлэл, техникийн цуулдас, цоолтуур, хянгар, түүхий эд, залтас, хагархай юм (Хүснэгт 20).

Хүснэгт 21. Тэнгэр тойромн чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл

№	Олдворын төрөл	Тоо	Хэмжээ (mm)	Олдворын дугаар
1	Үлдэц	1	27x25x24	T.T. №1
2	Үлдэц маягийн эдлэл	1	19x29x11	T.T. №2
3	Техникийн цуулдас (tablet)	1	43x27x14	T.T. №3
4	Цоолтуур	1	50x42x21	T.T. №4
5	Хянгар	1	109x50x34	T.T. №5
6	Цохиур чулуу	1	63 мм	T.T. №6
7	Залтас	1	Том	T.T. №7
8	Залтас	6	Дундаж, жижиг	GSN-2024. Survey. Bag-13(2)
9	Хагархай	2	Жижиг	GSN-2024. Survey. Bag-13(2)
Нийт		15		

Үлдэц. Холтчиж зассан нэлээд том цохилтын талбайтай үлдэц юм. Суурийг ирмэг гарган зассан агаад хажууг тойруулан богино, тэгш хэмт нимгэн ялтас салгав авсан зэрэгцээ

оромтой. Үлдэц маягийн эдлэл нь жижгэвтэр чулууны өнгөн хэсгийг хуулж зассаны дараа нимгэн, жижиг ялтас цуулах оролдлого хийсэн оромтой.

Цоолтуурыг олон цуулалтын оромтой цахиур чулууны хагархайн нэг урт үзүүрийг жижгээр холтчин хэдэн талаас нь хэлтчиж үзүүрлэн шовхолжээ.

Хянгарыг урт, зузаан залтсаар хийжээ. Залтасны хажуугийн хоёр урт ирмэгийг нүүрэн талаас нь босоо холтчин ирлэжээ.

Цохиур чулууг нарийн ширхэгтэй элсэн чулуугаар хийсэн, бөөрөнхий хэлбэртэй. Гадрын зарим хэсэгт хортон үүсэж холцорч хэлтэрсэн нь цуулалтын ул мөр байж магадгүй Монголын неолит, мөстлөгийн дараах үеийн дурсгалуудад ийм эдлэл мэр сэр тааралддаг бөгөөд чулуун зэвсэг цуулах үйл ажиллагаанд хэрэглэх цохиур чулуу хэмээн тодорхойлсоор ирсэн. Харин өөр зориулалтаар ашигладаг ч байж болно. Неолитын үед хатуу цохиурын хэрэглээ буурч шахалтын арга давамгайлах болсон тул эдгээр нь арьс шир элдэх, хоол боловсруулах зэрэгт ашигладаг ахуйн зориулалттай эдлэл байхыг үгүйсгэхгүй

Тэнгэр нуурын шалаас илрүүлсэн дээрх олдворын холбогдох он цагийн асуудал бүрхэг байна. Ямартай ч Цахиурт толгойн дурсгалаас хожуу үед буюу дээд палеолитын төгсгөл, голоцены эрт үед холбогдох болов уу хэмээн таамаглаж байна.

2.2.19. Арын усны шивээ

Тэнгэр тойрмоос Ханбулаг сумын төв буцах замд, алдарт Хатны булгаас баруун урагш шулуунаар 36.2 км зайд нэгэн цонж байна (Зураг 84).



Зураг 84. Уулын оройг хашиж өрсөн цонж (хойд талаас)

Энэ дурсгалыг Арын усны шивээ хэмээн нэрийдэх бөгөөд анх СУИС-ийн Соёл, урлаг судлалын хүрээлэн, ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн хамтарсан “Хатны булгийн нууцаас” төслийн хээрийн шинжилгээний анги 2016-2018 онд Хатны булаг орчимд малтлага, хайгуул судалгаа хийхдээ илрүүлжээ. Судлаачид Хатны булаг орчмын бэхлэлт шивээнүүдтэй нэг цаг үеийнх байх магадлалтайг дурдаад зориулалт нь цэргийн бэхлэлт хэмээн үзжээ⁴¹. Харин нутгийн олон Чингис хаантай холбон домоглодог ажээ. Энэ дурсгал баруунаас зүүн тийш сунаж тогтсон намхан хярын дундуур зүүн хойноос баруун урагш чиглэсэн хуурай сайрын зүүн этгээдэд, тэр хавьдаа ноёлог өндөр уулын оройд бий. Үргэлжилсэн хярын дундуур нэвтрэх энэ сайраар орон нутгийн зам дайрч өнгөрөх бөгөөд сайрын зүүн талаас шахаж тогтсон бусдаас харьцангуй өндөрлөг толгойн оройд өмсгөн хажуу талуудыг чулуу давхарлан орж хашсан байжээ (Зураг 85).

Өдгөө хойд талын хашлаганы хэсэг сайтар хадгалагдан үлдсэн бөгөөд 2 м гаруй өндөр ажээ. Толгойн оройн хажуу талуудыг ингэж чулуун өрлөгөөр хашиж байсны ул мөр толгойн зүүн, урд, баруун бүх талд мэдэгдэнэ. Гэвч ихэнх нь газрын хэвгий даган тарж нурсан ажээ.



Зураг 85. Өрлөг нь харьцангуй сайн хадгалагдсан хойд талын хана



Зураг 86. Цонжийн орой дээрээс олдсон ахуйн ваарын хагархай

Агаарын зургаас харахад, толгойн оройг 8 тал гарган хашсан байсны ихэнх нурж тарсан бололтой. Толгойн орой ерөнхийдөө тэгшивтэр гадаргуутай. Тав хэсэгт нь зүүн урагшаа харсан саран хэлбэртэй жижиг чулуун өрлөг байна (Зураг 87). Ер нь говь нутгийн тухайн орчиндоо өндөрлөг толгой, уулын орой дээр ийм байгууламж олон тааралддаг бөгөөд зонхилгоч буюу баруун хойд зүгийн салхинаас нөмөрлөж задгай талын зүүн урагш харуулсан байдаг билээ.

⁴¹ С.Өлзийбаяр, Б.Баатархүү, Б.Очир, А.Уранжаргал. Домогт хатны булаг (2016-2018 онд хэрэгжүүлсэн “Хатны булгийн нууц” төслийн хээрийн судалгааны хэрэглэгдэхүүнээр). УБ., 2022. тал. 28



Зураг 87. Цонжийн дээд хэсэг ба орой дээрх чулуун өрлөг (Зүүн урд талаас)

Тэгэхээр саран хэлбэртэй энэ байгууламж цонжтой хамааралтай бус, хожим нь харууц сайн энэ оройгоос орчны газрын дурандахад нөмөр халхавч болгон барьсан эд бололтой. Мөн толгойн оройн баруун урд хэсэгт жижиг чулуун овоо босгожээ. Бид орой дээгүүр хайгуул хийх явцад ахуйн хэрэглээний паалантай ваарын хагархай илрүүлсэн. Ваарын паалан ховхорч унасан бөгөөд эргэдэг хүрдэн дээр хийсэн, нэлээд зузаан ажээ (Зураг 86).

2.2.20. Дулааны говьд хийсэн хайгуул судалгаа

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын өмнөд нутаг, улсын хилийн ойролцоо орших Тэнгэр нуурын хөндийд дээр дурдсан сонирхолтой дурсгалыг илрүүлсний дараа хээрийн судалгааны баг Дорноговь аймгийн Эрдэнэ сумын нутагт орших Дулааны говийн дурсгал руу хөдөлсөн юм. Дорноговь аймгийн Хатанбулаг, Хөвсгөл, Улаанбадрах сумаар дайрч явав. Улаанбадрах сумаас Дулааны говь шулуунаар 40 км орчим зайтай боловч сүүлийн хэдэн жил элс ихэд нэмэгдсэн тул тойрч явах нь дээр гэж нутгийн олон зөвлөсөн тул Замын-Үүд – Сайншандын төв замаар тойрч Дулааны говьд зүүн талаас нь хүрч очив (Зураг 88).



Зураг 88. Дулааны говь

Дулааны говь бол Монголын археологийн судалгаанд хэдийнээ танил болсон газар билээ. Анх 1955 онд Дорноговь аймгийн Улаан Уулын төмөр замын станцын барилгын ахлагч К.В.Ефремов Дулааны ус (худаг)-ны өмнөх элстэй дэнжээс чулуун зэвсгийн зүйлс олжээ. Түүний мөрөөр 1956 онд Х.Пэрлээ, Н.Сэр-Оджав нар хайгуул судалгааны ажил явуулжээ. Тэд Дулаан говийн элсэн дундах хатуу шавар далан дээрээс гал голомтын ормууд илрүүлж, 4-5 км үргэлжилсэн элст дэнжийн хотгоруудаас шинэ чулуун зэвсгийн дундад ба хожуу үед холбогдох хэд хэдэн төрлийн чулуун зэвсэг түүвэрлэжээ. Жижиг хэмжээтэй сумны зэв, зуулга ир, тал дугариг хусуур, хутган ялтас, үлдэц, шөвөг-хатгуураас гадна янз бүрийн хэмжээтэй сүх, ооль, цүүцний хугархай, хусуур, хянгар, алх буюу цохиур зэрэг том эдлэлүүд, нүдүүр, нухуур, самбар чулуу, гар тээрмийн чулууны хагархай зэрэг эд зүйлс ихээр олжээ. Эдгээр хөдөлмөрийн багаж зэвсгээс гадна загасчлах ажилд холбогдсон чулуун загасны хугархай олдсон нь эрхлэх аж ахуйн олон салаа бий болж хэлбэржин тогтсоны баталгаа юм хэмээн дүгнэсэн байна⁴². Түүнчлэн чулуун зэвсгийн хамт төмөрлөгийн шаар олдсон нь ногоон зэвтэй байжээ. Энэ нь хүрлээр юм үйлдсэний гэрч болно.

Чулуун эдлэлээс гадна шавар сав үйлдэж байсны гэрч болох хэдэн янзын сав суулганы үлдэгдэл олджээ. Шавар савны нарийн хэмжээ мэдэгдэхгүй боловч бөөрцөгний зузаан нимгэн, хээ угалзны байдлыг ялгаж болохоор байв. Вааруудад ихэвчлэн самнамал хээ, “гачуур модон хээ”, цувраа цэгэн хээ голлох бөгөөд багласан ширүүн өвс-дэрсээр шүүрдэн гаргасан, эсвэл шовх мод мэт юмаар зурчиж буюу хатгалан гаргасан байдалтай. Мөн шавар ээрүүлийн таваг олдсон нь утас ээрэх, нэхэх, хатгах үйл ажилд чамгүй амжилт олсны гэрч юм⁴³.

Дулааны говь нь эрт цагт их усан сан, ой мод бүхий газар байсан тул тэр ой модон дотор усны хөвөө эргээр, шинэ чулуун зэвсгийн дундад ба хожуу үед (НТӨ 4-2 мянган жил) хүн сууж байсан байна. Эндээс олдсон материал нь эндэх хүний амьдралд эртний болхи

⁴² Х.Пэрлээ, Н.Сэр-Оджав. Дорноговиос эртний хүний ул мөр олдлоо // ШУТ. №5-6. УБ., 1957

⁴³ Х.Пэрлээ, Н.Сэр-Оджав. Дорноговиос эртний хүний ул мөр олдлоо // ШУТ. №5-6. УБ., 1957

тариалан, ан агнуур, модоор юм хийх зэрэг аж ахуйн салаа мөчир байсны гэрч олдлоо гэж үзжээ⁴⁴.

1978 онд Д.Цэвээндорж, П.Хосбаяр нар Дулааны говийг археологи, геологийн талаар дахин судлах ажлыг хийжээ. Энэ хамтарсан судалгааны үр дүнгээр “Дулааны говийг археологи, геологийн талаар дахин судалсан нь” нэртэй эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлсэн байна⁴⁵. Судлаачид Дулааны говийн геологийн тогтцыг тодорхойлсны зэрэгцээ тэндээс түүвэрлэн цуглуулсан чулуун зэвсэг, шавар ваарын хагархайд тулгуурлан холбогдох он цагийн асуудлыг тодруулсан юм.

Энэ үеэс хойш Дулааны говьд дорвитой судалгаа хийгдэлгүй өнөөг хүрчээ. Харин 2009 онд Соёлын өвийн үндэсний төвөөс түүх, соёлын үлд хөдлөх дурсгалыг бүртгэн баримтжуулах явцад Дулааны говьд ирж дурсгалыг солбицлыг тогтоосон бөгөөд дурсгалын гэрэл зураг, хожуу үеийн ваар савны хагархайн зургийг нийтэлжээ⁴⁶.



Зураг 89 Дулааны говь (зургийг урд талаас)

Дулааны говь Монголын түүх бичлэгт мезолит, неолитын үеийг төлөөлөх гол дурсгалын нэг хэмээн тооцогддог (Зураг 89). Гэвч 1970-аад оны сүүл үеэс энэ дурсгалд

⁴⁴ Х.Пэрлээ, Н.Сэр-Оджав. Дорноговиос эртний хүний ул мөр олдлоо // ШУТ. №5-6. УБ., 1957

⁴⁵ Д.Цэвээндорж, П.Хосбаяр. Дулааны говийг археологи, геологийн талаар дахин судалсан нь // Studia Archaeologica. Tom X. Fasc.3. УБ., 1982

⁴⁶ Г.Энхбат, Б.Даваацэрэн. Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал. IV дэвтэр. Дорноговь аймаг. УБ., 2010. т. 95

судалгаа хийлгүй өнөөг хүрсэн. Сүүлийн жилүүдэд тухайн бүс нутгийн элсэн хурдас улам бүр нэмэгдэж, анчин, түүвэрлэгчдийн бууц суурины үлдэгдэл дарагдсаар байж болзошгүй нөхцөл байдал үүссэн юм. Тиймээс бид Дулааны говьд очиж чулуун зэвсгийн дурсгалт газруудыг бүртгэн баримтжуулах хайгуул судалгааг гүйцэтгэсэн юм.

Дулааны говь Дорноговь аймгийн Эрдэнэ сумын баруун зах нутаг бөгөөд Далайн элснээс хойших өргөргийн дагуу сунаж тогтсон уужим хоолой юм. Сайншандаас Замын-Үүд чиглэсэн төв замын баруун талд байх хоолойг зүүн талаас нь Далайн хоолой, Дулааны хоолой, Дулааны говь, хоолойн нэлээд баруун хэсгийн дов сондуултай хэсгийг Дулаан товцгийн худаг хэмээн нэрлэх ажээ. Х.Пэрлээ, Н.Сэр-Оджав, Д.Цэвээндорж нарын ахмад эрдэмтэд чухамдаа Дулааны говийн баруун биед, дов сондуулан дунд байх худгийн орчимд судалгааны ажлаа гүйцэтгэсэн бололтой. Харин эндээс зүүн тийш говь дагуу хэд хэдэн худаг байх боловч одоогоор хайгуул судалгаа хийгээгүй байна.

Бид Дулаан товцгийн худаг орчимд явган хайгуул хийж, археологийн дурсгал бүхий 10 газрыг илрүүлж тэмдэглэсэн. Дурсгалуудаас цөөн олдворыг сонголтын зарчмаар түүвэрлэн цуглуулсан.

Дулааны говийн 1-р суурин

Дулаан товцгийн худгаас зүүн урагш, говийн хотгорын урд талын дэнжийн хойш харсан налуу дээр энэ дурсгал оршино. Дэнжийн хажуугийн элс салхинд хийсэж, нэлээд хатуу бор шаргалдуу өнгөтэй шаварлаг давхарга зурвас газарт ил гарчээ (Зураг 90). Энэ давхаргын дээр чулуун зэвсгийн олдвор, ясны жижиг хэлтэрхий, ваар савны хагархай зэрэг тухайн үеийн амьдралын ул мөр ил гарсан байна.



Зураг 90. Дулааны говийн 1-р дурсгал (зургийг хойд талаас)

Хайгуулын явцад эндээс чулуун зэвсэг 200, ваарын хагархай 40, тэмээн хяруулын өндөгний хальсны хэлтэрхий нэгийг түүвэрлэн цуглуулсан (Хүснэгт 21).

Хүснэгт 22. Дулааны говийн 1-р суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл

№	Олдворын төрөл	Тоо	Хэмжээ (mm)	Олдворын дугаар
1	Бэлдэц	2	50x26x16; 38x21x16	DG-1. №1, 2
2	Шаантган үлдэц	4	52x27x19; 41x24x21; 41x19x20; 28x12x15	DG-1. №3, 4, 5, 6
3	Шовх үлдэц	4	45x12x10; 34x15x11; 40x12x7; 30x9x8	DG-1. №7, 8, 9, 10
4	Зэрэгцээ цуулалттай үлдэц	3	27x12x10; 22x14x10; 32x11x10	DG-1. №11, 12, 13
5	Техникийн цуулдас	4	56x19x9; 40x23x12; 30x11x36; 25x8x4	DG-1. №14, 15, 16, 17
6	Харуул	1	72x44x14	DG-1. №18
7	Төгсгөл хусуур	1	16x16x4	DG-1. №19
8	Самбар чулууны хагархай	7	Жижиг	GSN-2024. Survey. Bag-8(3)
9	Бүтэн ялтас	13	Том, жижиг	GSN-2024. Survey. Bag-8(3)
10	<i>Ялтасны дээд хэсгийн хугархай</i>	17	Жижиг, бичил	GSN-2024. Survey. Bag-8(3)
11	<i>Ялтасны дунд хэсгийн хугархай</i>	15	Жижиг	GSN-2024. Survey. Bag-8(3)
12	<i>Ялтасны үзүүрийн хугархай</i>	9	Жижиг	GSN-2024. Survey. Bag-8(3)
13	Залтас	94	Том, дундаж, жижиг	GSN-2024. Survey. Bag-8(3)
14	Хагархай, хэлтэрхий	26	Том, жижиг	GSN-2024. Survey. Bag-8(3)
15	Ваарын хагархай 1-р бүлэг	9	8-10 мм зузаан	GSN-2024. Survey. Bag-8(3)
16	Ваарын хагархай 2-р бүлэг	22	6-7 мм	GSN-2024. Survey. Bag-8(3)
17	Ваарын хагархай 3-р бүлэг	9	4-5 мм	GSN-2024. Survey. Bag-8(4)
18	Тэмээн хяруулын өндөгний хальс	1	17x11x2	GSN-2024. Survey. Bag-8(2)
Нийт		Чулуун зэвсэг 200, ваарын хагархай 40, өндөгний хальс 1		

Бэлдэц. Нарийн цохилтын талбайг холтчин нямбай засжээ. Нэг хажууг хоёр талаас нь холтчин ирмэг бэлтгэжээ. Нөгөө хажуугийн дээд хэсэг цуулалтад автаж хагарсан. Дараагийнх нь цөөн цуулалтаар гаргасан тэгш цохилтын талбайтай бөгөөд хажуу талуудыг холтчин зассан оромтой. Эдгээр бэлдэц нь жижиг, бичил ялтас цуулах зорилгоор бэлтгэгджээ.

Шаантган үлдэц. Хоёр нь нэлээд том хэмжээтэй (Зураг 91. 1, 3). Тэдгээрийн цохилтын талбайг нямбай засаад суурь, нэг талыг шаантаглан суулгахад эвтэй болгож хоёр талаас нь холтчин хурц ирмэг бэлтгэжээ. Нөгөө хажуу талд цуулалтын гадаргууг бэлтгэж тэгш хэмтэй олон ялтас цуулж авчээ. Мөн өргөн гадаргууд ч цуулалтууд хийж ялтас авсан оромтой бөгөөд шаантган ирмэгийн дээд хэсэг мөн цуулалтад автжээ. Дараагийнх нь арагш ялимгүй налуу цохилтын талбайтай, нэг хажууг нь хоёр талаас хөндлөн холтчин шаантган ирмэг бэлтгэсэн үлдэц юм. Үлдцийн хажуугийн гадаргын тал хэсэгт зэрэгцээ цуулалтаар ялтас цуулж авсан зэрэгцээ ором байна. Энэ төрөлд хамаарах сүүлийн эдлэл жижиг

хэмжээтэй. Нэг цохилтоор гаргасан тэгш цохилтын талбайтай бөгөөд сууриас эхлэн зассан шаантган ирмэг цуулалтат автжээ. Нэг хажуугаас тэгш хэмт бичил ялтас цуулж авсан олон зэрэгцээ ором байна. Том хэмжээтэй шаантган үлдэц эрт үед буюу дээд палеолитын төгсгөл, голоцены эхэн үед холбогдох магадлалтай. Харин жижиг хэмжээтэй эдлэлээс авсан ялтасны ормоос үзэхэд сүүл үед буюу неолитод хамаарах нь тодорхой байна.



Зураг 91. Дулааны говийн 1-р суурин. 1, 2, 3 – үлдэц, 4 – нүхэлсэн тэмээн хяруулын өндөгний хальс

Шовх үлдэц. Нэг нь нэлээд шовх, бусад нь мохоодуу суурьтай. Цохилтын талбайг гүйцэд зассан агаад хажуугийн периметрийн дагууд цуулалтын гадаргууг бэлтгэж зэрэгцээ цуулалтаар тэгш хэмт нимгэн бичил ялтаснууд салган авчээ (Зураг 91. 2).

Зэрэгцээ цуулалттай үлдэц. Өмнөх үлдцийн төрлөөс богино бөгөөд өргөн сууриар ялгагдана. Цуулалтын гадаргуудаа тэгш хэмт богино бичил ялтас цуулж авсан олон оромтой.

Техникийн цуулдас. Хоёр нь том, хоёр нь жижиг. Тэдгээрийг үлдцийн хажууг дахин засах явцад бий болгожээ.

Харуул. Уртавтарт тэгш өнцөгт маягийн хэлбэртэй байгалийн чулуугаар хийжээ. Хоёр талын өргөн гадаргууд чулууны өнгөн бүрхүүл хадгалагдаж үлдсэн бөгөөд хажуу ирмэгүүдээс засах оролдлого хийж хагачиж цуулсан оромтой. Чулууны нэг богино ирмэгийг налуу холтчин ирлэсэн агаад нөгөө тал нь гарт барихад эвтэй.

Төгсгөл хусуур. Тэгш өнцөгт маягийн хэлбэртэй бөгөөд гадаргуудаа зэрэгцээ цуулалтаар тэгш хэмтэй олон ялтас салган авсан оромтой. Залтасны цохилтын товгор бүхий дээд хэсгийг тайрч авсан нь ишинд суулгахад зориулагджээ. Дээд палеолитын дунд үеэс ийнхүү залтас, жижиг ялтасны цохилтын товгорыг тайрч засах болсон ажээ. Тамсагбулаг зэрэг неолитын эхэн үед холбогдох дурсгалд ийнхүү засаж бэлтгэсэн байдал ажиглагддаг юм.

Самбар чулууны хагархай. Дулааны говь орчмын газар нутгаас өмнө самбар чулуу олдож байсан билээ. Энэ дурсгалаас илрүүлсэн самбар чулууны жижиг хэлтэрхий хагархайг элсэн чулуу, нэлээд бүдүүндүү ширхэгтэй боржин чулуу зэрэг материалаар хийжээ. Элсэн чулуугаар хийсэн самбар чулууны нэг тал ихэд зүлгэгдэж мөлийсөн бөгөөд хажуу ирмэгийг зассан нь мэдэгдэнэ. Эдгээр нь 12-13 мм зузаантай. Харин бүдүүн ширхэгтэй цайвар боржингоор хийсэн эдлэл нэлээд зузаан агаад зүлгэгдсэн ором аль нэг талд нь байна.

Дээр дурдсан анхдагч цуулалт болон хоёрдогч боловсруулалт хийсэн олдвороос гадна ялтас, залтас, хагархай хэлтэрхий цуглуулгад олон бий.

Бид дулааны говийн энэ дурсгалаас илрүүлсэн ваар савны хэлтэрхийг хэдэн бүлэг болгон ангилсан билээ. 1-р бүлэгт нэлээд зузаан ханатай ваарын хагархайнууд хамаарна. Эдгээрийг жижиг чулуунаас нь гүйцэд салгаагүй чулууны орцтой шавраар хийжээ. Амсрын хагархай нэг буй нь өргөн, босоо амсартай байсныг илтгэнэ. Гадаргуу дээр нь хөндлөн товойлгон түүнийгээ нэлээд гүн ташуу, хөндлөн зурчин хээлсэн ором байна. Энэ төрлийн ваар хожуу үед хамаарах бололтой. Шатаалт дунд зэрэг. 2-р бүлэгт босоо амсартай ваарын жижиг хэлтэрхийнүүд хамаарна. Тэдгээр нь өмнөхтэй харьцуулахад нэлээд нимгэн боловч ваарыг хийсэн шаврын орц найрлага, шатаалт зэргээр төстэй ажээ. Зарим хэлтэрхий шууд хуурч унаж буй нь шатаалт төдийлөн сайнгүй гэдгийг илэрхийлж байна. 3-р бүлэгт бараан, улбардуу өнгөтэй нимгэн ханатай хэлтэрхий хамаарна. Чулууны орцод жижиг чулуу харьцангуй багатай. Энэ ангилалд хамаарах ваарын хэлтэрхий эндэхийн неолитын оршин суугчидтай холбоотой байж мэднэ.

Мөн нэг буланд нь нүхэлсэн тэмээн хяруулын өндөгний хальсны хэлтэрхий илрүүлсэн (Зураг 91. 4). Энэ эдлэл уг дурсгалыг үлдээгчид тэмээн хяруулын өндгийг хоол хүнсэндээ хэрэглэхээс гадна эдлэл хэрэгсэл хийж байсны баримт юм.

Дулааны говийн 2-р суурин

Өмнөх дурсгалаас зүүн тийш 300 м зайд, элст дэнжийн баруун тийш харсан налуугаас дараагийн дурсгалыг илрүүлсэн. Газрын хэвгий дагаж элстэй хөрсөн дээр (Зураг 92) чулуун зэвсгийн олдвор ил гарсан байснаас 83 олдвор түүвэрлэн цуглуулсан (Хүснэгт 22). Олдворын бүрдэлд үлдэц, багаж зэвсэг, цуулдасны үйлдвэрлэл зэрэг чулуун зэвсэг үйлдвэрлэлийн бүх үе шатыг илэрхийлэх эдлэл байна.




Зураг 92. Дулааны говийн 2-р дурсгал (зургийг баруун хойд талаас)

Үлдэц. Эхнийх нь хажуу ирмэг нь суурь руугаа нарийссан гурвалжиндуу хэлбэртэй үлдэц юм. Хажуу талуудыг сууринд нийлтэл нь хөндлөн цуулалт хийж хурц ирмэг гарган зассан байна (Зураг 93). Цохилтын талбайг мөн нүүрэн талд нь гаргаж өргөн ялтас цуулж авсан хоёр ором байна. Ар талын ихэнх хэсэгт чулууны өнгөн бүрхүүл үлджээ. Ийм үлдэц, бэлдэц Арц Богдын нурууны орчмын голоцены эхэн үеийн дурсгалуудад нэлээд элбэг тааралддаг. Дараагийнх нь суурь, хажуу ирмэгийг нь хоёр талаас нь холтчин ирмэг гаргаж зассан жижиг хэмжээтэй үлдэц ажээ. Цуулалтыг хоёр талын өргөн талд гүйцэтгэж тэгш хэмт бичил ялтас цуулж авсан олон зэрэгцээ оромтой. Өргөн талд цуулалт хийсний дараа хоёр ирмэгийн дагууд цуулалт хийж эвджээ. Мөн цохилтын талбайг засах оролдлого хийсэн нь

мэдэгдэнэ. Сүүлийнх нь Эргэн тойрон цуулалт хийж жижиг ялтас цуулж авсан оромтой үлдэц бөгөөд ар талын дээд хэсэгт цуулалтын гадаргууг дахин засах явцад залтас салган авсан ором байна.

Бифасны бэлдэц. Зуувандуу хэлбэртэй гадаргуудаа чулууны өнгөн бүрхүүлээ тэр чигээр нь хадгалсан манаар хийжээ. Зах ирмэгийг чулууны өнгөн бүрхүүлтэй талаас тойруулан холтчин зассан оромтой. Нөгөө талаас нь холтчин хэлтэчсэн ором байна. Энэ эдлэлийг нэлээн том хэмжээтэй бифас, эсвэл хутга хийхээр засаж байгаад дутуу орхижээ.

Хутганы хугархай. Нимгэн хавтгай манын хагархайн шулуун ирмэгийг хоёр талаас нь жижгээр холтчин ихэд нямбай ирлэжээ. Хутганы хугархай ажээ.



Зураг 93. Дулааны говийн 2-р суурин.
Үлдэц

Иртэй ялтас. Хоёр талтай тэгш хэмт ялтасны дунд хэсэг бөгөөд ар талаас нь хоёр ирмэгийг жижгээр ирлэжээ.

Хусуур. Дундаж хэмжээтэй залтсаар хийжээ. Нэгнийх нь залтасны цохилтын товгор бүхий дээд хэсгийг тайрч зассан байна. Нөгөөх нь нэлээд өргөн.

Самбар чулууны хагархай. Нарийн ширхэгтэй боржингоор хийсэн бөгөөд нэг тал нь зүлгэгдэж мөлийжээ. Өөр нэг эдлэлийн гадаргуугийн зарим хэсэг ихэд элэгдсэн буй нь зүлгэсний ором бололтой.

Ялтасны хугархай, залтас, хагархай хэлтэрхий зэрэг цуулдасны үйлдвэрлэлд хамаарах эдлэл цөөнгүй бий.

Ваарын хагархайнууд нь Сааралдуу өнгөтэй нарийн ширхэгтэй шавраар хийсэн жижиг. Нэг нь амсар хэсэг агаад босоо амсартай ваар байжээ. Шатаалт муу.

Хүснэгт 23. Дулааны говийн 2-р суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл

№	Олдворын төрөл	Тоо	Хэмжээ (mm)	Олдворын дугаар
1	Үлдэц	3	52x35x15; 33x18x14; 32x20x14	D.G-2. №1, 3, 2
2	Бифасны бэлдэц	1	69x52x20	D.G-2. №4
3	Хутганы хугархай	1	38x25x8	D.G-2. №5
4	Иртэй ялтас	1	19x7x1	D.G-2. №6
5	Хусуур	2	17x19x6; 21x29x6	D.G-2. №7, 8
6	Самбар чулууны хагархай	2	17 мм зузаан	GSN-2024. Survey. Bag-9(1)
7	Бүтэн ялтас	1	Жижиг	GSN-2024. Survey. Bag-9(1)

8	Ялтасны дээд хэсгийн хугархай	5	Жижиг	GSN-2024. Survey. Bag-9(1)
9	Ялтасны дунд хэсгийн хугархай	2	Жижиг	GSN-2024. Survey. Bag-9(1)
10	Ялтасны үзүүрийн хугархай	4	Жижиг	GSN-2024. Survey. Bag-9(1)
11	Залтас	42	Том, дундаж, жижиг	GSN-2024. Survey. Bag-9(1)
12	Хагархай, хэлтэрхий	12	Дундаж, жижиг	GSN-2024. Survey. Bag-9(1)
13	Ваарын хагархай	6	Хэлтэрхий	GSN-2024. Survey. Bag-9(1)
14	Амьтны чөмөг ясны хугархай	1		GSN-2024. Survey. Bag-9(1)
		Чулуун зэвсэг 76, ваарын хагархай 6, ясны хэлтэрхий 1		

Дулааны говийн 3-р суурин

Дулаан товцгийн худгаас зүүн хойш 50 м орчим зайд, говийн шалын урд захын зузаан элсэн хурдас дунд цөөн тооны чулуун зэвсгийн олдвор, амьтны яс илрүүлсэн (Зураг 94). Энэ хэсэг зузаан элстэй тул бууц суурингийн ором хурдаст дарагдаж мэдэгдэхгүй болжээ. Эндээс 5 чулуун зэвсэг, ваарын хагархай 8 илрүүлж түүвэрлэсэн (Хүснэгт 23).



Зураг 94. Дулааны говийн 3-р дурсгал (Баруун хойд талаас)

Чулуун зэвсгийн олдвор нь дундаж хэмжээтэй залтас, цуулалтын оромтой хагархай, хэлтэрхий юм.

Хүснэгт 24. Дулааны говийн 3-р суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл

№	Олдворын төрөл	Тоо	Хэмжээ (mm)	Олдворын дугаар
1	Залтас	2	Дундаж	GSN-2024. Survey. Bag-9(2)
2	Хагархай, хэлтэрхий	3	Дундаж, жижиг	GSN-2024. Survey. Bag-9(2)
3	Ваары хагархай	8	Хагархай, хэлтэрхий	GSN-2024. Survey. Bag-9(2)
Нийт		13		

Ваарын хагархай бүгдээрээ эргэдэг хүрд дээр хийсэн оромтой (Зураг 95) Эхний бүлэгт 9 мм зузаан ханатай ваарын хагархайнууд хамаарна. Тэдгээр нь хожуу үед холбогдох нь тодорхой байна. Дараагийн бүлэгт 4-5 мм нимгэн ханатай жижиг хэлтэрхий хамаарна. Мөн эргэдэг хүрд дээр хийсэн бөгөөд шатаалт сайн. Эдгээр ваар Чингийн үед холбогдох магадлалтай. Нэг нь амсрын хагархай бөгөөд ирмэгийг гадагш эргүүлж дэрвийлгэсэн. Хүннү ваартай төстэй.



Зураг 95. Дулааны говийн 3-р суурин. *Ваарын хагархай*

Дулааны говийн 4-р суурин

Дулаан товцгийн худгийн орчимд, сондуулын хооронд янз бүрийн өнгөтэй ваар савны хэлтэрхий, чулуун зэвсгийн олдвор газрын хөрсөн дээр нэлээд сийрэг тархжээ. Мал

амьтны хөлөөр олдворууд нэлээд хөдөлсөн бололтой бөгөөд эндэхийн олдвор, тэр дундаа шавар сав суулганы хагархай олон үеийг төлөөлж байгаа нь тодорхой юм (Зураг 96).



Зураг 96. Дулааны говийн 4-р дурсгал (Баруун урд талаас)

Зэвсгийн бэлдэц. Зууван хэлбэртэй чулууны хажуугийн нэг урт ирмэг, төгсгөл хөндлөн ирмэгийг босоо хагачин холтчиж зассан оромтой. Нэг тал нь гарт барихад эвтэй. Харуул, хянгар маягийн том баргил зэвсэг хийхээр бэлтгэсэн бололтой. Залтаснууд нь жижиг хэмжээтэй.

Хүснэгт 25. Дулааны говийн 4-р суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл

№	Олдворын төрөл	Тоо	Хэмжээ (mm)	Олдворын дугаар
1	Зэвсгийн бэлдэц	1	113x60x32	D.G-4, №1
2	Залтас	8	Жижиг	GSN-2024. Survey. Bag-9(3)
3	Түүхий эд	1	Дундаж	GSN-2024. Survey. Bag-9(3)
4	Ваарын хагархай	2	Хэлтэрхий	GSN-2024. Survey. Bag-9(3)
Нийт		11		

Ваарын хагархай. Чулууны орцтой шавраар хийсэн 7-8 мм зузаан ваарын ханын хэлтэрхий юм. Нэгнийх нь гадна талд хар ис тогтсон бөгөөд дотор тал нь улбар. Ийм ваарын хагархай говь, хээрийн бүс нутгийн ил задгай бууц сууринуудад нэлээд тааралддаг бөгөөд ямар нэг харьцуулалтгүйгээр судлаачид хожуу хүрлийн үед холбогдуулан авч үздэг. Неолитын үеийн бууц суурины орчмоос Улаан зуух хэлбэрийн булшны дэргэдээс ийм ваарын хагархай илрэх нь түгээмэл байдаг.

Дулааны говийн 5-р суурин

Дулаан товцгийн худгаас хойш 170 м зайд, заг сондуулын хоорондоос цөөн олдвор илрүүлсэн бөгөөд 5-р дурсгал хэмээн тэмдэглэв. Эндээ олдвор, эд өлгийн зүйл түүвэрлэж цуглуулаагүй.

Дулааны говийн 6-р суурин

Дулааны худгаас баруун хойш 500 м орчим зайд янз бүрийн үед холбогдох ваар савны хэлтэрхийнүүд илрүүлсэн. Эндээс цөөн олдвор түүвэрлэн цуглуулсан. Тэдгээр нь иртэй залтас, түүхий эд, ваарын хагархай юм (Хүснэгт 25).

Хүснэгт 26. Дулааны говийн 6-р суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл

№	Олдворын төрөл	Тоо	Хэмжээ (mm)	Олдворын дугаар
1	Иртэй залтас	1	37x45x6	D.G-6. №-1
2	Түүхий эд	2	Жижиг	GSN-2024. Survey. Bag-9(4)
3	Ваарын хагархай	10	Хэлтэрхий	GSN-2024. Survey. Bag-9(4)
Нийт		23		

Ваарын хагархай хоорондоо харилцан адилгүй. Эхний бүлэгт зузаан 7-10 мм ханатай шатаалт муу ваарын хагархайнууд хамаарна. Гадар нь улбар, бордуу өнгөтэй бөгөөд дотроо хар ис тогтсон. Шаврын найрлагыг нэлээд цэвэрлэжээ. Дараагийн бүлэгт 6 мм зузаан ханатай, шатаалт өмнөхөөс сайн жижиг хэлтэрхий хамаарна. Сүүлийн бүлэгт бараан өнгөтэй шатаалт сайн хятан ваарын хагархай 3 ш хамаарна.

Дулааны говийн 7-р суурин

Дулааны говийн 1-р сууринаас ялимгүй зүүн урагш 1.5 км зайд, хоолойн урд талын дэнжийн оройн хойш харсан налуугаас дараагийн дурсгалыг илрүүлсэн. Энд элсэн хурдас зузаан хуримтлагдсан боловч салхинд гадаргын элс хийсэж шаварлаг давхарга ил гарсан хэсэгт цөөн боловч чулуун зэвсгийн олдвор ил гарч иржээ (Зураг 97). Хайгуулын явцад эндээс тэгш цохилтын талбайг тууш цуулалтаар гаргасан, хажуу ирмэгийн дагууд цохилтын талбайгаас цуулалтууд хийж тэгш хэмтэй нимгэн ялтас цуулж авсан үлдэц, самбар чулууны захын жижиг хагархай, том баргил зэвсгийн бэлдэц, ялтас, залтас, ховилтой хавтан чулуу, ваарын хагархай (Хүснэгт 26) зэрэг олдвор цуглуулсан.

Эндээс илрүүлсэн нэг сонирхолтой олдвор бол голоороо уртааш гүехэн ховилтой хавтан чулуу юм. Ийм эдлэл баруун зүгт Денистр мөрнөөс зүүн тийш Монголын говь хүртэлх

өргөн уудам нутгаас олддог⁴⁷ бөгөөд их төлөв бууц суурин хэлбэрийн дурсгалаас гардаг байна⁴⁸. Монгол орны говийн бүс нутгийн дурсгалуудаас ийм эдлэл цөөн боловч олдож байжээ. Тухайлбал, Өмнөговь аймгийн Булган сумын Баянзагийн шавар усны суурин⁴⁹, Баянхонгор аймгийн Баянлиг сумын Зуухын голын 7-р суурин, Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутгаас⁵⁰ олдож, судалгааны эргэлтэд оруулжээ. Мөн хөрш зэргэлдээх Өвөр Монголын Алашаагийн говь, Алтат уул зэрэг газраас илрүүлсэн байдаг⁵¹. Үүрэг зориулалтын хувьд нум сумны мөс тэгшлэх, зүлгэх зориулалттай, арьс, ширэн эдлэлийн өө сэвийг дарах хэрэгсэл, жад шидэгчийн хүндрүүлэгч хэмээн янз бүрээр үзсэн байдаг.



Зураг 97. Дулааны говийн 7-р дурсгал (Хойд талаас)

1930-аад оны үед Хятад-Шведийн экспедиц Алашаагийн говийн Ух тохой (Ukh-Tokhoi) хэмээх газрын агуйгаас ваар сав, дуусгаагүй үлдээсэн халцедонон сувсны хэсэг, дунд зэрэг хэмжээтэй цөөн хэдэн ховил бүхий хавтан чулуун (элсэн чулуу, хайлуур жоншоор хийсэн) хамт илрүүлсэн байна. Эндээс илрүүлсэн жижиг чулуун сувс (зүүлт) хавтанд байх жижиг ховилд таарч байсан тухай судлаачдын тайлан эх хэрэглэгдэхүүнд дурдсан байдаг⁵².

⁴⁷ Т.И.Нохрина, И.В.Усачёва, Б.Гүнчиүнсүрэн. Нрвые данные о территории распространение “утюжков” и некоторые проблемы их изучения // *Studia Archaeologica*. Tom XVI. fasc.5. УБ., 1996. тал. 76-81

⁴⁸ Я.Цэрэндагва. Ханбогдоос олдсон содон чулуун багаж зэвсгүүд // *Acta Historica*. Tom. XI, fasc. 1. УБ., 2010. тал. 8

⁴⁹ Fairservis, W.A. The Archaeology of the Southern Gobi, Mongolia. Durham: Carolina Academic Press. 1993. p. 39

⁵⁰ Я.Цэрэндагва. Ханбогдоос олдсон содон чулуун багаж зэвсгүүд // *Acta Historica*. Tom. XI, Fasc. 1. УБ., 2010. Тал. 8

⁵¹ Л.Яанз, Д.Бөхчулуун. Говийн өргөжих бүс нутгийн харилцаа ба нийгэмд гарсан өөрчлөлт // *Studia Archaeologica*. Tom XXXVII, fasc. УБ., 2018. тал. 30-45

⁵² J.Maringer. Contribution to the prehistory of Mongolia. Reports from the Scientific Expedition to the North-western Provinces of China under the Leadership of Sven Hedin. Sino-Swedish Expedition Publication, 34. Stockholm: Statens Etnografiska Museum

Тэгэхээр дээрх ховилтой хавтан чулуу чулуун зүүлт хийхэд ашиглагдаж байсан хэмээн үзэж болох бөгөөд зүүлтийн гадна талыг хэлбэржүүлэн засах хэрэгсэл ажээ.

Хүснэгт 27. Дулааны говийн 7-р суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл

№	Олдворын төрөл	Тоо	Хэмжээ (mm)	Олдворын дугаар
1	Үлдэц	1	31x16x14	G.D-7. №1
2	Ховилтой хавтан чулуу	1	5x89x21	G.D-7. №2
3	Самбар чулууны хагархай	1	50x41x15	G.D-7. №3
4	Зэвсгийн бэлдэц	1	56x53x12	G.D-7. №4
5	Ялтасны дээд хэсгийн хугархай	1	Жижиг	GSN-2024. Survey. Bag-10(1)
6	Залтас	2	Жижиг	GSN-2024. Survey. Bag-10(1)
7	Ваарын хагархай	1	Хэлтэрхий	GSN-2024. Survey. Bag-10(1)
Нийт		8		

Энэ зуны хээрийн судалгааны үед яг үүнтэй адил ховилтой хавтан чулууг Сүхбаатар аймгийн Дарьганга сумын ахмад настан Дугарсүрэн гуайн цуглуулгад буйг мөн үзсэн юм. Тэрээр чулуун зэвсгийн цуглуулгыг Дарьганга сумын орчимд Молцог элс хийгээд Онгон сумын хөндлөнгийн голын орчмоос газрын хөрсөн дээрээс түүвэрлэн бүрдүүлжээ. Тэгэхээр ийм эдлэл говиос зүүн тийш, хээрийн бүс нутгийн өмнөд хэсгийн дурсгалуудад ч мөн байгаа нь тодорхой болж байна.

Дулааны говийн 8-р суурин

Өмнөх дурсгалаас баруун урагш 60 м орчим зайд зузаан элсээр хучигдсан гадаргуугаас нүхэлсэн шавар ваарын хэлтэрхий илрүүлэв. Тэр нь Хар сааралдуу өнгөтэй нарийн ширхэгтэй шавраар хийсэн сайн шатаалттай ваарын хагархай ажээ (Зураг 98). Сонирхолтой нь энэ ханын хагархайг гадна талаас нь 9 мм голчтой нэвт нүхэлжээ. Шавар сав суулгыг ийнхүү нүхэлсэн тохиолдол неолитын үеийн дурсгалуудад ч тохиолддог. Хэрэглээний явцад ан цав гарч хагарсан шавар сав суулгыг ийнхүү нүхлэн хэрж бэхэлдэг. Харин энэ ваарын нүх нэлээд том байгаа нь анхаарал татаж байгаа юм.



Зураг 98. Дулааны говийн 8-р суурин ба тэндээс илрүүлсэн нүхэлсэн ваарын хагархай

Дулааны говийн 9-р суурин

Өмнөх дурсгалаас баруун хойш 184 м зайд, элст дэнжийн оройгоос дараагийн дурсгалыг илрүүлсэн (Зураг 99). Эндээс 67 олдвор түүвэрлэн цуглуулжээ. Тэдгээр нь зэв, ялтас, ялтасны хугархай, залтас, хайрс, ваарын хэлтэрхий юм (Хүснэгт 27).



Зураг 99. Дулааны говийн 10-р суурин (Зүүн талаас)

Зэв. Гурвалжин хэлбэртэй тэгш суурьтай зэв ажээ. Хажуу ирмэг, сууриас төв рүү чиглүүлэн ихэд нимгэн жижгээр нямбай холтчин нимгэлж бэлтгэжээ. Хажуу ирмэг, суурийн ирмэг долгио багатай тэгш буй нь гүйцэд бэлтгэснийг илтгэнэ. Үзүүр нь хурц шовх юм. Ийм хоёр талаас нь засаж боловсруулсан жижиг зэв неолитын дундаас хойших үед хэрэглээнд нэвтэрсэн билээ.



Зураг 100. Дулааны говийн 9-р суурин. Чулуун зэв

Чулуун зэвсгийн цуглуулгад ялтас, ялтасны хугархай, залтас, хайрс зэрэг цуулдасны үйлдвэрлэлд хамаарах эдлэл ихэнх хувийг бүрдүүлжээ.

Хүснэгт 28. Дулааны говийн 9-р суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл

№	Олдворын төрөл	Тоо	Хэмжээ (mm)	Олдворын дугаар
1	Зэв	1	19x13x2	GSN-2024. Survey. Bag-10(3)
2	Бүтэн ялтас	2	Жижиг	GSN-2024. Survey. Bag-10(3)
3	Ялтасны дээд хэсгийн хугархай	1	Жижиг	GSN-2024. Survey. Bag-10(3)
4	Ялтасны дунд хэсгийн хугархай	3	Жижиг, бичил	GSN-2024. Survey. Bag-10(3)
6	Залтас	20	Жижиг	GSN-2024. Survey. Bag-10(3)
7	Хайрс	8	Жижиг	GSN-2024. Survey. Bag-10(3)
8	Хагархай	4	Дундаж	GSN-2024. Survey. Bag-10(3)
9	Ваарын хэлтэрхий	28	Хэлтэрхий	GSN-2024. Survey. Bag-10(3)
Нийт		67		

Чулуун зэвсгийн олдвортой хамт хэдэн төрлийн ваарын хэлтэрхий илрүүлсэн. Ваарын хэлтэрхийн хамгийн нимгэн нь 4, зузаан нь 7 мм хэмжээтэй боловч дунджаар 4-5 мм ажээ. Чулууг шавраас нэлээд сайн ялгаж цэвэрлэсэн шавраар хийжээ. Ихэнх нь бордуу өнгөтэй. Бараан өнгөтэй хэлтэрхий ганц нэг бий. Ваарын гадар нэгэн жигд таар маягийн дармал хээтэй. Ийм хээ өмнө нь тал, хээрийн бүс нутгийн дурсгалуудад таарч байв. Хэнтий аймгийн Шавартай булаг⁵³, Сүхбаатар аймгийн Зараа уул⁵⁴ зэрэг газарт ийм

⁵³ Д.Одсүрэн. Шавартайн булагийн Ар шандын шинэ чулуун зэвсгийн суурингийн судалгаа // Acta Historica. Tom. XXIV, fasc. 1. УБ., 2023. тал. 7-23

⁵⁴ Д.Одсүрэн, Д.Бөхчулуун, Л.Яанз. Зүүн Монголын нутагт хийсэн шинэ чулуун зэвсгийн судалгааны зарим үр дүн // Studia Archaeologica. Tom. XXXV, fasc. 5. УБ., 2015. тал. 72-96.

хээтэй ваарын хагархай илрүүлсэн нь шинжилгээгээр неолитын төгсгөл үед холбогдох нь тодорхой болсон билээ. Мөн нэг ваарын гадна талаас дотогш нэвт нүхэлсэн нь ваарыг засаж сэлбэж байсны ор бололтой. Дулааны говь орчимд чулуун зэвсэгтэй хамт олон үеийн ваар савны хагархай хамт байдаг. Тэдгээрийн дотор 9-р суурины эдгээр олдвор ялгарах бөгөөд бид эндэхийн неолитын оршин суугчдын шавар сав суулганы хэлтэрхий мөн хэмээн үзэж байна.

Дулааны говийн 10-р суурин

Өмнөх дурсгалаас зүүн тийш 900 м зайд, дэнжийн оройн элсэн хурдас салхинд хийсэж, цайвар өнгөтэй нарийн ширхэгтэй хатуу шаварлаг хөрс ил гарсан хэсэгт янз бүрийн ваарын хагархай тархсан дурсгалыг илрүүлсэн (Зураг 101). Эндээс эргэдэг хүрд дээр хийсэн хятан хээтэй хөх саарал өнгөтэй жижиг хэлтэрхий, задгай, том амсартай, амсрын дээд ирмэгийг гадагш эргүүлж дэрвийлгэсэн, эргэдэг хүрд дээр хийсэн ваарын хагархай илрүүлж баримтжуулсан. Мөн чулуун зэвсгийн олдворын ганц нэг хагархай хэлтэрхий тааралдаж байна. Хожуу үеийн бууц суурингийн үлдэгдэл гэдэг нь тодорхой байна.



Зураг 101. Дулааны говийн 10-р суурингийн ваар савны хагархай

Дулааны говийн баруун хэсэг, Дулаан товцгийн худаг орчмын газар нутаг нь олон үеийн туршид хүмүүс ирж суурьшин өөрсдийн ул мөрийг үлдээсэн бууц суурингийн судалгаанд сонирхолтой газар болох нь тодорхой байна. Чулуун зэвсгийн дурсгалууд их төлөв говийн тойром шалын урд талын намхан дэнжийн орой, хажуугаар тархсан бөгөөд элсэн хурдаст ихэд дарагджээ.

2.2.21. Сайрын бууцны хойд толгойн Улаан зуух хэлбэрийн булш

Дулаан товцгийн орчимд хайгуул судалгаа хийсний дараа Дорноговь аймгийн Эрдэнэ сумаар дайрч Сүхбаатар аймгийн Онгон сумыг чиглэн хөдлөв. Эрдэнэ сумаас зүүн хойш гарч улсын хилийн замаар явахад өвөлжөө бууц мэр сэр тааралдах боловч айл хунар алга. Энэ зун энэ хавь ихэд гандуу байгаа тул малчид нутгийн гүн рүү отор хийсэн ажээ. Зам мэдэх хүн байхгүй тул хилийн замаар явсаар Эрдэнэ сумаас шулуунаар 44.5 км зайд, улсын хилээс баруун тийш 2.8 км зайтай, Эрээн тойрмын араас нэгэн Улаан зуух хэлбэрийн булш илрүүлэв. Газрын зурагт энэ хавийг Сайрын бууцны хойд толгой хэмээн тэмдэглэжээ. Эндээс хойш харагдах үргэлжилсэн хярыг Давхарын хяр, Давхарын уул хэмээнэ. Бидний явсан энэ зам нутгийнхан зорчдог төв зам бус, хилийн анги, застав хооронд дамжин гардаг хилийн зам ажээ.

Улаан зуух хэлбэрийн булш үргэлжилсэн намхан хярын зүүн талд, задгай газарт орших бөгөөд хөрсөнд ихэд дарагдсан тэгш өнцөгт маягийн дараасыг дундаж хэмжээтэй чулуу ашиглан хийжээ. Толгой буюу зүүн талын өрлөгийн гадна талаас өндөр чулуу босгож манасан нь мэдэгдэнэ (Зураг 102). Тоногдсон шинж тэмдэггүй. Хэмжээ: 480 x 360 см.



Зураг 102. Эрдэнэ сумаас Онгон сум явах зам дагуух Улаан зуух хэлбэрийн булш (зургийг урд талаас)

2.2.22. Баян хошууны Улаан зуух хэлбэрийн булш

Дорноговь аймгийн Эрдэнэ сумаас Сүхбаатар аймгийн Онгон сум орох төв замын дагууд, Дорноговь аймгийн Өргөн сумын нутаг, Аргалантын уулын өмнөд хэсэг өргөн хөндийн араас урагш хошуурч тогтсон хар толгойг Баянхошуу хэмээдэг. Баянхошууны үзүүрээр төв зам дайрч өнгөрөх бөгөөд энд гурван Улаан зуух хэлбэрийн булш илрүүлж бүртгэв.

1-р булш. Эхнийх нь жижгэвтэр чулуугаар ялимгүй овгор дараас үйлдсэн булш юм. Дараас гадагш нэлээд тарсан, өвс өндөр ургасан зэргээс хашлаганы чулуу мэдэгдэхгүй байна (Зураг 103). Хэмжээ 430 x 280 см.

2-р булш. Өмнөх дурсгалаас хойш 80 м орчим зайд бий. Гадаад зохион байгуулалтын хувьд 1-р булштай адил жижиг чулуугаар дараасыг хийсэн боловч ялимгүй ажээ. Дараасны буланд арай өндөр чулуу босгосон нь зүүн хойд, баруун урд талд мэдэгдэнэ (Зураг 104). Хэмжээ: 320 x 210 см.



Зураг 103. Баянхошууны 1-р Улаан зуух хэлбэрийн булш



Зураг 104. Баянхошууны 2-р Улаан зуух хэлбэрийн булш

3-р булш. Өмнөх дурсгалаас хойш 87 м зайд жижиг чулуугаар хийсэн намхан дараастай улаан кзуух хэлбэрийн булш байна. Хөрсөнд дарагдаж мэдэгдэхгүй шахам болжээ (Зураг 105). Хэмжээ: 430 x 310 см.



Зураг 105. Баянхошууны 3-р Улаан зуух хэлбэрийн булш

2.2.23. Дөрвөлжин овооны дурсгал

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын баруун өмнөд нутаг, өргөргийн дагуу сунасан өргөн хотос говийн урд дэнж, төв зам дайрч өнгөрөх овоотой толгой дээр, овооны орчимд неолитын чулуун зэвсгийн олдвор сийрэг тархсан байна. Энд шаргал өнгийн хас, цахиураар хийсэн хагачиж цуулсан оромтой хагархай нэлээд тааралдаж байна. Бид энд түр буудаллахдаа чулуун зэвсгийн олдворыг овооны эргэн тойрноос илрүүлсэн бөгөөд цаашид нарийвчилсан хайгуул судалгаа хийвэл, тухайн газрын орчноос, ялангуяа, говийн хаяанаас бууц суурингийн дурсгал илрүүлэх магадлалтай юм.

Эндээс баруун урагш шулуунаар 9.1 км орчим зайд Тойг толгой хэмээх газраас 2020 онд бид дөрөвдөгчийн сүүл үеийн амьтны яс, чулуун зэвсгийн олдвор бүхий баялаг дурсгал, тухайн орчмоос савагт хирсний чөмөг зэрэг сонирхолтой олдвор илрүүлж байсан билээ.

2.2.24. Хавиргын булагийн адагийн дурсгал

Хайгуул судалгааны баг Сүхбаатар аймгийн Онгон сумаар дайрч, сумын урд талд, Хавиргын булагийн зүүн талд буюу Онгон – Дарьганга чиглэсэн автозамын дэргэд хонов. Энэ орчимд хайгуул хийхэд булгийн гармаас урагш голын зүүн дэвсгээс цөөн тооны чулуун зэвсгийн олдвор илрүүлсэн. Олдвор их сийрэг, ганц нэгээр олдож байв. Эндээс зүлгэж өнгөлсөн ооль маягийн эдлэл, хусуур, шүдлэг иртэй зэвсэг зэрэг цөөн олдвор илрүүлсэн (Хүснэгт 28).

Хүснэгт 29. Хавиргын булагийн чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл

№	Олдворын төрөл	Тоо	Хэмжээ (mm)	Олдворын дугаар
1	Зүлгэсэн эдлэл	1	51x39x22	Kh.B. №1
2	Хусуур	1	26x20x6	Kh.B. №2
3	Шүдлэг иртэй зэвсэг	1	18x27x5	Kh.B. №3
Нийт		3		

Хавиргын булагийн адгаас илрүүлсэн дэгээр олдвор цөөн боловч зүлгэж өнгөлөх аргаар хийсэн неолитын үед өргөн хэрэглэгдэх болсон оолийн төрлийг илэрхийлж буй зэргээрээ неолитын үед холбогдох нь тодорхой байна.

2.2.25. Их булагийн урд дэнжид хийсэн хайгуул судалгаа

Онгон сумаас Дарьганга орох авто замын 19 дэх км-т, замын урд талд газрын өнгөн хэсэг салхины нөлөөгөөр эвдэгдэж хэд хэдэн том хонхор үүссэн байв. Энэ газар Үйзэнгийн цагаан нуураас урагш орших бөгөөд нэлэнхүйдээ элсэн хөрстэй, бэлчээр сайхан нутаг ажээ. Хайгуул судалгааны үед ир сэн нутгийн хүмүүс энэ газрыг Их булагийн урд дэнж хэмээн нэрлэсэн тул бид уг нэрээр дурсгалыг баримтжуулав. Ер нь Хөндлөнгийн голын адаг орчимд Их булаг ар талаас нь цутгах агаад Хөндлөнгийн гол Үйзэнгийн цагаан нуурт ордог ажээ. Өөрөөр хэлбэл, Их булаг бидний судалгаа хийсэн энэ газраас нэлээд зайтай хол бий.

Бид элсэн хонхруудаар хайгуул судалгаа хийхэд хоёр газраас неолитын үеийн чулуун зэвсэг, ваар савны хагархай, амьтны яс тархсан дурсгал илрүүлэв.

Их булагийн урд дэнжийн 1-р суурин

Авто замын урд талд, дэнжийн оройн салхинд идэгдэж бий болсон том элсэн хотгорын өмнөд хэсэгт оршино. Хотгорын зах ирмэгээр хар хөрс ажиглагдах бөгөөд 43 олдвор түүвэрлэн цуглуулав (Хүснэгт 29).

Хүснэгт 30. Их булаг 1 суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл

№	Олдворын төрөл	Тоо	Хэмжээ (mm)	Олдворын дугаар
1	Зэв	2	20x12x3; 18x15x4	GSN-2024. Survey. Bag-14(2)
2	Иртэй залтас	1	30x21x10	GSN-2024. Survey. Bag-14(2)
3	Ялтасны дунд хэсгийн хугараай	1	Жижиг	GSN-2024. Survey. Bag-14(2)
4	Залтас	5	Дундаж, жижиг	GSN-2024. Survey. Bag-14(2)
5	Хагархай, хэлтэрхий	5	Нэг том, бусад жижиг	GSN-2024. Survey. Bag-14(2)
6	Ваарын хагархай	29	Хэлтэрхий	GSN-2024. Survey. Bag-14(2)
Нийт		43		

Тэдгээр нь неолитын үеийн чулуу зэв, иртэй залтас, ялтас, залтас, хагархай, хэлтэрхий, ваарын хагархай юм.

Зэв гурвалжин хэлбэртэй, хоёр талаас нь жижгээр холтчин хэлтчиж ихэд уртай нямбай бэлтгэсэн зэв юм. Эдгээрийн суурь хэсэг хугарчээ. Хажуу ирмэг долгио багатай буй нь эдгээрийг гүйцэд бэлтгэснийг харуулна. Үзүүр нь ихэд хурц. Ийм уран нарийн хийцтэй зэв неолитын дундаас хойших үед үйлдвэрлэлд нэвтэрсэн бололтой. Бусад нь иртэй залтас, цуулдасны үйлдвэрлэлд хамаарах эдлэл ажээ.

Эндээс илрүүлсэн ваарын хагархай лав хэдэн төрөлд хуваагдах ажээ. Бордуу өнгөтэй гадар дээрээ сүлжилдсэн зураасан хээтэй 5-6 мм зузаан хээтэй ваарын хагархай нэг бүлэг болно. Тэдгээрийг чулууны орцтой шавраар хийсэн агаад дунд зэргийн шатаалттай. Дараагийн бүлэгт нэлээд зузаан боловч өмнөхтэй төстэй ваарын хагархайнууд хамаарна. Дараагийн хэсэгт улаан өнгөтэй зузаан ханатай чулууны орцтой шавраар хийсэн эдлэл хамаарна. Мөн жижиг хэлтэрхийнүүд нь ч чулууны орцтой юм. Эдгээр ваар чулуун зэвсгийн үетэй холбоотой нь эргэлзээтэй. Арай сүүл үед буюу хүрлийн үед хамаарах магадлалтай. Шатаалт сайн зүлгэсэн оромтой хоёр ваарын хагархай харьцангуй хожуу буюу түүхэн үед хамаарна.

Их булагийн урд дэнжийн 2-р суурин

Өмнөх дурсгалаас баруун тийш 160 м зайд бий. Газрын хөрсөн дээрээс 13 олдвор түүвэрлэжээ. Тэдгээр нь холтчин зассан тэгш цохилтын талбайтай, шовх суурьтай урт үлдэц, тэгш бус хэмтэй богино өргөн ялтас болон ваарын хагархай юм (Хүснэгт 30).

Ваарын хагархай нь бор, саарал өнгөтэй. Шатаалт сайн ваарын их биеийн ханын хагархай юм. Ихэнх хэлтэрхий дээр Хятаны үеийн нэг эгнээнд босоо зураас гаргаж хээлсэн (дусал хээ) байна. Нэг хагархайг 5 мм голчтой нэвт нүхэлж гадна талыг зүлгэсэн нь ээрүүлийн дунгуй хийхээр засаж байсны ор бололтой.

Хүснэгт 31. Их булаг 2 суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл

№	Олдворын төрөл	Тоо	Хэмжээ (mm)	Олдворын дугаар
1	Үлдэц	1	39x11x10	GSN-2024. Survey. Bag-14(3)
2	Ялтас	1	Жижиг	GSN-2024. Survey. Bag-14(3)
3	Ваарын хагархай	11	Хэлтэрхий	GSN-2024. Survey. Bag-14(3)
Нийт		13		

2.2.26. Өлзийтийн шар манханы орчимд хийсэн хайгуул судалгаа

Хайгуул судалгааг цааш үргэлжлүүлж Сүхбаатар аймгийн Дарьганга суманд ирэв. Сумын удирдлагад судалгааны зорилгыг танилцуулсны дараа нутгийн ахмад настан, эртний түүх сонирхогч Д.Дугарсүрэн гуайтай уулзав. Д.Дугарсүрэн абугай Дарьганга сумын орчимд Молцог элс, Хөндлөнгийн гол болон энэ хавийн газруудаас явж хөрсөн дээр ил гарсан чулуун зэвсгийн олдвор, ваар сав зэрэг эртний түүхийн олдворыг сонирхон түүвэрлэж баялаг цуглуулгыг бий болгосон хүн билээ. Тэрээр бидэнд Дарьганга сум, Наран сум, Онгон сумын зарим дурсгалыг танилцуулж, зааж өгсөн юм.



Зураг 106. Өлзийтийн Шар манхан (Сүхбаатар аймаг, Наран сум. Зүүн хойд талаас)

Д.Дугарсүрэн абугай Наран сумын Өлзийт булагийн урд талын Шар манханы арын хунхаас сонирхолтой олдвор олддог тухай хэлсэн тул энэ орчмоор хайгуул судалгаа хийв (Зураг 106). Бид өмнө нь 2017 онд Өлзийт булагийн орчимд хайгуул хийж зузаан элсэн хурдаст хадгалагдаж буй цөөн дурсгалыг илрүүлж тэмдэглэсэн юм (Зураг 107).



Зураг 107. Өлзийтийн Шар манханы ар хотгорт буй газрын хөрсөн дээрх ваарын хагархай, галын ором

Өлзийтийн шар манхан нь тухайн орчиндоо нэлээд өндөр бөгөөд ар тал нь салхинд идэгдэж том хунх хотгор бий болжээ. Хотгорын ар ирмэг, төв хэсгээр хар бараан өнгөөр

ялгарах голоцены хөрс ил гарсан байв. Энд улбар болон бор өнгөтэй ваарын жижиг хэлтэрхий, амьтны яс, цахиур чулуугаар хийсэн чулуун зэвсгийн олдвор ил гарчээ. Мөн галд шатаж халтардсан хөрс байна. Бид хөрсөн дээрх олдворын зураг авч баримтжуулсан бөгөөд 1 x 2 м хэмжээтэй газарт сорилын малтлага хийсэн юм. Гэвч тухайн орчин нь Дарьгангын тусгай хамгаалалттай газар нутагт ордог тул Байгаль орчны яамнаас зөвшөөрөл аваагүй гэдэг үндэслэлээр Дарьгангын тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаа хийгээд Байгаль орчны яамнаас малтлага судалгаа хийхийг хориглов. Тиймээс малтлагыг зогсоож эргүүлэн булав. Дарьганга сум, Наран сумаас ажлын хэсэг томилж төлөвлөгөөт судалгаатай танилцсан.

Бид хайгуул хийх явцад цөөн олдворыг дээжлэн цуглуулсан. Тэдгээр нь чулуун зэвсэг, ваарын хагархай юм (Хүснэгт 31).

Хүснэгт 32. Өлзийтийн Шар манханы суурины чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл

№	Олдворын төрөл	Тоо	Хэмжээ (mm)	Олдворын дугаар
1	Ялтас	1	Жижиг	GSN-2024. Survy. Bag-15(1-1)
2	Ваарын хагархай	12	Хэлтэрхий	GSN-2024. Survy. Bag-15(1-2)
3	Ваарын хагархай	7	Том, жижиг хагархай	GSN-2024. Survy. Bag-15(1-2)
4	Ваарын хагархай	4	Том, жижиг хагархай	GSN-2024. Survy. Bag-15(1-2)
5	Хүрэл бугуйвч	1		GSN-2024. Survy. Bag-15(1-3)
Нийт		25		

Эхний бүлэгт хамаарах ваарын хагархай 6-8 мм зузаан ханатай, жижиг чулууны орцтой шавраар хийсэн шатаалт муу ваарын хагархайнууд байна. Заримынх нь гадар, дотор талд зузаан ис тогтжээ. Гадар дээр нь босоо болон хөндлөн сүлжилдсэн мэдэгдэх төдий бүдэг зураас нь ваарыг хэлбэрт оруулахад сүрэл, дэрс мэт нарийн ширхэгтэй ургамал сүлжиж гадна талаас нь бариулсны ором бололтой бөгөөд зориуд гаргасан хээ чимэглэл гэхэд хэцүү ажээ. Нэг хэлтэрхий дээр 5 мм орчим өргөн цувьсан шавраар наамал хээ тавьж байсан оромтой. Зоог, Зуухын суурингийн ваарын хэлтэрхий дээр ийм босоо цувьсан наамал хээ тавьж байсан ором байдаг. Эдгээр ваар элсэн манханы арын хунхаас неолитын чулуун зэвсэг багажийн хамт ил гарсан байв. Неолитын үед холбогдох магадлалтай. 10 мм зузаан ханатай нэг эдлэл бусдаас ялгарах бөгөөд шатаалт сайн. Энэ нь тагнай маягийн гурвалжин хээгээр чимэглэжээ. Хожуу буюу түүхэн үе, тэр дундаа уйгурын үед холбогдох магадлалтай.

Дараагийн бүлэгт хамаарах ваарын хагархай улбар, хар бараандуу хоёр янзын өнгөтэй гадартай. Энэ нь ваарын гадна тал хэрхэн хадгалагдаж үлдсэнээс хамаарч буй бөгөөд зарим эдлэлийн гадар зүлгэгдэж элэгдэн гадар нь хуурч дотор талын улбар шавар ил гарчаа. Чулуу агуулсан нарийн ширхэгтэй шавраар хийсэн бөгөөд шатаалт дунд зэрэг

юм. Гадар нь хадгалагдаж үлдсэн зарим эдлэл дээр сүлжилдсэн нарийн зураасны ором байна. Босоо уужим амсартай нэлээд том ваар байсан бололтой бөгөөд амсрын ирмэгийг гадагш нь эргүүлж дэрвийлгэжээ. Амсар гадагш ихэд дэрвэгэр тул гадна талаас нь амсрын доор тулаас хийж товойлгож өгчээ. Неолитын үеийн сууринаас олдсон боловч он цаг тогтоох шинжилгээ хийхээс нааш нарийн он цагийн холбогдлыг хэлэх боломжгүй байна.

Ваарын сүүлийн бүлэгт амсрын хагархай, хүзүүний хэсэг орно. Амсрын хагархай нь хүннүгийн самнаа хээний ор үлдэцтэй. Жижиг хэлтэрхийнүүд нь гадар дээрээ хятаны дусал хээний оромтой.

Хайгуул судалгааны явцад илрүүлсэн өөр нэг сонирхолтой олдвор бол хүрэл бугуйвч юм. Энэ бугуйвчийг цувьж хийсэн бөгөөд задгай амтай. Дээд тал нь хавтгай. Түүн дээр таван дэлбээт цэцэг, түүний хоёр талаас зүүлтийг голлуулан нахиа навчийг уртаар цохиж гаргасан байна. Амсар буюу төгсгөлд бөөрөнхийлсөн нь зүүж хэрэглэхэд эвтэй болгожээ. Он цагийн хувьд хэдий үед холбогдох нь тодорхойгүй. Биднийг 2017 онд Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Баруун булаг орчимд хайгуул судалгаа хийж, тэнд Сяньбигийн үеийн булш илрүүлэн малтахад нутгийн хүмүүс зэс бугуйвчтай гар элснээс олддог хэмээн өгүүлж байсан. Энэ эдлэл магадгүй элсний оршуулгатай холбоотой, сяньби, хүннү зэрэг эртний улсуудын үед хамаарах магадлалтай ажээ.

2.2.27. Хөндлөнгийн голын сав дагууд хийсэн хайгуул судалгаа

Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутаг, Алтан овооноос зүүн хойш Баарайн хавцал хэмээх хоёр талдаа тэгш дэвсэгтэй цавчим хавцлаас жижиг булаг эх авах бөгөөд хойш урсан Адгийн булаг хэмээн нэрлэдэг. Энэ булаг цааш урсан зүүнээс баруун тийш сунасан хотос хоолойтой нийлж Уулзварын гол болдог. Уулзварын голын хуурай сайрыг баруун тийшлээд Хөндлөнгийн гол хэмээн нэрийддэг. Хөндлөнгийн гол Үйзэнгийн цагаан нуурт цутгадаг ажээ. Хэдийгээр өдгөө байнгын урсгалгүй боловч голын сав өргөн, зарим газарт олон салаатай байгаа нь эрт цагт ус их байсны илрэл юм (Зураг 108).


Ахмад багш Д.Дугарсүрэн гуай бидэнд Хөндлөнгийн гол орчмоос чулуун зэвсгийн олдвор олддог тухай мэдээлсэн бөгөөд замчилж дагуулж үзүүлсэн билээ. Хөндлөнгийн голын сав нутагт хайгуул судалгаа хийх явцад Нам ухаа, Хөндлөнгийн голын урд эрэг, Их булгийн адаг зэрэг хэд газраас чулуун зэвсгийн бууц суурины үлдэгдэл илрүүлж баримтжуулав.



Зураг 108. Хөндлөнгийн гол (Нам ухаагийн баруун хэсгээс зүүн тийш)

2.2.28. Нам ухаагийн дурсгал

Хөндлөнгийн голын дунд орчимд, ар талд нь зүүнээс баруун тийш буюу голын урсгалын дагууд аажим намссан дэнжийг нутгийн олон Нам ухаа хэмээн нэрлэдэг ажээ. Нам ухаа зүүн талдаа ялимгүй өндөр хар толгойтой нийлэх бөгөөд эндээс баруун тийш 4 км орчим үргэлжилдэг, тэгш оройтой хад чулуу багатай газар ажээ. Нам ухаагийн оройгоор хүрлийн үеийн Улаан зуух хэлбэрийн булш буюу чулуун байгууламжит дурсгал олон бий. Түүнээс гадна Нам ухаагийн оройгоор байгалийн эвдрэл, салхины нөлөөгөөр газрын өнгөн хэсгийн элс салхинд хийсэж бий болсон том хотгорууд бий. Ийнхүү гадаргын элс зөөгдсөн тул эдгээр элсэн хотгороос эртний амьдралын ул мөр гарч ирэх нь цөөнгүй байдаг ажээ. Мөн Хөндлөнгийн гол руу шахсан дэнжийн урд ирмэг, баруун талын төгсгөл ирмэгийн өвс багатай халцархай газарт шинэ чулуун зэвсгийн үеийн баялаг олдвор агуулсан дурсгалт газар байна (Зураг 109).



Зураг 109. Нам ухаагаас илрүүлсэн чулуун зэвсгийн дурсгалт газрууд (зургийг баруунаас зүүн тийш)

Нам ухаагийн 1-р суурин

Нам ухаагийн оройн тэгш дэвсгэ дээр, авто замын урд талд салхины нөлөөгөөр хөрс эвдэгдэж үүссэн зэрэгцээ хоёр хонхор бий. Эдгээр нь 1 м орчим гүн бөгөөд нарийн ширхэгтэй элсэн хөрстэй ажээ (Зураг 111). Хоёр хонхрын ар талынхаас Д.Дугарсүрэн гуай 2010 онд олон хэсэг болж хагарсан, гадрыг нь улаан хар өнгөөр өнгө алаглуулан будсан будмал хээтэй ваар олжээ (Зураг 110).



Зураг 110. Нам ухаагаас 2010 онд олсон будмал хээтэй ваарын сэргээн засварласан байдал (Д.Дугарсүрэн абугайн цуглуулга)

Хожим энэ ваарыг Соёлын өвийн үндэсний төвд сэргээн засварласан агаад судлаач Д.Содномжамц, Г.Анхсанаа нар тусгай өгүүлэл бичиж хэлбэр дүрс, өнгө будаг, хээ чимэглэлийг хөрш зэргэлдээ бүс нутгаас олдсон хэрэглэгдэхүүнтэй харьцуулан шинэ чулуун

зэвсгийн үеийн Яншаогийн соёлын “Мяодигоу хэлбэр”-ийн зарим ваартай ижил байгаад тулгуурлан НТӨ 4200-3500 орчим жилийн өмнөх үед холбогдуулан⁵⁵ үзсэн юм.

Бид 2017 онд Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутаг Молцог элсний Салаа булагийн эхэнд сорилын малтлага хийхэд мөн улаан будагтай, маш сайн шатаалттай нимгэн ваарны хагархай нэлээд гарсан юм⁵⁶. Эдгээр нь орон нутгийнх гэхээс илүүтэй Хятадын хойд хэсэг, ӨМӨЗО-ны нутаг дэвсгэрт байх неолитын хожуу үеийн дурсгал, тэр дундаа Яншаогийн соёлын дурсгалуудтай зарим талаар адилсаж байгаа тул анчин - түүвэрлэгчдийн арилжаа солилцооны үйл явцыг тодруулах чухал баримт хэмээн үзсэн юм.



Зураг 111. Нам ухаагийн 1 дүгээр суурин (зургийг баруун хойд талаас)

Тиймээс Хөндлөнгийн голын Нам ухаагийн будмал хээтэй ваар олдсон газарт Д.Дугарсүрэн абугай замчлан биднийг авч очив. Элсэн хотгоруудад хайгуул хийхэд чулуун зэвсгийн олдвор хотгорын дотор болон зах ирмэгээр сийрэг боловч тархсан байв. Харин улаан өнгөтэй будмал гадартай ваарын хагархай тааралдсангүй. Бид чулуун зэвсгийн олдвороос түүвэрлэн цуглуулсан. Ямар нэг сууц оромжийн ул мөр мэдэгдсэнгүй. Салхины нөлөөгөөр хөрс эвдэгдэж археологийн дурсгалын анхны байршил алдагдсан байх магадлалтай.

Хайгуул судалгааны явцад илрүүлсэн нэг сонирхолтой олдвор бол тэмээн хяруулын өндөгний хальс юм. Хэдийгээр Монголын говийн бүс нутгийн плейстоцен, голоцений үеийн

⁵⁵ Д.Содномжамц, Г.Анхсанаа. Дорнод Монголоос олдсон будмал хээтэй нэгэн ваар // Нүүдэлчдийн өв судлал. Том. XII-II. fasc. 2. УБ., 2021. тал.17-23

⁵⁶ Д.Одсүрэн, Д.Бөхчулуун, Л.Яанз, А.Розен. Говь, хээрийн бүсийн неолитын судалгаа төслийн 2017 оны хээрийн шинжилгээний ажлын тайлан. УБ., 2017. АХГБСХ.

дурсгалаас өндөгний хальс нэлээд гардаг боловч бид Сүхбаатарын өмнөд хэсэг буюу улсын хилийн дагуу дахь бууц сууринаас өмнө нь өндөгний хальс олоогүй байсан билээ.

Тамсагбулагийн дурсгалт газарт хийсэн малтлагаас тэмээн хяруулын өндөгний хальс, түүгээр хийсэн эдлэл олдоогүй. Энэ нь голоцений үеийн тэмээн хяруулын тархалт, нутагшилттай холбоотой бололтой. Говийн бүс нутгийн эртний оршин суугчид тэмээн хяруулын өндгийг хүнсэнд хэрэглэж, хальсаар нь янз бүрийн эдлэл хэрэгсэл хийсэн баримт бууц суурингийн дурсгалуудад олонтаа тааралддаг. Харин Хэрлэн голын сав нутаг болоод Тамсагбулаг зэрэг томоохон дурсгалаас тэмээн хяруултай холбоотой баримт олдоогүй. Тиймээс тэмээн хяруул говиос зүүн тийш хаана хүртэл нутаглаж байсныг тодруулах шаардлагатай байсан бөгөөд ямартай ч өнөөгийн Сүхбаатар аймгийн өмнөд нутаг хүртэл неолитын дунд үед тэмээн хяруул нутаглаж байсан нь тогтоогдсон юм.

Хайгуул судалгааны явцад Нам ухаагийн 1-р дурсгалаас 350 олдвор түүвэрлэн цуглуулсан. Тэдгээр нь чулуун зэвсэг, тэмээн хяруулын өндөгний хальсны хэлтэрхий, ваарын хагархай (Хүснэгт 32) юм.

Хүснэгт 33. Нам ухаагийн 1-р суурины олдворын ангилал

№	Олдворын төрөл	Тоо	Хэмжээ (mm)	Олдворын дугаар
1	Үлдэц	6	-	GSN-2024. Survey. Bag-16
2	Үлдцийн хагархай	4	-	GSN-2024. Survey. Bag-16
3	Техникийн цуулдас	3	-	GSN-2024. Survey. Bag-16
4	Хусуур	18	-	GSN-2024. Survey. Bag-16
5	Хянгар	1	-	GSN-2024. Survey. Bag-16
6	Иртэй хагархай	1	-	GSN-2024. Survey. Bag-16
7	Зэвсгийн бэлдэц	2	-	GSN-2024. Survey. Bag-16
8	Иртэй залтас	1	-	GSN-2024. Survey. Bag-16
9	Зэв	1	-	GSN-2024. Survey. Bag-16
10	Зэвийн бэлдэц	2	-	GSN-2024. Survey. Bag-16
11	Зэвийн хугархай	4	-	GSN-2024. Survey. Bag-16
12	Бэлдэц	1	-	GSN-2024. Survey. Bag-16
13	Бүтэн ялтас	10	-	GSN-2024. Survey. Bag-16
14	Ялтасны дээд хэсгийн хугархай	14	-	GSN-2024. Survey. Bag-16
15	Дунд хэгийн хугархай	18	-	GSN-2024. Survey. Bag-16
16	Үзүүрийн хугархай	3	-	GSN-2024. Survey. Bag-16
17	Залтас	118	Дундаж, жижиг	GSN-2024. Survey. Bag-16
18	Хагархай	38	Дундаж, жижиг	GSN-2024. Survey. Bag-16
19	Тэмээн хяруулын өндөгний хальсны хагархай	86	Хэлтэрхий	GSN-2024. Survey. Bag-16
20	Ваарын хагархай	19	-	GSN-2024. Survey. Bag-16
Нийт		350		

Үлдэц. Гурав нь жижиг шаантган үлдэц ажээ. Хоёр нь шовх суурьтай үлдэц юм. Нэг нь цуулалтын нэг гадаргуут, цохилтын нэг талбайт үлдэц юм. Бүгд жижиг, бичил ялтас цуулж авсан зэрэгцээ оромтой.

Үлдцийн хагархай. Үлдцийн цуулалтын гадаргуу, цохилтын талбай, суурь хэсгийн хагархайнууд юм. Үлдцийг дахин боловсруулж засах явцад хагарчээ.

Хоёрдогч боловсруулалт хийсэн багаж зэвсгийн зүйл нь ялтас, залтсаар хийсэн хусуур, том залтасны ирмэгийг жижгээр ирлэсэн хянгар, иртэй хагархай, сумны чулуун зэв юм. Зэв нь ялимгүй хүнхэр суурьтай гурвалжин хэлбэртэй. Зах ирмэгээс төв рүү чиглүүлэн нямбай холтчин нимгэлж бэлтгэжээ. Неолитын дундаас хожуу үед хамаарна. Мөн гурвалжин зэв хийхээр зэхсэн бэлдэц, хэрэглээний явцад хугарсан ихэд уртай засаж бэлтгэсэн гурвалжин зэвийн хугархай зэрэг олдворыг илрүүлэв.

Олон тооны залтас, ялтас, хагархай хэлтэрхий хотгорын төв болон зах ирмэгээр тааралдаж байна. Эндээс илрүүлсэн өөр нэг сонирхолтой олдвор бол тэмээн хяруулын өндөгний хальсны янз бүрийн хэлбэртэй хэлтэрхий бөгөөд эдлэл хэрэгсэл хийсэн ул мөргүй.

Ваарын хагархай нэлээд зузаан ханатай. Шаврын найрлагаас жижиг чулууг бүрэн цэвэрлээгүй. Зарим эдлэлийн гадна талыг зүлгэсэн ор мэдэгдэх агаад зарим дээр нь ихэд нимгэн наамал хээний ор ажиглагдана. Эндэхийн неолитын дурсгалтай холбоогүй бололтой. Харин тухай орчинд буй булш оршуулгын дурсгалтай хамааралтай байж магадгүй

Энэ дурсгалаас илрүүлсэн олдвор, эд өлгийн зүйл, ялангуяа чулуун зэвд тулгуурлавал неолитын дундаас хойших үед хамаарах магадлалтай. Харин өмнө нь олдвор байсантай адил будмал хээтэй ваарын хэсэг энэ удаа илрүүлсэнгүй.

Нам ухаагийн 2-р суурин

Нам ухаагийн зүүн хэсэгт оршино. Хөндлөнгийн голын савын ар талаас шахсан дэнжийн ирмэг зарим хэсэгтээ өвс халцарч хөрс ил гарсан байх агаад энд чулуун зэвсгийн олдвор ил гарчээ (Зураг 112).



Зураг 112. Нам ухаагийн 2 дугаар суурин (зургийг баруун талаас)

Эндээс 47 олдвор түүвэрлэн цуглуулсан. Түүвэр цуглуулгыг чулуун зэвсгийн үйлдвэрлэлийн янз бүрийн шатыг илэрхийлэх олдвор бүрдүүлж байна (Хүснэгт 33).

Хүснэгт 34. Нам ухаагийн 2-р суурины олдворын ангилал

№	Олдворын төрөл	Тоо	Хэмжээ (mm)	Олдворын дугаар
1	Шаантган үлдэц	1	-	GSN-2024. Survey. Bag-17(1)
2	Хусуур	4	-	GSN-2024. Survey. Bag-17(1)
3	Самбар чулууны хагархай	2	-	GSN-2024. Survey. Bag-17(1)
4	Бүтэн ялтас	1	-	GSN-2024. Survey. Bag-17(1)
5	Ялтасны дээд хэсгийн хугархай	8	-	GSN-2024. Survey. Bag-17(1)
6	Ялтасны дунд хэсгийн хугархай	7	-	GSN-2024. Survey. Bag-17(1)
7	Ялтасны үзүүрийн хугархай	1	-	GSN-2024. Survey. Bag-17(1)
8	Залтас	19	Дундаж, жижиг	GSN-2024. Survey. Bag-17(1)
9	Хагархай, хэлтэрхий	4	Жижиг	GSN-2024. Survey. Bag-17(1)
Нийт		47		

Шаантган үлдэц. Суурь, нэг хажууг нь суулгахад зориулан ирмэг гарган зассан. Нэг хажуу талд цуулалтын гадаргууг бэлтгэж бичил ялтас цуулж авчээ.

Хусуур. Хоёрыг ялтас, хоёрыг залтсаар хийжээ. Гурав нь төгсгөл хусуурын төрөлд хамаарах бол сүүлийнх нь залтасны хажуу ирмэгийг босоо холтчин ирлэсэн байна.

Самбар чулууны хагархай. Нарийн ширхэгтэй элсэн чулуугаар хийжээ. Нэг тал нь хэрэглээний явцад үрэгдэн зүлгэгдэж мөлийжээ. Мөн ийм жижиг хэлтэрхий 1 байна.

Бусад нь ялтас, залтас, хагархай хэлтэрхий юм. Эндэхийн чулуун зэвсгийн олдвор ерөнхийдөө неолитын хэв шинжийг илтгэж байна.

Нам ухаагийн 3-р суурин

Өмнөх дурсгалаас ялимгүй баруун хойш 220 м орчим зайд оршино. Хөндлөнгийн голын араас шахаж тогтсон Нам ухаагийн дэнжийн ирмэгээр хөрсөн дээр цөөн тооны олдвор тархсан байна (Зураг 113). Эндээс бид 88 олдвор түүвэрлэн цуглуулсан. Тэдгээр нь чулуун зэвсэг, ваарын хагархай, ширмэн тогооны хэлтэрхий зэрэг юм (Хүснэгт 34).



Зураг 113. Нам ухаагийн 3 дугаар суурин (зургийг баруун талаас)

Үлдэц. Нэг хажуу талд цуулалтын гадаргууг бэлтгэж ялтас салган авсан оромтой. Цохилтын талбайг дахин засаж тайрчээ. Хоёр дахь үлдэц жижиг шаантган ирмэгтэй, цуулалтын гадаргуудаа олон ялтас салгаж авсан оромтой.

Техникийн цуулдас. Нэг нь үлдцийн хажууг дахин засах явцад гарчээ. Нөгөөх нь цохилтын талбайн хэсэг юм.

Хусуур. Нимгэн дугуй залтасны төгсгөл ирмэгийг босоо холтчин жижгээр ирлэжээ.

Иртэй залтас. Тэгш хэмт ялтасны дунд хэсгийн хугархай бөгөөд хоёр ирмэгийг ар талаас жижгээр холтчин ирлэжээ. Цуглуулга дахь чулуун зэвсгийн олдворын ихэнхийг залтас, ялтас, ялтасны хугархай, хагархай хэлтэрхий бүрдүүлнэ.

Ваарын хагархай нэг олдсоныг гялтгануурын орцтой нарийн ширхэгтэй шавраар хийжээ. Шатаалт сайн. 8 мм орчим зузаан ханатай ажээ.

Хэдийгээр олдвор цөөн боловч жижиг, бичил ялтас цуулж авахад зориулагдсан шаантган үлдэц, жижиг техникийн цуулдас зэрэгт тулгуурлавал, неолитын үед холбогдох нь тодорхой байна.

Хүснэгт 35. Нам ухаагийн 3-р сууринны олдворын ангилал

№	Олдворын төрөл	Тоо	Хэмжээ (mm)	Олдворын дугаар
1	Үлдэц	2	-	GSN-2024. Survey. Bag-17(2)
2	Техникийн цуулдас	2	-	GSN-2024. Survey. Bag-17(2)
3	Хусуур	1	-	GSN-2024. Survey. Bag-17(2)
4	Самбар чулууны хагархай	1	-	GSN-2024. Survey. Bag-17(2)
5	Иртэй ялтас	2	-	GSN-2024. Survey. Bag-17(2)

6	Залтас	43	Дундаж, жижиг	GSN-2024. Survey. Bag-17(2)
7	Ялтасны дээд хэсэг	5	-	GSN-2024. Survey. Bag-17(2)
8	Ялтасны дунд хэсгийн хугархай	11	-	GSN-2024. Survey. Bag-17(2)
9	Ялтасны үзүүрийн хугархай	4	-	GSN-2024. Survey. Bag-17(2)
10	Хагархай хэлтэрхий	15	-	GSN-2024. Survey. Bag-17(2)
11	Ваарын хагархай	1	-	GSN-2024. Survey. Bag-17(2)
12	Ширмэн тогооны хэлтэрхий	1	-	GSN-2024. Survey. Bag-17(2)
Нийт		88		

Нам ухаагийн 4-р суурин

Нам ухаагийн 1 дүгээр сууринаас зүүн урагш, Хөндлөнгийн голын арын дэнж салхинд идэгдэж урагш харсан нэлээд том хунх хотгор үүссэн (Зураг 114) байх бөгөөд эндэхийн элсэн дунд хайгуул хийх явцад цөөн тооны чулуун зэвсгийн олдвор илрүүлсэн.

Чулуун зэвсгийн олдвор сийрэг боловч зузаан элсэн дундаас хотгорын энд тэндээс нэлээд олдох төлөвтэй.



Зураг 114. Нам ухаагийн 4 дүгээр суурин (зургийг баруун талаас)

Эндээс 97 олдвор түүвэрлэн цуглуулсан нь чулуун зэвсэг, ваарын хагархай юм (Хүснэгт 35).

Бэлдэц. Ар тал руугаа хазгайдуу том цохилтын талбайтай. Хажуугийн нарийн ирмэгийг дагуулан урт ялтас салган авсан оромтой. Урт ялтас цуулж авах шаантган үлдэц хийхээр зэхсэн бололтой.

Шаантган үлдэц. Жижиг хэмжээтэй. Суурь, нэг хажууг ирмэг гарган засжээ. Цуулалтын гадаргуудаа тэгш хэмт бичил ялтас салган авсан олон оромтой.

Хүснэгт 36. Нам ухаагийн 4-р сууринны олдворын ангилал

№	Олдворын төрөл	Тоо	Хэмжээ (mm)	Олдворын дугаар
1	Бэлдэц	1	-	GSN-2024. Survey. Bag-18
2	Шаантган үлдэц	2	-	GSN-2024. Survey. Bag-18
3	Цохилтын нэг талбайт, цуулалтын нэг гадаргуут үлдэц	1	-	GSN-2024. Survey. Bag-18

4	Хусуур	6	-	GSN-2024. Survey. Bag-18
5	Зуулга ир	2	-	GSN-2024. Survey. Bag-18
6	Зэвсгийн бэлдэц	1	-	GSN-2024. Survey. Bag-18
7	Бүтэн ялтас	4	-	GSN-2024. Survey. Bag-18
8	Ялтасны дээд хэсгийн хугархай	5	-	GSN-2024. Survey. Bag-18
9	Дунд хэсгийн хугархай	3	-	GSN-2024. Survey. Bag-18
10	Залтас	27	-	GSN-2024. Survey. Bag-18
11	Хагархай, хэлтэрхий	13	-	GSN-2024. Survey. Bag-18
12	Ваарын хагархай	32	-	GSN-2024. Survey. Bag-18
Нийт		97		

Цохилтын нэг талбайт, цуулалтын нэг гадаргуут үлдэц. Гурвалжиндуу хэлбэртэй. Нарийн цохилтын талбайтай бөгөөд цуулалтын гадаргууд өргөн тэгш хэмт ялтас цуулж авсан хэд хэдэн зэрэгцээ оромтой.

Хусуур. Бүгдийг залтсаар хийжээ. Гурав нь жижиг, бусад нь дундаж хэмжээтэй. Залтасны ирмэгийг босоо болон налуу холтчин хусуурын ир гаргажээ.

Зуулга ир. Тэгш хэмтэй ялтасны дунд хэсгийг тайрч зах ирмэгийг жижгээр ирлэжээ.

Зэвсгийн бэлдэц. Гурвалжиндуу хэлбэртэй зэв хийхээр бэлтгэсэн бөгөөд зах ирмэгээс төв рүү чиглүүлэн холтчин засаж эхлээд орхижээ.

Цуулдасны үйлдвэрлэлийн ангилалд хамаарах ялтас, залтас, хагархай, хэлтэрхий цуглуулгын үлэмж хувийг бүрдүүлж байна.

Ваарын хагархай дотор неолитын хэв шинжтэй ваарын хагархай алга. 4 нь амсрын хагархай ажээ. Тэдгээрийн амсрын ирмэг гадагш эргэсэн дэрвэгэр. Түүнчлэн зарим эдлэл дээр хятан хээ буй нь эдгээр ваарын хагархай хожуу үед холбогдохыг харуулж буй.

Нам ухаагийн 5-р суурин

Хөндлөнгийн голын Нам ухаагаас илрүүлсэн дурсгалуудаас хамгийн сонирхолтой нь энэ суурин юм. Нам ухаа баруун талдаа аажуу налж голын түвшний дэвсгэ газартай нийлдэг (Зураг 115).



Зураг 115. Нам ухаагийн 5 дугаар суурин (зургийг баруун урд талаас)

Ийнхүү налсан ирмэгийн өвс халцарч элсэрхэг хөрс нэлээд том талбайд ил гарсан (Зураг 116) байх бөгөөд янз бүрийн материалаар хийсэн чулуун зэвсэг, самбар чулуу, шавар ваарын хагархай зэрэг эртний амьдралын ул мөр элсэрхэг хөрсөн дээр шигүү тархжээ. Мөн амьтны яс хэд хэдэн газарт мэдэгдсэн билээ.



Зураг 116. Нам ухаагийн 5 дугаар суурины олдвор тархсан хэсэг (зургийг урд талаас)

Эндээс 155 олдвор түүвэрлэн цуглуулсан бөгөөд зарим эдлэл элсэрхэг шаварлаг хөрсөнд гүн шигдсэн байв (Хүснэгт 36).

Бэлдэц. Гурван эдлэлд цохилтын талбай гүйцэд бэлтгэжээ. Үлдсэн хоёрт гаргаад гүйцэд засалгүй орхисон байна. Бэлдцийн хажуу ирмэг, суурийг зассан оромтой. Эдгээр

бэлдэц жижиг, бичил ялтас цуулж авах шаантган болон торх хэлбэртэй үлдэц хийхэд зориулагдсан бололтой.

Шаантган үлдэц. Суурь, нэг хажуу талыг шаантган ирмэг гарган зассан үлдэц юм. Цуулалтын гадаргууг нэг хажуу талд гаргаж зэрэгцээ цуулалтаар жижиг болон бичил ялтас цуулж авсан олон оромтой (Зураг 117. 1, 2).



Зураг 117. Нам ухаагийн 5-р суурин. 1, 2 – шаантган үлдэц, 3, 4 – шовх үлдэц.

Тайрдсан үлдэц. Ар талыг нь тэгшлэн зассан. Шовхдуу суурьтай бөгөөд хоёр хажуу, нүүрэн талаас олон ялтас цуулж авсан оромтой.

Шовх үлдэц. Бүгд тэгш цохилтын талбайтай бөгөөд хажуугийн периметрийн дагууд цуулалт хийгджээ. Суурь нь шовх болон өргөндүү хоёр янз байна (Зураг 117. 3, 4).

Хүснэгт 37. Нам ухаагийн 5-р сууринны олдворын ангилал

№	Олдворын төрөл	Тоо	Хэмжээ (mm)	Олдворын дугаар
1	Бэлдэц	5	-	GSN-2024. Survey. Bag-19(1)

2	Шаантган үлдэц	5	-	GSN-2024. Survey. Bag-19(1)
3	Тайрдсан үлдэц	3	-	GSN-2024. Survey. Bag-19(1)
4	Шовх үлдэц	5	-	GSN-2024. Survey. Bag-19(1)
5	Хусуур	4	-	GSN-2024. Survey. Bag-19(1)
6	Сүх	1	-	GSN-2024. Survey. Bag-19(2)
7	Цоолтуур	1	-	GSN-2024. Survey. Bag-19(2)
8	Самбар чулууны хагархай	1	163x116x23	GSN-2024. Survey. Bag-19(2)
9	Чулуун эдлэл	1	62x79x78	GSN-2024. Survey. Bag-19(2)
10	Бүтэн ялтас	8	-	GSN-2024. Survey. Bag-19(1)
13	Ялтасны дээд хэсгийн хугархай	5	-	GSN-2024. Survey. Bag-19(1)
14	Ялтасны дунд хэсгийн хугархай	7	-	GSN-2024. Survey. Bag-19(1)
15	Ялтасны үзүүрийн хугархай	4	-	GSN-2024. Survey. Bag-19(1)
16	Залтас	59	Том, дундаж, жижиг	GSN-2024. Survey. Bag-19(1)
17	Хагархай	21	Жижиг	GSN-2024. Survey. Bag-19(1)
18	Ваарын хагархай	25	Хагархай, хлтэрхий	GSN-2024. Survey. Bag-19(1)
Нийт		155		

Сүх. Зуувандуу хэлбэртэй, оольтой төстэй боловч ирэн хэсгийг гол тэнхлэгийн дагууд гаргажээ. Хажуу талаас хөндлөн, ташуу цуулалтаар нимгэлжээ. Суурь нь ялимгүй долиотой хурц ирмэгтэй. Сүхний чулуун толгой ажээ (Зураг 118. 1).



Зураг 118. Нам ухаагийн 5-р суурин. 1 – сүх, 2 - хусуур

Хусуур. Дугуй хэлбэртэй жижиг залтасны ирмэгийг тойруулан ирлэжээ (Зураг 118. 2).

Цоолтуур. Хоёр талтай ялтасны дээд хэсгийг тайрч хоёр ирмэгийг үзүүр хүртэл нь ар талаас нь холтчин ирлэж хурцалжээ. Иш суулгаж ашиглах цоолтуурын үзүүр ажээ.

Самбар чулууны хагархай. Нарийн ширхэгтэй элсэн чулуугаар хийсэн урт, нарийн самбар чулууны нэг талын хугархай юм. Зах ирмэгийг мөлийлгөн зассан бөгөөд нэг талын үзүүрт гурив ховил гарган гарт барихад эвтэй, үзэмжтэй болгон засжээ. Нэг өргөн талд хэрэглээний явцад зүлгэгдэн мөлийсөн байна (Зураг 118). Үүнтэй төстэй самбар чулуу урд өмнө нь олдож байсан билээ.

Чулуун эдлэл. Нарийн ширхэгтэй элсэн чулуугаар хийжээ. Бөөрөнхийдүү хэлбэртэй боловч нэг тал нь хавтгайдуу ажээ. Энэ нь газарт тавих хэсэг бололтой. Дээд талд нь 3 мм орчим голчтой, доош нь 1.5 мм орчим гүн хонхойлжээ (Зураг 120). Үүрэг зориулалт нь төдийлэн тодорхойгүй. Бид ямар нэг зүйлийн суурь, огтоогч болов уу хэмээн таамаглаж байна.



Зураг 119. Нам ухаагийн 5-р суурин. *Самбар чулууны хагархай*



Зураг 120. Нам ухаагийн 5-р суурин.
Чулуун эдлэл

Ваарын хагархай. Хоёр өөр төрлийн ваар байна. Эхний бүлэгт сайн шатаалттай, гадар дээрээ шүүр маягийн дэлдүүрээр гаргасан хээтэй ваарын хоёр хагархай хамаарна. Дараагийн бүлэгт чулуу, гялтгануурын хольцтой шавраар хийсэн 8 мм орчим зузаан ханатай дунд зэргийн шатаалттай ваарын хагархай хамаарна. Эдгээр нь тухайн суурины оршин суугчидтай холбоотой байж мэднэ. Мөн зах руугаа нимгэн дунд зэргийн шатаалттай шавар самбар маягийн эдлэлийн хагархай байна. Эдгээр ваар нь тухайн сууринг үлдээгчдийн шавар эдлэл байх бүрэн

боломжтой ажээ.

Чулуун зэвсгийн олдвор, ваар сав тухайн газарт өндөр нягтаршилтай тархсан, төрөл зүйл олон байгаа зэрэг нь энд анчин, түүвэрлэгчид нэлээд урт хугацаанд амьдарч байсны илрэл бололтой. Тиймээс цаашид малтлага судалгаа хийж тодруулах шаардлага бий. Бид ирэх жилүүдэд энд малтлага хийхээр төлөвлөж байна.

Хөндлөнгийн голын 1-р суурин

Нам ухаагийн 5 дугаар дурсгалаас баруун урагш 720 м орчим зайд, Хөндлөнгийн голын урд талд хойш харсан өндөр эрэг бий. Үерийн усанд эрэг нурж голын сав тэлсээр байгаа бөгөөд эргийн дээд тал салхины нөлөөгөөр өвс халцарч хойш буюу эргийн ирмэг рүү ялимгүй налсан хунх бий болжээ (Зураг121).



Зураг 121. Хөндлөнгийн голын 1 дүгээр суурин (зургийг зүүн талаас)

Эргийн оройн элсэн хунхаар хайгуул судалгаа хийх явцад энд чулуун зэвсэг, ваар савны хагархай зэрэг олдвор илрүүлсэн юм (Хүснэгт 37).

Эндээ илрүүлсэн хамгийн сонирхолтой олдвор бол цайвар өнгөтэй хасаар хийсэн гоёл чимэглэлийн зүйл юм (Зураг 122).



Зураг 122. Хөндлөнгийн голын 1 дүгээр суурингаас илрүүлсэн хасаар хийсэн гоёл чимэглэлийн зүйл ба олдсон газар

Бэлдэц. Нэг нь шаантган үлдэц хийхээр зэхсэн бөгөөд ихэнх хэсэгтээ чулууны өнгөн бүрхүүлээ хадгалжээ. Нөгөөх нь Тайрдсан үлдцийн бэлдэц ажээ.

Үлдэц. Бүгд тэгш цохилтын талбайтай. Цуулалтын гадаргууг эдлэлийн нүүр, хажуу талд бэлтгэж ялтас салган авсан оромтой (Зураг 123. 1, 3).



Зураг 123. Хөндлөнгийн голын 2-р дурсгал. 1, 3 – үлдэц, 2 – чулуун зүүлт

Хусуур. Жижиг болон дундаж хэмжээтэй залтсаар хийжээ. Залтасны хажуу, төгсгөл ирмэгийг босоо, налуу холтчин ирлэжээ.

Хүснэгт 38. Хөндлөнгийн голын 1-р суурины олдворын ангилал

№	Олдворын төрөл	Тоо	Хэмжээ (mm)	Олдворын дугаар
1	Бэлдэц	2	-	GSN-2024. Survey. Bag-20
2	Үлдэц	7	-	GSN-2024. Survey. Bag-20
3	Хусуур	3	-	GSN-2024. Survey. Bag-20
4	Самбар чулууны хагархай	5	-	GSN-2024. Survey. Bag-20
5	Чулуун зүүлт	1	38x32x3	GSN-2024. Survey. Bag-20
6	Ялтасны дээд хэсгийн хугархай	2	-	GSN-2024. Survey. Bag-20
7	Ялтасны дунд хэсгийн хугархай	2	-	GSN-2024. Survey. Bag-20
8	Залтас	18	-	GSN-2024. Survey. Bag-20
9	Хагархай, хэлтэрхий	4	-	GSN-2024. Survey. Bag-20
10	Ваарын хагархай	18	-	GSN-2024. Survey. Bag-20
Нийт		62		

Самбар чулууны хагархай. Янз бүрийн хэлбэртэй. Аль нэг тал нь хэрэглээний явцад зүлгэгдэж мөлийжээ.

Чулуун зүүлт. Зуувандуу хэлбэртэй дундаа нэвт нүхтэй чулуун зүүлт юм. Түүнийг цайвар өнгөтэй манаар хийсэн агаад бүхэлд нь зүлгэх аргаар бэлтгэжээ. Хажуугийн ирмэгүүд ихэд гөлгөр, нимгэн ажээ. Эдлэлийн голд 12x10 мм хэмжээтэй нэвт нүхтэй (Зураг 123. 2). Ийм төрлийн олдвор Монголоос анх удаа олдож буй бөгөөд Өвөр Байгалын неолитын оршуулгад толгойн гоёл маягаар тавьсан эдлэл тааралдаж байжээ.

Чулуун зэвсгийн олдворын бүрдэлд ялтас, ялтасны хугархай, залтас, хагархай, хэлтэрхий олон бий.

Ваарын хагархай. Янз бүрийн ваарын хагархай юм. Хожуу үеийн гадрыг нь зүлгэсэн, пааландсан эдлэлээс гадна шатаалт муухантай, чулууны орцтой шавраас хийсэн зузаан хэлтэрхий хэд хэд байна. 6 мм орчим зузаан босоо амсрын хэсэг неолитын үед хамаарах магадлалтай бөгөөд түүний гадар дээр наамал хээний ор байна.

Хөндлөнгийн голын урд эрэгт орших энэ дурсгал неолитын үед холбогдох нь тэндээс олдсон үлдэц, багаж зэвсгийн зүйл зэргээс тодорхой байна. Харин олдвор эд өлгийн зүйл элсэн хөрсөнд ихэд холилдон анхны байрлал хөдөлсөн шинжтэй ажээ.

Хөндлөнгийн голын 2-р суурин

Өмнөх дурсгалаас баруун тийш 1.6 км зайд, Хөндлөнгийн гол, Их булагийн бэлчрээс урагш, голын урд талын хойшоо ялимгүй налуу газарт энэ дурсгал оршино (Зураг 124).

Голын урд талд өнгөн хэсгийн элс салхинд хийссэн, өвс ургамалгүй, нарийн ширхэгтэй шаварлаг хөрсөн дээр чулуун зэвсгийн олдвор, ваарын хагархай, амьтны ясны үлдэгдэл, тэмээн хяруулын өндөгний хальс өндөр нягтаршилтай тархсан байна (Зураг 126). Энэ газар ширүүн бороо орсон үед голын урд дэнжээс буусан борооны усанд угаагдаж шал маягтай болсон бөгөөд олдворын байршилд ч зохих нөлөө үзүүлдэг бололтой.

Д.Дугарсүрэн эндээс ясан биетэй чулуун ир бүхий зуулга хутга хийгээд амьтны яс олж байсан тухай хэлсэн тул бид энэ газрыг шалгаж үзэв.



Зураг 124. Хөндлөнгийн голын 2 дугаар дурсгал ба голын адаг, Үйзэнгийн цагаан нуур (зургийг зүүн талаас)

Их төлөв цахиурын төрлийн чулуугаар хийсэн үйлдвэрлэлийн янз бүрийн үед холбогдох чулуун зэвсгийн олдвор асар их байна (Хүснэгт 38). Мөн гүйцэд зассан, ашиглаж байсан ул мөртэй самбар чулууны хагархай зэргээс харахад, энэ газарт хүмүүс урт хугацаагаар суурьшиж байсан нь тодорхой байна.



Зураг 125. Хөндлөнгийн голын 2-р суурин. 1 – үлдэц, 2 – ооль, 3, 4 - хусуур

Хайгуул хийх явцад шаварлаг хөрсөн дээр гал голомтын үлдэгдэл байж магадгүй жижиг чулуу тойруулсан ул мөр мэдэгдсэн тул шалгаж малтаж үзсэн боловч голомтын ул мөр биш ажээ.

Чулуун зэвсгийн олддворын хувьд үлдэц (Зураг 125. 1), бэлдэц, хоёрдогч боловсруулалт хийсэн олон янзын багаж зэвсэг (Зураг 125. 2, 3, 4), цуулдасны үйлдвэрлэлд хамаарах залтас, ялтас, хагархай хэлтэрхий зэрэг олон төрлийн олдвор хөрсөн дээр тархсан байна.

Хүснэгт 39. Хөндлөнгийн голын 2-р суурины олдворын ангилал

№	Олдворын төрөл	Тоо	Хэмжээ (mm)	Олдворын дугаар
1	Бэлдэц	5	-	GSN-2024. Survey. Bag-21
2	Шаантган үлдэц	3	-	GSN-2024. Survey. Bag-21
3	Тайрдсан үлдэц	3	-	GSN-2024. Survey. Bag-21
4	Шовх үлдэц	10	-	GSN-2024. Survey. Bag-21
5	Үлдцийн хагархай	5	-	GSN-2024. Survey. Bag-21
6	Техникийн цуулдас	4	-	GSN-2024. Survey. Bag-21
7	Ооль	2	-	GSN-2024. Survey. Bag-21
8	Зэвсгийн бэлдэц	2	-	GSN-2024. Survey. Bag-21
9	Хусуур	14	-	GSN-2024. Survey. Bag-21
10	Шүдлэг, хүнхэр ирт зэвсэг	1	-	GSN-2024. Survey. Bag-21
11	Ирлэсэн хагархай	1	-	GSN-2024. Survey. Bag-21
12	Сийлүүр	1	-	GSN-2024. Survey. Bag-21

13	Иртэй ялтас	5	-	GSN-2024. Survey. Bag-21
14	Бүтэн ялтас	11	-	GSN-2024. Survey. Bag-21
15	Ялтасны дээд хэсгийн хугархай	14	-	GSN-2024. Survey. Bag-21
16	Ялтасны дунд хэсгийн хугархай	16	-	GSN-2024. Survey. Bag-21
17	Ялтасны үзүүрийн хугархай	9	-	GSN-2024. Survey. Bag-21
18	Залтас	4	Том	GSN-2024. Survey. Bag-21
19	Залтас	127	Дундаж, жижиг	GSN-2024. Survey. Bag-21
20	Хайрс	6		GSN-2024. Survey. Bag-21
21	Хагархай, хэлтэрхий	32	Дундаж, жижиг	GSN-2024. Survey. Bag-21
22	Самбар чулууны хагархай	9	Дундаж, жижиг	GSN-2024. Survey. Bag-22
23	Нүдүүрийн хугархай	1	Хэлтэрхий	GSN-2024. Survey. Bag-22
24	Шавар эдлэлийн хэлтэрхий	26	Хагархай, хэлтэрхий	GSN-2024. Survey. Bag-23
25	Хясааны хэлтэрхий	2	-	GSN-2024. Survey. Bag-23
26	Тэмээн хяруулын өндөгнийхаль	8	-	GSN-2024. Survey. Bag-23
Нийт		321		



Зураг 126. Хөндлөнгийн голын 2 дугаар суурин (зургийг баруун хойд талаас)

Хэдийгээр энэ орчимд бараандуу өнгөтэй хөрс мэдэгдэх боловч голоцены үеийнх, эсэх нь одоогоор тодорхойгүй байна. Бид газрын хөрсөн дээр буй асар олон олдвороос сонголтын зарчмаар цөөн олдвор түүвэрлэн авсан бөгөөд цаашид өргөн хүрээнд малтлага судалгаа хийхээр төлөвлөж байна.

Нам ухаагийн хүрлийн үеийн дурсгал

Нам ухаагийн орой, түүний зүүн талын хадархаг өндөрлөг дээр хүрлийн үеийн улаан зуух хэлбэрийн булш оршуулга нэлээд олон байна. Бид хайгуулын явцад булш оршуулгын дурсгалыг нэг бүрчлэн тэмдэглэж баримтжуулаагүй боловч чулуун зэвсгийн дурсгалт газрын орчимд байсан дурсгалуудыг бүртгэн баримтжуулав.

Нам ухаагийн 1-р булш. Нам ухаагийн чулуун зэвсгийн 1 дүгээр сууринд, урд талын элсэн хотгорын хойд ирмэг дээр бий. Элсэн хөрсөнд нэлээд дарагдсан тэгш өнцөгт маягийн дараастай ажээ (Зураг 127).

Нам ухаагийн 2-р булш. Өмнөх булшнаас баруун тийш 30 м зайд, элсэн хотгорын ирмэг дээр хөрсөнд ихэд дарагдсан дараас чулууны хэсэг мэдэгдэнэ. Улаан зуух хэлбэрийн булш бололтой (Зураг 128).



Зураг 127. Хөндлөнгийн голын Нам ухаагийн 1-р булш



Зураг 128. Хөндлөнгийн голын Нам ухаагийн 2-р булш

Нам ухаагийн 3-р булш. Өмнөх дурсгалаас баруун тийш 28 м зайд, элсэн хотгорын ирмэгт оршино. Булшны дараасны зарим хэсэг хотгорын ирмэгт идэгдэж нуржээ. Дундаж хэмжээтэй чулуугаар үйлдсэн тэгш намхан дараастай Улаан зуух хэлбэрийн булш ажээ (Зураг 129).

Нам ухаагийн 4-р булш. Өмнөх дурсгалаас зүүн тийш Нам ухаагийн оройн тэгш дэвсгэг дээр оршино (Зураг 130).



Зураг 129. Хөндлөнгийн голын Нам ухаагийн 3-р булш



Зураг 130. Хөндлөнгийн голын Нам ухаагийн 4-р булш

Нам ухаагийн 5-р булш. Нам ухаагийн оройн тэгш дэвсгэг дээр тэгш өнцөгт маягийн хэлбэртэй, намхан дараастай Улаан зуух хэлбэрийн булш байна. Ер нь Нам ухаагийн оройн

тэгш дэвсэг дээр буюу өмнө өгүүлсэн хоёр элстэй хотгороос зүүн тийш Улаан зуух хэлбэрийн булш оршуулга нэлээд хэд бий (Зураг 131).

Нам ухаагийн 6-р булш. Нам ухаагийн зүүн талын хадархаг өндөрлөг дээр булш оршуулгын дурсгал нэлээд олон байна. Бид цаг хугацааны боломжоос шалтгаалан нэг бүрчлэн тэмдэглээгүй. Эндэхийн булш оршуулга нь тухайн бүс нутгийн хүрлийн үеийн хамгийн эртний дурсгал болох Улаан зуух хэлбэрийн булш ажээ (Зураг 132).



Зураг 131. Хөндлөнгийн голын Нам ухаагийн 5-р булш



Зураг 132. Хөндлөнгийн голын Нам ухаагийн 6-р булш

Нам ухаагийн 7-р булш. Нам ухаагийн баруун төгсгөл, чулуун зэвсгийн 5 дугаар дурсгалын дэргэд бий. Нам ухаагийн баруун ирмэгийн өндөрлөг газарт буюу холоос харууц сайн газарт энэ булшийг үйлджээ.

Дараас чулуу хөрсөнд ихэд дарагдсан бөгөөд баруунаас зүүн тийш нэлээд сунасан хашлага чулуутай ажээ (Зураг 133). Дурсгалын орших орчин, ерөнхий хэлбэрээс харахад, түрүүлгэ нь харуулсан оршуулгат булшны том төлөөлөл шоргоолжин булш бололтой. Энэ дурсгалаас хойш авто замын хойд, урд талд хэд хэдэн улаан зуух хэлбэрийн булш бий.



Зураг 133. Хөндлөнгийн голын Нам ухаагийн 7-р булш

Нам ухаагийн орчмоос илрүүлсэн дээр дурдсан булш оршуулгын дурсгал бүгд Монгол орны говь, хээрийн бүс нутагт голлон тархсан түрүүлгэ нь харуулсан оршуулгат булш ажээ. Ихэнх нь Улаан зуух хэлбэрийн булшны төрөлд хамаарах бол нэг дурсгалын гадаад байгууламж шоргоолжин булш болохыг илтгэж байна. Хэдийгээр булш оршуулгын дурсгал тонож сүйтгэсэн зүйл байхгүй боловч байгалийн элэгдлээр эвдэгдэж сүйдэж буй хэд

хэдэн оршуулга тааралдав. Тиймээс эдгээр дурсгалыг авран хамгаалж малтлага судалгаа хийх зайлшгүй шаардлагатай байна.

2.2.29. Хөндлөнгийн голын хэрэм

Хөндлөнгийн голын сав нутагт судалгаа хийх явцад Д.Дугарсүрэн гуай голын урд биед нэг сонирхолтой дурсгал байдаг. Чухам юу гэдгийг сайн мэдэхгүй ч хүний гараар бүтсэн зүйл гэдэг нь тодорхой хэмээн биднийг замчилж авч очсон билээ.

Энэ нь шороо дагтаршуулан барьсан хэрэм ажээ. Энэ хэрэм Их булаг, Хөндлөнгийн голд цутгах бэлчрээс зүүн урагш 4 км зайд, Нам ухаагаас урагш 800 м хүрэхгүй зайд, голын урд талыг тэгш дэвсэг дээр байна (Зураг 134).

Хэрэм баруун хойноос зүүн урагш буюу ялимгүй ташуу байрлалтай, зууван хэлбэртэй. Өөрөөр хэлбэл, талууд нь тэгш харьцаатай бус, гадагш цүлхгэр ажээ (Зураг 135). Зүүн талд хоёр хаалганы ор мэдэгдэнэ. Хэрэм баруунаас зүүн тийш 850 м, хойноос урагш 633 м хэмжээтэй, газрын хөрснөөс дээш 0,7 – 1 м орчим өндөр ажээ.



Зураг 134. Хөндлөнгийн голын урд дэвсэгийн хэрэм (зургийг урд талаас)

Хэрмийн дотор барилга байшингийн ул мөр байхгүй. Хожуу үеийн бололтой паалантай ваарын хагархай, ахуйн хэрэглээний төмрийн хугархай зэргээс өөр эд өлгийн зүйл олдсонгүй. Гэхдээ бидэнд цаг хугацаа давчуу байснаас хангалттай хугацаанд энд хайгуул хийгээгүйг хэлэх хэрэгтэй. Гэвч хөрсөн дээрх олдвор эд өлгийн зүйл хомс байгаа нь

уг хэрэмд хүн урт хугацаагаар байгаагүйг илтгэж байна. Харин ваарын хагархай, төмөр эдлэлийн хэсэг нь тухайн хэрмийг төлөөлөх олдвор болж чадахгүй юм.

Хэдийгээр хэлбэрийн хувьд адилгүй боловч орших орчин, дотор нь орон суурийн ул мөр байхгүй зэрэг байдлаараа Өмнөговь аймгийн Баяндалай сумын нутгаас судлаачдын илрүүлсэн зэрэгцээ хэрэм, Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын нутагт Онгийн голын баруун эрэгт буй Шивээт хошууны хэрэмтэй⁵⁷ төстэй зүйл байна. Эдгээр хэрмийг судлаачид Манжийн үед холбогдуулан үздэг.

Дарьганга бол Манжийн эрхшээлийн үед Сүрэгчин хошууны гол нутаг байсан билээ. Ялангуяа, Хөндлөнгийн голын сав нутаг нь өн шимлэг өвс бэлчээртэй тул уг хэрэм даланг мал ахуйн үйлтэй холбоотой байх магадлалтай хэмээн таамаглаж байна. Дарьгангын нутгийн зурагт энэ хэрмээс холгүй Их булагаар дайрч өнгөрсөн худалдааны замыг тэмдэглэсэн байдаг⁵⁸.

Энэ газар өвс бэлчээр сайн, мал амьтны бэлчээр нутаг тул лавтай голоцены дунд үеэс хойш хүн нутаглаж ирснийг илтгэх олон үеийн дурсгал байна. Тиймээс цаашид хайгуул судалгааг илүү нарийвчлалтай хийж хэрмийн холбогдох үе, үүрэг зориулалттай холбоотой баримт илрүүлэх шаардлага тулгарч байна.



Зураг 135. Хөндлөнгийн голын хэрмийн агаарын зураг

⁵⁷ Э.Уртнасан, л.Эрдэнэболд, Б.Анхбаяр, Д.Содномжамц. Сайн ноён хан аймгийн Үйзэн засгийн хошууны нутаг дахь эртний хот, суурины дурсгал. Сайн ноён хан аймгийн Үйзэн засгийн хошуу: хэл, түүх, соёл, байгаль. УБ., 2024. тал. 175-178

⁵⁸ Ж.Гэрэлбадрах. Дарьгангын гурван газрын зургийг нятлах нь. Монгол судлал ба тогтвортой хөгжил II. Олон Улсын Монголч Эрдэмтний XI их хурлын "Монголын түүх судлал" II салбар хуралдааны илтгэлүүд. Эрхэлсэн С.Чулуун. УБ., 2017. тал 47

Хөндлөнгийн голын сав, тэр дундаа Нам ухаа орчмын нутаг түүхийн олон үед холбогдох дурсгалтай, судалгааны хувьд ихээхэн сонирхолтой нь тэнд хийсэн хайгуул судалгааны явцад тодорхой болсон юм. Цаашид эндэхийн хүрлийн үеийн булш оршуулгын дурсгалыг нэг бүрчлэн бүртгэн баримтжуулах, бусад түүхэн үеийн дурсгалын учир холбогдол, он цагийн асуудлыг тодруулах шаардлагатай байна.

Бид ирэх жилүүдэд Хөндлөнгийн гол цутгах Үйзэнгийн цагаан нуур хийгээд Их булагийн орчимд нарийвчилсан хайгуул хийх, Нам ухаа 5 дурсгалыг малтан судлахаар төлөвлөж байна.

2.2.30. Баруун Сөдөтийн голын сав нутагт хийсэн хайгуул судалгаа

Сүхбаатар аймгийн Онгон сумын нутаг Хөндлөнгийн голын сав нутагт хайгуул судалгаа хийж сонирхолтой дурсгал баримтжуулсны дараа бид Молцог элснээс урагш Баруун Сөдөтийн гол орчмоор хайгуул судалгааг үргэлжлүүлэн гүйцэтгэв.

Энд бид их төлөв сүүл үеийн дурсгалтай танилцсан бөгөөд Баруун Сөдөтийн хийд, түүнийг барих явцад ашиглаж байсан болов уу хэмээн таамаглаж буй зуухны үлдэгдэл, төмрийн бэлдэц, төмөр эдлэл олддог газруудад очив.

Тамга бичигтэй чулуу

Сүхбаатар аймгийн Наран сумын нутаг, Сөтөдийн хийдээс хойш 3.8 км зайд, намхавтар уулын баруун хажууг дайрч гарсан авто замын дэргэд бүдүүн ширхэгтэй, цайвар шаргал өнгөтэй зассан боржин чулууны хагархай байна. Гадар дээр нь юу нь үл мэдэгдэх дүрс тэмдэг байх ажээ (Зураг 136). Энэ чулуу эндээс холгүй байх сүм хийдээс авчирсан байх магадлалтай.



Зураг 136. Тамга тэмдэг дүрсэлсэн бололтой боржин чулууны хагархай

Баруун Сөдөтийн зуухны үлдэгдэл

Баруун Сөдөтийн хийдийн тууриас хойш 1.6 км зайд, өргөн хөндийн зүүн хэсгийн элсэн манхны үзүүрт энэ дурсгал оршино. Нэлээд өндөр манхны ар хормойн элс салхинд идэгдсэн байх бөгөөд хар бараан өнгөтэй түлэгдэж халтардсан хөрс ил гарсан нь зуухын ор үлдэц бололтой (Зураг 137). Эргэн тойронд нь шатсан шавар, нүүрсний үлдэгдэл олон байна.



Зураг 137. Манхны арын салхинд идээгдсэн хормойгоос ил гарсан шатсан хөрс

Ямартай ч энэ газар үйлдвэрлэлийн түүхтэй холбоотой гэдэг нь тодорхой байна. Харин хэзээ үе вэ? Гэдэг асуулт гарна. Ойролцоохон газарт Баруун Сөдөтийн хийдийн туурь байгаа тул хийдийг барихад энд барилгын материал юм уу түүнд хэрэгцээтэй зүйлийг үйлдвэрлэж байсан газар болов уу хэмээн таамаглаж байна.

Баруун Сөдөтийн хийдийн туурь

Сүхбаатар аймгийн Наран сумын нутагт, сумын төвөөс зүүн урагш шулуунаар 17 км зайд, элсэн манхны баруун талын тэгш дэвсэг газарт Сөдөтийн хийдийн туурь бий (Зураг 138). Энд олон дуган, байшин байсан бололтой хээтэй, хээгүй хавтан чулуунууд (Зураг 139), хөх тоосго, дээврийн ваар (Зураг 140), газарт чулуу шигтгэж хийсэн байшингийн суурь олон байна.



Зураг 138. Баруун Сөдөтийн хийдийн туурь

Мөн зассан боржин чулуунууд (Зураг 141) нь сүм хийдийн барилга, эсвэл хөшөөний хэсэг бололтой. “Монголын сүм хийдийн товчоон”-нд энэ хийдийг Сөдөтийн хурал хэмээн

тэмдэглэсэн агаад 1868 онд байгуулагдсан⁵⁹ хэмээжээ. Сүхбаатар аймгийн нутаг дахь түүх, соёлын дурсгалт зүйлийг бүртгэлд ч энэ хийдийн тухай мэдээлэл алга. Харин Дарьгангын нутгийн зурагт энэ хийдийг Сөдөтийн сүм гэж тэмдэглэсэн байна⁶⁰. Цаашид энэ хийдийн тухай архивын баримт, нутгийн иргэдийн аман мэдээг цуглуулж, дурсгалын түүхийг тодруулах хэрэгтэй ажээ.



Зураг 139. Сөдөтийн хийдийн туурь. Хавтан чулуу



Зураг 140. Сөдөтийн хийдийн туурь. Дээврийн ваарын хагархай



Зураг 141. Сөдөтийн хийдийн туурь. Хээтэй хавтан чулуу



Зураг 142. Хээлж бичмэглэсэн боржин чулуу

Сөдөтийн хийдийн туурь орчмын түүвэр олдворт газар

Хийдийн тууриас зүүн хойш 500 м орчим зайд, ирмэглэн тогтсон элсэн далангуудын баруун хаяагаар ваар савны хагархай, шинэ чулуун зэвсгийн хэв шинжит чулуун зэвсгийн зүйл сийрэг боловч олдож байна (Зураг 143). Д.Дугарсүрэн гуай эндээс нэлээд олон төмөр зэв олсон бөгөөд бид тэдгээрийг түүний цуглуулгаас үзэхэд, дундад зууны үед холбогдох янз бүрийн хэлбэртэй зэвүүд болох нь тодорхой байв. Бид эндээс түүний цуглуулгад буйтай

⁵⁹ Монголын сүм хийдийн түүхэн товчоон. Ерөнхий ред. С.Цэдэнбямба. УБ., 2009. тал. 598

⁶⁰ Ж.Гэрэлбадрах. Дарьгангын гурван газрын зургийг нятлах нь. Монгол судлал ба тогтвортой хөгжил II. Олон Улсын Монголч Эрдэмтний XI их хурлын “Монголын түүх судлал” II салбар хуралдааны илтгэлүүд. Эрхэлсэн С.Чулуун. УБ., 2017. тал 46-

адил зэв олсонгүй. Харин чулуун зэвсгийн олдвортой хамт улаан өнгөтэй ваарын хагархай хэд хэдийг илрүүлсэн. Мөн хөх өнгөтэй хятан хээтэй шатаалт сайн ваарын хагархай ч таарч байна.



Зураг 143. Сөдөтийн хийдийн туурь орчмын түүвэр олдворт газар ба хятан ваар (зургийг баруун урд талаас)

Тэгэхээр Баруун Сөдөтийн булаг орчмын газар нутаг ус бэлчээр сайхан тул олон үеийн дурсгал энд байгаа бололтой. Мөн эндээс боловсруулсан төмрийн бэлдэц бололтой эдлэл илрүүлсэн. Ер нь Хийдийн ойр орчимд буй зуухны үлдэгдэл, төмрийн үлдэгдэл бүхий газрууд энэ хийдийг байгуулах, засаж сэлбэх үйл явцтай холбоотой нэлээд сүүл үеийнх байж мэдэхээр ажээ.

2.2.31. Эрдэнэ ууланд хийсэн хайгуул судалгаа

Баруун Сөдөтийн хийдийн тууриас хөдөлж Молцог элсний өмнөд талд орших Эрдэнэ ууланд ирэв. Эрдэнэ ууланд Д.Дугарсүрэн гуай янз бүрийн чулуун байгууламж өмнө үзсэн ажээ. Эдгээр нь хүрлийн үеийн булш оршуулга болон чулуун байгууламж байсан юм. Бид уулын өмнөд хэсэг, оройн дэвсгээр явган хайгуул хийж археологийн дурсгалыг бүртгэн баримтжуулав.

Молцог элсний урд талд, Сүмтийн нуураас зүүн тийш орших галт уулын гаралтай содон тогтоц бүхий намхан хар уулыг нутгийн олон Эрдэнэ уул хэмээдэг ажээ (Зураг 144). Эрдэнэ уул оройгоос ар шил рүүгээ аажим налуу дэвсэгтэй бөгөөд баруун, өмнө, зүүн талдаа огцом хажуутай ажээ. Уулын баруун, өмнө, зүүн талыг ороон том нуурын сав байх бөгөөд энд мал гишгэсэн мөрөн дээр ус тогтоход тос тунарч солонгорч үлддэг гэнэ. Газрын нэр, өвөрмөц тогтоц, нутгийнхны ярианаас энд газрын тос байгаа нь илт ажээ.



Зураг 144. Эрдэнэ уул (зургийг урд талаас)

Эрдэнэ уулын хажуу ирмэг, гол хэсгээс нарийн судаг маягийн хоолойгоор зааглагдаж урагш түрж тогтсон жижиг толгойн оройгоор бутарч унасан галт уулын гаралтай хүрмэн чулуулаг элбэг ажээ. Энэ чулуулгаар эртний нүүдэлчид нас барагчдаа булш оршуулга, чулуун байгууламж үйлдсэн нь Эрдэнэ уулын ар шилийн дэвсгэ, урагш хошуурсан жижиг хошуун дээр хэд хэдээрээ бүлэглэн оршиж байна.

Бид Эрдэнэ уулын булш оршуулгын дурсгалыг урд талаас нь эхлэн бүртгэж баримтжуулав.

Эрдэнэ уулын 1-р чулуун байгууламж. Эрдэнэ уулын урд талын жижиг толгой дээр зэрэгцэн орших хэдэн чулуун байгууламж байна. Эхнийх нь зүүн талынх бөгөөд галт уулын гаралтай хөвсгөр хүрмэн чулуугаар хийсэн дугуй хэлбэртэй, намхан битүү дараастай ажээ. Гадаад байгууламжид тулгуурлан он цаг, үүрэг зориулалтыг тодорхойлох боломжгүй. Магадгүй Монголын үед холбогдох булш оршуулга байх магадлалтай (Зураг 145).

Эрдэнэ уулын 2-р чулуун байгууламж. Өмнөх дурсгалын баруун талд зэрэгцэн оршино. Дундаж хэмжээтэй чулуугаар хийсэн овгордуу дараастай чулуун байгууламж юм (Зураг 146а).



Зураг 145. Эрдэнэ уулын 1-р чулуун байгууламж (зургийг зүүн талаас)



Зураг 146а. Эрдэнэ уулын 2-р чулуун байгууламж (зургийг зүүн талаас)

Эрдэнэ уулын 3-р чулуун байгууламж. Өмнөх дурсгалаас баруун хойш 15 м зайд бий. Дугуй хүрээ маягийн дараастай жижиг чулуун байгууламж юм (Зураг 146b).

Эрдэнэ уулын 4-р чулуун байгууламж. Өмнөх дурсгалтай зэрэгцэн оршино. Овгордуу дараастай чулуун байгууламж ажээ (Зураг 147).



Зураг 146b. Эрдэнэ уулын 3-р чулуун байгууламж (зургийг зүүн талаас)



Зураг 147. Эрдэнэ уулын 4-р чулуун байгууламж (зургийг зүүн талаас)

Эрдэнэ уулын 5-р дурсгал. Уулын оройн хамгийн өндөрлөг дээр өргөргийн дагуу сунаж тогтсон, талууд нь дотогш ялимгүй нумарсан хашлага бүхий шоргоолжин булш байна. Булшны орой дээр хожим овоо босгожээ. Ер нь шоргоолжин булш тухайн орчиндоо өндөрлөг газарт онцгойдуу оршдог зүй тогтолтой энэ дурсгал адил байна. Тиймээс хожмын нүүдэлчид булшны дараас чулууг ашиглан овоо босгох тохиолдол говь, хээрийн бүс нутагт өмнө нь нэг бус удаа тааралдаж байсан билээ (Зураг 148).

Эрдэнэ уулын 6-р дурсгал. Эрдэнэ уулын ар шил дээр байх бүлэг дурсгалын өмнөд хэсэгт бий. Хөрсөнд ихэд дарагдсан намхандуу дараасыг дундаж хэмжээтэй чулуу ашиглан хийжээ. Дараас хөрсөнд дарагдсан тул гадаад зохион байгуулалтыг тодруулахад төвөгтэй байна. Ерөнхий хэв шинж нь Улаан зуух хэлбэрийн булш байх магадлалтай (Зураг 149).

Эрдэнэ уулын 7-р дурсгал. Өмнөх дурсгалаас зүүн хойш 45 м зайд, бүлэг дурсгалын зүүн өмнөд хэсэгт бий. Дотор талдаа чулуугүй дугуй цагариг мэт дараастай бөгөөд хөрсөнд ихэд дарагджээ. Хүннү булшны гадаад зохион байгуулалттай төстэй (Зураг 150).

Эрдэнэ уулын 8-р дурсгал. Бүлэг дурсгалын зүүн өмнөд хэсэгт бий. Дугуй хэлбэртэй, дундаа чулуугүй жижгэвтэр булш юм. Хүннү булштай төстэй боловч дараас нь ихэд дарагджээ (Зураг 151).

Эрдэнэ уулын 9-р дурсгал. Эрдэнэ уулын ар шил дээр байх бүлэг дурсгалын дунд оршино. Дундаж хэмжээтэй чулуу ашиглан хийсэн битүү намхан дараастай Улаан зуух хэлбэрийн булш ажээ (Зураг 152)

Эрдэнэ уулын 10-р дурсгал. Бүлэг дурсгалын зүүн хэсэгт бий. Хөрсөнд ихэд дарагдаж гадаад байгууламжид тулгуурлан ямар дурсгал болохыг тогтооход хүндрэлтэй байна. Улаан зуух хэлбэрийн булш байх магадлалтай (Зураг 153)

Эрдэнэ уулын 11-р дурсгал. Бүлэг дурсгалын зүүн хойд хэсэгт, өмнөх дурсгалаас холгүй газарт оршино. Баруунаас зүүн тийш сунасан урт хашлага нь дотогш ялимгүй нумарсан шоргоолжин булш ажээ. Түүний булангуудад том чулуу тавьсан бөгөөд дараас, хашлага хөрсөнд дарагджээ (Зураг 154)

Эрдэнэ уулын 12-р дурсгал. Бүлэг дурсгалын зүүн хойд хэсэгт бий. Хөрсөнд ихэд дарагдсан тэгш өнцөгт маягийн хэлбэртэй Улаан зуух хэлбэрийн булш бололтой. Дараасны төв хэсэг чулуу багатай (Зураг 155).

Эрдэнэ уулын 13-р дурсгал. Бүлэг дурсгалын баруун хойд хэсэгт оршино. Тэгш өнцөгт маягийн хэлбэртэй дараасыг дундаж хэмжээтэй чулуу ашиглан хийжээ. Дараасны ихэнх хэсэг хөрсөнд дарагдсан (Зураг 156). Түүний хойд талд мөн хөрсөнд нэлээд дарагдсан чулуун байгууламж байна. Тусдаа булш оршуулга уу? Эсвэл тахил тайлгын холбогдолтой дурсгал эсэх нь тодорхойгүй.

Эрдэнэ уул хаанаас ч харсан тэр хавьдаа содон онцлог тогтоцтой. Тиймээс ч эртнээс нүүдэлчдийн ариун дагшин газар болж, нас барагчдаа онголон оршуулжээ. Эндэхийн чулуун байгууламжит дурсгал газрын хөрсөнд ихэд дарагдсан, гадаад зохион байгуулалтын хэлбэр дарагдсан зэрэг шалтгаанаас үүдэн бүгдийг тодорхойлоход бэрхшээлтэй байна.

Гэвч энд түрүүлгэ н харуулсан оршуулгат булшны төлөөлөл Шоргоолжин булш, Улаан зуух хэлбэрийн булш оршин буй нь тодорхой байна. Эдгээр нь тухайн газарт буй булш оршуулгын хамгийн эрт үед холбогдох дурсгал нь тодорхой.

Өнөөгийн судалгааны байдлаар говь, хээрийн бүс нутгийн хүрлийн үеийн хамгийн эртний дурсгал бол Шоргоолжин булш, Улаан зуух хэлбэрийн булш юм. Харин гадаад зохион байгуулалтын хувьд хүннү булштай төстэй хэдэн дурсгал буй нь анхаарал татаж байна. Хүннү булш хийгээд түрүүлгэ нь харуулсан оршуулгат булш байршил зүйн хувьд давхцах тохиолдол ховор. Гэвч энд гадаад байгууламжийн хувьд хүннү булш байж мэдэхээр дурсгалууд байна. Мөн он цаг тодорхойгүй, зарим талаар Монгол булштай төстэй чулуун байгууламж байна.


Ямартай ч Эрдэнэ ууланд тухайн бүс нутгийн хүрлийн үеийн нүүдэлчид анхлан булш оршуулга үйлдэж эхэлсэн агаад хүннү, түүний дараах үед нас барагсдаа оршуулсан ариун дагшин газар байх магадлалтай байна.



Зураг 148. Эрдэнэ уулын 5-р дурсгал.
Шоргоолжин булш



Зураг 149. Эрдэнэ уулын 6-р дурсгал. Улаан
зуух хэлбэрийн булш



Зураг 150. Эрдэнэ уулын 7-р дурсгал.
Хүннү булш



Зураг 151. Эрдэнэ уулын 8-р дурсгал.
Хүннү булш



Зураг 152. Эрдэнэ уулын 9-р дурсгал.
Улаан зуух хэлбэрийн булш



Зураг 153. Эрдэнэ уулын 10-р дурсгал.
Улаан зуух хэлбэрийн булш?



Зураг 154. Эрдэнэ уулын 11-р дурсгал.
Шоргоолжин булш



Зураг 155. Эрдэнэ уулын 12-р дурсгал.
Улаан зуух хэлбэрийн булш



Зураг 156. Эрдэнэ уулын 13-р дурсгал. Улаан зуух хэлбэрийн булш ба чулуун байгууламж



2.2.32. Дагшин булагийн орчимд хийсэн хайгуул судалгаа

Эрдэнэ уулаас хөдөлж Сүмтийн тууриар дайрч Дарьганга сумын өмнө талд байх Дагшин булагт ирэв. Дагшин булаг бол Молцог элсний ар биеэс эх авах тунгалаг хүйтэн устай булгуудын нэг ажээ. Бид өмнө нь 2017 онд энэ орчимд хайгуул судалгаа хийж чулуун зэвсэг бүхий хэдэн газар тэмдэглэсэн билээ. Энэ удаад Д.Дугарсүрэн гуай төмрийн баас, шатсан хөрс бүхий газар зааж өгсөн юм.

Булгийн зүүн талд элсний ар хэсгийн хойш ялимгүй хазгай хэсгээр шатаж хатуурсан хөрс, төмрийн баасны хэлтэрхий, голд нь нэвт нүхэлсэн босоо амсартай ваарын хагархай зэрэг эд өлөг олдож байна (Зураг 157).



Зураг 157. Дагшин булагийн эхэн орчимд байх төмрийн баас, шатсан хөрс бүхий газар

Өмнөх дурсгалаас баруун тийш 300 м зайд дугуй хэлбэртэй нэлээд том элсэн хотгорын дотор чулуун зэвсэг, ваарын хагархай, төмрийн баас нэлээд тархсан байна (Зураг 158). Зузаан элстэй тул олдвор ихэд холилджээ. Энэ хотгорын төв хэсэгт гадаргын элс салхинд хийсэж хатуу шаварлаг хөрс ил гарсан газраас 2017 онд галын ором илрүүлж байв⁶¹. Өдгөө элсэнд дарагдаж мэдэгдэхгүй болжээ.



Зураг 158. Дагшин булагийн эхэн хэсгийн чулуун зэвсэг, ваарын хагархай, төмрийн баас тархсан элсэн хотгор

⁶¹ Д.Одсүрэн, Д.Бөхчулуун, Л.Яанз, А.Розен. Говь, хээрийн бүсийн неолитын судалгаа төслийн 2017 оны хээрийн шинжилгээний ажлын тайлан. УБ., 2017. АХГБСХ

Эндээс цааш хөдлөхөд сумын урд талын дэвсэг газарт хөрсөнд нэлээд дарагдсан тэгш өнцөгт маягийн дараастай Улаан зуух хэлбэрийн булш байв. Булшны зүүн талд хөшөө чулуу босгожээ (Зураг 159). Монгол орны говь, хээрийн бүс нутгаар голлон тархсан түрүүлгэ нь харуулсан оршуулгат булшны зүүн талд хөшөө босгох уламжлал байсан нь өмнө нь Уулбаян сумын нутагт хийсэн хайгуул судалгааны явцад тодорхой болсон юм. Энэ нь дараа үеийн дөрвөлжин булшны соёлтой адил боловч одоогоор хүний төрх гаргасан хөшөө таараагүй байна. Магадгүй дөрвөлжин булшны зүүн талд босгодог хүн төрхт хөшөөний өвөг дүр түрүүлгэ нь харуулсан оршуулгад анх гарч ирсэн байхыг үгүйсгэхгүй. Энэ нь эдгээр дурсгалын угсаа хамаарал нэг гэдгийг зааж буй баримт байж болно.



Зураг 159. Дагшин булагийн Улаан зуух хэлбэрийн булш

2.2.33. Зүүн Нарт орчимд хийсэн хайгуул судалгаа

Хамтарсан төслийн судлаачид Хөндлөнгийн гол, Баруун Сөдөтийн булаг, Дагшин булаг орчмоор судалгаа хийсний буцах замдаа Дарьганга сумын нутаг Зүүн Нарт ууланд гүймэг хайгуул хийв. Нутгийн иргэд бидэнд Зүүн Нартад агуй байдаг тухай мэдээлсэн юм.

Зүүн Нарт нь тэр хавьдаа ноёлог өндөр бөгөөд хад асгатай. Тиймээс агуй хонгил байдаг бол анчин, түүвэрлэгчдийн дурсгал байх магадлалтай тул бид буцах замд энд түр саатаж гүймэг хайгуул хийв.



Зураг 160. Зүүн Нартын энгэрийн агуй

Зүүн Нарт нь Алтан овооноос хойш 20 км орчим зайд, өргөн хөндийн ар талаар хөндөлсөн тогтсон нам өндөртэй уул ажээ. Уулын орой, хажуугаар галт уулын хүрмэн чулуун барсгар хадан тогтоцтой. Эндэхийн хад үйрч бутарч унасан сийрэг бүтэцтэй тул жижиг хонгил, агуй олон байдаг ажээ. Өөрөөр хэлбэл, эндэхийн агуйнууд элэгдлийн гаралтай ажээ (Зураг 161).



Зураг 161. Зүүн Нартын агуй

Агуй, хонгилууд их төлөв уулын дундаас дээш хэсэгт орших тул их зүтгэж хүрнэ. Зарим нь шороон хөрстэй байхад зарим нь хадан шалтай ажээ. Агуйн ам их талав урагш буюу хөндий рүү харсан байрлалтай. Харин гол өндрийн зүүн өмнөд талд, ханан хадны дэргэд байх агуй зүүн урагш харсан үүдтэй ажээ. Зарим жижиг агуйд модон хайрцагтай бурхан шашны холбогдолтой бололтой эд зүйл ч байна (Зураг 160). Өнгөрсөн жилийн зудын хатуу цагт мал амьтан агуй хонгил нөмөрлөж үхсэн сэг зэм бишгүй олон тааралдаж, тэдгээр нь агуйн доторхыг шалгахад саад тотгор болж байв. Бид эндэхийн агуй хонгилоос ямар нэг эртний түүхийн ул мөр илрүүлсэнгүй. Үйрч унасан барсгар чулуутай тул хана, таазанд зураг зурах, сийлэх боломжгүй ажээ. Мөн агуй хонгил нэлээд өндөрлөгт байрлах тул хүрч очиход төвөгтэй байж мэднэ. Мөн хуурч ховхорч унадаг хаднууд нь хүн удаан суурьших нөхцөл боломжийг үгүйсгэж байж ч болно. Гэвч цаашид агуй хонгил бүрийг нэг бүрчлэн нарийн шалгах, Зүүн Нартын уулын зүүн өмнөд талаар ороосон хуурай сайрын дагууд хайгуул судалгаа хийвэл эртний түүхийн дурсгал илрүүлэх магадлалтай хэмээн үзэж байна.

2.3. Малтлага судалгаа

Монгол орны хээрийн бүс нутгийн өмнөд хэсгээр элсэн манхан, элсэн тарамцагт орших баянбүрдийн орчимд неолитын үеийн анчин – түүвэрлэгчдийн ахуй амьдралын ул мөр бууц суурины дурсгал нэлээд тааралддаг билээ.

Монгол, Канадын хамтарсан “Говь, хээрийн бүс нутгийн неолитын судалгаа” төслийн баг 2017 онд Сүхбаатар аймгийн Онгон, Наран, Дарьганга сумдын нутгаар элсэн манханы баянбүрдүүдийн орчимд хайгуул судалгааг гүйцэтгэсэн юм. Хайгуул судалгааны үр дүнд олон шинэ дурсгал илрүүлсний нэг нь Дарьганга сумын нутагт, Молцог элсний араас эх авах Салаа булгийн дурсгал юм (Зураг 161). Бид тэр жил Салаа булагт бага хэмжээтэй сорилын малтлага хийж соёлт давхаргатай дурсгал болохыг тогтоосон бөгөөд хас, мана, цахиурын төрлийн чулуугаар хийсэн неолитын сүүл үеийг илэрхийлэх багаж зэвсгийн зүйл, амьтны ясны жижиг хэлтэрхий, гадрыг нь улаанаар будсан нимгэн ваарын хагархай зэрэг сонирхолтой эд өлгийн зүйлийг илрүүлсэн билээ⁶². Эндээс илрүүлсэн амьтны ясанд он цаг тогтоох шинжилгээ хийхэд неолитын хожуу үед холбогдох нь мөн тодорхой болсон юм⁶³.



Зураг 162. Салаа булагийн дурсгал

⁶² Д.Одсүрэн, Д.Бөхчулуун, Л.Яанз, А.Розен. Говь, хээрийн бүсийн неолитын судалгаа төслийн 2017 оны хээрийн шинжилгээний ажлын тайлан. УБ., 2017. АХГБСХ.

⁶³ Lisa Janz, Asa Cameron, Dashzeveg Bukhchuluun, Davaakhuu Odsuren, Laure Dubreuil. Expanding frontier and building the Sphere in arid East Asia. *Quaternary International*. Volume 559, 10 September 2020, Pages 150-164. <https://doi.org/10.1016/j.quaint.2020.04.041>

Энэ оны хээрийн судалгааны улиралд хамтарсан төслийн судлаачид Салаа булагийн дурсгалд өргөн хэмжээтэй малтлага судалгаа хийж шинэ хэрэглэгдэхүүн бүрдүүлэх, сууц оромж, гал голомтын үлдэгдэл илрүүлэх, эртний соёлын ул мөрийг хадгалсан хөрсний давхаргаас дээж авч нарийвчлан шинжлэхээр төлөвлөсөн юм.

Салаа булаг орчимд элсэн хурдаст чулуун зэвсгийн олдвор, шавар ваар савын зүйл энд тэнд олддог боловч булгийн эхэн хэсэгт эртний хүмүүсийн амьдралын ул мөр харьцангуй сайн хадгалагдаж үлдсэн байдаг билээ.

Анчин – түүвэрлэгчид голоцены хожуу үед ил задгай усны ундарга, ялангуяа цэнгэг устай булгийн эх орчмын газар нутагт суурьших болсон нь ажиглагддаг. Энэ нь юуны өмнө сайн усыг хэрэглэхээс гадна түүнийг өмчлөх, эзэмшихтэй холбоотой байж ч болно. Дорнод Монголын Тамсагбулаг, хээрийн бүс нутгийн Шавартайн булаг зэрэг олон газарт ийнхүү булгийн эхтэй ойр хүмүүс суурьшиж байсан баримт тохиолддог билээ.

Ийнхүү булгийн эх орчмын дурсгалыг малтан шинжлэх нь өнөө цагийн орон нутгийн иргэдийн дургүйцэлтэй тулгардаг. Салаа булагт ч энэ байдал тохиолдсоныг хэлэх хэрэгтэй.

Бид булгийн эхээс дээш баруун тийш ирмэглэсэн элсэн товцгийн ар талаар чулуун зэвсэг, ваар савны хэлтэрхий тархсан хэсэгт малтлага судалгааг гүйцэтгэв. Энэ газар 2017 оны сорилын малтлагын зүүн талд орших бөгөөд баруунаас зүүн тийш 300 см, урдаас хойш 350 см талбайд буюу нийт 10.5 м² талбайд малтлага судалгааг гүйцэтгэсэн юм (Зураг 162).

Малтлага хийхээр сонгосон газар арагш огцом налуу юм. Малтлагын талбайг тус бүр нь 100 х 100 см хэмжээтэй өрөгт хувааж зүүнээс баруун тийш А, В, С хэмээн үсгэн дугаар, урдаас хойш 1, 2, 3, 4 хэмээн тоон дугаар өгч талбайг өрөгт хуваасан.

Талбайн өмнөд хэсэг буюу А1, В1, С1 өрөг харьцангуй өндөр тул малтлагыг эдгээр өргөөс эхлэн гүйцэтгэсэн. Малтлагыг 5 см гүнтэй хусаж үелэн гүйцэтгэсэн агаад 3 х 3 мм хэмжээтэй тортой шигшүүрээр бүх шороог шигшиж шалгав.

Малтлага судалгааны явцад энд хөрсний бүтэц, бүрдэл хэсгээр харилцан адилгүй үе давхаргууд тогтсоныг илрүүлж баримтжуулсан (Зураг 163).

Малтлагын 1-р үеийг сүүл үед хуралдсан өнгөн хэсгийн бор шаргал өнгөтэй элсэн хөрс бүрдүүлнэ. Ийм хөрс Салаа булаг төдийгүй Молцог элс орчмын газрын гадаргыг хучиж тогтсон байдаг.

2-р давхарга нь 8-20 см зузаан. Хар бараандуу өнгөтэй элсэрхэг хөрс бөгөөд эндээс чулуун зэвсгийн олдвор нэлээд гарсан. Газрын өнгөн хэсгийн элсний доор, бусад үеэс нэлээд дээр орших ийм хар бараан давхарга малтлагын талбайн өмнөд хэсэг буюу газрын дээд талд А1, В1, С1, А2, В2, С3 өргийн урд талаар мэдэгдсэн. Ямартай ч голоцены үеийн

хөрс гэдэг нь эргэлзээгүй бөгөөд чулуун зэвсэг, амьтны яс, шавар сав суулганы үлдэгдэл зэрэг эртний амьдралын ул мөрийг хадгалсан нь тодорхой банья.



Зураг 163. Салаа булагт малтлагын талбай сонгосон байдал

Дээр өгүүлсэн хар бараан хөрсний доор 29-47 см зузаан шаргалдуу элсэн давхарга тогтсоныг малтлагын явцад илрүүлж 3-р давхарга хэмээн тэмдэглэсэн билээ. 1-р давхаргатай ихэд төстэй энэ үеэс чулуун зэвсгийн олдвор цөөн гарсан. Мөн хөрсний бүтцэд чулууны орц бага буй нь анзаарагдсан юм.

Дараагийн давхаргыг малтлагын баримтжуулалтад 4а хэмээн тэмдэглэсэн бөгөөд 15-18 см зузаан. Бордуу өнгөтэй элсэрхэг хөрстэй энэ давхаргаас чулуун зэвсгийн олдвор, ваар савны хэлтэрхий, амьтны яс цөөн олдсон. Харин галын ормын орчимд тааралддаг жижгэвтэр чулууны хагархай нэлээд олон гарсан.

Дараагийн давхарга нь хар бараан өнгөтэй шаварлагдуу хөрс юм. Голоцены үеийн хөрс болох нь тодорхой бөгөөд 4b хэмээн тэмдэглэж баримтжуулав. 24-30 см зузаан энэ давхаргаас олдвор эд өлгийн зүйл хамгийн олон илрүүлсэн. Энэ давхаргын дээд хэсгээс Тамсагбулагийн 13-р дурсгалын малтлагатай ихэд төстэй гүн хар хөрс илэрсэн бөгөөд анчин – түүвэрлэгчдийн ахуй амьдралын ул мөрийг илэрхийлж буй нь дамжиггүй.

Дээрх давхарын доор элсэрхэг хөрс ялимгүй бор өнгөтэй болж хувирах ба 5-7 см зузаан юм. Энэ үеийг 4с хэмээн тэмдэглэж баримтжуулсан. Цөөн тооны чулуун зэвсгийн олдвор энэ давхаргаас илрүүлсэн.

Энэ үеийн доор цайвар бордуу өнгөтэй нарийн ширхэгтэй элсэн хөрстэй давхарга илрэв. Эндээс олдвор, эд өлгийн зүйл гарсангүй. Энэ нь плейстоцены үеийн давхарга бололтой.



Зураг 164 Салаа булагт хийсэн малтлагын урд хана ба хөрсний үе давхаргын тэмдэглэгээ.

Газрын өнгөн хэсэг буюу хөрсөн дээрээс 54 олдвор илрүүлсэн (Хүснэгт 39). Чулуун зэвсгийн олдворыг цайвар мана, хасын төрлийн чулуу, цахиураар хийсэн бөгөөд залтас, ялтасны хугархай, хагархай хэлтэрхий юм.

Хүснэгт 40. Салаа булагийн малтлагын 1-р давхаргаас илрүүлсэн олдворын ангилал

№	Олдворын төрөл	Өрөг А				Өрөг В			Өрөг С		Нийт
		1	2	3	4	1	2	4	1	2	
1	Ялтасны дунд хэсгийн хугархай	-	-	-	2	-	-	-	-	-	2
2	Ялтасны үзүүрийн хугархай	1	-	-	-	-	-	1	-	-	2
3	Залтас	1	-	4	1	-	3	1	-	-	10
4	Хайрс	1	4	-	3	-	-	2	-	-	10
5	Хагархай, хэлтэрхий	-	-	3	5	-	4	-	-	-	12
6	Ваарын хагархай	1	1	-	-	2	4	1	2	-	11
7	Ясны хэлтэрхий	2	-	-	2	-	-	-	-	3	7
Бүгд		6	5	7	13	2	11	5	2	3	54

Малтлагын 2-р давхарга буюу хар хөрсөн давхаргаас (Зураг 164) харьцангуй олон буюу 134 олдвор илрүүлсэн (Хүснэгт 40). Чулуун зэвсгийн олдворын ихэнхийг 2 см-ээс бага, нимгэн залтас, чулуун зэвсэг цуулалт, ирлэлтийн явцад бий болсон жижиг хайрс бүрдүүлж байна. Чулуун зэвсэг хийсэн түүхий эд нь гол төлөв мана, цахиур хас бөгөөд ар хөрсөнд хадгаладаж үлдсэн эдгээр олдвор неолитын хожуу үеийн анчин – түүвэрлэгчдийн ул мөр ажээ.



Зураг 165. Салаа булагийн малтлагын 2-р давхарга

Хүснэгт 41. Салаа булагийн малтлагын 2-р давхаргаас илрүүлсэн олдворын ангилал

№	Олдворын төрөл	Өрөг А	Өрөг В			Өрөг С		Нийт
		1	1	3	4	1	3	
1	Ялтасны дээд хэсгийн хугархай	1	-	-	-	-	-	1
2	Ялтасны дунд хэсгийн хугархай	-	2	-	-	-	-	2
3	Ялтасны үзүүрийн хугархай	3	-	-	-	2	-	5
4	Залтас	15	8	-	-	7	3	33
5	Хайрс	6	7	-	-	4	2	19
6	Хагархай, хэлтэрхий	1	4	-	-	1	1	7
7	Ваарын хагархай	5	27	5	-	17	-	54
8	Амьтны ясны хэлтэрхий	-	-	-	11	-	2	13
Бүгд		31	48	5	11	31	8	134

Салаа булагийн малтлагын хамгийн зузаан давхарга бол 3-р давхарга юм. Неолитын үеийн соёлт давхарга дээр хожим хуралдсан өнгөн хөрстэй ихэд төстэй цайвар шаргал өнгөтэй элсэрхэг хөрснөөс 83 олдвор илрүүлж баримтжуулсан (Хүснэгт 41). Дээд, доод талдаа эртний амьдралын ул мөрийг агуулсан энэ давхаргаас олдвор, эд өлгийн зүйл харьцангуй цөөн олдсон нь анхаарал татаж буй юм. Эдгээр давхаргаас илрүүлсэн органик эдлэлд он цаг тогтоох шинжилгээ хийж давхарга бүр хэзээ бүрэлдсэнийг тогтоохоор зорьж буй бөгөөд бидний хувьд дээд, доод талдаа хар хөрсөөр зааглагдсан энэ давхарга эртний уур амьсгал байнга нэгэн хэвийн байгаагүй, зарим үед чийгшил багасаж хуурайшиж байсны илрэл байх магадлалтай хэмээн таамаглаж байна.

3-р давхаргаас илрүүлсэн чулуун зэвсгийн олдвор бүгд цуулдасны үйлдвэрлэлд хамаарна. Тэдгээрийн ихэнх 2 см-ээс бага жижиг залтас, хайрс юм.

Хүснэгт 42. Салаа булагийн малтлагын 3-р давхаргаас илрүүлсэн олдворын ангилал

№	Олдворын төрөл	Өрөг А			Өрөг В	Өрөг С	Нийт
		1	3	4	1	1	
1	Ялтасны үзүүрийн хугархай	-	3	-	-	-	3
2	Ялтасны дунд хэсгийн хугархай	-	-	-	-	2	2
3	Залтас	-	13	1	10	3	27
4	Хайрс	1	7	-	-	4	12
5	Хагархай, хэлтэрхий	-	5	-	-	1	6
6	Ваарын хагархай	1	6	1	17	6	31
7	Ясны хэлтэрхий	-	-	1	-	1	2
Бүгд		2	34	3	27	17	83

Шаргал өнгөтэй элсэрхэг давхаргын доор бараандуу буюу бор өнгөтэй элсэрхэг хөрс гарсан нь олдвор, эд өлгийн зүйл харьцангуй олон агуулжээ. Малтлагын бүх өргөөс энэ давхаргаас 300 олдвор илрүүлэн баримтжуулсан (Хүснэгт 42) нь төрөл зүйлийн хувьд олон, баялаг ажээ. Хэдийгээр анхдагч цуулалтыг илэрхийлэх эдлэл олдоогүй боловч хусур, хоёр талаас нь холтчин жигд нимгэлэн зассан зэвийн хугархай, холтчин нимгэлж зассан зэвийн хагархай, ялтсаар хийсэн сийлүүр, ирлэсэн ялтас, ирлэсэн залтас гэх мэт неолитын хожуу үеийн чулуун зэвсэг үйлдвэрлэлийн арга ажиллагааг илтгэх эдлэлүүд гарчээ. Чулуун зэвсгийн олворын бүрдэлд бусад давхаргатай адил 2 см-ээс бага жижиг, нимгэн залтас, хайрс ихэнх хувийг эзэлж байна. Мөн ваарын хагархай, хэлтэрхий энэ давхаргаас нэлээд олон олдсон байна.

Хүснэгт 43. Салаа булагийн малтлагын 4а давхаргаас илрүүлсэн олдворын ангилал

№	Олдворын төрөл	Өрөг А	Өрөг В	Өрөг С	Нийт
---	----------------	--------	--------	--------	------

		1	2	3	1	2	3	1	2	3	4	
1	Хусуур	-	-	1	-	-	1	-	1	-	-	3
2	Зэвийн хугархай	-	-		-	-		1	-	1	-	2
3	Зэвсгийн хагархай	-	-		-	-		-	-	1	-	1
4	Сийлүүр	-	-		-	-		-	-	1	-	1
5	Ирлэсэн ялтас	-	-		-	-	1	-	-	-	-	1
6	Ирлэсэн залтас	-	-		-	-	1	-	-	-	-	1
7	Бүтэн ялтас	-	-		-	2		-	-	1	-	3
8	Ялтасны дээд хэсгийн хугархай	-	-	1	-	2		2	-	-	-	5
9	Ялтасны дунд хэсгийн хугархай	-	1	1	-	-		-	-	-	-	2
10	Ялтасны үзүүрийн хугархай	-	-		-	-	2	-	-	-	-	2
11	Залтас	-	19	41	1	8	35	12	10	18	-	144
12	Хайрс	1	14		5	9	3	-	8	4	-	44
13	Хагархай, хэлтэрхий	1	9	7	-	16	20	2	7	5	-	67
14	Ваарын хагархай	-	1	9	-	1	5	-	-	5	1	22
15	Ясны хэлтэрхий	-	-		-	-		2	-	-	-	2
Бүгд		2	44	60	6	38	68	19	26	36	1	300

Салаа булагт 2024 онд хийсэн малтлагын хамгийн баялаг олдвортой давхарга бол малтлагын баримтжуулалтад 4b тэмдэглэсэн давхарга юм (Зураг 165). Эндээс 623 олдвор илрүүлсэн (Хүснэгт 43). 4b давхарга бусад үетэй харьцуулахад илүү тод хар өнгөтэй шаварлаг хөрстэй. Неолитын дурсгалуудад ийм хар бараан хөрс тааралддаг бөгөөд оромж сууцын үлдэгдэл буюу хүний үйл ажиллагаатай холбоотой антропогены нөлөөгөөр бий болох нь түгээмэл. Мөн тухайн цаг үеийн байгаль, уур амьсгалын таатай орчинд үржил шимтэй хар хөрс бүрэлдэн тогтож, түүнд эртний амьдралын ул мөр хадгалагдсан байх нь тохиолддог билээ. Бидний хувьд энэ хар хөрс антропогений нөлөөтэй буюу хүний үйл ажиллагаатай холбоотой бий болсон хэмээн үзэж байна. Хоёрдогч боловсруулалт хийж зассан багаж зэвсгийн төрөлд бифасны хугархай, төгсгөл болон дугуй хусуур, зэвийн хугархай, сийлүүр зэрэг неолитын дундаас хойших үеийн чулуун зэвсэг үйлдвэрлэлийн арга ажиллагааг илтгэх эдлэлүүп нэлээд байна. Мөн ялтасны тоо нэлээд нэмэгдэхийн зэрэгцээ өмнөх болон дараагийн давхаргатай адил чулуун одворын дотор жижиг залтас, хайрс хамгийн олон байна.



Зураг 166. Салаа булагийн 4b давхаргаас илрүүлсэн олдвор

Шавар сав суулганы зүйл хэдэн янз бөгөөд зарим нь орон нутгийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн бол заримыг нь арилжаа солилцооны явцад хөрш бүс нутгаас авсан хэмээн үзэж болохоор байна. Умард Хятадын неолитын дурсгал, ялангуяа Яншао-гийн соёлын шавар эдлэлтэй туйлын төстэй улаан будгаар гадрыг нь будсан, нарийн ширхэгтэй шавраар хийсэн нимгэн ваарын хагархай Салаа булагийн малтлагаас нэлээд гарсан нь сонирхол татаж байна. Түүнчлэн, шавар эдлэлийн дотор нэлээд зузаан, нэг тал нь ирмэг гарсан хагархайнууд буйг бид сав суулгын зүйл хэмээн үзэхгүй байна. Неолитын үеэс ашиглах болсон шавар хүлсний хөл хэмээн үзэж байна. Ийм шавар хүлс Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Чандмань хар уулын хүрлийн үеийн булш оршуулгын малтлагаас илэрч байсан билээ⁶⁴. Мөн хөрш зэргэлдээ Умард Хятадын нутаг дэвсгэрээс ийм олдвор неолит, хүрлийн үеийн дурсгалаас олон гардаг байна. Хэдийгээр бүтнээр олдоогүй, жижиг хагархай хэлтэрхий буй нь эргэлзээ төрүүлж буй ч нэг хэв загвараар хийсэн нэлээд олон шавар эдлэл хоорондоо тун төстэй буй нь хүлсний хөлийн үлдэгдэл байх боломжтойг илтгэж байна.

4b үеийн малтлагаас илрүүлсэн нэг сонирхолтой баримт бол зосны үлдэгдэл юм. Говийн бүс нутагт палеолит, неолитын дурсгалуудад зос олон тааралддаг. Харин судлаачид

⁶⁴ Ч.Амартүвшин, Н.Батболд, Г.Эрэгзэн, Б.Батдалай. Чандмань Хар уулын археологийн дурсгал I. УБ., 2015.

тэдгээр нь байгалаараа тухайн орчинд байснаас хүмүүсийн соёлын үлдэгдэлтэй холилдож бидний үед ирсэн үү? Эсвэл зориуд хэрэглээний явцад тухайн газарт авчирсан уу? гэдгийг анхааралгүй явж ирсэн юм. Салаа булаг, Молцог элсний ойр орчимд одоогоор зосын үлдэгдэл, зостой газар бидэнд мэдэгдээгүй. Тиймээс энэ жижиг хэлтэрхийг тухайн үеийн хүмүүс зөөвөрлөн аваачиж хэрэглэж байсан байх өндөр магадлалтай юм. Ер нь дээд палеолитын үеэс анчин – түүвэрлэгчид зосыг өргөн ашигаж эхэлсэн баримт бэлхнээ хадны зураг хадгалагдаж үлдсэнээс гадна зүүлт чимэглэлийг будаж байсан ор мөр тааралддаг. Неолитын үед нас барагчийн булшинд зос цацах уламжлал байсан нь Монгол орны дорнод, умард хэсгийн дурсгалуудад нэгэнт тодорхой болсон билээ. Харин бууц сууринд ямар нэг ёслолын зориулалтаар нүүр амаа будах эрээлэх зорилгоор, эсвэл ахуйн хэрэглээний зүйлийг будах зорилгоор зосыг хэрэглэж байсан байх магадлалтай билээ.

Хүснэгт 44. Салаа булагийн малтлагын 4b дахаргаас илрүүлсэн олдворын ангилал

№	Олдворын төрөл	Өрөг А			Өрөг В			Өрөг С			Нийт
		1	2	3	1	2	3	1	2	3	
	Бифасны хугархай	1	1	-	-	-	-	-	-	-	2
1	Хусуур	2	2	-	-	-	-	1	2	-	7
2	Зэвийн хугархай	4	-	-	-	-	-	1	-	-	5
3	Сийлүүр	1	-	-	-	-	-	-	-	-	1
4	Бүтэн ялтас	1	1	-	2	-	-	-	-	-	4
5	Ялтасны дээд хэсгийн хугархай	4	1	-	1	-	-	2	3	-	11
6	Ялтасны дунд хэсгийн хугархай	5	3	-	2	-	2	2	3	-	17
7	Ялтасны үзүүрийн хугархай	1	1	-	-	-	-	-	1	-	3
8	Залтас	88	34	6	26	11	20	36	18	9	248
9	Хайрс	27	15	-	17	-	19	23	12	7	120
10	Хагархай, хэлтэрхий	50	17	-	13	1	8	19	17	5	130
11	Ваарын хагархай	6	7	2	3	4	21	10	6	2	61
12	Шавар эдлэлийн хэлтэрхий	3	1	1	-	1	1	-	-	3	10
13	Ясны хэлтэрхий	-	-	-	1	-	-	1	1	-	3
14	Зосны үлдэгэл	1	-	-	-	-	-	-	-	-	1
Бүгд		194	83	9	65	17	71	95	63	26	623

Тод хар өнгөтэй баялаг олдвортой 4b давхарга доод хэсгээрээ бордуу хөрстэй зах нийлэх бөгөөд эндээс олдворын тоо эрс багасаж байна. Энэ давхаргаас 75 олдвор илрүүлэн баримтжуулсан нь чулуун зэвсгийн зүйл, ваарын хагархай, шавар эдлэлийн хэлтэрхий, амьтны ясны үлдэгдэл хэлтэрхий юм (Хүснэгт 43). Энэ давхаргаас үлдэц, техникийн цуулдас зэрэг анхдагч цуулалтын арга ажиллагааг илтгэх эдлэл олдсон нь сонирхолтой. Үлдэц нь

бичил ялтас цуулж авсан оромтой шовхдуу суурьтай. Ийм үлдэц неолитын хожуу үеийн дурсгалаас ихэвчлэн олддог билээ. Харин багаж зэвсгийн зүйл цөөн байна. Ваар савнаас гадна өмнөхийн адил хүлс олджээ.

Хүснэгт 45. Салаа булагийн малтлагын 4с давхаргаас илрүүлсэн олдворын ангилал

№	Олдворын төрөл	Өрөг А			Өрөг В			Өрөг С		Нийт
		1	2	3	1	2	3	1	3	
1	Үлдэц	1		1						2
2	Техникийн цуулдас	1		1						2
3	Ирлэсэн ялтас				1					1
4	Хусуур	1		1						2
5	Ялтасны дээд хэсгийн хугархай	3						3		6
6	Ялтасны дунд хэсгийн хугархай	1			1		1	2		5
7	Ялтасны үзүүрийн хугархай	1			1			1		3
8	Залтас	16	4	3	5	1		3		32
9	Хайрс				3			4		7
10	Хагархай, хэлтэрхий					2		1	2	5
11	Ваарын хагархай	1				1		1		3
12	Шавар эдлэлийн хэлтэрхий	1								1
13	Ясны хэлтэрхий	1	4		1					6
Бүгд		27	8	6	12	4	1	15	2	75

4с үеийн доор цайвар бордуу өнгөтэй нарийн ширхэгтэй элсэн давхарга илэрсэн. Хөвсгөр зөөлөн энэ давхаргаас олдвор, эд өлгийн зүйл илрээгүй. Голоцены давхарга бус, түрүү үед тогтсон хөрс ажээ. Эртний амьдралын ул мөр зөвхөн энэ үеийн дээд талын хар бараан давхаргуудад хадгалагдаж буй нь тодорхой байсан учраас судалгааг зогсоож хөрсний дээж (Зураг 166)-ийг малтлагын ханаас авсны дараа малтлага хийсэн газрыг нөхөн сэргээж булав (Зураг 167).



Зураг 167. Салаа булагийн малтлагын ханаас хөрсний дээж авч буй нь



Зураг 168. Салаа булагт хийсэн малтлагыг нөхөн сэргээж булсан байдал

Салаа булагт хийсэн малтлагаар хамтарсан төслийн судлаачид хожуу голоцены үеийн элсэн манханы баярбүрдэд суурьшсан анчин – түүвэлэгчдийн ул мөрийг илрүүлж, судалгааны үнэт хэрэглэгдэхүүнийг бий болгосон юм. Ялангуяа, анчин – түүвэрлэгчид хөрш бүс нутагтай харилцаатай байж, тэдний бүтээгдэхүүнийг авч ашиглаж байсан нь шавар сав суулгаас тодорхой болсон юм. Энэ баримтыг цаашид гүнзгийрүүлэн судлахаар зорьж буй бөгөөд ваар савыг зөвхөн хөрш бүс нутгаас авах бус орон нутгийн шавар сав суулганы баримт ч энэ малтлагаас хамт гарч ирсэн нь сонирхолтой юм. Бид урьдчилсан байдлаар гурван өөр шавар сав суулга Салаа булагийн оршин суугчид хэрэглэж байсан хэмээн үзэж байна. Тэдгээрийн нэг нь арилжаа солилцооны замаар хөрш бүс нутгаас ирсэн байх магадлалтай. Харин дунд зэргийн шатаалттай, босоо амсартай ваарын хагархай, гадна талдаа хээ гаргагчаар хээлсэн босоо амсартай нимгэн хагархай зэрэг нь эндэхийн эртний оршин суугчдын сав суулга бололтой.

Салаа булагийн неолитын суурингаас илрүүлсэн члуун зэвсгийн олдворын бүрдэл, тэдгээрийг хийсэн арга барил зэрэг нь бүхэлдээ неолитын хожуу үеийн илэрхийлж буй бөгөөд гол, булаг шандын эх орчмын сайн устай газруудад хүмүүс суурьшихыг илүүтэй эрмэлзэх болсон голоцены хожуу үеийн дурсгал ажээ.

3. ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

“Говь, хээрийн бүс нутгийн неолитын судалгаа” төслийн баг 2024 оны хээрийн судалгааг урьдчилсан төлөвлөгөөний дагуу амжилттай зохион байгуулсан билээ. Судалгааны багийн гишүүд өмнө археологийн судалгаа бага хийсэн Монгол Улсын өмнөд хилийн дагуух өргөн уудам, алс зэлүүд газар нутагт хайгуул судалгааг амжилттай зохион байгуулж шинэ дурсгал илрүүлэн баримтжуулав. Түүнчлэн зарим газар ямар нэг археологийн дурсгалгүй “хоосон” нутаг дэвсгэр буйг анзаарч цаашид учир шалтгааныг тодруулахыг зорьж байна.

Хайгуул судалгааны явцад илрүүлсэн дурсгалуудыг газар нутаг, орших орчин, дурсгалын ерөнхий хэв шинжээр хэд ангилж болно. Хайгуул судалгааны эхлэл цэг нь Өмнөговь аймгийн Номгон сумын өмнөд нутаг байсан билээ. Бид юуны өмнө газрын зурагт олон булаг, задгай ус тэмдэглэгдсэн Хөрхийн нурууны өвөр биеийн баянбүрдүүдийг шалгаж үзэхийг зорьсон билээ.

Говь-Алтайн нурууны төгсгөл Хөрхийн нурууны өвөр бэлд, Борзрнгийн говийн хойд биед Баянбулаг, Эрдэнэ булаг зэрэг 10 гаруй задгай усыг Борзонгийн булаг хэмээх нэрээр газрын зурагт тэмдэглэсэн боловч нутгийн зон олон тус тусад нь оноосон нэрээр нэрэлдэг ажээ.

Тухайн бүс нутагт Бяруухайн гол орчимд өмнө нь чулуун зэвсэг, хожуу үеийн дурсгал илрүүлж байсан мэдээ бий. Бид Бяруухайн голын дагууд өмнөх судлаачдын тэмдэглэсэн дурсгалыг баримтжуулав. Мөн Бяруухайн голын зүүн талд зэрэгцэн орших Ганган задгай, Харанхуй ус зэрэг газраас шинэ дурсгал илрүүлсэн.

Хөрхийн нурууны өвөр бие рүү буусан өргөн сайруудаас эх авах эдгээр булгийн эх орчимд чулуун зэвсгийн бууц суурины үлдэгдэл хадгалагдаж үлдсэн байна. Ер нь цэнгэг усны үүсвэр булаг шандын эх орчимд анчин – түүвэрлэгчдийн бууц суурин орших нь түгээмэл билээ. Газрын хөрсөн дээр тархсан олдвор нь том баргил багаж зэвсэг, жижиг хэмжээтэй бичил чулуун зэвсэг ажээ. Сүх, ооль зэрэг том хэмжээтэй багаж зэвсэг олон олдсон нь сонирхол татахаас гадна тэдгээрийг хагачин цуулах, үрж зүлгэх хоёр аргаар хийж бэлтгэжээ.

Хэдийгээр үрэх, зүлгэх аргыг нэлээд хожуу чулуун зэвсгийн үйлдвэрлэлд нэвтэрсэн хэмээн үздэг боловч харьцангуй бахим, эртний шинжтэй чулуун зэвсгүүдэд энэ аргыг хэрэглэж байсан нь тодорхой байна. Борзонгийн булаг орчимд илрүүлсэн өөр нэг сонирхолтой дурсгал бол Бүрэгийн сайрын суурин юм. Борзонгийн говийн зүүн этгээдэд элс, загтай далан бүхий сайрын эргээр чулуун зэвсгийн олдвор нэлээд нягтаршилтай тархжээ.

Хагархай, хэлтэрхий, залтас, ялтас хөрсөн дээр тархсан олдворын дунд олон байхаас гадна зарим хэсэгт нэлээд эртний шинжтэй олдворын бөөгнөрөл ажиглагдав.

Борзонгийн говийн зүүн, хойд талаар байрлах дээр дурдсан дурсгалуудын он цагийн хамаарлын тухай бид урьдчилсан таамаг гаргах боломжтой юм. Хэдийгээр бичил чулуун зэвсгийн үйлдвэрлэл давамгайлах хандлагатай боловч зарим газарт палеолитын үйлдвэрлэлийн арга ажиллагаа илэрхий буйг хэлэх хэрэгтэй. Ялангуяа, Харанхуй усны суурингийн хар бараан өнгөтэй цахиурлаг чулуугаар хийсэн олдворууд нэлээд эртнийх байх магадлалтай байна.

Борзонгийн говь орчмын дурсгалаас неолитын хэв шинжтэй шавар сав суулганы үлдэгдэл одоогоор олдоогүй. Өөрөөр хэлбэл, энд неолитын үеийн шавар ваарын хагархай алга. Эндэхийн чулуун зэвсгийн дурсгалыг үлдээсэн эртний анчин – түүвэрлэгчид шавар ваар сав хийдэггүй, хэрэглээнд нэвтрээгүй байсан уу? эсвэл ан гөрөөний түр зуурын буудал бууцын нэгэн адил шавар сав суулганы үлдэгдэл энэ газарт хадгалагдаж үлдээгүй юу? Гэдэг асуулт урган гарч байна. Энэ хавийн газрын ерөнхий төрх, булаг шанд олон байгаа зэрэг нь түр зуурын буудлын газар бус, урт хугацаанд суурьшдаг үржил шимтэй газар нутаг байсныг харуулна. Бяруухайн голын эх зэрэг элсэн хурдаст бага автсан гадруудад чулуун зэвсгийн олдвор өндөр нягтаршилтай буй нь түр зуурын бууц буудал бус урт хугацаагаар суурьшдаг суурины шинжтэй дурсгал гэдгийг илтгэж байна. Сүүлийн жилүүдэд элсэн хурдаст ихэд автсан боловч чулуун зэвсгийн олдвор өндөр нягтаршилтай тархсан нь хуралдсан элсний зах хаяа, элс салхинд хийссэн шаварлаг хөрснөөс тодорхой мэдэгдэж байна. Тиймээс неолитын үеийн шавар сав суулга олдоогүй нь энэ дурсгалыг үлдээгчид шавар ваар сав хэрэглэдэггүй буюу эрт үед холбогдох дурсгал байх магадлалтай ажээ.

Дэлхийн олон улс орон, ялангуяа, Ойрх Дорнодын бүс нутагт неолитын үеийн дурсгалыг үечлэхэд шавар ваар сав чухал хэрэглэгдэхүүн болдог билээ. Үүнтэй адил чулуун зэвсэг үйлдвэрлэлийн арга барилын хувьд неолит, голоцены эхэн үеийн дурсгалуудтай зарим талаар төстэй боловч шавар ваар савын олдворгүй дурсгалуудыг анхаарч, учир холбогдол, он цагийн асуудлыг тодруулах нь чухал байна. Бид Борзонгийн говийн Бяруухайн суурин, Ганган задгай, Харанхуй ус зэрэг газар дээд палеолитын төгсгөл, голоцены эрт үед холбогдох магадлалтай хэмээн таамаглаж байна.

Хайгуул судалгааг анх эхэлсэн Борзонгийн говь орчмын нутаг нь үе үеийн археологийн дурсгалаар баялаг бөгөөд тухайн орчиндоо стратегийн чухал цэг болсон газар ажээ. Хүннүгийн үеийн цэргийн бэхлэлт хэрмээс гадна дээр дурдсан уст цэгүүдэд түүхэн үед холбогдох янз бүрийн ваар савын хагархай олон байдаг. Борзонгийн говиор алдарт Чингисийн хэрэм дайрч өнгөрөх бөгөөд хэрмийн орчимд эртний амьдралын ул мөр олон

буйн нэг нь Эхэн гүний худаг орчмын дурсгал ажээ. Энд заг ургасан хуурай сайрын эргээр чулуун байгууламж, ваар савын зүйл, эртний төмөр эдлэлийн зэвэрч муудсан хэлтэрхий олон тааралдаж байна. Борзонгийн говиос цааш Булган Хорго уулаар дайрч улсын хилийн бүсэд судалгааг үргэлжлүүлэхэд Борзонгийн говь орчмын өмнө өгүүлсэнтэй ижил дурсгал огт тааралдаагүйгээр барахгүй “хоосон” газар нутаг болох нь тодорхой болсон юм. Тиймээс Борзонгийн говь, түүний хээлээс эх авах олон булаг буюу уст цэг Монгол нутгийн гүнд нэвтрэх түшиц газрын нэг байснаас олон үеийн дурсгал энд цогцолсон байх боломжтой ажээ. Суурьшмал ард түмний зүгээс говийг гаталж унаа хөсөг, хүн хүчээ амрааж сэргээх чухал газар бол Борзонгийн булаг орчмын нутаг гэдэгт эргэлзэхгүй байна. Археологийн дараа дараагийн судалгааны үр дүнд энэ газрын түүхэн үнэ цэнэ илүү тодорхой болох биз ээ.

Улсын хилийн дагууд Баянбулаг, Цал гүний сайр, Хар хөвийн булаг, Хавцалын булаг зэрэг газарт хайгуул судалгааг үргэлжлүүлэн гүйцэтгэсэн боловч томоохон дурсгал олж тогтоож чадсангүй. Монгол Улсын өмнөд цэг Орвог Гашууны бор толгойтой ойрхон БНХАУ-ын ӨМӨЗО-ны нутагт Ингэн худаг хэмээх неолитын том дурсгал байдаг тул манай нутаг дэвсгэрт энэ дурсгалтай ойролцоо дурсгал байх магадлалтай хэмээн үзэж судалгааг гүйцэтгэсэн боловч амжилтад хүрээгүй. Харин Цал гүний сайрын орчмоос чулуун зэвсэг хийх түүхий эдийн орд илрүүлсэн билээ.

Монгол Улсын өмнөд хилийн орчимд өдгөө хүн амьтан нутагладаггүй. Газар нутгаа сайн мэдэх нутгийн хүн байхгүй нь хайгуул судалгаанд тодорхой бэрхшээл учруулснаас гадна газрын зурагт тэмдэглэгдсэн зарим булаг өдгөө мэдэгдэхгүй болтол элсэнд дарагдаж, жил ирэх бүр элсэн хурдасны эзлэх талбай тэлсээр буй нь хүний нүдэнд тэр бүр өртдөггүй бууц суурины үдэгдлийг дарж мэдэгдэхгүй болгож байх магадлалтай байв.

Хайгуул судалгаа гүйцэтгэсэн дараагийн цэг бол Өмнөговь аймгийн Манлай сумын нутаг Говийн Төхөм юм. Нэрт археологич Х.Пэрлээ абугай энд зэсийн хүдэр хайлуулсан ул мөрийг илрүүлэн судалсан бөгөөд чулуун зэвсгийн олдвортой тухай анх мэдээлсэн юм. Зэсийн хүдэр, чулуун зэвсгийн олдвор хоорондоо холбоо хамааралтай, ойролцоо цаг үеийнх үү? Өөр цаг үед хүмүүсийн үлдээсэн дурсгал нэг газарт байна уу? гэсэн асуулт сонирхолтой байсан билээ. Говийн төхөмд хийсэн хайгуул судалгааны үр дүнд 8 байршилд чулуун зэвсгийн олдворын бөөгнөрөл буйг тогтоосон. Мөн шаварлаг хөрсөн дээр хадгалагдаж үлдсэн хэд хэдэн голомтын үлдэгдлийг тодруулсан билээ. Орших орчин, байршил зүйн хувьд энэ дурсгал Арц Богдын нурууны өврийн Баруун хүрээний тойромын голоцны эрт үеийн дурсгатай нэн төстэй ажээ.

Говийн төхөмийн чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл нэлээд эртний хэв шинжтэй байна. Анчин – түүвэрлэгчид дээд палеолитын төгсгөл үеэс жижиг болон бичил ялтсан зэвсгийг өргөн ашиглах болсон юм. Ялтас цуулахад шаантган хэв шинжийн үлдцийг сууринд суулгаж зэрэгцээ цуулалтаар ялтас салган авч байжээ. Дээд палеолитын төгсгөл, голоцены эрт үеийн шаантган үлдэц нэлээд том хэмжээтэй байдаг онцлогтой. Говийн төхөмийн дурсгалд ч энэ байдал ажиглагдав. Мөн хоёр талаас нь нимгэлж зассан бифас маягийн зэвсэг олон тааралдаж байна. Палеолитын үеийн туршид өргөн хэрэглэгдэж байсан хянгар зэвсгийг ийм хутга маягийн эдлэл орлох болсон бөгөөд Арц Богдын нурууны өвөр хоолойн дурсгалуудад элбэг тааралддаг. Харин неолитын дунд, хожуу үеийн дурсгалуудад ийм төрлийн зэвсэг байдаггүй. Бифасан хутга маягийн зэвсэг цаашид олон төрлийн зүймэл зэвсгээр солигдсон хэмээн үзэж болно.

Говийн төхөмийн дурсгалыг эрт үед холбон үзэх өөр нэг шижим бол эндээс неолитын дунд, төгсгөл үед өргөн хэрэглэгдэх болсон сийлүүр, хатгуур зэрэг багаж алга. Мөн шавар ваар савны зүйл нэн цөөн, байгаа зарим нэг нь чулуун зэвсэгтэй хамааралгүй хожуу үеийнх бололтой.

Говийн төхөм орчимд хийсэн хайгуул судалгааны үр дүнд энд буй зэсийн хүдэр хайлуулж, боловсруулж байсан ул мөр, чулуун зэвсгийн бууц суурин хоорондоо хамааралгүй хэмээн үзэж байна. Чулуун зэвсгийн олдвор нь үйлдвэрлэлийн арга барил, төрөл зүйн бүрдлээрээ дээд палеолитын төгсгөл, голоцены эхэн үеийг илэрхийлж байна. Мөн говийн төхөмийн орчимд Аргалантын уулын баруун хойд биед Булаг шавагтай хэмээх газраас илрүүлсэн цөөн олдвор бүхий бууц ч энэ он цагийн хүрээлэлд багтах магадлалтай байна.

Хайгуул судалгааг үргэлжлүүлсэн дараагийн газар бол Дорноговь аймгийн Хатанбулаг сумын өмнөд зах улсын хилийн ойролцоох Тэнгэр тойром, Цахиурт овоо орчмын газар юм. Ялангуяа, Цахиурт овоо орчмоос палеолит, хүрэл, хожуу үеийн сонирхолтой дурсгал илрүүлэв. Тэнгэр тойром ерөнхийдөө өргөн уудам газар нутгийн хамарсан том хотос хөндий бөгөөд энэ хавьд хамгийн өндөрлөг нь Цахиурт толгой ажээ. Энэ газар баруунаас зүүн тийш хошуурч тогтсон үргэлжилсэн хэдэн толгодоос бүрдэх бөгөөд тэдгээрийн бэл, хажуу, оройг хүрэн, шаргалдуу өнгөтэй цахиурын төрлийн чулуу нэлэнхүйдээ хучжээ. Өөрөөр хэлбэл, энд чулуун зэвсэг хийх түүхий эд элбэг байна. Хайгуул судалгааны явцад Цахиурт толгойн ар, баруун хажуу, орой, зүүн бэлд 4 газарт цэг авч баримтжуулсан.

Газрын хөрсөн дээрх олдвор болон цуглуулгын хэрэглэгдэхүүн дотор залтас давамгайлах хандлагатай байна. Ер нь суурин – дархны газрын олдворын бүрдэлд залтас

олон байдаг онцлогтой билээ. Эндэхийн хоёрдогч боловсруулалт хийсэн багаж зэвсэг нь цөөн төрөл зүйлтэй агаад иртэй залтас, ялтас голлож байна. Мөн цөөн тооны шүдлэг хүнхэр ирт зэвсэг байх ажээ.

Цахиурт овооны суурин – дархны газраас бид үлдэц, үлдэц хэлбэрийн эдлэл цөөн илрүүлсэн бөгөөд зэрэгцээ цуулалтын арга ажиллагааг илтгэж байна. Мөн леваллуагийн хэв шинжийн үлдэц, бэлдэц тааралдсангүй. Тиймээс бид орон нутгийн онцлогийг хадгалсан дээд палеолитын эхэн үеэс дунд үед холбогдох дурсгал хэмээн үзэж байна.

Цахиурт толгойн шил, өвөр бэлээр хүрлийн үед холбогдох цөөн боловч булш оршуулга, тахил тайлгын холбогдолт дурсгал байгааг бүртгэж баримтжуулав. Ер нь тухайн бүс нутаг булш оршуулга зэрэг чулуун байгууламжит дурсгал цөөн бөгөөд харин Цахиурт овоонд нэг доор харьцангуй бөөгнөрсөн байдалтай дурсгал буй нь тухайн газар энд аж төрж байсан нүүдэлчдийн хувьд нас барагсдаа оршоосон онгон дагшин газар байсантай холбоотой бололтой. Өдгөө ч нутгийн иргэд Цахиурт овоог “догшин” хэмээн хэлэлцэх бөгөөд цагаан цахир чулуунаас нь авч болохгүйг сануулж байв.

Эндэхийн булш оршуулга нь говийн бүс нутгийн хүрлийн үеийн хамгийн эртний булш оршуулга болох шоргоолжин булш, улаан зуух хэлбэрийн булш юм. Харин зэл чулуу нь харьцангуй хожуу үед хамаарах юм.

Хайгуул судалгаанд хамрагдсан дараагийн газар бол Дулааны говь юм. Дулааны говь Дорноговь аймгийн Эрдэнэ сумын баруун зах нутаг бөгөөд Далайн элснээс хойших өргөргийн дагуу сунаж тогтсон уужим хоолой юм. Сайншандаас Замын-Үүд чиглэсэн төв замын баруун талд байх хоолойг зүүн талаас нь Далайн хоолой, Дулааны хоолой, Дулааны говь, хоолойн нэлээд баруун хэсгийн дов сондуултай хэсгийг Дулаан товцгийн худаг хэмээн нэрлэх ажээ. Х.Пэрлээ, Н.Сэр-Оджав, Д.Цэвээндорж нарын ахмад эрдэмтэд чухамдаа Дулааны говийн баруун биед, дов сондуулан дунд байх худгийн орчимд судалгааны ажлаа гүйцэтгэсэн бололтой. Харин эндээс зүүн тийш говь дагуу хэд хэдэн худаг байх боловч одоогоор хайгуул судалгаа хийгээгүй байна.

Бид Дулаан товцгийн худаг орчимд явган хайгуул хийж, археологийн дурсгал бүхий 10 газрыг илрүүлж тэмдэглэсэн. Дурсгалуудаас цөөн олдворыг сонголтын зарчмаар түүвэрлэн цуглуулсан. Дулааны говь орчимд неолитын дунд ба хожуу үеийг илэрхийлэх чулуун зэвсгийн олдворын хамт хожуу үеийн ваар савын зүйл элбэг тааралдах ажээ. Энэ нь бүс нутаг олон үеийн турш зам газар байсны илрэл байж магадгүй юм. Чулуун зэвсгийн дурсгалууд их төлөв говийн тойром шалын урд талын намхан дэнжийн орой, хажуугаар тархсан бөгөөд элсэн хурдаст ихэд дарагджээ. Дулааны говиос чулуун зүүлтийг хэлбэржүүлэх ховилтой хавтан чулуу, неолитын ваар савын хагархай зэрэг сонирхолтой

олдворыг илрүүлснээс гадна тэмээн хяруулын өндөгний хальс, амьтны ясны үлдэгдэл зэргийг элсээр хучигдаж сайн хадгалагдсан шаварлаг давхаргаас илрүүлсэн билээ. Энэ нь Дулааны говийн суурины холбогдох он цагийг лабораторийн судалгаагаар тодруулах үнэт хэрэглэгдэхүүн болно. Бид Дулааны говийн чулуун зэвсгийн бууц суурин неолитын дунд ба хожуу үед холбогдох магадлалтай хэмээн үзэж байгаа юм.

Хамтарсан төслийн өмнөх судалгааны үр дүнд Сүхбаатар аймгийн өмнөд хэсэг, Дарьганга, Онгон, Наран сумдын нутагт голоцены үеийн сонирхолтой дурсгалууд илрүүлсэн билээ. Тиймээс энэ онд өмнөх судалгааг үргэлжлүүлэхээр төлөвлөсөн бөгөөд Онгон сумын Их булагийн өмнөд хэсэг, Хөндлөнгийн голын сав дагууд сонирхолтой дурсгалыг илрүүлж анхан шатны баримтжуулалтыг хийв. Энэ судалгаанд Дарьганга сумын ахмад багш Д.Дугарсүрэн абугай үлэмж тус хүргэснийг цохон тэмдэглэх хэрэгтэй бөгөөд археологийн дурсгалт газруудыг бидэнд зааж өгсөн билээ.

Судалгааны үр дүнд Сүхбаатар аймгийн Онгон сумын Хөндлөнгийн голын сав нутаг нь неолит, хүрлийн үеийн арвин баялаг дурсгалтай нь тогтоогдсон. Хөндлөнгийн голын Нам ухаагаас 5 байршилд анчин – түүвэрлэгчдийн ул мөрийг илрүүлж тэмдэглэсэн билээ. Эндээс Умард Хятадын неолитын дурсгалаас олддог будмал хээтэй ваар савын зүйл олддог нь бүс нутгийн эртний түүх, анчин – түүвэрлэгчдийн харилцааг судлах нэг шижим хэмээн үзэж буй юм. Нам ухаагийн неолитын үеийн бууц сууринаас будмал ваарын хагархайнаас гадна орон нутгийн гаралтай бордуу өнгөтэй босоо амсартай ваарын хагархай илрүүлэв. Чулуун зэвсгийн төрөл зүйлд бичил ялтсан зэвсгийн үйлдвэрлэл давамгайлахын зэрэгцээ хоёр талаас нь холтчин зассан сумын зэв, олон төрлийн жижиг хусуур, сийлүүр зэрэг неолитын дунд, хожуу үеийг илэрхийлэх эдлэл олон байна. Мөн хусуур, сүх зэрэг том хэмжээтэй багаж цөөн боловч илрүүлсэн. Нам ухаа, Хөндлөнгийн голын дурсгалуудад самбар чулуу, самбар чулууны хагархай олон тоогоор хадгалагдаж буй нь энд анчин – түүвэрлэгчдийн отог буудал оршиж урт хугацаанд хүмүүс амьдарч байсныг илэрхийлж байна. Неолитын тогтсон хэв шинжтэй багаж зэвсгээс гадна хасаар хийсэн дугуй зүүлт зэрэг сонирхолтой эд өлгийн зүйл, тэмээн хяруулын засаж янзлаагүй өндөгний хальс илрүүлсэн.

Хөндлөнгийн голын сав дагууд Нам ухаа 1 – 5, Хөндлөнгийн гол 1, 2, Их булаг 1, 2 дурсгалыг шинээр илрүүлж анхны баримтжуулалтыг хийсэн бөгөөд цаашид өргөн цар хүрээтэй малтлага судалгааг гүйцэтгэх, хайгуулыг илүү нарийвчлалтай хийхээр төлөвлөж байна.

2024 оны хээрийн судалгааны явцад бид зөвхөн эртний бууц сууринд анхаарал хандуулалгүй булш оршуулга, тахил тайлгын байгууламж, цонж хэрмийн үлдэгдэл, сүм хийдийн туурийг баримтжуулсан билээ.

Говь, хээрийн бүс нутгийн хүрлийн үеийн хамгийн эртний дурсгал болох шоргоолжин булшийг Өмнөговь аймгийн Номгон сумын Задгайтын булаг, Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Цахиурт толгой, Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Эрдэнэ уул зэрэг газруудад бүртгэн браимтжуулав. Улаан зуухын булш мөн Задгайтын булаг, Тавьтын худаг, Цахиурт толгой, Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Сайрын бууцны хойд толгой, Өргөн сумын Баян хошуу, Онгон сумын Хөндлөнгийн голын Нам ухаа, Дарьганга сумын Эрдэнэ уул, Дагшин булаг зэрэг газарт бүртгэн баримтжуулсан юм. Мөн өмнө судлаачид илрүүлж тэмдэглэсэн Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Арын усны шивээг дахин баримтжуулав. Хожуу үед холбогдох дурсгалаас нэлээд сонирхолтой нь Хөндлөнгийн голын хэрэм юм. Голын өмнөд этгээдийн өн шимлэг бэлчээртэй газарт энэ хэмийг барьсан бөгөөд зүүн тийш харсан хоёр хаалгатай, зөв бус зууван дугуй хэлбэртэй. Хэрмийн дотор барилга байшингийн ул мөр байхгүй. Хожуу үеийн бололтой паалантай ваарын хагархай, ахуйн хэрэглээний төмрийн хугархай зэргээс өөр эд өлгийн зүйл олдсонгүй. Хэдийгээр хэлбэрийн хувьд адилгүй боловч орших орчин, дотор нь орон суурийн ул мөр байхгүй зэрэг байдлаараа Өмнөговь аймгийн Баяндалай сумын нутгаас судлаачдын илрүүлсэн зэрэгцээ хэрэм, Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын нутагт Онгийн голын баруун эрэгт буй Шивээт хошууны хэрэмтэй төстэй зүйл байна. Эдгээр хэрмийг судлаачид Манжийн үед холбогдуулан үздэг.

Дарьганга бол Манжийн эрхшээлийн үед Сүрэгчин хошууны гол нутаг байсан билээ. Ялангуяа, Хөндлөнгийн голын сав нутаг нь өн шимлэг өвс бэлчээртэй тул уг хэрэм даланг мал ахуйн үйлтэй холбоотой байх магадлалтай хэмээн таамаглаж байна.

Хамтарсан төслийн судлаачид Хөндлөнгийн гол, Баруун Сөдөтийн булаг, Дагшин булаг орчмоор судалгаа хийсний буцах замдаа Дарьганга сумын нутаг Зүүн Нарт ууланд гүймэг хайгуул хийв. Нутгийн иргэд бидэнд Зүүн Нартад агуй байдаг тухай мэдээлсэн юм.

Зүүн Нарт нь тэр хавьдаа ноёлог өндөр бөгөөд хад асгатай. Тиймээс агуй хонгил байдаг бол анчин - түүвэрлэгчдийн дурсгал байх магадлалтай юм.

Зүүн Нартын Агуй, хонгилууд их төлөв уулын дундаас дээш хэсэгт орших тул их зүтгэж хүрнэ. Зарим нь шороон хөрстэй байхад зарим нь хадан шалтай ажээ. Агуйн ам их талав урагш буюу хөндий рүү харсан байрлалтай. Харин гол өндрийн зүүн өмнөд талд, ханан хадны дэргэд байх агуй зүүн урагш харсан үүдтэй ажээ. Зарим жижиг агуйд модон хайрцагтай бурхан шашны холбогдолтой бололтой эд зүйл ч байна. Өнгөрсөн жилийн зудын хатуу цагт мал амьтан агуй хонгил нөмөрлөж үхсэн сэг зэм бишгүй олон тааралдаж, тэдгээр нь агуйн доторхыг шалгахад саад тотгор болж байв. Бид эндэхийн агуй хонгилоос ямар нэг эртний түүхийн ул мөр илрүүлсэнгүй. Үйрч унасан барзгар чулуутай тул хана, таазанд зураг зурах, сийлэх боломжгүй ажээ. Мөн агуй хонгил нэлээд өндөрлөгт байрлах тул хүрч очиход

төвөгтэй байж мэднэ. Мөн хуурч ховхорч унадаг хаднууд нь хүн удаан суурьших нөхцөл боломжийг үгүйсгэж байж ч болно. Гэвч цаашид агуй хонгил бүрийг нэг бүрчлэн нарийн шалгах, Зүүн Нартын уулын зүүн өмнөд талаар ороосон хуурай сайрын дагууд хайгуул судалгаа хийвэл эртний түүхийн дурсгал илрүүлэх магадлалтай хэмээн үзэж байна.


Монгол орны хээрийн бүс нутгийн өмнөд хэсгээр элсэн манхан, элсэн тарамцагт орших баянбүрдийн орчимд неолитын үеийн анчин – түүвэрлэгчдийн ахуй амьдралын ул мөр бууц суурины дурсгал нэлээд тааралддаг билээ.

Энэ оны хээрийн судалгааны улиралд хамтарсан төслийн судлаачид Салаа булагийн дурсгалд өргөн хэмжээтэй малтлага судалгаа хийж шинэ хэрэглэгдэхүүн бүрдүүлэх, сууц оромж, гал голомтын үлдэгдэл илрүүлэх, эртний соёлын ул мөрийг хадгалсан хөрсний давхаргаас дээж авч нарийвчлан шинжлэхээр төлөвлөсөн юм.

Салаа булагт хийсэн малтлагаар хамтарсан төслийн судлаачид хожуу голоцены үеийн элсэн манханы баярбүрдэд суурьшсан анчин – түүвэрлэгчдийн ул мөрийг илрүүлж, судалгааны үнэт хэрэглэгдэхүүнийг бий болгосон юм. Ялангуяа, анчин – түүвэрлэгчид хөрш бүс нутагтай харилцаатай байж, тэдний бүтээгдэхүүнийг авч ашиглаж байсан нь шавар сав суулгаас тодорхой болсон юм. Энэ баримтыг цаашид гүнзгийрүүлэн судлахаар зорьж буй бөгөөд ваар савыг зөвхөн хөрш бүс нутгаас авах бус орон нутгийн шавар сав суулганы баримт ч энэ малтлагаас хамт гарч ирсэн нь сонирхолтой юм. Бид урьдчилсан байдлаар гурван өөр шавар сав суулга Салаа булагийн оршин суугчид хэрэглэж байсан хэмээн үзэж байна. Тэдгээрийн нэг нь арилжаа солилцооны замаар хөрш бүс нутгаас ирсэн байх магадлалтай. Харин дунд зэргийн шатаалттай, босоо амсартай ваарын хагархай, гадна талдаа хээ гаргагчаар хээлсэн босоо амсартай нимгэн хагархай зэрэг нь эндэхийн эртний оршин суугчдын сав суулга бололтой.

Салаа булагийн неолитын суурингаас илрүүлсэн члуун зэвсгийн олдворын бүрдэл, тэдгээрийг хийсэн арга барил зэрэг нь бүхэлдээ неолитын хожуу үеийн илэрхийлж буй бөгөөд гол, булаг шандын эх орчмын сайн устай газруудад хүмүүс суурьшихыг илүүтэй эрмэлзэх болсон голоцены хожуу үеийн дурсгал ажээ.

Эцэст нь тэмдэглэхэд, Монгол – Канадын хамтарсан судалгааны 2024 оны хээрийн судалгааны зорилго бүрэн биелсэн бөгөөд өмнө нь судалгаа бага хийсэн газар нутгаас олон шинэ дурсгал илрүүлж мэдээллийн санг баяжуулав. Бид цаашид тухайн бүс нутагт хайгуул судалгааг үргэлжлүүлэх, зарим дурсгалг малтан шинжилэхээр төлөвлөж байна.



Зураг 169. Хамтарсан төслийн 2024 онд хайгуул судалгаа хийсэн, шинээр илрүүлсэн археологийн дурсгаалын тархалтын бүрдүүвч

4. НОМ ЗҮЙ

1. Ч.Амартүвшин, Н.Батболд, Г.Эрэгзэн, Б.Батдалай. Чандмань Хар уулын археологийн дурсгал I. УБ., 2015.
2. Н.Батболд, Ц.Амгалантөгс, Б.Эрдэнэ. Дорноговь аймгийн Хэцүү уулын агуйгаас илэрсэн хүний ясны олдворууд // *Studia Archaeologica*. Tom. XXXIV, fasc. 26. УБ., 2014. тал. 323-327
3. З.Батсайхан. Бяруухайн суурины чулуун зэвсгүүд. Шинжлэх Ухааны Академийн мэдээ. №3. УБ., 1993. тал. 49-51
4. К.Н.Вяткина. Археологические памятники МНР. С.А. №1. 1960. стр. 59
5. Б.Гүнчинсүрэн, Д.Одсүрэн, Г.Лхүндэв. Шарилын уулын чулуун зэвсгийн дурсгал // *Studia Archaeologica*. Tom. XXXIV, fasc.1, УБ., 2014. тал. 7-14.
6. Ж.Гэрэлбадрах. Дарьгангын гурван газрын зургийг нятлах нь. Монгол судлал ба тогтвортой хөгжил II. Олон Улсын Монголч Эрдэмтний XI их хурлын “Монголын түүх судлал” II салбар хуралдааны илтгэлүүд. Эрхэлсэн С.Чулуун. УБ., 2017. тал. 44-54.
7. А.П.Деревянко, Д.Дорж, Р.С.Васильевский, В.Е.Ларичев, В.Т.Петрин, Е.В.Девяткин, Е.М.Малаева. Каменный век Монголии. Палеолит и неолит Монгольского Алтая. Новосибирск. 1990. стр. 43
8. А.П.Деревянков, Д.Олсен, Д.Цэвээндорж, В.Т.Петрин, А.Н.Зенин, А.И.Кривошапкин, Р.У.Ривс, Е.В.Девяткин, В.П.Мыльников. Археологические исследования Российско-Монгольско-Американской экспедиции в Монголии 1995 г. Новосибирск. 1996; А.П.Деревянков, Д.Олсен, Д.Цэвээндорж, В.Т.Петрин, А.Н.Зенин, А.И.Кривошапкин, С.В.Николаев, В.П.Мыльников, Р.У.Ривс, Б.Гунчинсүрэн, Я.Цэрэндагва. Археологические исследования Российско-Монгольско-Американской экспедиции в Монголии 1995 г. Новосибирск. 1998
9. А.П.Деревянко, Д.Олсен, Д.Цэвээндорж, В.Т.Петрин, С.А.Гладышев, А.Н.Зенин, В.П.Мыльников, А.И.Кривошапкин, Р.У.Ривс, П.Д.Брантигхэм, Б.Гунчинсүрэн, Я.Цэрэндагва. Археологические исследования Российско-Монгольско-Американской экспедиции в Монголии в 1997-1998 годах. Новосибирск. 2000.
10. Д.Дорж. Неолит Восточной Монголии. УБ., 1971
11. Д.Дорж, Д.Цэвээндорж. Монголын палеолит. УБ., 1978.
12. Ц.Доржсүрэн. БНМАУ-ын нутаг дээрх чулуун зэвсгийн судлалын байдал. Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхтгэл. Улаанбаатар. 2003. тал. 94-95
13. Ц.Доржсүрэн. Улсын төв музейд байгаа чулуун зэвсгийн зүйлс. Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхтгэл. УБ., 2003. тал. 134.
14. В.Е.Ларичев, В.В.Волков. Мустиерские и неолитические памятники Южной Гоби «Древняя Сибирь» вып. 1 Новосибирск. 1964.
15. Г.Лхүндэв, Д.Одсүрэн, Б.Гүнчинсүрэн. Галбын говийн хойд хэсгээс шинээр илрүүлсэн палеолитын ил суурингууд // *Studia archaeologica*. Tom. XXXVI, fasc.3, УБ., 2017. тал 31-44.
16. О.Намнандорж. Бүтээлийн эмхтгэл. УБ., 2003. тал. 382-384.
17. Т.И.Нохрина, И.В.Усачёва, Б.Гүнчиүнсүрэн. Нрвые данные о территории распространение “утюжков” и некоторые проблемы их изучения // *Studia Archaeologica*. Tom XVI. fasc.5. УБ., 1996. тал. 76-81
18. Монголын сүм хийдийн түүхэн товчоон. Ерөнхий ред. С.Цэдэнбямба. УБ., 2009. тал. 598
19. Д.Одсүрэн. Хоёр хайрханы чулуун зэвсгийн дурсгалын судалгаа // *Acta Historica*. Tom. XV, fasc. 2, УБ., 2014. тал. 21-38
20. Д.Одсүрэн. Шавартайн булагийн Ар шандын шинэ чулуун зэвсгийн суурингийн судалгаа // *Acta Historica*. Tom. XXIV, fasc. 1. УБ., 2023. тал. 7-23

21. Д.Одсүрэн, Д.Бөхчулуун, Л.Яанз, А.Розен. Говь, хээрийн бүсийн неолитын судалгаа төслийн 2017 оны хээрийн шинжилгээний ажлын тайлан. УБ., 2017. АХГБСХ.
22. Д.Одсүрэн, Д.Бөхчулуун, Л.Яанз. Зүүн Монголын нутагт хийсэн шинэ чулуун зэвсгийн судалгааны зарим үр дүн // *Studia Archaeologica*. Tom XXXV. fasc. 5. УБ., 2015. тал. 72-96
23. Д.Одсүрэн, Л.Яанз, Д.Бөхчулуун. Говийн бүс нутгийн неолитын үеийн аж ахуй, соёлын асуудалд // *Studia Archaeologica*. Tom XXXIX. fasc. 2 УБ., 2020. тал. 13-25
24. А.П.Окладников. Новое в изучении древнейших культур. Монголии. СЭ. I. 1962.
25. А.П.Окладников. Новые данные по древнейшей истории Внутренней Монголии. ВДИ, № 4. Новосибирск. 1976.
26. А.П. Окладников, Д.Дорж. Памятники каменного века на Юге МНР (по работам 1971-1972 гг) // *Studia Archaeologica*. Tom. VII, fasc. I. УБ., 1976.
27. А.П.Окладников, Д.Дорж. Отчет палеолитического отряда ССМИКЭ за 1971-1973 и 1978 гг.
28. А.П.Окладников, Р.С.Васильевский. Новые исследования Аршан хаде в Монголии. Изв. СО АН СССР. № 6, Вып. 2, Серия общественных наук. Новосибирск. 1982.
29. С.Өлзийбаяр, Б.Баатархүү, Б.Очир, А.Уранжаргал. Домогт хатны булаг (2016-2018ондл хэрэгжүүлсэн “Хатны булгийн нууц” төслийн хээрийн судалгааны хэрэглэгдэхүүнээр). УБ., 2022.
30. Х.Пэрлээ. Монгол ард улсын эрт, дундад үеийн хот суурины товчоон. УБ., 1961. Х.Пэрлээ. Өмнөговь, Өвөрхангай аймгуудын говь талын нутгаас эртний судлалын хайгуул хийсэн нь. Эртний судлал-угсаатны зүйн бүтээл. УБ., 1963. тал. 26-37
31. Х.Пэрлээ. Монголын нүүдэлчдийн металлурги боловсруулалтын түүхийн асуудалд // *Studia Archaeologica*. Tom. X, fasc. 4. УБ., 1982. тал. 48-73
32. Х.Пэрлээ, Н.Сэр-Оджав. Дорноговиос эртний хүний ул мөр олдлоо // ШУТ. №5-6. УБ., 1957
33. Д.Содномжамц, Г.Анхсанаа. Дорнод Монголоос олдсон будмал хээтэй нэгэн ваар // Нүүдэлчдийн өв судлал. Tom. XII-II. fasc. 2. УБ., 2021. тал. 17-23
34. Н.Сэр-Оджав. Дорноговь аймагт мэдээ шалгах ажлаар явсан тухай. Хархорум шинжилгээний ангийн 1981-1982 оны ажлын тайлан. УБ., 1982. АХГБСХ
35. Э.Уртнасан, Л.Эрдэнэболд, Б.Анхбаяр, Д.Содномжамц. Сайн ноён хан аймгийн Үйзэн засгийн хошууны нутаг дахь эртний хот, суурины дурсгал. Сайн ноён хан аймгийн Үйзэн засгийн хошуу: хэл, түүх, соёл, байгаль. УБ., 2024. тал. 175-178
36. Б.Цогтбаатар, Х.Пүрэвжал. Ачаат уулын чулуун зэвсгийн суурин // *Studia archaeologica*. Tom. XXXIV, fasc.2. УБ., 2014. тал. 15-24
37. Н.В.Цыденова, Д.Тумэн, М.Эрдэнэ. Древнее поселение Барга элс в Восточной Монголии // *Древние Культуры Монголии и Байкальской Сибири*. УБ., 2012.
38. Д.Цэвээндорж, П.Хосбаяр. Дулааны говийг археологи, геологийн талаар дахин судалсан // *Studia Archaeologica*. Tom X, fasc.3. УБ., 1982
39. Д.Цэвээндорж, Д.Баяр, Я.Цэрэндагва, Ц.Очирхуяг. Монголын археологи. УБ., 2003
40. Д.Цэвээндорж, Б.Гүнчинсүрэн, Б.Цогтбаатар. Чулуун зэвсгийн судалгаа. Монгол Улсын шинжлэх ухаан. 32-р боть. УБ., 2007.
41. Я.Цэрэндагва. Ханбогдоос олдсон содон чулуун багаж зэвсгүүд // *Acta Historica*. Tom. XI, fasc. 1. УБ., 2010.
42. Я.Цэрэндагва, Д.Одсүрэн. Эргийн хоолойн шинэ чулуун зэвсгийн дурсгал // *Acta Historica*. Tom. X, fasc. 2, УБ., 2009. тал. 11-21
43. Г.Энхбат, Б.Даваацэрэн. Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал. IV дэвтэр. Дорноговь аймаг. УБ., 2010. т. 95
44. У.Эрдэнэбат. Хахуулын голын хадны зураг // *Studia Archaeologica*. Tom. (VI) XXVI, fasc. 3. УБ., 2008. тал. 32-56

45. Л.Яанз, Д.Бөхчулуун. Говийн өргөжих бүс нутгийн харилцаа ба нийгэмд гарсан өрчлөлт // *Studia Archaeologica*. Tom. XXXVII, fasc. УБ., 2018. тал. 30-45
46. Ch. P.Berkey, N.C. Nelson. *Geology and Prehistoric Archaeology of the Gobi Desert* // *American Museum Novitates*. 1926. No. 222. p. 1–16
47. Davaakhuu Odsuren, Lisa Janz, William Fox, Dashzeveg Bukhchuluun. Otson Tsokhio and Zuun Shovkh: the Initial Upper Palaeolithic in Eastern Mongolia. *Journal of Paleolithic Archaeology* (2023) 6:10. <https://doi.org/10.1007/s41982-023-00139-x>
48. Fairservis, W.A. *The Archaeology of the Southern Gobi, Mongolia*. Durham: Carolina Academic Press. 1993. p. 39
49. F.Iizuka, M.Izuho, B.Gunchinsuren, B.Tsogtbaatar, and D.Odsuren. Manufacturing techniques and formal variability of pottery from five neolithic sites in eastern steppe and the Gobi desert, Mongolia // *Археологийн судлал*. Tom. XXXVII, fasc. 1, УБ., 2018.
50. Lisa Janz, James K. Feathers, George S. Burr. Dating surface assemblages using pottery and eggshell: assessing radiocarbon and luminescence techniques in Northeast Asia. *Journal of Archaeological Science* 57 (2015) 119-129
51. Lisa Janz., Arlene M.Rosen, Dashzeveg Bukhchuluun, Davaakhuu Odsuren. Zараа Уул: An archaeological record of Pleistocene-Holocene paleoecology in the Gobi Desert. *Plos ONE* 16(4): e0249848. <https://doi.org/10.1371/journal.pone.0249848>
52. Lisa Janz, Asa Cameron, Dashzeveg Bukhchuluun, Davaakhuu Odsuren, Laure Dubreuil. Expanding frontier and building the Sphere in arid East Asia. *Quaternary International*. Volume 559, 10 September 2020, Pages 150-164. <https://doi.org/10.1016/j.quaint.2020.04.041>
53. D.Mania. *Archaeologische Studien in der zentralen Mongolei*, Sonderdrucke aus der Wissenschaftlichen Zeitschrift der Martin-Luther-Universität Halle-Wittenberg. 1964. Heft 13.
54. J.Maringer. Contribution to the prehistory of Mongolia. Reports from the Scientific Expedition to the North-western Provinces of China under the Leadership of Sven Hedin. Sino–Swedish Expedition Publication, 34. Stockholm: Statens Etnografiska Museum
55. N.C. Nelson. Notes on the Archaeology of the Gobi // *American Antropologist*. 1926a. Vol. 28. No. 1. 305–308
56. H.F.Osborn. The discovery of tertiary man. *Nature*. Vol. 71. 1930

Хавсралт 1. Археологийн малтлага судалгаа хийх зөвшөөрлийн хуулбар

ТУСГАЙ ТЭМДЭГЛЭЛ

МОНГОЛ УЛС
СОЁЛЫН ЯАМ

ТЭМДЭГЛЭЛ БИЧСЭН:

/албан тушаалын нэр/

Гарын үсэг нэрийн тайлал

/тэмдэг/

20 ... оны ... сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

20 ...

ПАЛЕОНТОЛОГИ, АРХЕОЛОГИЙН
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХАЙГУУЛ, МАЛТЛАГА
СУДАЛГААНЫ АЖИЛ ХИЙХ
ЗӨВШӨӨРӨЛ

№ 7-3	СУДАЛГААНЫ АЖИЛ ХИЙХ:
СОЁЛЫН САЙДЫН 20 ²⁴ ОНЫ 05 ДУГААР САРЫН 15 - ны өдрийн А/255 ДУГААР ТУШААЛААР Д.Одсүрэн, Д.Бөхчулуун	Засаг захиргааны нэгжийн нэр: Өмнөговь, Дорноговь, Сүхбаатар аймаг Номгон, Ханбогд, Хатанбулаг, Өргөн, Онгон Наран, Дарьганга сумд
УДИРДАГЧТАЙ Говь, хээрийн бүс нутгийн неолитын судалгаа	Газар нутгийн нэр: Баянгол, Бүдүүн хар уул, Ар хужиртын гол, Цахиуртын худаг, Тэнгэр тойром,
СУДАЛГААНЫ АНГИД ПАЛЕОНТОЛОГИ, АРХЕОЛОГИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХАЙГУУЛ, МАЛТЛАГА СУДАЛГААНЫ АЖИЛ ХИЙХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОВ.	Зүүн булангийн худаг, Их булагийн ам, Хар нуур, Нуган нуур, Зүүн, Баруун, Дунд хөдөө нуур, Агуйт уул, Салаа Зулаг
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОСОН: СОЁЛЫН САЙД: <i>[Signature]</i> Гарын үсэг (тэмдэг)	Дурсгалын нэр: Неолит, хүрлийн үеийн дурсгал Солбицол:
Ч.НОМИН нэрийн тайлал	Хугацаа: 20 ²⁴ оны 07 дугаар сарын 04 -ны өдөр 20 ²⁴ оны 08 дугаар сарын 04 -ны өдөр
	Энэхүү зөвшөөрөл нь зөвхөн зөвшөөрөлд бичигдсэн газар, хугацаанд хүчинтэй.

ТУСГАЙ ТЭМДЭГЛЭЛ

Хугацаа сунгах үндэслэл

.....газар, байгууллагын
тодорхойлолт,

Хүсэлт

.....ажил

гүйцэтгэх шаардлагын дагуу томилолтын
хугацааг.....хоногоор сунгав.

Дарга

/Овог нэр/

..... он сар өдөр

**АЛБАН ТОМИЛОЛТЫН
ҮНЭМЛЭХ**

№

МУБИС-ийн НХУС-ийн Түүхийн
тэнхимийн багш Д.Одсүрэн-г
/овог нэр/

албан ажлаар Өмнөговь, Дорноговь
Сүхбаатар аймгуудад

/ажиллах аймаг, сум, хотын нэр/

2024 оны 07 дугаар сарын 04-ны өдрөөс
эхлэн хуанлийн 30 хоног ажиллуулахаар
томилов.

МУБИС-ийн Нийгэм, хүмүүнлэгийн
ухааны сургууль

ЗАХИРАЛ Н.МЯГМАРЦООЖ

..... он ... сарын ... өдөр

Томилолтоор ажилласан тухай
тэмдэглэл

№	Хаана	Ирсэн сар өдөр	Буцсан сар өдөр	Гарын үсэг
	<u>Д.Одсүрэн-г</u>	<u>Ⅶ/4</u>	<u>Ⅶ/13</u>	<u>[Signature]</u>
	<u>Дорноговь</u>	<u>Ⅶ/14</u>	<u>Ⅶ/28</u>	<u>[Signature]</u>

Удирдамжид заасан ажлыг

Гүйцэтгэсэн гэж дүгнэв.

.... хоногоор тооцож, томилолтын зардал
олгохыг зөвшөөрөв

Дарга

/Овог нэр/

..... он сар өдөр

МУБИС-ИЙН НХУС-ИЙН
ЗАХИРАЛ



Н.МЯГМАРЦООЖ

**“МОНГОЛЫН ГОВЬ, ХЭЭРИЙН БҮС НУТГИЙН НЕОЛИТЫН СУДАЛГАА” ТӨСЛИЙН
2024 ОНЫ ХЭЭРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН УДИРДАМЖ**

Улаанбаатар

2024 оны 04 сарын 10-ны өдөр

Төслийн тухай

Монгол-Канадын хамтарсан “Говь, хээрийн бүс нутгийн неолитын судалгаа” төслийг 2015 оноос хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд говийн бүс нутгийн зүүн хэсэгт Зараа уул, хээрийн бүс нутагт Тамсагбулаг зэрэг томоохон дурсгалт газарт археологийн олон талт судалгааг гүйцэтгэж холбогдох он цагийг тодорхойлж, өвөг түүхийг шинэ хэрэглэгдэхүүнээр баяжуулах олон сонирхолтой баримт бий болгож үр дүнг дотоодын болоод олон улсын эрдэм шинжилгээний цувралд нийтлүүлсэн. Судалгааны дараагийн шатанд Монгол орны говь, хээрийн бүс нутгийн өмнөд хэсгээр судалгааг үргэлжлүүлэхээр төлөвлөж байна.

2024 оны судалгааны зорилго:

Энэ оны хээрийн шинжилгээний ажлын зорилго нь Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутагт Салаа булагийн неолитын сууринд малтлага судалгаа хийж шинэ эх хэрэглэгдэхүүн бий болгох; Сүхбаатар, Дорноговь, Өмнөговь аймгийн өмнөд нутгаар чулуун зэвсгийн хайгуул судалгааг гүйцэтгэж шинэ дурсгал илрүүлэх, Монгол хийгээд Зүүн хойд Азийн өвөг түүхийн үеийг шинэ хэрэглэгдэхүүнээр баяжуулахад чиглэгдэнэ.

Хайгуул, малтлага судалгаа хийх газрын байршил:

Өмнөговь аймгийн Номгон сумын нутаг Цал гүний сайр (N41 41 30.6 E104 57 04.8), Баянгол (N41 42 28.8 E104 53 13.2), Бүдүүн хар уул (N41 55 53.9 E104 58 46.7), Улаан хороотын толгод (N42 50 28.9 E104 54 15.4), Ханбогд сумын Ар хужиртын гол (N42 15 56.9 E106 38 18.9), Олон шандын толгод (N42 27 52.9 E107 15 57.8), Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Овоот улаан толгой, Цахиуртын худаг, тэнгэр тойром (N42 39 50.0 E108 27 11.4), Өргөн сумын нутаг Зүүн булангийн худаг (N44 55 26.4 E111 08 48.7), Сүхбаатар аймгийн Онгон сумын Их булагийн ам (N45 23 43.1 E113 20 31.0), Наран сумын Зүүн булаг, Баруун булаг, Хар нуур, Ноён нуур (N44 48 41.0 E113 38 03.6), Уулзварын гол (N45 21 59.6 E113 37 47.5), Сөдөтийн булаг (N45 03 18.4 E113 53 23.4), Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутаг Өндөр хүрээт толгой (N45 21 26.5 E114 11 49.8), Зүүн, Баруун, Дунд хөдөө нуур (солбицол: N45 17 43.3 E114 18 08.2), Сүүл толгой (N45 16 53.2 E114 14 24.5), Хадатын булаг (N45 14 23.5 E114 24 10.9), Байшинтын тойром (N45 07 57.1 E114 20 05.1), Бургасны худаг (N45 12 23.1 E114 07 29.0), Холбоо нуур, Бадрах уул (N45 14 14.3 E114 08 52.7), Хошмог нуур (N45 12 54.5 E114 02 02.8), Зэгэст нуур (N45 17 27.3 E113 51 24.6), Бадрайн худаг, Хойморийн гурван нуур (N45 24 17.5 E113 49 00.5), Агуйт уул (N45 29 52.8 E113 28 19.2)-ын орчимд хайгуул судалгаа, чулуун зэвсгийн сорилын малтлага хийнэ. Дарьганга сумын нутаг Салаа булаг (солбицол: N46 07 45.3 E111 42 33.3)-т бага хэмжээтэй малтлага судалгааг гүйцэтгэнэ.

Судлагдсан байдал:

Говь, тал хээрийн бүс нутгийн шинэ чулуун зэвсгийн дурсгалуудын судалгаа 1920-иод оноос эхэлжээ. 1922, 1923, 1925-1928 онуудад Р.Ч.Эндрюсийн удирдсан Америкийн “Төв Азийн экспедици” Монгол орны өмнөд болон баруун өмнөд хэсэгт ажиллаж, чулуун

зэвсгийн олдвор тархсан олон дурсгалт газар илрүүлсний ихэнх шинэ чулуун зэвсгийн үед холбогдохыг судлаачид тэмдэглэсэн байна.

XX зууны эхэн үеийн Монголын томоохон сэхээтний нэг Д.Буддарь 1924 онд Дорнод аймгийн Халхгол сумын нутаг Тамсагбулагийн шинэ чулуун зэвсгийн сууринг илрүүлсэн мэдээ байдаг бөгөөд 1949 онд А.П.Окладниковоор удирдуулсан шинжилгээний анги анхны эрдэм шинжилгээний тодорхойлолтыг хийжээ.

Устай, Бургастайн шинэ чулуун зэвсгийн томоохон дурсгалуудыг илрүүлсэн байна. 1960-1970-аад оны үед Монгол орны хээрийн бүс нутагт шинэ чулуун зэвсгийн судалгаа харьцангуй эрчимтэй хийгдсэн бөгөөд Сүхбаатар аймгийн Бүрдийн баруун эрэг, Онгон элсний зүүн хэсэг, Онгон сумын төвийн баруун тал, Хонгор сумын Гүн булаг, наран сумын Эхэн ус, Дорнод аймгийн Хэрлэнгийн эргийн дурсгалууд, Овоот, Баруун, Зүүн Өлзийт, Дөрөө нуур, Ямаат нуур, Тогоот нуур, Мөнх толгой, Баруун шорвог нуур, Хүйтэн булаг зэрэг газруудаас шинэ чулуун зэвсгийн дурсгал илрүүлжээ.

1933-1934 онд археологич Д.Д.Букинич Халхын голын сав дагууд хайгуул хийж хэд хэдэн суурин илрүүлсэн мэдээ бий. 1949 онд Монгол-Зөвлөлтийн Түүх, Соёлын Хамтарсан экспедицийн чулуун зэвсгийн дурсгал судлах хэсэг Дорнод Монголын Хэрлэн, Халх голын сав, Буйр нуур орчмоор хайгуул судалгаа хийсэн бөгөөд Тамсагбулагийн дурсгалт газрыг илрүүлжээ. 1955 онд Монголын говийн бүс нутгийн шинэ чулуун зэвсгийн үед холбогдох томоохон дурсгал Дулааны говийн сууринг илрүүлсэн бөгөөд хожим 1978 онд дахин судалгаа хийжээ. 1954 онд О.Намандорж Сүхбаатар аймгийн Урт сумын нутаг Долир манхан, Их айлын манхнаас хас болон цахиур чулуугаар хийсэн шинэ чулуун зэвсгийн хэв шинж бүхий олдворууд түүвэрлэсэн байна. 1953-1955 онд Х.Пэрлээ Хэнтий аймгийн Гүрэмийн нуурын орчмоос шинэ чулуун зэвсгийн хэв шинж бүхий шавар ваарны хагархай, галын ором, чулуун зэвсгийн олдвор, Хэрлэнгийн баруун эрэгт орших Баянцогт овооноос шинэ чулуун зэвсгийн суурин илрүүлжээ. Мөн энэ үед нутгийн иргэдийн оролцоотойгоор Молцог элсний дурсгал, Устай, Бургастайн шинэ чулуун зэвсгийн томоохон дурсгалуудыг илрүүлсэн байна. 1960-1970-аад оны үед Монгол орны хээрийн бүс нутагт шинэ чулуун зэвсгийн судалгаа харьцангуй эрчимтэй хийгдсэн бөгөөд Сүхбаатар аймгийн Бүрдийн баруун эрэг, Онгон элсний зүүн хэсэг, Онгон сумын төвийн баруун тал, Хонгор сумын Гүн булаг, наран сумын Эхэн ус, Дорнод аймгийн Хэрлэнгийн эргийн дурсгалууд, Овоот, Баруун, Зүүн Өлзийт, Дөрөө нуур, Ямаат нуур, Тогоот нуур, Мөнх толгой, Баруун шорвог нуур, Хүйтэн булаг зэрэг газруудаас шинэ чулуун зэвсгийн дурсгал илрүүлжээ. 1967 онд МЗТСХЭ Чулуун зэвсгийн дурсгал судлах ангийн судлаачид Тамсагбулагт неолитын үеийн хагас газар сууц, цооног нүхэнд суугаа байдлаар оршуулсан булш оршуулга зэрэг сонирхолтой дурсгалыг малтан шинжилж, үр дүнг хэвлүүлсэн байдаг.

1990-ээд оны эхэн үед “Дорнод Монгол” төслийн хүрээнд Монгол, Солонгосын судлаачид Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Молцог элсний орчимд бага хэмжээний малтлага хийжээ. Монгол-Францын хамтарсан экспедици 1998 онд Тамсагбулагийн дурсгалт газарт ажиллажээ. Сүүлийн жилүүдэд МУИС-иас зохион байгуулсан “Дорнод Монгол” экспедицийн хүрээнд Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын нутаг Ваарт элс, Түвшинширээ сумын нутаг Тогоотын голд малтлага судалгаа хийж байна. Монгол-Америкийн хамтарсан “Говь, хээрийн бүсийн неолитын судалгаа” төслийн хүрээнд 2013 онд Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан уул, Дарьганга сумын Молцог элс орчимд хайгуул судалгааг гүйцэтгэсэн бөгөөд Дэлгэрхаан уул орчимд Булагийн эхэн, Дунд булаг, Адагийн булаг, Тогоотын гол, Дэлгэрхаан уулын зүүн урд орших эртний нуурын савын ар, Зараа уул, Улаан зуух, Молцог элс орчимд Өлзийн булаг, Салаа булаг, Ганга нуурын зүүн эрэг, Сүмтийн нуур зэрэг газруудаас чулуун зэвсгийн дурсгалт газруудыг илрүүлсэн байна. Мөн 2015-2017 онуудад Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Зараа уулын шинэ чулуун зэвсгийн сууринд малтлага судалгааны ажил гүйцэтгэжээ.

2018 оноос Монгол-Канадын хамтарсан “Говь, хээрийн бүс нутгийн неолитийн судалгаа” төслийн хүрээнд Тамсагбулагт өргөн хэмжээтэй малтлага судалгааг эхлүүлсэн бөгөөд неолитын үеийн оромж сууцны үлдэгдлийг илрүүлээд байна. Мөн чулуун зэвсэг, шавар ваар савны хагархай, амьтны яс, гоёл чимэглэлийн зүйл агуулсан соёлт давхарга илрүүлэн малтлага судалгааг гүйцэтгэж байна. Малтлагаас олон тоогоор олдсон амьтны ясыг Канад улсын Трентийн их сургуулийн лабораторид нарийвчлан судалж буй бөгөөд хэд хэдэн дээжинд он цаг тогтоох шинжилгээ хийгээд байна.

Хугацаа:

2024 оны 07 сарын 04-нөөс 08 сарын 04-нийг дуустал 31 хоног

Судалгааны арга:

Археологийн хээрийн шинжилгээний малтлага болон хайгуул судалгааны арга зүйг ашиглах ба илэрсэн олдвор хэрэглэгдэхүүний гар зураг болон бусад баримтжуулалт үйлдэнэ.

Судалгааны ангийн бүрэлдэхүүн:

Монголын талаас

Доктор (Ph.) Д.Одсүрэн (МУБИС-ийн НХУС-ийн багш, ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн судлаач)

Доктор (Ph.) Д.Бөхчулуун (АНУ-ын Йелийн Их сургууль)

Магистр М.Адъяасүрэн (Канад улсын Мкмастерийн Их сургуулийн докторант)

Магистр М.Сугар-Эрдэнэ (Чингис хаан музейн эрдэм шинжилгээний ажилтан)

Б.Чинзориг (жолооч)

Д.Одхүү (жолооч)

М.Цэцэгбаяр (тогооч)

О.Амаржаргал (МУБИС-ийн Түүхийн салбарын оюутан)

Э.Донойдугар (МУБИС-ийн Түүхийн салбарын докторант)

Канадын талаас

Доктор (Ph.), профессор Л.Яанз (Канад Улсын Торонтогийн Их сургуулийн профессор)

Доктор (Ph.), профессор А.Розен (АНУ-ын Техасын Их сургуулийн профессор)

М.Агакун (Канад Улсын Торонтогийн Их Сургуулийн докторант)

Унаа машин:

- Ланд Крузер
- Мицубиши Делика

Багаж, техник, тоног төхөөрөмж:

- Археологийн малтлагын багаж хэрэгсэл
- Олдвор, дээж хэрэглэгдэхүүний уут
- Майхан
- Гал тогооны хэрэгсэл

Санхүүжилт:

- Канад Улсын Торонтогийн Их Сургууль

Маршрут:

Улаанбаатар – Даланзадгад – Номгон сум – Цал гүний сайр, Баянгол – Бүдүүн хар уул – Улаан хороотын толгод – Ханбогд сум – Ар Хужиртын гол – Олон шандын толгод – Хатанбулаг сум – Овоот улаан толгой, Цахиуртын худаг, Тэнгэр тойром – Өргөн сум – Зүүн булангийн худаг – Онгон сум – Их булагийн ам – Наран сум – Зүүн булаг, Баруун булаг, Хар нуур, Ноён нуур – Уулзварын гол – Сөдөтийн булаг Дарьганга сум – Өндөр хүрээт толгой – Зүүн, Баруун, Дунд хөдөө нуур – Сүүл толгой – Хадатын булаг – Байшинтын тойром – Бургасны худаг – Холбоо нуур, Бадрах уул – Хошмог нуур – Зэгэст нуур – Бадрайн худаг, Хойморийн гурван нуур – Агуйт уул – Салаа булаг – Дарьганга – Баруун-Урт – Улаанбаатар гэсэн чиглэлээр хөдөлгөөнөө үйлдэнэ. 2024 оны 07 дугаар сарын 04-нөөс 08 дугаар сарын 03-ныг дуустал 31 хоног ажиллана.

Гарах үр дүн:

Хайгуул, малтлага судалгааны явцад шинэ олдвор хэрэглэгдэхүүн илрүүлж нарийвчлан судлах. Тус экспедицид оролцсон талууд хамтарсан судалгаагаар олдсон хэрэглэгдэхүүнд боловсруулалт хийж, мөн малтлага судалгааны явцад илэрсэн дурсгалуудын талаар урьдчилсан үр дүнг мэдээлж, эрдэм шинжилгээний тайлан бичиж хүлээлгэн өгнө.

Удирдамж боловсруулсан: *Д. Огигуу* МУБИС-ийн НХУС-ийн Түүхийн
тэнхимийн багш, доктор (Ph.D) Д.Одсүрэн

ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

Талууд:

Монгол Улсын Боловсролын Их сургуулийн Нийгэм, Хүмүүнлэгийн Ухааны сургууль
Улаанбаатар хот, СБД, VIII хороо, Бага тойруу – 14, Монгол улс - 210648

Канадын Торонтогийн Их сургуулийн Удирдах зөвлөл
Сүйте 413, Бантинг Институт, 100 Коллеж гудамж, Торонто, Онтарио муж, M5G1L5, Канад улс

Монгол орны говь, хээрийн бүс нутгийн мезолит, неолит, түрүү хүрлийн үеийн дурсгалуудыг судалснаар эртний оршин суугчдын амьдралын хэвшил, аж ахуйн өөрчлөлт, мал аж ахуй, тариалангийн үүсэл, металл зэвсэгт шилжсэн шилжилтийн үеийн онцлогийг тодруулна. Судалгааны явцад илрүүлсэн чулуун зэвсэг, ваар савны олдворууд, ан амьтны яс, ургамлын үлдэгдлийг археологи, антропологи, палеозоологи, изотоп, дулаан хуримтлалын аргаар нарийвчлан шинжлэхийн зэрэгцээ эртний хүрээлэн буй орчин, тухайн үеийн уур амьсгалын байдлыг тодруулах үүднээс микроморфологийн шинжилгээ хийх бөгөөд эртний түүхийн зарим балархай асуудлыг тодруулахад энэхүү гэрээний зорилго чиглэгдэнэ.

Төслийн талууд болох Даваахүүгийн Одсүрэн (МУБИС-н Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургууль; төслийн удирдагч) болон Профессор Лиса Яанз (Торонтогийн Их сургууль; төслийн удирдагч) нар нь “Монголын говь, хээрийн бүс нутгийн неолитын судалгаа” төслийн хээрийн судалгааны төлөвлөгөөг жил бүр шинэчлэн гаргаж, биелэлтийг тооцож ажиллана.

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү гэрээ нь талууд хооронд түншийн харилцаа болон хууль эрх зүйн хамаарлыг үүсгэхгүй. Аль нэг тал дангаар гэрээний үүргийг хүлээхгүй. Гэрээний хүрээнд эрдэм шинжилгээний судалгааны зорилгын дагуу үнэнчээр хамтран ажиллаж цаашдын санхүүжилтийн боломж бололцоо болон хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ. Албан бичгээр харилцан тохиролцож хамтран ажиллана.

2. ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БАЙХ

2.1 Тус төслийн гэрээнд оролцогч талуудын эрх бүхий этгээдийн гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Гэрээний хүчинтэй хугацаа 3 жил.

2.2 Талууд гэрээг цуцлах бол 30 хоногийн дотор албан бичгээр мэдэгдэнэ. Хэрэв талуудын аль нэг нь гэрээ дуусгавар болох хугацаанаас өмнө гэрээг цуцлахыг хүсвэл хамтран зөвшилцөх үүрэгтэй.

2.3 Гэрээнд талууд гарын үсэг зурснаар албан бичгээр өөрчлөлт болон засвар эсвэл сунгалт хийх боломжтой. Гэрээнд тусгагдсан 4,5,6 болон 7 дугаар заалтууд гэрээг цуцлах эсвэл дуусгавар болгосон ч хүчин төгөлдөр үлдэх болно.

3. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

3.1 МУБИС-ийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн үүрэг, хариуцлага

- а) Хээрийн шинжилгээний ажилд шаардагдах холбогдох зөвшөөрөл, бичиг баримтыг зохих журмын дагуу бүрдүүлнэ.
- б) Хайгуул, малтлагын хугацаанд хээрийн шинжилгээний ажилд хэрэглэгдэх газрын зураг, агаарын зураг, өмнөх судлаачдын бичсэн хээрийн шинжилгээний ангийн тайлан, археологийн сан хөмрөгөөс шаардлагатай монгол, орос хэл дээр бичсэн материалыг

хамтрагч талуудад үзэж танилцуулах ба мөн монгол, орос хэлнээс зарим зайлшгүй шаардлагатай баримт материалыг англи хэлнээ орчуулна.

- c) МУБИС-н НХУС болон Торонтогийн Их сургууль хоорондын зөвшилцөл дээр үндэслэн гаргасан цаг хугацааны дагуу олон улсын судлаачдын Монгол Улсад орж ирэх, түр оршин суух бүртгэл хийлгэхэд шаардагдах урилга, бичиг баримтыг бүрдүүлнэ.
- d) Хээрийн шинжилгээний ажилд оролцох унаа тэрэг, туслах ажилтан, жолооч, тогооч, зохион байгуулагчийг бэлтгэх ба лабораторид ажиллах нөхцөлөөр бүрэн хангах.
- c) Хээрийн шинжилгээний ажилд хэрэглэсэн багаж хэрэгслийг хадгалан дараа жилийн ажилд бэлтгэж арчлан хамгаална.
- f) Хээрийн шинжилгээний ажлын үр дүнд олдсон эх хэрэглэгдэхүүнийг сэргээн засварлах, лабораторийн нарийвчилсан судалгаа хийлгэх, дурсгалын он цаг тогтоох шинжилгээнд дээж явуулах шаардлагатай бол Монгол Улсын зохих хуулийн дагуу хилээр гаргах гаалийн бичиг баримтыг бүрдүүлэх үүрэг хүлээнэ.

3.2 Торонтогийн Их сургуулийн үүрэг, хариуцлага

- a) Төслийг амжилттай явуулах зорилгоо хэрэгжүүлэхийн тулд санхүүгийн эх үүсвэрийг Канад улс болон бусад орны санхүүгийн дэмжлэг авч болохуйц хувь хүн ба байгууллагуудаас зохих журмын дагуу өргөдлийг бүрдүүлэн санхүүгийн дэмжлэг авах болно.
- b) Хэрэв төсөлд хамааралтай санхүүжилт авсан тохиолдолд санхүүжилтийн хуваарилалтыг Торонтогийн Их сургуулийн санхүүгийн дүрэм журмыг баримтлан ажиллах болно.
- c) Археологийн болон антропологийн эх хэрэглэгдэхүүнийг Торонтогийн Их сургуульд эргэж ирэх нөхцөлтэйгөөр лабораторийн шинжилгээнд илгээсэн тохиолдолд заасан хугацаанд (2 жил) эргэн илгээх үүрэгтэй.
